

Засгийн газрын 2019 оны 313 дугаар тогтоолын хавсралт

ТЭСЭЛГЭЭНИЙ АЖЛЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ДҮРЭМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Энэхүү дүрмийг үйлдвэрлэлийн зориулалттай тэсэлгээний ажил эрхлэх эрх бүхий байгууллага (цаашид “тэсэлгээний ажил эрхлэх” гэх) заавал дагаж мөрдөх бөгөөд дүрэм нь үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх материалыг бэлтгэх, үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх болон ашиглах шаардлагыг тогтооно.
2. Тэсэлгээний ажил эрхлэх эрх бүхий байгууллага нь Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн дагуу холбогдох тусгай зөвшөөрлийг авсан байна.
3. Тэсэлгээний ажил эрхлэх эрх бүхий байгууллагын тэсэлгээний ажлыг удирдах, гүйцэтгэх, тэсрэх материалтай харьцах ажилтан нь үнэмлэхтэй байна.
4. Тэсэлгээний ажилд ашиглах тэсрэх материал нь нэр, төрлөөрөө заавал бүртгэлтэй байна.
5. Тэсэлгээний ажилд мэргэжлийн хяналтын байгууллага хяналт тавина. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр тухай бүр томилогдсон ажлын хэсэг тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэр, агуулахын аюулгүй бүсийг тогтоох, тэсэлгээний ажлыг механикжуулах тоног төхөөрөмж, тэсэлгээний багаж, хэмжүүр, аппарат хэрэгслийг туршин хэрэглэх нөхцөлийн талаар дүгнэлт гаргана. Ажлын хэсгийн дүгнэлтээр техникийн нөхцөл, стандартын шаардлага хангахгүй, хэрэглэх боломжгүй нь тогтоогдсон тоног, төхөөрөмж, багаж хэрэгсэл, тэсрэх материалыг ашиглахыг хориглоно. Дүгнэлтийг гаргахад эрх бүхий тэсэлгээний мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллагын шинжилгээ, сорилт, туршилтын үр дүн, хэрэглэх баталгаат хугацаа нь дууссан тэсрэх материалын талаар дүгнэлтийг ашиглаж болно. (Энэ заалтыг Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан)
6. Үйлдвэрлэлийн зориулалттай бүх тэсрэх материал (тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ба цөмлөх-дэлбэлэх аппаратур) нь аюултай байдлын ангилалын I ангид багтана. Тэсрэх материалыг энэхүү дүрмийн хавсралт №1-д заасан хадгалах тээвэрлэхэд мөрдөх хамтатгах бүлэг болон энэхүү дүрмийн хавсралт №2-т заасан мэдрэмтгийн байдлын дэд ангид хуваана. Тэсрэх материалыг хэрэглээний нөхцөлөөр нь энэхүү дүрмийн хавсралт №3-т зааснаар ангилна.
7. Тэсрэх материалыг үйлдвэрлэгчийн тогтоосон аюултай байдлын зэрэглэлийн анги, хэрэглэх зааврын дагуу ашиглана.
8. Энэхүү дүрмийн 1-д заасан байгууллагаас мэргэжлийн туслалцаа авч байгаа захиалагч болон тэсэлгээний ажилтай хамааралтай байгууллага, хүмүүс энэхүү дүрмийг заавал мөрдөнө.

**ХОЁР. ТЭСРЭХ МАТЕРИАЛТАЙ ХАРЬЦАХ, ТЭСЭЛГЭЭНИЙ АЖИЛ
ГҮЙЦЭТГЭХ АЖИЛТАНД ТАВИХ ШААРДЛАГА**

Тэсэлгээний ажлын удирдагч

9. Уурхайн болон тэсэлгээний ажил, тэсрэх материалын чиглэлээр мэргэшсэн, бакалавраас доошгүй зэрэгтэй ажилтнаар тэсрэх материалтай харьцах, ашиглах, үйлдвэрлэх, бэлтгэх ажлыг удирдуулах ба мөн тэсрэх материалын эргэлттэй холбоотой дүрэм, заавар бусад баримт бичиг боловсруулах ажлыг гүйцэтгүүлнэ.

10. Тэсэлгээний ажлын удирдагчаар ажиллах ажилтан тусгай сургалтад хамрагдаж тэсэлгээний ажил удирдах эрх авсан байна.

11. Тэсэлгээний ажлыг байгууллагын хэмжээнд тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагч, тэсрэх материалтай харьцах, ашиглах, үйлдвэрлэх, бэлтгэх ажлын байрны үйл ажиллагааг тэсэлгээний ажлын удирдагч тус тус удирдана.

12. Тэсэлгээний ажил, үйлчилгээ явуулж, тэсрэх материал үйлдвэрлэж байгаа байгууллагын тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагч нь тэсэлгээний ажил удирдах эрх авсан байна.

13. Тэсэлгээний ажлын удирдагч, хариуцлагатай удирдагчийн эрхийг дараах мэргэжлээр дээд сургууль төгссөн болон дадлагажсан ажилтанд олгоно. Үүнд:

а) уул уурхайн ашиглалтын технологи, тэсэлгээний мэргэжлээр төгссөн бакалавр, магистр зэрэгтэй, тэсэлгээний курст суралцаж төгссөн;

б) далд уурхайн барилгын инженер технологи мэргэжлээр төгссөн, магистр зэрэгтэй, тэсэлгээний ажлын курст суралцаж төгссөн;

в) ил, далд уурхайн болон тэсэлгээний ажилд 2-оос доошгүй жил ажиллаж дадлагажсан;

г) энэ дүрмийг батлагдан гарахаас өмнө тэсэлгээний ажлын удирдагч, хариуцлагатай удирдагчийн эрх авсан хүмүүст энэ заалтын а), б), в) дэх дэд заалт хамаарахгүй. (Энэ дэд заалтыг Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор нэмсэн)

14. Далд уурхайн тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагчийн эрхийг зөвхөн нэмэлт сургалтад хамрагдаж шалгалт өгсний дараа олгоно.

15. Судалгааны зорилгоор тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагчаар ажиллах шаардлагатай болсон эрдэм шинжилгээний ажилтан тэсэлгээний сургалтад суралцаж төгссөн бол шалгалт авч “Тэсэлгээчний үнэмлэх”-ийг олгож болно.

**Тэсрэх материал ашиглах (тэсрэх материалтай харьцах)
ажилтныг бэлтгэх**

16. Тэсрэх материалтай харьцах ажилтан (тэсэлгээчин, тэсрэх материалын агуулахын эрхлэгч, нярав, лаборант, тэсрэх материал бэлтгэх үйлдвэрийн болон цэнэглэгч машины оператор, үйл ажиллагааныхаа чиглэлээр тэсрэх материал

ашиглахтай холбоотой ажилтан, тэсрэх материалын тээврийн жолооч) нь холбогдох сургалтад сурч, тэсэлгээчний болон тэсрэх материалтай харьцах эрхийн үнэмлэх авсан, тэсрэх материалтай харьцахад тавих эрүүл мэндийн шаардлага хангасан байна.

17. Тэсэлгээчний эрхийг бүрэн дунд боловсролтой, ажилласан жил, насны хувьд дараахь шаардлага хангасан хүнд олгоно. Үүнд:

а) хий, тоосны аюултай далд уурхайн тэсэлгээний ажилд нэвтрэгч болон цэвэрлэгээний мөргөцгийн ажилтнаар 2-оос доошгүй жил ажилласан, 20-оос дээш насны;

б) бусад тэсэлгээний ажилд тухайн байгууллагад 1-ээс дээш жил ажилласан, 18-аас дээш насны.

18. Халуун массив тэслэх ажлын эрхийг тэсэлгээний ажилд 2-оос доошгүй жил ажилласан тэсэлгээчинд олгоно.

19. Тэсрэх материалтай харьцах ажилтны сургалтын хөтөлбөрийг сургалтын байгууллага боловсруулж, мэргэжлийн зөвлөл батална. Тэсрэх материалын ашиглалттай холбоотой ажилтныг бэлтгэх сургалтын хөтөлбөрийг сургалтын байгууллага мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран боловсруулж мэргэжлийн зөвлөл батална. Уул уурхайн тэсэлгээчинд ил ба далд уурхайн нөхцөлд ажиллах эрх олгоно. (Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоогоор 3 дахь өгүүлбэрийг нэмсэн)

20. Тусгай тэсэлгээний ажлын төрлүүд:

а) чичирхийллийн хайгуулын, түүнчлэн газрын тос, хий, усны болон бусад цооногт цөмлөх-дэлбэлэх тэсэлгээний ажил;

б) хөлдүү газар, намгийн өнгөний хөлдүүс, мөс бутлах болон усны доорх тэсэлгээний ажил;

в) халуун массив бутлах, тэсрэлтийн энергиэр металл боловсруулах (огтлох, гагнах, бэхжүүлэх);

г) барилга байгууламж нураах, цутгамал суурь, барьцалдсан хүдэр бутлах тэсэлгээний ажил;

д) хожуул булгалах, мод унагах, барьцалдаж хөлдсөн мод бутлах, сал урсгах үед үүссэн түгжээс задлах, ойн түймэртэй тэмцэх тэсэлгээний ажил;

е) газрын тосны далд малталт дахь болон гадарга дээрх тэсэлгээний ажил;

ё) хонгил нэвтрэх, метроны барилга байгууламж байгуулах тэсэлгээний ажил;

з) хайгуулын нэвтрэлтийн тэсэлгээний ажил;

ж) тэсрэх материал, тэсрэлтийн аюултай төхөөрөмжийг газрын гадарга дээр устгах тэсэлгээний ажил;

и) шинжлэх ухааны болон сургалтын зориулалтаар тэсрэх материал ашиглах тэсэлгээний ажил;

к) дээрхээс бусад тэсэлгээний ажил.

21. Ажилтан нь тэсрэх материалтай харьцах ажилтан бэлтгэх сургалтад суралцсаны дараа мэргэжлийн хяналтын байгууллагын удирдсан мэргэжлийн комисст (цаашид “Мэргэжлийн комисс” гэх) шалгалт өгнө. Шалгалтын дүнгийн тэмдэглэлд мэргэжлийн комиссын гишүүд гарын үсэг зурсан байна.

22. Сургалт зохион байгуулсан байгууллага тэсрэх материалтай харьцах ажилтан бэлтгэх шалгалтын тушаал гаргаж, тэмдэглэл, бусад баримт бичгийг хөтөлнө.

23. Энэхүү дүрмийн 19-д заасан материалын нэг хувийг мэргэжлийн хяналтын байгууллагад хүргүүлэх бөгөөд уг материал нь “Тэсэлгээчний үнэмлэх” бичиж олгох, бүртгэх үндсэн баримт болно.

24. Тэсэлгээний ажил удирдах эрх бүхий этгээдийг мэргэжлийн комисст шалгалт өгч, нэг сарын дадлага хийсний дараа ажиллуулна.

25. Тэсэлгээчнийг нэг сараас багагүй хугацаагаар туршлагатай тэсэлгээчинг дагалдуулан ажиллуулсаны дараа бие даалган ажиллуулна.

26. Шинээр тэсрэх материалтай харьцах эрхийн үнэмлэх авсан ажилтныг 10-аас доошгүй хоног тэсрэх материалтай харьцах туршлагатай ажилтныг дагалдуулан ажиллуулсаны дараа бие даалган ажиллуулна.

27. Тэсрэх материал ашиглахтай холбоотой ажилтны дагалдан суралцах газар, хугацаа, удирдагчийг байгууллагын удирдлагын тушаалаар томилно.

28. Тэсэлгээний ажилд бэлтгэх, гүйцэтгэх ажилтанд тэсрэх материалтай харьцах ажилтны үүрэг хариуцлага, аюулгүй ажиллагааны зааврыг бичгээр өгч, гарын үсэг зуруулна.

29. Тэсрэх материалын агуулах, тэсэлгээний ажлын тусгай хөтөлбөрөөр сургалтад хамрагдаж, мэргэжлийн комисст шалгалт өгч, тэсэлгээчний үнэмлэх авсан ажилтныг тэсрэх материалын агуулахын эрхлэгч ба тэсрэх материалын үйлдвэрийн даргаар ажиллуулна. ~~Бага хэмжээний тэсрэх материалын агуулахын нярав, эрхлэгчээр тэсрэх материалтай харьцах эрхийн үнэмлэх авсан бусад ажилтныг давхар ажиллуулж болно.~~ (Энэ заалтын 2 дахь өгүүлбэрийг Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор хассан)

30. Тэсрэх материалын агуулахын эрхлэгч, нярав тэсэлгээний ажил гүйцэтгэж болохгүй. Тэсэлгээний ажил гүйцэтгэж буй тэсэлгээчин тэсрэх материалын агуулахын эрхлэгч, няравын үүрэг хүлээж болохгүй.

31. Тэсрэх материалын түр хадгалах түр агуулахын нярав, эрхлэгчээр тэсрэх материалтай харьцах эрхийн үнэмлэх авсан бусад ажилтныг давхар ажиллуулж болно. (Энэ заалтыг Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан)

32. Тэсэлгээний ажлын удирдагч, тэсэлгээчин, тэсрэх материалын агуулахын нярав, лаборант болон бусад холбогдох ажилтны сургалтыг Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан журмын дагуу явуулна.

33. Сургалт эрхлэх байгууллага нь сургалтын хөтөлбөрийг мэргэжлийн зөвлөлөөр батлуулсан байна.

34. Сургалт явуулах байгууллага нь дараахь шаардлагыг хангасан байна. Үүнд:

а) уул уурхайн мэргэжлийн бакалавраас дээш зэрэгтэй, 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай, тэсэлгээний ажлаар мэргэшсэн, 3-аас цөөнгүй багштай байх;

б) үзүүлэн таниулах болон сургалтын материалаар иж бүрэн тоноглосон анги танхимтай;

в) багш нь багшлах эрхийн сургалтад хамрагдсан байна.

35. Тэсэлгээний ажлын харьцах үнэмлэх олгох сургалтыг тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрөл бүхий байгууллага явуулж болох бөгөөд энэхүү дүрмийн 33, 34-д заасан шаардлагыг хангасан байна.

36. Тусгай хөтөлбөрөөр сурч, Мэргэжлийн комисст шалгалт өгч, тэнцсэн ажилтанд үнэмлэх олгоно.

37. Үнэмлэх нь нэгдсэн загвар, бүртгэлийн ба серийн дугаартай, анхааруулах талонтой, мэргэжлийн хяналтын байгууллагад бүртгэгдсэн байна. (хавсралт №4).

а) үнэмлэхэд мэргэжлийн комиссын дарга, гишүүд гарын үсэг зурж, мэргэжлийн хяналтын байгууллагын тамгыг дарна.

б) серийн болон улсын бүртгэлийн дугаар нь мэргэжлийн хяналтын байгууллагын бүртгэл хяналтад байна.

в) тэсэлгээчний гүйцэтгэх эрх авсан тэсэлгээний ажлын төрлийг үнэмлэхэд тэмдэглэнэ.

г) бүртгэлийн дэвтэрт үнэмлэх хүлээж авсан тухай гарын үсэг зурж баталгаажуулна.

38. Үнэмлэхийн хугацаа нь олгосон өдрөөс эхлэн 2 жилийн хугацаатай байна.

Үнэмлэхийн хугацаа дуусахаас өмнө давтан сургалтад хамрагдаж сунгалт хийлгэнэ. Үнэмлэхийн сунгалтыг хийлгээгүй бол түүнийг хүчингүйд тооцож дахин сургалтад хамрагдан шинээр үнэмлэх авна.

39. Ажилтан өөр байгууллагад шилжихэд үнэмлэхэд заасан ажлыг гүйцэтгэх эрх нь хадгалагдана.

40. Тэсэлгээний ажил гүйцэтгэж буй тэсэлгээчин үнэмлэхээ биедээ авч явна.

Бусад тохиолдолд байгууллагын тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагч үнэмлэх хадгалах журмыг тогтооно. Эрх бүхий ажилтанд үнэмлэхийг шалгах боломжоор хангана.

41. Үнэмлэх гээгдүүлсэн тохиолдолд байгууллагын хүсэлтээр мэргэжлийн хяналтын байгууллагаас үнэмлэхийг нөхж олгож болно.

42. Тэсэлгээчний хувийн хэрэг, давтан сургалтад суралцсан байдал, шалгалтын дүнгийн хуудас, үнэмлэх холбогдох материалыг мэдээллийн нэгдсэн санд тухай бүр оруулна.

43. Тэсрэх материал ашиглах, хадгалах, тээвэрлэх, бүртгэх тогтоосон дүрэм, журмыг зөрчсөн нь осол, аваар гаргахад хүргэсэн, тэсрэх материал алдагдсан буюу тийм нөхцөл үүсгэсэн тохиолдолд мэргэжлийн хяналтын байгууллагын болон тухайн байгууллагын эрх бүхий этгээдийн мэдүүлснээр үнэмлэхийг хүчингүй болгож тэсрэх материалтай харьцах эрхийг хасна.

44. Байгууллага нь тэсэлгээчний хураагдсан үнэмлэхийг мэргэжлийн хяналтын байгууллагад устгуулахаар хүлээлгэн өгнө. Мэргэжлийн хяналтын байгууллага хураагдсан үнэмлэхийн бүртгэл хөтөлнө.

45. Үнэмлэхийн бэлдэцийг мэргэжлийн хяналтын байгууллагаас тогтоосон журмаар бэлтгэнэ.

Тэсрэх материалын ашиглалттай холбоотой ажилтны мэдлэгийг шалгах

46. Тэсрэх материал ашиглах, хадгалах, тээвэрлэх, үйлдвэрлэх, бүртгэх журмын талаар байгууллагын удирдлагын шийдвэрийг үндэслэж давтан сургалтад оруулна. Давтан сургалтын шалгалтыг тухайн байгууллага комисс томилон авна.

47. Байгууллага давтан сургалтын болон шалгалтын баримт бичиг хөтлөх, хадгалах журмыг тогтооно.

48. Тэсэлгээчнийг өөр төрлийн тэсэлгээний ажилд шилжүүлэхдээ зохих журмаар баталсан хөтөлбөрөөр сургаж, шалгалт авсан байна. Тэсэлгээчин шинэ төрлийн ажлыг 10 хоног туршлагатай тэсэлгээчнийг дагалдсаны дараа бие дааж гүйцэтгэнэ.

49. Тэсэлгээчнийг хий, тоосны аюултай уурхайд шилжүүлэхдээ мэргэжлийн хяналтын байгууллагатай зөвшилцсөн хөтөлбөрөөр уурхай дээр давтан сургаж, мэргэжлийн комисс шалгалт авч 15 хоногийн дадлага хийлгэнэ. Онцгой ангиллын уурхай болон нүүрс, хөрс, хийн гэнэтийн хаялтай уурхайд 20 хоногийн дадлага хийлгэнэ.

50. Үнэмлэхтэй ажилтан 1 жилээс дээш хугацаагаар ажиллаагүй бол байгууллагын комисст шалгалт өгч, 10 хоног дагалдсаны дараа бие даалган ажиллуулж болно.

51. Байгууллага нь ашиглаж байгаагүй тэсрэх материал, аппарат, тоног төхөөрөмж шинээр ашиглах бол тэсэлгээний ажилд оролцдог бүх ажилтнаа тэдгээрийн шинж чанар, онцлогтой нь танилцуулах, ашиглах сургалт зохион байгуулна.

ГУРАВ. ӨДӨӨХ ХЭРЭГСЭЛ АШИГЛАХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

Цахилгаан тэслүүр ашиглах

52. Цахилгаан тэслүүрийг тавьж олгохын өмнө гадаад үзлэг хийж, эсэргүүцлийг нь шалгана. (Энэ заалтын зарим хэсгийг Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор хассан)

53. Цахилгаан тэслүүрийг шалгахдаа хананы цаанаа байрлуулсан ажилчдыг гэмтэхээс хамгаалах хуягласан хоолой дотор юмуу тусгай төхөөрөмжид байрлуулна. Шалгалтын дараа цахилгааны утсыг богино холбоо үүсгэн битүүлж, тэсэлгээний хэлхээнд холбох хүртэл тэр чигээр нь авч явна. Шалгах үед нэг ширээн дээр 100-аас илүүгүй цахилгаан тэслүүр байлгах бөгөөд гүйдлийн эх үүсвэр байлгахыг хориглоно. (Энэ заалтад Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон)

54. Цахилгаан тэсэлгээний хэлхээг сайтар тусгаарлаж, холболтуудыг найдвартай хийнэ. Утас буюу кабелийн төгсгөлийг сайн цэвэрлэн боож, эсхүл тусгай хавчаар болон бусад хэрэгслээр холбож тусгаарлана. Хий, тоосны аюултай уурхайд цахилгаан тэслүүрийн болон тэсэлгээний хэлхээг зөвхөн холболтын хавчаараар холбоно.

55. Цахилгаан тэсэлгээний хэлхээ нь заавал хоёр уастай байна. Төмөр хоолой, төмөр зам, ган татлага, газар, ус зэргийг цахилгааны нэг утасны оронд ашиглахыг хориглоно. Тэсэлгээчин цэнэглэлт эхлэхийн өмнө тэжээлийн цахилгаан хэлхээний бүрэн бүтэн байдлыг шалгасан байна.

56. Хий, тоосны аюултай уурхайд зөвхөн зэс уастай цахилгаан тэслүүр хэрэглэнэ. Холболтын болон төв шугам (кабель) мөн зэс уастай байна.

57. Цахилгаан хэлхээг цэнэг талаас нь эхэлж эх үүсвэр чиглэлд угсарна.

58. Тэсэлгээний ажилд хэрэглэж буй цахилгаан тэслүүр бүрт тухайн бүтээгдэхүүний техникийн баримт бичигт зааснаас багагүй гүйдэл өгнө.

59. Тэсэлгээний тэжээлийн төв шугам нь тэсэлгээ хийх газраас 50 метрээс багагүй зайд байрлана. (Энэ заалтад Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон)

60. Тэсэлгээний хэлхээг угсарч, үзлэг хийсний дараа хэлхээний дамжуулах чадварыг шалгана. Энэ үед ажилтан аюултай бүсийн гадна байрласан байна. Цахим тэслүүртэй тэсэлгээний үед мөргөцөгт холболт хийсний дараа шалгах, цахим тэслүүрт мэдээлэл оруулах, удаашруулал тохируулах ажлыг гүйцэтгэж болно. (Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор З дахь өгүүлбэрийг нэмсэн)

61. Цооногийн болон камерын цэнэгийг тэслэхийн өмнө тэсэлгээний цахилгаан хэлхээний ерөнхий эсэргүүцлийг урьдчилан тооцож, аюулгүй зайнлас хянан хэмжих багажаар шалгана. Хэмжилтийн болон тооцооны эсэргүүцлийн зөрүү 10 хувиас илүү байвал тэсэлгээ хийхийг хориглоно. Тэсэлгээний цахилгаан хэлхээний эсэргүүцлийг хэмжих боломжгүй үед тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагчийн зөвшөөрлөөр цахилгаан хэлхээний зөвхөн дамжуулах чадварыг шалгасны үндсэн дээр тэсэлгээ хийж болно.

62. Тэсэлгээний ажлын паспорт болон өрөмдлөг, тэсэлгээний ажлын төслөөр тогтоосон аюулгүй байрлалаас тэсэлгээний цахилгаан хэлхээнд хүчдэл өгнө.

Тэсэлгээний төхөөрөмж нь цахилгаан хэлхээний төв шугамыг холбох зориулалтын хавчаартай байна.

63. Аюултай бүсээс ажилчдыг бүрэн гаргасны дараа тэсэлгээний цахилгаан хэлхээг тэсэлгээний төхөөрөмжид холбоно.

64. Бөөнөөр нь тэсэлгээ хийх тохиолдолд зөвхөн тэсэлгээний ажлын удирдагч хариуцлагатай удирдагчаас зөвшөөрөл авч цахилгаан гүйдэлд холболт хийнэ.

65. Цахилгаан тэсэлгээний хэлхээний холбогдсон хэсгийн утасны төгсгөлийн үзүүрүүд дараагийн хэсгийн хэлхээнд холбох хүртэл богино холболттой байна.

66. Тэсэлгээний цахилгаан хэлхээний төв шугамын утасны үзүүр нь хүчдэл өгөх төхөөрөмжид холбох хүртэл богино холболттой байна.

67. Цахилгаан тэсэлгээний шугамыг холбох үед түүний орчинд байгаа бүх төрлийн цахилгаан байгууламж, кабель, агаарын болон бусад цахилгаан тэжээгч, түүнчлэн цахилгаан соронзын нөлөөлөл бүхий эх үүсвэрийг уг ажлыг эхлэхийн өмнө тэжээлээс салгана. Цахилгаан тэсэлгээний хэлхээний орчинд:

- а) газрын доор тэсэлгээ хийх нөхцөлд холбох малталтууд;
- б) газрын дээр тэсэлгээ хийх нөхцөлд гүйдэл дамжуулах шугамын утасны өлгөлтийн өндрийг үл харгалзан цахилгаан тэсэлгээний хэлхээнээс 50 метр;
- в) цооногт цөмлөх аппаратур тэслэх үед 10 метрээр тус тус тооцно.

68. Цахилгаан тоног төхөөрөмжийн хүчдэлийг салгах боломжгүй тохиолдолд тэсэлгээний ажил гүйцэтгэгч байгууллагын баталсан шийдвэрийн дагуу тэнэмэл гүйдлээс урьдчилан сэргийлнэ. Үүнд:

- а) хамгаалалттай цахилгаан детонатор хэрэглэх;
- б) ашигласан утсыг холболтонд дахин хэрэглэхийг хориглох;
- в) утасны үзүүр холбоход тусгай хавчаар хэрэглэх.

69. Газрын доорх малталтад цахилгаан тэсэлгээний хэлхээг холбох үед цахилгаан тэслүүрийг тэнэмэл гүйдлээс хамгаалах арга хэмжээ авснаар холболтын бүсэд байгаа 42 вольтоос илүүгүй хүчдэлтэй гэрэлтүүлгийн шугам, хэсгийн агааржуулах сэнс, далд уурхайн зориулалтын аппаратын хүчдэлийг таслахгүй байж болно.

70. Усны ундрага ихтэй босоо малталтад зайлшгүй шаардлагатай бол тэнэмэл гүйдлээс сэргийлэх арга хэмжээ авч, насосны хүчдэлийг салгахгүй байж болно.

71. Газрын доорх томоохон малталтад тэнэмэл гүйдэл болон статик цахилгаанжилтын хамгаалалттай цахилгаан тэслүүр ашиглаж тэсэлгээ хийхэд цэнэглэлт, холболтын ажилд өргөх тавцантай зориулалтын өөрөө явах төхөөрөмж ашиглаж болно.

72. Тэсэлгээний төхөөрөмж, тэсэлгээний суурин төхөөрөмжийг хүн оролдох боломжгүй байранд хадгална.

73. Тэсэлгээний төхөөрөмжийн түлхүүр зөвхөн хариуцсан тэсэлгээчинд байна.

74. Хүчний, гэрэлтүүлгийн болон авалцах цахилгаан хэлхээнд тэсэлгээний цахилгаан хэлхээг шууд холбохыг хориглоно.

75. Цахилгаан тэсэлгээний үед цахилгаан тэслүүрийн болон цахилгаан хэлхээний утсыг металл эд зүйлд шүргэлцүүлэхийг хориглоно.

76. Цахилгаан тэслүүрээр тэсэлгээ хийж, агааржуулалт явагдсаны дараа тэсэлгээчин хэлхээний утсыг цахилгааны эх үүсвэрээс салгаж, үзүүрийг богино холболтоор холбож, 5 минутаас багагүй хугацаа өнгөрсний дараа хоргодах байрнаас гаражыг зөвшөөрнө.

77. Хэлхээнд хүчдэл өгөхөд тэсрэлт явагдаагүй бол тэсэлгээчин нь хэлхээний утсыг төхөөрөмж (цахилгаан гүйдэл үүсгэгч)-ээс салгаж, үзүүрийг нь богино холбож, тэслэх төхөөрөмжийн түлхүүрийг өөртөө авсны дараа тэсрээгүй шалтгааныг тодорхойлно.

78. Байгууллага бүр тэсэлгээний төхөөрөмж, шалгах хянах багажийг хадгалах, тавьж олгох болон техникийн үйлчилгээ хийх журамтай байна.

79. Тэсэлгээний төхөөрөмжийг тэсэлгээчинд өгөхийн өмнө тогтоосон техникийн үзүүлэлтийн дагуу шалгасан байна.

80. Нүүрс, занарын болон хий, тоосны аюултай уурхай, геологи, хайгуулын объектын тэсэлгээний суурин төхөөрөмжийг байрлуулсан газарт нь 15 хоног тутамд шалгаж байна.

Цочир дамжуулах шижим ашиглах

81. Цочир дамжуулах шижим (түүнийг отглох, хооронд нь холбох), удаашруулагч реле, өдөөлтийн цахилгаан бус болон электрон системийг тухайн бүтээгдэхүүний зааврын дагуу ашиглана.

82. Цочир дамжуулах шижмийн хэлхээний үндсэн болон туслах шугамыг хамтад нь нэг өдөөлтөөр тэсэлнэ.

83. Бага чадлын долгион дамжуулах гуурстай өдөөх системийг ашиглалтын зааврын дагуу хэрэглэнэ. Ингэхдээ системийн элементүүдийн холболтыг найдвартай хийж, гадаргад байрлуулахдаа долгион дамжуулах гуурсыг гэмтэхээс урьдчилан сэргийлнэ.

84. Цахилгаан бус, электрон, цахилгаан болон ердийн тэслүүрээр өдөөлт өгөхөд тэдгээрийн үзүүрийн хонхорхойг тэсрэлтийн цохилт тархах чиглэл рүү харуулж байрлуулна.

85. Эдгээр системийг ашиглах үед тэсэлгээчин тэсрэлт явагдсанаас 5 минут, хэрэв тэсрэлт явагдаагүй бол 15 минутаас багагүй хугацааны дараа тэсэлгээ хийсэн газарт ойртохыг зөвшөөрнө. (Энэ заалтад Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон)

Нонел системийн хэрэгсэл ашиглах

86. Цохилтын долгион дамжуулах гуурстай өдөөх системийг үйлдвэрлэгчийн ашиглалтын зааварт заасан орчинд хадгалах буюу хэрэглэнэ. Ингэхдээ системийн элементүүдийн холболтын шат дарааллыг найдвартай хийж, гадаргууд байрлуулахдаа долгион дамжуулах гуурсыг гэмтэхээс урьдчилан сэргийлнэ.

87. Нонел системийн эхэлж тэсэрсэн элемент дараагийн элементийг гэмтээхгүй байхаар хугацааг тооцож тэсэлгээний паспортод тусгасан байна.

88. Нонель системийн гуурсны уртыг цооногийн гүн, цооног хоорондын зайд харгалзан хамгийн оновчтой байхаар сонгоно.

89. Тэсэлгээ хийх талбайгаас тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг холдуулсны дараа тэсэлгээний гадаргуугийн хэлхээний нонел системийн холболтыг хийнэ.

90. Гадаргуугийн хэлхээний элемэнтүүдийн гуурсыг аль болох богино, хэт чангаль татаагүй байхаар холбоно.

91. Тэсэлгээний хэлхээнд гал өгөх нонел гуурсын төв шугамын урт нь тэсэлгээчний хоргodoх байр буюу аюултай бүсийн гадна байрлах газарт чөлөөтэй хүрч байхаар байна.

Радио долгионы удирдлага ашиглах

92. Тэсэлгээг радио удирдлагаар зориулалтын тоног төхөөрөмж, техникийн холбогдох баримт бичгийн бүрдэлтэйгээр зайнаас хийж болно.

а) радио дамжуулагчтай удирдлагын блокийг аюулгүй бүсэд байрлуулна.

б) радио хүлээн авагчтай гүйцэтгэх блокийг тэсэлгээнээс үүссэн чулуулгийн бутармагт өртөж гэмтэхээргүй, очиход боломжтой газарт байрлуулна.

93. Бөөнөөр тэслэх үед тэсэлгээний ажлын удирдагч нь гүйцэтгэх блокуудын тэсэлгээнд бэлтгэгдсэн байдлыг хянаж, бүх ажилчдыг аюулгүй бүсэд гарсныг магадлан, радио долгионоор тэслэх тушаал өгнө.

94. Цахилгаан тэслүүрийг радио хүлээн авагчтай гүйцэтгэх блокийн хавчаарт холбохын өмнө уг блок түгжээтэй байгааг шалгасны дараа цахилгаан тэслүүрийг тэсэлгээний хэлхээнд холбоно.

95. Тэсэлгээ хийгдсэнээс хойш радио хүлээн авагчтай гүйцэтгэх блокийг түгжээтэй байгааг шалгаж тэсэлгээний ажлын удирдагчийн зөвшөөрлөөр 10 минутын дараа тэслэгдсэн блокт очиж болно. (Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор нэмэлт орсон)

96. Цахилгаан бус гуурсаар тэсэлгээний хэлхээнд гал өгөх үед удирдлагын машиныг аюулгүй бүсэд байрлуулна.

Галлагч бэлтгэх

97. Тэслүүртэй бүүстрийг тэсэлгээний ажил явуулж буй газарт болон тэсэлгээний ажил гүйцэтгэгч байгууллагын шийдвэрээр тусгайлан тогтоосон сир орших газарт бэлтгэнэ.

98. Цочир дамжуулах шижимтэй, тэслүүргүй бүүстер, галлагчийг тэсрэх материалын агуулахын тэсрэх материал бэлтгэх зориулалтын байранд бэлтгэж болно.

99. Тэслүүрийг боодолтой тэсрэх бодис (патрон)-д гүйцэд суулгаж, найдвартай бэхлэнэ. Тэслүүр суулгах нүхийг оч үүсгэдэггүй, тэсрэх бодистой харьцанаас зэврэлтэнд ордоггүй материалаар хийсэн шороор гаргана.

100. Шахмал, цутгамал бүүстрийн тэслүүр суулгах зориулалтын нүхийг гүнзгийлэх, өргөсгөх оролдлого хийхийг хориглоно.

101. Тэслүүр, цочир дамжуулах шижим ашиглан бэлтгэсэн бүүстер, галлагчийг хэрэглээгүй бол тэсэлгээний ажил гүйцэтгэгч байгууллагын баталсан журмын дагуу тэсэлж устгана.

ДӨРӨВ. ТЭСЭЛГЭЭНИЙ АЖЛЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Тэсрэх материалыг турших ерөнхий шаардлага

102. Байгууллага нь бүх материалыа хадгалах, ашиглахад тохирч байгааг шалгаж, шаардлагатай тохиолдолд туршина. Үүнд:

а) тэсрэх материалын агуулахад материал хүлээж авах шалгалт;

б) тэсрэх материалын гадаад үзлэгээр болон тэсэлгээний ажлын явцад гологдол илэрч, чанарт нь эргэлzsэн тохиолдолд;

в) хэрэв тухайн тэсрэх материалын хадгалалтын хугацааг сунгаж болохыг үйлдвэрлэгчийн ашиглалтын заавар бусад баримт бичигт заасан бол хадгалалтын хугацаа дуусахын өмнө.

103. Тэсрэх материалыг нэг байгууллагын агуулах хооронд шилжүүлэх тохиолдолд туршилт хийхгүй байж болно.

104. Туршилтыг тэсрэх материалын агуулахын лаборатори болон туршилтын талбайд тухайн төрлийн материалыг турших стандарт, техникийн нөхцөл, хэрэглэх арга, аюулгүй ажиллагааны зааврын дагуу гүйцэтгэнэ.

105. Энэхүү дүрмийн хавсралт 5, хавсралт 6-ын дагуу туршилтын үр дүнгийн акт бичиж, туршилтын бүртгэлийн дэвтэрт бүртгэнэ.

106. Хадгалалтын хугацаа хэтэрсэн тэсрэх материалыг цаашид хэрэглэх эсхүл устгах дүгнэлтийг мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллагаар гаргуулна.

107. Шинээр зохион бүтээсэн, туршилтаар үйлдвэрлэсэн тэсрэх материалыг мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллагын шинжилгээ, сорилт, туршилтын үр дүн, дүгнэлтийг үндэслэн мэргэжлийн зөвлөлөөс томилогдсон комисс үйлдвэрлэлд нэвтрүүлэх зөвшөөрөл олгоно.

108. Туршилтад ашигласан тэсрэх материалын зарлагыг бүртгэнэ.

**Тэсрэх бодисыг хатаах, бутлах, нунтаглах
өрөнхий шаардлага**

109. Тэсрэх бодисыг хатаах, бутлах, нунтаглах, гэсгээх ажлыг тэсрэх материалын агуулахын талбай дахь зориулалтын байр (тэсрэх материал бэлтгэх байр) болон туршилт, устгалын талбай дахь задгай саравчинд гүйцэтгэнэ. Эдгээр байр, талбайг төсөл зургийн дагуу байгуулна.

110. 1.5% хүртэл чийгшилтэй аммиакийн шүүнд суурилсан тэсрэх бодисын патроныг үйлдвэрийн сав баглаатай нь хатааж болно. 1.5%-иас дээш чийгшилтэй бол задгайлж хатаана. Тэсрэх бодис хатаах өрөөний температур 50°C-ээс ихгүй байна.

111. Утаат дарийг 40°C-ээс ихгүй температурт хатаана.

112. Тасалгаанд тэсрэх бодис хатааж байгаа ширээ, тавиур нь халаах гадаргуу (пийшин, яндан, радиатор г.м.)-аас 1 метрээс багагүй зайд байрласан байна.

113. Үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодисыг халуун агаартай шкаф, камерт хатааж болно. Ингэхдээ хатаах агаарын температур нь тротилоор мэдрэгжүүлсэн тэсрэх бодист 60°C-ээс, нитроэфирээр идэвхжүүлсэн тэсрэх бодист 30°C-ээс ихгүй байх бөгөөд агаар халааж үлээх төхөөрөмж нь тусгай өрөөнд байрлана.

114. Гексоген болон нитроэфир агуулсан тэсрэх бодисыг бутлах, нунтаглахыг хориглоно.

115. Үйлдвэрийн сав баглаатай тэсрэх бодисыг газрын гадарга дээрх агуулахын халаалгатай өрөөнд 30°C-ээс ихгүй температурт болон газрын доорх агуулахад гэсгээж болно. Тэсрэх бодис оруулах, гаргах цагийн бүртгэл хөтөлж гэсэлтийн байдалд хяналт тавина.

Тэсрэх материалыг устгах өрөнхий шаардлага

116. Ашиглалтын шаардлага хангахгүй болсон тэсрэх материалыг устгана.

117. Тэсрэх материалыг устгах тухай бүрт тэсрэх материалын нэр төрөл, тоо хэмжээ, устгах арга, шалтгааныг тусгасан актыг үйлдэж, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээллийн санд оруулж, нэг хувийг агуулахын эрхлэгчид үлдээнэ.

118. Тэсрэх материал устгах талбайг төслийн дагуу байгуулж, аюултай бүсийг тодорхойлсон байна.

119. Тэсрэх материалын устгалыг тэсэлгээний ажлын удирдагчийн хяналттайгаар тэсэлгээчин гүйцэтгэнэ.

120. Тэсрэх материалыг тэсэлж устгахдаа сайн чанарын тэсрэх материал ашиглан боодолтой тэсрэх бодис (патрон)-ыг багцаар нь, цочир дамжуулах шижим болон удаашруулах релег тэсрээгүй эд хэсэг цацагдахааргүй боож баглаж тэсэлнэ.

121. Тэслүүр болон тэслүүр агуулсан тэсрэх материалыг шатаахыг хориглоно. Зөвхөн тэсэлж усгана.

122. Тэсрэхгүй болсон тэсрэх материалыг шатааж устгана. Тэсрэх материал шатааж устгах үеийн аюулгүйн зайд тийм хэмжээний тэсрэх бодисыг тэслэх үеийн аюулгүйн зайгаар тооцно.

123. Тэсрэх материалыг зөвхөн хур тунадасгүй үед ашиглалтын зааварт заасан аргачлалын дагуу шатааж устгана.

124. Тэсрэх бодис, гал дамжуулах шижим, цочир дамжуулах шижмийг тус тусад нь нэг түүдгээр 20 кг-аас ихгүйгээр шатаана. Дарийг 30 см-ийн өргөн, 10 см-ийн зузаан, 5 метрээс багагүй зйтай 3-аас илүүгүй зэрэгцээ зурvas болгон асгаж шатаана.

125. Боодолтой тэсрэх бодисыг хоорондоо шүргэлцэхгүйгээр нэг үе өрж шатаана.

126. Боодолтой дарийг түүний техникийн нөхцөлд заасан зааврын дагуу устгана.

127. Тэсрэх материалыг сав, баглаа, боодолтой нь шатаахыг хориглоно. Тэсрэх бодисыг шатаахын өмнө дотор нь тэсэлгээний хэрэгсэл байгаа эсэхийг нарийн шалгана.

128. Түүдэгт шатаахаар бэлтгэсэн тэсрэх материалыг салхины дээд талаас нь 5 метрээс багагүй урттай гал дамжуулах шижим буюу түргэн асдаг материалын зурvasаар асаана. Зурvasыг асаасны дараа тэсэлгээчин хоргodoх аюулгүй байранд орно.

129. Бүх бэлтгэл ажил дуусч, ажилчдыг аюулгүй зайд гарсны дараа түүдгээ асаана.

130. Тэсрэх материал шатааж буй түүдгийн гал унтраагүй байхад ойртохыг хориглоно.

131. Нитроэфир, гексоген агуулаагүй, усанд тэсвэргүй тэсрэх бодисыг тусгай төмөр торх болон түүнтэй адилтгах саванд хийж хүрээлэн буй орчинд хор хөнөөлгүй байхаар устгаж болно.

132. Уусаагүй үлдсэн тунадасыг шатааж устгана.

133. Устгал гүйцэтгэсэн ажилтан тэсрэх материал бүрэн устсаныг нягтлан шалгах үүрэгтэй.

134. Суларсан сав баглаанаас тэсрэх бодисын үлдэгдлийг сайтар цэвэрлэнэ. Дахин ашиглах боломжгүй болон шингэн ялгарсан ор мөртэй сав баглааг тэсрэх материалаас тусад нь шатааж устгана.

135. Тэсрэх материалыг дахин боловсруулж болох, эсэхийг зөвхөн үйлдвэрлэгч нь тогтооно.

136. Устгах, дахин боловсруулах тэсрэх материалыг орлого, зарлага бүртгэх журмын дагуу бүртгэнэ.

137. Бoodлын гадарга дээр нь шингэн ялгарсан боодолтой тэсрэх бодисыг тавьж олгохыг хориглоно. 15%-иас дээш шингэн нитроэфирийн найрлагатай хөлдүү тэсрэх бодисыг хэрэглэх, халааж гэсгээхийг хориглоно.

**Тэсрэх материалыг ачиж буулгах, тээвэрлэх
ерөнхий шаардлага**

138. Тэсрэх материал хүлээж авах, ачих буулгах ажлыг тусгайлан гаргасан харуул хамгаалалт бүхий ачилт, буулгалтын талбайд тэсэлгээний ажил удирдагчийн хяналтын дор гүйцэтгэнэ.

139. Ачилт, буулгалтын талбайг төслийн дагуу тоноглосон байх бөгөөд хамааралгүй хүн ачилт, буулгалтын талбайд орохыг хориглоно.

140. Байгууллага нь ачилт, буулгалтын талбайд тэсрэх материал хүлээн авах үед ирж буй бүх тэсрэх материалын тоо хэмжээг хянаж бүртгэнэ.

141. Ачилт, буулгалтын талбай нь:

а) тэсрэх материал ачих, буулгах газрын гэрэлтүүлгийн цахилгаан хэлхээний ердийн таслуурыг 50 метрээс багагүй зайд байрлуулсан байх; (*Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор нэмэлт орсон*)

б) цагдаа, онцгой байдлын байгууллагатай холбогдох холбооны хэрэгсэлтэй байх;

в) тэсрэх материалыг вагонд ачих, буулгах талбай нь орон сууц, үйлдвэрлэлийн байгууламж болон төв төмөр замаас 125 метрээс багагүй зайд байрласан байх.

142. Тэсрэх бодисын үйлдвэрээс агуулах хүртэл тэсрэх материалын агуулахаас тэсэлгээний ажлын байр хүртэл тэсрэх материалыг байгууллагын удирдлагын эсхүл түүний томилсон эрх бүхий албан тушаалтны тогтоосон маршрутаар тээвэрлэнэ.

143. Тэсрэх материалыг ажлын байранд хүргэхдээ зөвхөн зориулалтын тээврийн хэрэгсэл ашиглана. Тэсрэх материал тээвэрлэсэн тээврийн хэрэгслээр гадны хүн зорчихыг хориглоно.

144. Далд уурхайд тэсрэх материал тээвэрлэхээр зориулан тоноглосон бүх төрлийн тээврийн хэрэгсэл ашиглаж болно.

145. Далд уурхайд тротил, гексоген, шингэн нитроэфир агуулсан мөхлөгжүүлсэн тэсрэх бодисыг өөрийнх нь жингээр хоолойгоор урсгаж буулгахыг хориглоно.

146. Далд уурхайн гол амаар хүн тээвэрлэж байх үед тэсрэх материал тээвэрлэхийг хориглоно. Тэсрэх материалыг гол амаар тээвэрлэж ачих, буулгах үед гол амны дээрх барилга болон тухайн түвшний орчимд уг ажилтай холбогдолгүй хүн байлгахыг хориглоно.

147. Далд уурхайн босоо амаар тэсрэх материалыг оруулах, гаргахдаа өргөх машины машинч, уурхайн амны дохиочин, өргөлтийг хариуцсан бусад ажилчдад заавал урьдчилан мэдэгдсэн байна.

148. Сав, баглаа, боодолтой тэсрэх материалыг өргөх машинаар тээвэрлэхдээ клетний өндрийн 2/3-оос илүүгүй өндөртэй, гэхдээ түүний хаалганаас өндөргүйгээр ачна.

149. Тэсэлгээний хэрэгслийг тэсрэх бодисоос тусад нь уурхайд оруулж, гаргана.

Тэслүүртэй хайрцаг, цүнхийг тээвэрлэхдээ үйлдвэрлэгчийн зааварчилгааг дагах ба зааварчилгаагүй нөхцөлд давхарлахгүй нэг үе байрлуулна. (Энэ заалтыг Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан)

150. Тэсрэх материал бүхий цүнх, савтай тэсэлгээчинг налуу малталтаар оруулах, гаргахдаа хүн зөөврийн тэргэнцэрийн нэг суудалд зөвхөн нэг тэсэлгээчин буюу туслах ажилчныг суулгана.

151. Клетэнд тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл бүхий цүнх, савтай хэд хэдэн тэсэлгээчин, туслах ажилчныг нэг зэрэг тээвэрлэхийг зөвшөөрнө. Ингэж зөөхдөө клетний 1 м² шаланд нэг хүн ногдохоор тооцно. Хүн бүрт ногдох тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл нь энэхүү дүрмийн 163-т зааснаас хэтрэхгүй хэмжээтэй байна.

152. Тэсрэх материалтай тэсэлгээчин, туслах ажилчныг дараалал харгалзахгүй уурхайн гүнд оруулж, гаргана.

153. Тэсрэх материалыг газрын гүнд тээвэрлэх хурд 5 м/сек-ээс илүүгүй байна. Машинч нь тэсрэх материал ачсан клет, дамарт татлага, цахилгаан зүтгүүрийг аажмаар хөдөлгөж, зогсооно.

154. Газрын доорх малталтад тэсрэх материалыг хүргэхэд дараах нөхцөлийг хангана. Үүнд:

- а) тэсрэх материалыг ачих, буулгах ажлыг зөвхөн тогтоосон газарт гүйцэтгэх;
- б) ослын тохиолдолд тэсрэх материалыг ачих, буулгах газрыг тэсэлгээний ажлын удирдагч тогтооно;
- в) тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг нэг цуваанд өөр өөр тэргэнцэрт тээвэрлэж болно. Энэ тохиолдолд тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй тэргэнцрууд нь хоорондоо болон цахилгаан тэргнээс хоосон тэргэнцрээр 3 метрээс багагүй урт зайд тусгаарлагдсан байна. Уг цуваанд өөр төрлийн ачаа тээвэрлэхийг хориглоно;
- г) тэслүүрийг модоор доторлосон, галд тэсвэртэй материалаар битүү тагласан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. Тэсэлгээний хэрэгсэлтэй хайрцаг цүнхийг эсгийгээр зөвлөвчилсөн тусгай тэргэнцэрт дан эгнээгээр ачиж тээвэрлэнэ. Бусад төрлийн тэсрэх материалыг ердийн тэргэнцэрт ачиж тээвэрлэхийг зөвшөөрнө;
- д) тэсрэх материалыг цахилгаан зүтгүүртэй цуваагаар тээвэрлэхдээ тэргэнцэрийг галд тэсвэртэй материалаар битүү тагласан байна. Мөхлөгжүүлсэн тэсрэх бодисыг галд тэсвэртэй даавуугаар бүтээж тээвэрлэж болно;
- е) тэсрэх материал тээвэрлэж байгаа тээврийн хэрэгслийн цувааны өмнө болон эцэст онцгойлон анхааруулах гэрлэн дохиоллыг байрлуулж, дохионы утгыг бүх ажилчдад танилцуулсан байна;

ё) уурхайн малталтаар тэсрэх материал тээвэрлэж яваа тээврийн хэрэгслийг өөдөөс нь явж байгаа бусад тээврийн хэрэгсэл болон явган зорчигчид хөдөлгөөнөө зогсоон өнгөрүүлнэ;

ж) тэсрэх материал зөөх, тээвэрлэх ажилтай холбоотой далд уурхайн тээврийн хэрэгслийн жолооч, машинч, тэсэлгээчин, туслах ажилчдад ажил өхлэхээс өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгсөн байна;

з) тэсрэх материалыг төмөр замаар тээвэрлэхэд цахилгаан зүтгүүрийн бүхээгт машинчаас өөр уг ажилтай холбогдолгүй хүн байхыг хориглоно. Тэсрэх материал дагалдах ажилтнуудыг цувааны төгсгөлийн суудлын тэргэнцэрт суулгана. Цувааны хурд дагаж яваа хүний дундаж хурдаас хэтрэхгүй байна;

и) тэсрэх материалын агуулахад битүүмжилж лацадсан тусгайлан тоноглосон тэргэнцэр, чингэлэг, бусад савтай тэсрэх материалыг дагалдах ажилтангүйгээр хүргэж болно;

к) тэсрэх материал тээвэрлэлтэд оролцож байгаа ажилтан амь хамгаалах багтай байна.

155. Томилогдсон ажилтан тэсрэх материал тээвэрлэх тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг сар, ээлж тутам шалгаж байна. Тэсрэх бодис буулгах зориулалттай хоолой, хаалт, сав, тоног төхөөрөмжид байгууллагын баталсан журмын дагуу үзлэг, үйлчилгээ хийж байна.

156. Уурхайн амны гаднах тэсрэх материал ачих талбай нь хаалт хамгаалалт, таних тэмдэгтэй байна.

157. Далд малталтад тэсрэх материал ачсан цувааг тэсэлгээний мөргөцөгт шууд хүргэх буюу тусгайлан тоноглосон зогсоолтой малталтад хүргэнэ. Тэсрэх бодис төвлөрсөн ажлын байранд 4-өөс цөөнгүй хөөсөн галын хор болон галын усны шугаманд холбосон галын хошуутай байна.

158. Тэсрэх материалыг далд малталтаар тээвэрлэхэд цахилгаан зүтгүүрийн машинч болон тэсрэх материал дагалдан хүргэх ажилтнуудын хооронд мөрдөх дохиог байгууллагын удирдлага эсхүл тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагч батална.

159. Шурф малтах үед гар лебедкаар тэсрэх материал буулгах, гаргахад дараахь нөхцөлийг хангана:

а) мөргөцөгт тэсэлгээний ажилд холбогдолгүй хүн байхыг хориглох;

б) тэсрэх материал оруулах, гаргах ажлыг 2-оос доошгүй хүн гүйцэтгэх;

в) лебедка нь шүдээ түгжих төхөөрөмж буюу автомат тормозны аппарattай, холбох дэгээ нь түгжээтэй байх;

г) тэсрэх бодис, өдөөх хэрэгслийг тус тусад нь оруулж, гаргана.

160. Тэсрэх материалыг босоо малталтаар лебедкийн тусламжтайгаар буулгаж, гаргахдаа тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагчийн баталсан ажлын даалгавар, лебедка байрлуулах паспортын дагуу гүйцэтгэнэ.

161. Тэсрэх бодис, өдөөх хэрэгслийг тэсэлгээ хийх ажлын байранд гараар зөөж хүргэхдээ тус тусад нь цүнхтэй болон үйлдвэрийн сав баглаатай нь зөөнө.

162. Өдөөх хэрэгсэл болон тэслүүртэй бүүстер, галлагчийг зөвхөн тэсэлгээчин дотор талыг нь зөөлөвчилсөн хатуу дайз, хайрцагтай цүнхэнд хийж зөөнө.

163. Тэсэлгээчин тэсрэх бодис ба тэсэлгээний хэрэгслийг хамтад нь гараар зөөхөд тэсрэх материалын нийт жин 12 кг-аас хэтрэхгүй байна. Тэслүүртэй бүүстрийн жин 10 кг-аас хэтрэхгүй байна.

164. 25 кг хүртэл жинтэй тэсрэх бодисыг өдөөх хэрэгсэлгүйгээр зөөж болно.

165. Жин нь гараар зөөх зөвшөөрөх хэмжээнээс хэтрээгүй тэсрэх бодисыг үйлдвэрийн сав баглаатай нь зөөнө.

166. Тэсрэх материал тээвэрлэх авто тээврийн хэрэгсэл нь “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн үед мөрдөх аюулгүй ажиллагааны журам”-ын шаардлага хангасан байна.

167. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг авто зам, төмөр зам, усан зам, агаараар тээвэрлэхдээ тухайн тээврийн төрөлд зориулсан аюулгүй ажиллагааны дүрмийг баримтална.

Тэсэлгээний ажил гүйцэтгэх ерөнхий шаардлага

168. Ажлын байранд хүргэсэн тэсрэх материал нь цүнх, дайз болон үйлдвэрийн сав баглаа, тусгай зориулалтын машин, контейнерт савласан байна.

169. Ажлын байран дахь тэсрэх бодис болон цэнэглэсэн шпур, цооногийг харуул хамгаалалт, хяналтгүй орхихыг хориглоно. Харуул хамгаалалт, хяналтын журмыг тэсэлгээний ажил гүйцэтгэгч байгууллага тогтооно.

170. Ил уурхайн тэсэлгээний блок дээр байгаа тэсрэх материал болон цэнэглэсэн цооног шөнийн цагт гэрэлтүүлэгтэй байна. Тэсрэх материалыг хур тунадаснаас хамгаална.

171. Хүн ам оршин суух газарт болон барилга байгууламжийн дотор тэсэлгээний ажил хийхдээ тэсрэх материалыг тусгаарласан, харуул хамгаалалттай тасалгаанд байлгана.

172. Цэнэглэлтийн ажил эхлэх хүртэл хоногийн хэрэгцээний тэсрэх материалыг хориотой бүсийн гадна, ээлжийн хэрэгцээний тэсрэх материалыг хамгаалалтын бүсэд хадгалж болно. Өдөөх хэрэгсэл болон бэлтгэсэн бүүстрийг тэдгээрээс тэсрэлт дамжих зайн гадна тусад нь хадгална.

173. Ачаатай цэнэглэгч машиныг тэсрэх материалын агуулахын болон тэсрэх материал бэлтгэх үйлдвэрийн тусгайлсан талбайд 2 хоног хүртэл хугацаатай хадгалж болно.

174. Босоо болон хэвтээ амны малталт нэвтрэх үед газрын гадарга дээрх малталтын ам болон бусад барилга байгууламжаас 50 метрээс багагүй зайд байрлах байранд ээлжийн хэрэгцээний тэсрэх материалыг хадгалж болно.

175. Тэсрэх материалтай харьцахдаа тэдгээрийг хэрэглэх заавар, аюулгүй ажиллагаа, галын аюулгүйн зааврыг чанд мөрдөнө.

176. Тэсрэх материал байгаа газраас 100 метрээс дотогш ил гал гаргахыг хориглоно. Галын аргаар тэсэлгээ хийж байгаа тэсэлгээчинд асаах хэрэгсэлтэй байхыг, харуулын ажилтныг галт зэвсэгтэй байхыг зөвшөөрнө.

177. Зайлшгүй тохиолдолд ил гал гаргах бол тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагчийн баталсан онцгой ажлын даалгаврын дагуу гүйцэтгэнэ.

178. Нухаж няцлах боломжгүй барьцалдаж хатуурсан, гексоген болон шингэн нитроэфир агуулаагүй тэсрэх бодисыг энэхүү дүрмийн шаардлагын дагуу нунтаглах бөгөөд дараа нь зөвхөн хий, тоосны аюулгүй далд уурхай, тоосны тэсрэлтийн аюулгүй давхарга ашиглах болон газрын гадарга дээрх тэсэлгээний ажилд хэрэглэнэ.

179. Гексоген болон шингэн нитроэфир агуулсан, барьцалдаж хатуурсан тэсрэх бодисыг няцалж нунтаглалгүйгээр зөвхөн газрын гадарга дээрх тэсэлгээний ажилд хэрэглэнэ.

180. Хий, тоосны аюултай далд уурхай, тоосны тэсрэлтийн аюултай давхарга ашиглах тэсэлгээний ажилд боодол нь цоорч гэмтсэн тэсрэх бодис хэрэглэхийг хориглоно.

181. Тэсэлгээний ажил гүйцэтгэгч байгууллага нь тэсрэх материалтай харьцах ажилтнуудын аюулгүй байдлыг хангах, ажилчдыг тэсрэх бодисын тоос, тэсрэлтээс үүссэн хорт хийнээс хордохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний баримт бичгийг баталж, мөрдөнө.

182. Тэсэлгээний ажлыг тэсэлгээний ажлын удирдагчийн бичгээр өгсөн үүрэг даалгавар болон тэсэлгээний ажлын паспорттой (энэхүү дүрмийн хавсралт 7, 8, 9, 11, 12-т заасан маятууд) танилцаж, гарын үсэг зурсан тэсэлгээчин гүйцэтгэнэ. Тэсэлгээний ажил явуулах газар нь тэсэлгээг аюулгүй гүйцэтгэх шаардлага хангасан байна.

183. Тэсрэх материалтай харьцах ажилтны хувцас цахилгаанждаггүй (статик гүйдэл хуримтлуулдаггүй) байх ёстой.

184. Тэсэлгээний ажлыг тогтоосон журмаар боловсруулж баталсан тэсэлгээний ажлын төсөл, паспортын дагуу гүйцэтгэнэ.

185. Цооногийн, камерын, тогоон цэнэгээр тэсэлгээ хийхийн тулд өрөмдлөг, тэсэлгээний ажлын төсөл, паспорт зохионо. Түүнчлэн барилгын объектын тэсэлгээний ажил, барилга байгууламж нураах, усны ёроол гүнзгийлэх, усан доор тэслэх, халуун масс тэслэх, чичирхийллийн хайгуул, цөмлөх-дэлбэлэх зэрэг тусгай тэсэлгээний ажлыг төсөл боловсруулж гүйцэтгэнэ.

186. Тэсэлгээний ажил гүйцэтгэгч байгууллага нь бөөнөөр тэслэх өрөмдлөг, тэсэлгээний ажлын жишиг төсөл, тухайлан тодорхой нөхцөлд гүйцэтгэдэг тэсэлгээний ажлын төсөл боловсруулж мөрдөж ажиллана. Жишиг төслийг тухайн ашигт малтмалын

ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэл, туршилтын болон үйлдвэрлэлийн тэсэлгээний ажлын үр дүн, шинжлэх ухаан техникийн судалгаа, ижил төстэй нөхцөл дэх үйлдвэрлэлийн тэсэлгээний ажлын туршлага болон энэхүү дүрмийн шаардлагад үндэслэн боловсруулна.

187. Төсөлд:

- а) өрөмдлөг, тэсэлгээний ажлын үндсэн хэмжээсүүд;
- б) цэнэгийг өдөөх арга;
- в) тэсэлгээний хэлхээний (дараалал, удаашралын хугацаа) тооцоо;
- г) цэнэгийн бүтэц, бүүстрийн байрлал;
- д) тэсрэх материалын зарцуулалтын тооцоо;
- е) тэсэлгээний нөлөөллийн хүрээнд байрлах объектын (барилга, байгууламж, шугам хэлхээ) аюулгүй байдлыг хангах аюултай бүсийн тооцоо, хамгаалах арга;
- ё) тэсэлгээний бүсийг агааржуулах болон энэхүү дүрэмд заасан аюулгүй ажиллагааны бусад арга хэмжээг зааж, өрөмдлөг, тэсэлгээний ажлыг аюулгүй зохион байгуулах шийдлийг тусгасан байна.

188. Тэсэлгээний ажлын паспортод:

- а) шпурын болон ил цэнэгийн байрлал, тэсрэх материалын нэр, шпурын тоо, гүн, диаметр, цэнэг болон бүүстрийн бүтэц, жин, цэнэглэх арга, цэнэгийг тэслэх дараалал, түгжээний материал, түгжээний урт, тэсэлгээний хэлхээ (цахилгаан хэлхээ), тэдгээрийн холболтын урт (цахилгаан хэлхээний эсэргүүцэл), удаашралын хугацаа, мөргөцгийн агааржуулалтын схем, хугацаа;
- б) аюултай бүсийн хүрээ;
- в) тэсэлгээ явагдах үеийн аюултай бүсийн гаднах тэсэлгээчний байрлал;
- г) харуулын байршил, аюултай бүс болон тэсэлгээ хийх газар руу нэвтрэхээс хамгаалах төхөөрөмж, анхааруулах, хориглох тэмдгийн байршлыг заана.

Түүнээс гадна хий, тоосны тэсрэлтийн аюултай уурхайд тэсрэлтээс урьдчилан сэргийлэх тусгай хэрэгслийн байршлын схем, авах тусгай арга хэмжээг тусгана. Паспортыг 3-аас доошгүй туршилтын тэсэлгээний үр дүнд тулгуурлаж боловсруулна. Туршилтын тэсэлгээний оронд ижил нөхцөлд явагдсан тэсэлгээний үр дүнг ашиглаж болно. (Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтооолоор нэмэлт орсон)

189. Тэсэлгээний ажлын төсөл, паспортыг тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагч, эсхүл түүний томилсон эрх бүхий ажилтан, харин тэсэлгээний ажил гүйцэтгэгч нь туслан гүйцэтгэгчээр ажиллаж байгаа тохиолдолд захиалагч байгууллагын тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагч, эсхүл түүний томилсон эрх бүхий ажилтан батална.

190. Малтальтын хүрээг төсөлд заасан хэмжээнд хүртэл засах, хана таазанд үүссэн оврыг унагах, мөргөцгийн хана, ул тэгшлэх, бэхэлгээ хийхээр малталь өргөсгөх болон туршилтын нэг удаагийн тэсэлгээний паспортыг тэсэлгээний ажлын удирдагч зохиож баталж болно. Харин хий, тоосны аюултай далд уурхайд тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагчаар батлуулна. Паспортод шпурын байршил, цэнэгийн жин, бүтэц, харуулын болон тэсэлгээчний байрлал, шаардлагатай нэмэлт арга хэмжээг заана. Тэсэлгээчин паспорттой танилцаж гарын үсэг зурна.

191. Тэсэлгээний ажлын үед тэсрэх материалыг тэсэлгээ хийх газарт авч ирэх мөчөөс хамгаалалтын хориотой бус тогтоож, цэнэглэлтийн ажилтай холбогдолгүй этгээд орохыг хориглоно.

Хамгаалалтын бусэд гүйцэтгэгч, захиалагч байгууллагын болон хяналтын байгууллагын ажилтан зөвхөн тэсэлгээний ажлын удирдагчийг дагалдан нэвтрэхийг зөвшөөрнө.

Хамгаалалтын бусийн хэмжээг өрөмдлөг, тэсэлгээний ажлын төсөл, паспортоор тогтооно.

Ил уурхайн тэсэлгээнд хамгаалалтын бусийн хязгаарыг хамгийн ойрхон цэнэгээс 20 метрээс багагүй зайд тогтооно. Бусийн хязгаарыг тухайн болон дээд, доод түвшинд ойрын цэнэгээс хэвтээ чиглэлд мөн хэмжээгээр тооцон тогтооно.

Далд малтальтад хамгаалалтын бусийн хэмжээг байж болох цэнэгийн дээд хэмжээгээр тооцон энэхүү дүрмийн 455-ын е заалтын шаардлагаас бусад тохиолдолд 50 метрээс ойргүй зайд тогтооно. Хамгаалалтын бусийг тэсэлгээний ажил явуулж буй малталтай холбогдсон бүх малтальтад мөн хэмжээгээр тогтооно.

Ашиглалтын системийн онцлогоос шалтгаалан дээрх заалтыг ханган ажиллах боломжгүй тохиолдолд хориотой бусийн хэмжээг Мэргэжлийн хяналтын төв байгууллагатай зөвшилцөн тэсэлгээний ажлын төсөл, паспортаар тогтооно. (Энэ заалтад Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор 8 дахь өгүүлбэрийг нэмсэн)

192. Аюултай бусийг:

- а) тэсэлгээнд цахилгаан тэслүүртэй бүүстэр хэрэглэх бол бүүстрийг цэнэгт байршуулж эхлэх үеэс;
- б) цочир дамжуулах шижим хэрэглэх бол тэсэлгээний хэлхээнд удаашруулагч реле холбохын өмнө;
- в) бага хүчин чадлын гууртай цахилгаан бус тэслүүртэй бүүстэр хэрэглэх бол хэсгийн холболтыг төв шугаманд холбох үеэс;
- г) өдөөлтийн электрон системтэй бүүстэр хэрэглэх бол хэсгийн холболтыг төв шугаманд холбох үеэс тус тус хамгаалалтанд авна.

Хамгаалалтын болон аюултай бусэд тавьсан харуулд үндсэн үүргээс нь өөр ажил давхардуулан өгөхийг хориглоно.

193. Далд уурхайн тэсэлгээнээс үүссэн утаа тоос гарах чиглэлийн малтальтуудад аюултай бусэд орохыг хориглосон тэмдэг тавина. Тэмдгийг тэсрэлтээс үүссэн хортой

агаарын найрлага аюулгүй байх тэр зайд тавих бөгөөд энэ зайд мөргөцөгт хамгийн их тэсрэх бодис тэсэрсэн үед авсан агаарын сорьцын үр дүнгээр тогтооно. Тэсэлгээний дараа малталтуудыг бүрэн агааржуулж, заасан хаалт, тэмдгүүдийг хурааж авна.

194. Тэсэлгээний ажлын аюултай бүсэд бусад байгууллагын объект орохоор байвал удирдлагад нь тэсэлгээний ажил хийх газар, хугацааны тухай нэг хоногоос багагүй хугацааны өмнө бичгээр мэдэгдэнэ.

195. Тэсэлгээний ажлын үед аюултай бүсэд орж байгаа объектын удирдлага нь бүх ажилчдыг аюулгүй зайд гаргасан тухайгаа тэсэлгээний ажлын удирдагчид заавал эргэж бичгээр мэдэгдэнэ.

196. Тэсэлгээний ажлын үед өгөх дуут дохио нь чанга дуулдахаар, гэрлэн дохио нь тэсэлгээний ажлын үед аюул гарч болзошгүй газруудад харагдахуйц байрлагдсан байна. Тэсэлгээний ажлын үед заавал дуут дохио ашиглана. Дуут дохиог өгөхдөө тэсэлгээний ажлын нөлөөллийн бүсийг бүрэн хамарч дуулдахаар зохион байгуулна. Дохиог амаар болон тэсрэх материал хэрэглэж өгөхийг хориглоно. (Энэ заалтад Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор 3 дахь өгүүлбэрийг нэмсэн)

Дохионы утга ба түүнийг өгөх зарчим:

- а) нэгдүгээр дохио - анхааруулах (нэг урт). Дохио өгч аюултай бүсийг хамгаалалтанд авна;
- б) хоёрдугаар дохио - тэслэх (хоёр урт). Энэ дохиогоор тэсэлнэ;
- в) гуравдугаар дохио - тэсэлгээ дууссан (гурван богино). Тэсэлгээний ажил дууссаныг зарлана.

Дохиог тэсэлгээний ажил гүйцэтгэсэн тэсэлгээчин (ахлах тэсэлгээчин), харин бөөнөөр тэслэх үед тэсэлгээний ажил гүйцэтгэгч байгууллагын тусгайлан томилогдсон ажилтан өгнө.

197. Дохионы агуулга, зориулалт, өгөх арга, тэсэлгээний ажил явуулах хугацааг байгууллагын ажилтнуудад болон аюултай бүстэй залгаа нутаг дэвсгэрт амьдардаг хүн амд таниулсан байна.

198. Тэсэлгээний ажлын удирдагч, эсхүл түүний даалгаснаар тэсэлгээчин нь тэсэлгээ хийсэн газрын аюулгүй болохыг тогтоож, уг газар руу хүн орох зөвшөөрлийг өгнө.

199. Цэнэглэхээр бэлтгэсэн шпур, цооног болон бусад малталтын амны орчмын широо чулуу, өрмийн нунтаг, бусад зүйлийг сайтар цэвэрлэсэн байна.

200. Сүмбийг зөвхөн оч үүсгэхгүй материалаар хийнэ.

201. Цахилгаан тэслүүртэй бүүстер, галлагчийг шпур, цооногийн аман талд байрлуулна. Бүүстерт бага хүчин чадлын гууртай цахилгаан бус тэслүүрийн өдөөлтийн систем хэрэглэсэн үед бүүстрийг шпур, цооногт уг системийн ашиглалтын зааврын дагуу байрлуулна. Механикуулсан цэнэглэх төхөөрөмж хэрэглээгүй үед цахилгаан тэслүүртэй бүүстрийг шпур, цооногийн ёроол талд байрлуулж болно. Ингэхдээ цахилгаан тэслүүрийн хонгионы ёроолын хонхорхойг шпурын ам руу чиглүүлж байрлуулна. Нүүрс, занарын далд уурхайд шпур дахь цахилгаан тэслүүртэй бүүстрийн

ийм байршлыг зөвхөн хийн ялгаралтгүй болон тэсрэмтгий тоосгүй тохиолдолд, цахилгаан тэслүүрийн утсыг шпурын амсраас гадагш 0.6 метрээс багагүй урттай байхад хэрэглэхийг зөвшөөрнө.

202. Гацсан бүүстер, галлагчийг цохиж оруулахыг хориглоно. Хэрэв гацсан бүүстер, галлагчийг гаргаж авах боломжгүй байвал шпур, цооногийн цэнэглэлтийг зогсоож, тэдгээрийг бусад цэнэгийн хамт тэсэлнэ.

203. Нүүрсний цулыг урьдчилан сийрэгжүүлэх тэсэлгээнд 5 метрээс илүү урттай шпур, цооногийг тууш болон тасалж байрлуулсан цэнэгээр цэнэглэж усан түгжээс хийсэн бол цочир дамжуулах шижмийг шпур, цооногийн амсраас цухуйлгалгүйгээр байрлуулан нэмэлт өдөөх хэрэгсэл ашиглаж болно.

204. Хий, тоосны аюултай далд уурхайн малталтын шатах хийн ялгаралгүй мөргөцөгт тасалж байрлуулсан цэнэгийг зөвхөн цөмлөх шпурт хэрэглэж болно.

205. Шпур, цооног цэнэглэх явцад цэнэгийн хэсэг нь асгарсан тохиолдолд шпур, цооногийг гүйцээж цэнэглээд нэмэлт цэнэгт заавал бортгон өдөөгчийг байрлуулж тэсэлнэ.

206. Цэнэг дэх бүүстэртэй холбогдсон цочир дамжуулах шижим, электрон, цахилгаан, цахилгаан бус тэслүүрийн утсыг угзарч татахыг хориглоно. Цэнэгээс гарч буй цочир дамжуулах шижмийн үзүүрийг нугалж, хугалахыг хориглоно.

207. Хий, тоосны аюултай далд уурхайд цэнэгийг түгжээсгүй тэслэхийг хориглоно.

208. Шпур, цооногийг түгжихдээ түүн доторх тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг гэмтээхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна. Түгжээс хийх үед цахилгааны утас, цочир дамжуулах шижим, цохилтын долгион дамжуулах гуурс татагдаагүй сул байна. Шпур, цооногийг хэт том ширхэглэлтэй болон халуун материалыаар түгжиж болохгүй.

209. Шпур, цооногийг түгжээний машинаар түгжихдээ тэдгээрийн ашиглалтын зааврыг мөрдөж ажиллана.

210. 1.5 метрээс өндөрт байрлах шпурыг цэнэглэх, тэсэлгээний хэлхээг холбох ажлыг зөвхөн мөргөцөгт тулгаж тогтоосон зориулалтын тавиур, тавцан болон цэнэглэх, холбох ажлыг аюулгүй, зөв хийх тохиромжтой нөхцөлийг хангасан өргөх механизмын тавцан дээрээс хийнэ. 1.5 метрээс өндөрт байрлах шпур, цооногийн цэнэглэлт, хэлхээний холболтыг шатан дээр байрлаж хийхийг хориглоно. (Энэ заалтад Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон)

211. Ил цэнэгийг зэрэгцээ цэнэгээ гэмтээхгүй байхаар байрлуулна. Хэрэв тийм бололцоогүй бол цэнэгүүдийг тохирох өдөөх хэрэгслээр зэрэг тэсэлнэ. Ил цэнэгийг чулуу хайрга болон бусад том ширхэглэлтэй материалыаар хучиж далдлахыг хориглоно.

212. Тэслэх цэнэгийн урт 10 метрээс илүү бол цооногийн доторх хэлхээг заавал хослуулж хийнэ. Газрын доорх малтальтад хос хэлхээ хийхийг өрөмдлөг, тэсэлгээний ажлын төсөл, паспортаар тодорхойлно. (Энэ заалтад Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон)

213. Хамгаалах хучлагатай бүлэг цэнэгийг нэгэн зэрэг буюу 200 м/с-ээс ихгүйгээр удаашралтайгаар тэсэлнэ.

214. Аянга цахилгаантай үед газрын гадарга дээр болон гадаргаас нэвтэрч буй далд малталтад цахилгаан тэсэлгээ хийхийг хориглоно. Хэрэв аянга цахилгаан эхлэхээс өмнө хэлхээг холбосон бол тэсэлгээг хийх, эсхүл хэсгийн холболтуудыг төв шугамаас салгаж үзүүрийг нь сайтар тусгаарлан, ажилчдыг аюулгүй бүсээс гаргах буюу хоргодох байранд оруулна.

215. Ил уурхайд шөнийн цагаар тэсэлгээний ажил хийхийг хориглоно. (Энэ заалтыг Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан)

216. Нуранги, налуу гадарга дээрх цэнэглэлт, тэсэлгээний хэлхээний холболтыг зөвхөн газрын дээрээс доош чиглэлийн дарааллаар хийнэ.

217. Тэсэлгээний дараа гүйцэд авагдаагүй шпур, цооногийн ёроол руу, түүний дотор цэнэг байгаа эсэхээс үл хамааран өрөмдөхийг хориглоно.

218. Цооног, шпурт хий буудлага хийсний дараахь цэнэглэлтийг 30 минутаас багагүй хугацааны дараа дахин хэмжилт хийж цэнэглэлтийг хийнэ. (Энэ заалтад Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор нэмэлт орсон)

219. Камерын цэнэгийг цочир дамжуулах шижим, цахилгаан тэслүүр, цахилгаан бус өдөөлтийн систем ашиглан тэсэлж болно. Цэнэгийн камер бүрт хоёр бүүстэр буюу галлагч хийх бөгөөд тэдгээрийг өдөөх, холбох арга нь ижил байна. Цэнэгийн камер дахь бүүстэр, галлагчийг хатуу бөх бүрхүүлтэй гэмтээхгүйгээр байрлуулна.

220. Камерын цэнэг байрлуулах малталтын цахилгаан дамжуулах шугамыг цэнэглэлт эхлэхийн өмнө хураасан байна.

221. Газрын дээрх цэнэгийг бөөнөөр тэслэх тэсэлгээнээс агаарын хөдөлгөөнд аюул учруулж болзошгүй бол холбогдох байгууллагатай зохих журмын дагуу зөвшилцсөний дараа тэсэлгээний ажлыг гүйцэтгэнэ.

**Баарсан цэнэгийг устгахад тавих аюулгүй
ажиллагааны шаардлага**

222. Тэсэлгээний ажил гүйцэтгэгч байгууллага нь баарсан цэнэгийг устгах зааврыг баталж, мөрдөнө.

223. Баарсан цэнэгийг устгах зааврыг тэсэлгээний ажил явуулж буй газрын онцлог, түүнчлэн уул геологи, уул техникийн нөхцөл, тэсэлгээний арга, тэсэлгээний ажилд хэрэглэж буй тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тооцон энэхүү дүрмийн шаардлагад нийцүүлэн боловсруулна. Үүнд:

- а) цэнэг баарахаас урьдчилан сэргийлэх үндсэн арга хэмжээ;
- б) тэсрээгүй цэнэгийг олж илрүүлэх журам;
- в) тэсэлгээний ажлын төрөл тус бүрд тохирсон баарсан цэнэгийг устгах арга;

г) баарсан цэнэгийг устгах үеийн аюултай бүсийн хэмжээ, газрын гадаргад болон далд малталаад түүнийг тэмдэглэх журам, аюултай бүсийн хамгаалалт;

д) баарсан цэнэгийг устгахад илэрсэн тэсрээгүй тэсрэх материалыг цуглуулах, бүртгэх, устгах журам;

е) аюулгүй ажиллагааны арга хэмжээг тусгасан байна.

224. Тэсэлгээний ажилд бэлтгэх, гүйцэтгэхэд оролцдог бүх ажилтанд баарсан цэнэг устгах зааврыг танилцуулж, гарын үсэг зуруулсан байна.

225. Тэсэлгээний хэлхээнд өдөөлт өгснөөс хойш цэнэг, түүний хэсэг, бүлэг цэнэгт тэсрэлт явагдаагүй бол энэ тухай баарсан цэнэгийн бүртгэлийг хүснэгт 1-ийн дагуу тэмдэглэнэ.

Хүснэгт 1. Тэсэлгээний ажлын гологдол, бааралтын бүртгэл

| № | Огноо, тэсэлгээний ээлж | Тэсэлгээ хийсэн газар | Бүх цэнэгийн тоо, ширхэг | Тэсэлгээний үр дүн | | Бааралт илрүүлсэн тэсэлгээчний нэр, гарын үсэг | Бааралтыг устгасан тэмдэглэл | Огноо, тэсэлгээний ээлж | Бааралтыг устгасан тэсэлгээчний нэр, гарын үсэг | Устгалыг удирдсан тэсэлгээний ажлын удирдагчийн нэр, гарын үсэг |
|---|-------------------------|-----------------------|--------------------------|--------------------|-----------------|--|------------------------------|-------------------------|---|---|
| | | | | Тэсэрсэн цэнэг | Тэсрээгүй цэнэг | | | | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |

226. Цэнэгийг техникийн шинж чанартай шалтгаанаар тэсэлж чадахгүй бол (жишээ нь, ээлжийн хугацаанд арилгаж чадахааргүй тэсэлгээний хэлхээний гэмтэл гэх мэт) бааралт гэж үзнэ.

227. Бааралтыг ганцаар, бүлгээр, бөөнөөр гэж ангилна:

а) ганцаар бааралт-тэсэлгээний хэлхээний аль нэг хэсэгт холбогдсон нэг болон хэд хэдэн цэнэгийн бааралт, ингэхдээ хэрэв хэлхээний ижил хэсэгт холбогдсон цэнэгүүдийн дундаас нэгээс илүүгүй цэнэг баарсан бол;

б) бүлгээр бааралт-тэсрэх бодисын хэсгийн (хоёр болон түүнээс дээш) бааралт, ингэхдээ баарсан цэнэгүүд бүгд болон хэсэг нь тэсэлгээний хэлхээний ижил хэсэгт холбогдсон байсан бол;

в) бөөнөөр бааралт-тэсрэх ёстой бүх цэнэгийн бааралт, эсвэл нэг хэлхээнд холбосон хэд хэдэн блок (мөргөцөг) тэслэх үед блокоороо (мөргөцгөөрөө) тэсрээгүй тохиолдол.

228. Бааралтыг цаг тухайд нь илрүүлэх, гэнэтийн тэсрэлтээс сэргийлэхийн тулд бүх тэсэлсэн газрыг сайтар шалгана.

229. Тэсрээгүй цэнэг илрүүлсэн тэсэлгээчин газрын гадарга дээр бол цэнэгийн дэргэд, далд уурхайд бол малталтад орохыг хориглосон тэмдэг тавьж, тэсэлгээний ажлын удирдагчид мэдээлнэ.

230. Баарсан цэнэгийг устгахтай холбоотой ажлыг батлагдсан зааврын дагуу тэсэлгээний ажил гүйцэтгэгч байгууллагын тэсэлгээний ажлын удирдагч удирдан гүйцэтгэнэ.

231. Бааралт гарсан газарт түүнийг устгахтай холбоогүй бусад ажил явуулахыг хориглоно.

232. Баарсан цэнэг дэх цахилгаан тэслүүрийн илэрсэн утсыг богино холбоно.

233. Баарсан цэнэг илрүүлсэн (эсвэл баарсан цэнэг байна гэж үзсэн) экскаваторын оператор нь:

а) ухаж малтах, ачих ажлыг даруй зогсоох;

б) тээврийн хэрэгслийн оператор, жолооч нарт машин, техникээ аюулгүй зайд гаргах талаар мэдэгдэх;

в) ээлжийн мастер, диспетчер зэрэг байгууллагын холбогдох удирдлагад баарсан цэнэг илэрснийг мэдээлж, тэсэлгээний ажлын удирдагчийг дуудуулах,

г) холбогдох ажилтныг иртэл аюултай бүсэд үйл ажиллагаа явуулахаас сэргийлэх хяналт тавьж тэсрээгүй цэнэгийн байршлыг зааж өгөх.

234. Далд уурхайд баарсан цэнэг илрүүлсэн ажилтан нь ажлаа зогсоож, малталтад орохыг хориглосон тэмдэг тавьж, ажилчдыг аюултай бүсээс гаргаж, тэсэлгээний ажлын удирдлагчид даруй мэдэгдэнэ.

235. Уурхайн диспетчер нь баарсан цэнэгийн тухай мэдээлэл авмагц холбогдох удирдах ажилтанд мэдэгдэж, баарсан цэнэгтэй бүсэд үйл ажиллагаа явуулахыг зогсоох арга хэмжээ авна.

236. Баарсан ил цэнэгийг устгахдаа түүн дээр шинэ цэнэг тавьж ердийн журмаар тэсэлнэ.

237. Баарсан шпурын цэнэгийг түүнтэй 30 см-ээс ойргүй зайд паралель туслах шпур өрөмдөж цэнэглэн тэсэлж, устгаж болно. Туслах шпурын тоо, байршил, өрөмдөх чиглэлийг тэсэлгээний ажлын удирдагч тогтооно. Баарсан шпурын чиглэлийг тодорхойлохын тулд түгжээсийг нь түүний амнаас 20 см хүртэл гүн ухан гаргаж болно.

238. Түгжээсгүй цэнэглэж тэсэлсэн тохиолдолд баарсан цэнэгтэй шпурт нэмэлт бүүстэр хийж устгахыг зөвшөөрнө.

239. Газрын гадарга дээрх болон хий, тоосны аюулгүй далд уурхайд баарсан шпурын цэнэгээс гарсан цахилгаан тэслүүрийн утасны эсэргүүцлийг аюулгүй зайнаас зориулалтын хэмжих багажаар шалгаж, шаардлага хангаж байвал ердийн журмаар тэсэлж болно.

240. Хий, тоосны аюултай далд уурхайд энэ аргаар зөвхөн баарсан цэнэг ил гараагүй, улны эсэргүүцлийн хэмжээ буураагүй тохиолдолд устгал хийж болно.

241. Баарсан цэнэгийг устгахдаа бүүстерт холбосон гал дамжуулах шижим, цочир дамжуулах шижим, цахилгаан тэслүүрийн утас болон цахилгаан бус тэслүүрийн системийн гуурснаас татаж дугтрахыг хориглоно.

242. Усан буутай мөргөцөгт баарсан шпурын цэнэгийг даралттай усаар угааж гаргаж болно. Үүнийг тэсэлгээний ажлын удирдагч болон тэсэлгээчний хяналттай гүйцэтгэх бөгөөд яг цэнэгийг гаргах үед мөргөцөгт хүн байлгагүй, усан бууг алсаас удирдана. Угаагдсан тэслүүртэй галлагч, бүүстрийг барих арга хэмжээг авсан байна.

243. Металл болон металл хийц бутлах үед баарсан шпурын цэнэгийн түгжээсийг гаргаж, шинээр бүүстэр нэмж хийн тэсэлж устгана.

244. Цооногт баарсан цэнэгийг дараахь аргуудаар устгаж болно:

а) хэрэв гадаргуугийн хэлхээнээс шалтгаалан бааралт гарсан, гэхдээ баарсан цэнэгийн хамгийн бага эсэргүүцлийн шугамын хэмжээ багасаагүй тохиолдолд тэсэлж устгана. Хэрэв чулуулгийн бутармагийн шидэлт, агаарын долгионы цохилтоос аюул үүсэхээр байвал тэслэхийг хориглоно;

б) баарсан цооногийн цэнэгийг ил гаргахын тулд чулуулгийг гараар зайлцуулна. Найрлагандаа дарь, нитроэфир, гексоген агуулаагүй аммиакийн шүүний суурьтай тэсрэх бодисыг цочир дамжуулах шижмээр өдөөсөн цооногийн чулуулгийг экскаваторын шанагаар тэсрэх материалд хүргэлгүйгээр ухаж авч болно;

в) баарсан цэнэгээс 3 метрээс багагүй зайд параллель цооног өрөмдөж цэнэглэн тэсэлж устгаж болно;

г) цооногийг D хамтатгах ангиллын (утаат даринаас бусад) тэсрэх бодисыг цочир дамжуулах шижмээр өдөөхөөр цэнэглэсэн бол цооногоос цэнэгийг усаар угаан гаргаж болно;

д) хэрэв дээрх аргуудаар баарсан цэнэгийг устгах боломжгүй бол тэсэлгээний ажил гүйцэтгэгч байгууллагын тусгайлан боловсруулж, баталсан төсөл, паспортаар устгана.

245. Ханцуйд баарсан цэнэгийг түүний уртын 1/3-ээс багагүй зйтай зэрэгцээ хонгил ухаж цэнэглэн тэсэлнэ.

246. Камерт баарсан цэнэгийн хамгийн бага эсэргүүцлийн шугамын хэмжээ багасаагүй бол түгжээсийг гаргаж, шинээр бүүстэр оруулж түгжин ердийн журмаар тэсэлж устгана.

247. Баарсан цэнэгийг устгах тэсэлгээний дараа бутлагдсан чулуулгийг сайтар шалгаж тэсрэх материалын үлдэгдлийг цуглуулсны дараа тэсэлгээний ажлын удирдагч нь аюулгүй ажиллагааны заавар өгч ажилчдыг тухайн ажлын байранд ажиллуулахаар оруулна. Илрүүлсэн тэсрэх материалыг байгууллагад мөрддөг зааврын дагуу устгана.

248. Чичирхийллийн хайгуулын тэсэлгээний шпур, цооногт баарсан цэнэгийг гаргаж гэмтлийг арилган буцааж заасан гүнд оруулна. Хэрэв гаргах боломжгүй байвал

нэмэлт цэнэг оруулан тэсэлж устгана. Бусад тохиолдолд тухайн нөхцөл байдлыг тооцон боловсруулсан тусгай төсөл, паспортын дагуу устгана.

249. Цөмлөх (дэлбэлэх) буудлагын аппаратад бааралт гарвал тэсэлгээний хэлхээг гүйдлийн эх үүсвэрээс салгаж, аппаратыг өргөж гарган холболтын утаснаас салгаж, богино холболт хийнэ.

250. Цооногоос өргөж гаргасан буудлагын аппаратад тэсэлгээчин үзлэг хийж, тэсэлгээний хэрэгслийг салган авч богино холболт хийнэ. Аппаратад үлдсэн баарсан тэсрэх бодисын үлдэгдлийг цуглуулан авч, тогтоосон журмын дагуу устгана.

251. Цөмлөх буудлагын аппарат цооногт гацсан тохиолдолд түүнийг устгах буюу өргөж гаргах үйл ажиллагааг тэсэлгээний ажлын удирдагчийн шийдвэрээр гүйцэтгэнэ.

252. Мөс болон усан доорх тэсэлгээнд баарсан цэнэгийг сүүлчийн цэнэг тэсэрснээс хойш 15 минутаас багагүй хугацааны дараа гаргана. Баарсан цэнэгийг гаргах боломжгүй бол түүний жингийн 25%-иас багагүй жинтэй цэнэг түүнд холбож тэсэлж устгана.

253. Халуун масс тэслэхэд баарсан цэнэг рүү 15 минутаас багагүй хугацааны дараа, температур 80°C-ээс бага, аммиакийн шүүний задрал явагдаж байгаа байдал ажиглагдахгүй тохиолдолд ойртож болно. Шпурт баарсан цэнэгийн тэсрэх материалыг усаар угааж устгана.

254. Хожуул булгалах тэсэлгээний шпурт баарсан цэнэгийн түгжээсийг гараар ухан гаргаж, нэмж цэнэглэн тэсэлж устгана.

255. Баарсан цэнэгийн устгалын ажлыг ээлжиндээ дуусгаагүй бол дараагийн ээлжийн тэсэлгээчинд гүйцээн хийх үүрэг даалгавар, зохих зааврыг даалгаврын хуудсанд нь тэмдэглэн өгч устгалыг үргэлжлүүлж болно. Энэ тохиолдолд устгалын дараа ажилчдыг оруулах зөвшөөрлийг ээлжийн тэсэлгээний ажлын удирдагч өгнө.

ТАВ. ГАЗРЫН ГАДАРГА ДЭЭР ТЭСЭЛГЭЭНИЙ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД ТАВИГДАХ НЭМЭЛТ ШААРДЛАГА

Үндсэн нөхцөл

256. Аюултай бүсийн хязгаарт нь онцгой чухал объект (цахилгаан станц, төмөр зам, авто зам, усан зам, цахилгаан дамжуулах шугам, цахилгааны дэд өртөө, үйлдвэрийн газар, төмөр замын өртөө, усан зогсоол, газар доорх байгууламж, холбооны шугам гэх мэт) байрлаж буй тэсэлгээний ажлыг тухайн объектыг ашиглагч байгууллагатай тохиролцон гүйцэтгэнэ.

257. Тэсэлгээнд гал өгөх цэг аюултай бүсийн гадна байрлана. Боломжгүй бол аюултай бүсийн дотор байрлуулах зай хэмжээ, хийц бүтцийг нь тэсэлгээний ажлын төсөл, паспортаар тодорхойлж, зориулалтын хоргodoх байр байгуулна. Хоргodoх байр нь тэсэлгээчдийг тэсрэлтийн үйлчлэл болон тэсэлгээнээс үүсэх хорт хийнээс найдвартай хамгаална. Хоргodoх байрны зам саад бартаагүй чөлөөтэй байна.

258. Хэд хэдэн тэсэлгээчин нэг аюултай бүсэд зэрэг ажиллаж буй тохиолдолд нэгийг нь ахлагчаар томилно. Ахлагч нь шийдвэр, заавраа бусдадаа амаар болон тэсэлгээний ажил гүйцэтгэгч байгууллагын баталсан дохиогоор өгнө.

259. Д ангилалын тэсрэх бодисоор цэнэглэж буй цооногтой талбайд галын аюулаас хамгаалах хэрэгслээр тоноглосон тээврийн хэрэгслээр түгжээний материал буулгаж, түгжиж болно. Түгжээс хийхдээ тээврийн хэрэгслээр тэсэлгээний холбох хэрэгсэл дайрахаас сэргийлсэн байна.

260. Галын аргаар өрөмдсөн цооногийг өрөмдлөг дууссанаас хойш 24 цагийн хугацаанд цэнэглэхийг хориглоно.

261. Нуралттай чулуулгийн цооногийг тэсэлгээний ажил гүйцэтгэгч байгууллагын баталсан баримт бичгийн дагуу аюулгүй ажиллагааны шаардлагатай арга хэмжээг авч өрмийн машиныг даган цэнэглэж болно. Ингэхдээ өрмийн машин болон цэнэглэж буй цооногийн хоорондын зайд 10 метрээс багагүй байна.

262. Тэсэлгээнд гал өгөх цэгт зөвхөн уг ажлыг гүйцэтгэх үүрэг даалгавартай тэсэлгээчид байна.

263. Богино долгионы радио станц зэрэг холбооны хэрэгслийг тэсэлгээний хэрэгсэлтэй хамт тээвэрлэх, байрлуулахыг хориглох бөгөөд машины кабинд буюу тэсэлгээнд гал өгөх цэгийн тусгайлан тасалгаатай хэсэгт байрлуулна.

264. Цэнэг бэлтгэх болон цооног цэнэглэх үед тэсэлгээнд гал өгөх алсын удирдлагын бүрэн унтраасан төхөөрөмжийг аюултай бүсийн хязгаар дотор байлгахыг зөвшөөрнө.

265. Цахилгаан тэсэлгээний аппаратурт холбох зориулалтын залгуургүй утсыг тэсэлгээний хэлхээний төв болон туслах шугаманд хэрэглэхийг хориглоно.

266. Цэнэгийг цооногт байрлуулахдаа зориулалтын бус хэрэгсэл хэрэглэхийг хориглоно. Цооног шалгах аргыг тэсэлгээний ажлын төсөл, паспортаар тодорхойлсон байна.

267. Цэнэг цооногийн ёроолд хүрэхгүй байвал түүнийг гаргаж аюулгүй зайд байрлуулан цооногийг засна. Цэнэгийг гаргах боломжгүй бол тэсэлнэ.

ГАЗРЫН ГАДАРГА ДЭЭРХ ОБЬЕКТОД ТУСГАЙ ТЭСЭЛГЭЭНИЙ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД МӨРДӨХ НЭМЭЛТ ШААРДЛАГУУД

Чичирхийлийн хайгуулын тэсэлгээний ажил

268. Чичирхийлийн хайгуулын тэсэлгээний галыг тэсэлгээний ажлын удирдагчийн шийдвэрээр, чичирхийлийн станцын оператор өгнө.

269. Баарсан цэнэгтэй болон баарсан цэнэгийг нь тэсэлж устгасан цооногийг дахин өрөмдөхийг хориглоно.

270. Нуур, цөөрөм, голын савд чичирхийлийн хайгуулд тэсрэх материал хэрэглэх бол төрийн захиргааны холбогдох байгууллагуудтай зөвшилцсөн тэсэлгээний ажлын төсөл, паспортын дагуу гүйцэтгэнэ.

Газрын тос, байгалийн хийн цооногт хийх
тэсэлгээний ажил

271. Газрын тос, байгалийн хийн цооногт хийх тэсэлгээний ажлыг зөвхөн актаар хүлээж авч, бэлтгэсэн цооногт гүйцэтгэнэ.

272. Тэсрэх материал, цэнэглэсэн буудлагын төхөөрөмжийг цооногийн амнаас 50 метрээс ойргүй зайд тусгайллан тогтоосон талбайд хадгална. Тэдгээрийг цэнэглэх машин (перфорацийн зөөврийн цэнэглэх байр)-д хадгалах бол цооногийн амнаас 20 метрээс багагүй зайд байрлуулна.

273. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслээр цэнэглэсэн буудлагын төхөөрөмжийг задлахыг хориглоно. Тэсэлгээний хэлхээнд холбосон цочир дамжуулах шижмийг огтолж болохгүй.

274. Буудлагын төхөөрөмжийн ажиллагааг цэнэглэхийн өмнө шалгасан байна. Тэдгээрийг ашиглалтын зааврын дагуу зориулалтын цэнэглэх байранд цэнэглэнэ. Ингэхдээ тухайн төхөөрөмж хэрэгслийн хэмжээнд тохиromжтой, зөвлөвчилсөн тавцан, ирмэгийн хамгаалах хашлагатай ширээ, зориулалтын тавиур, багаж, тоног төхөөрөмж ашиглан тэсэлгээний ажил гүйцэтгэгчийн баталсан аюулгүй ажиллагааны зааврын дагуу ажиллана.

275. Цэнэглэсэн буудлагын төхөөрөмж тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь тэдгээрийг бэхлэх тоноглолтой байна. Тэсэлгээний хэрэгсэл угсарсан буудлагын төхөөрөмж тээвэрлэхийг хориглоно.

276. Буудлагын төхөөрөмжид холбосон тэсэлгээний цахилгаан хэлхээний эсэргүүцэл, цахилгаан дамжуулах чадварыг цооногийн амсраас доош 50 метрээс багагүй гүнд буулгасны дараа хэмжинэ.

277. Цооногт хийх бүх бэлтгэл ажил дууссаны дараа торпедыг цэнэглэнэ.

278. 10 кг-аас дээш жинтэй буудлагын төхөөрөмжийг гараар зөөхдөө түүнийг унагаахаас хамгаалах төхөөрөмж ашиглана.

279. Буудлагын төхөөрөмжийг түүнийг оруулах цооногийн амсрын дэргэд байрлуулж, тэсэлгээний хэрэгслийг холбоно. Тохиолдлын ажиллагаанаас болон тэнэмэл гүйдлээс хамгаалалттай буудлагын төхөөрөмжийн тэсэлгээний хэрэгслийг цэнэглэх байранд холбож болно.

280. Цооногийн хөндийн хэмжээ, гидростатик даралт, өрөмдлөгийн шингэний температурыг тухайн буудлагын төхөөрөмжийн зөвшөөрөх хэмжээнд тохирч байгаа эсэхийг урьдчилан шалгалгүйгээр түүнийг цооногт буулгахыг хориглоно.

281. Газрын тосны болон байгалийн хийн цооногийн тэсэлгээний ажлыг дараахь тохиолдолд хориглоно:

а) үзэгдэх орчин 50 метрээр хязгаарлагдаж байгаа байгалийн үзэгдлийн үед (энд тасалгаанд гүйцэтгэх ажил хамаarahгүй);

б) хуурай хийн даралттай, шингээх уусмалтай цооногт битүүмжлэх төхөөрөмж (лубрикатор) хэрэглэлгүйгээр гүйцэтгэх.

282. Буудлагын төхөөрөмжийг геофизикийн кабелиар цооног руу буулгах, өргөхдөө тэсэлгээний цахилгаан хэлхээний утаснуудын үзүүрийг тусгаарласан байна.

283. 50 кг-аас хүнд, 2 метрээс илүү урттай буудлагын төхөөрөмжийг цооног руу оруулахдаа өргөх механизм ашиглана.

284. Хэрэв буудлагын төхөөрөмж цооногийн тогтоосон гүнд хүрэхгүй байвал түүнийг буцааж гаргана. Энэ үед цооногийн дэргэд тухайн ажлыг гүйцэтгэх үүрэгтэйгээс бусад хүн байлгахыг хориглоно.

285. Ашиглаагүй буудлагын төхөөрөмжийг цэнэглэх байранд буцаан хүргэнэ.

286. Тэсэлгээнд гал өгөх аппаратыг зөвхөн тэслэх үед тэсэлгээний хэлхээнд холбож, тэсрэлтийн дараа шууд салгана. Бааралт гарсан тохиолдолд тэсэлгээний хэлхээний утасны цооногийн гаднах үзүүрийг богино холбоод, дараа нь салгаж тусгаарлана.

287. Баарсан буудлагын төхөөрөмжийг цооногоос өргөж гарган кабелиас салгасны дараа бааралтын шалтгааныг олно. Шаардлагатай бол цэнэгийг задална. Юуны өмнө буудлагын төхөөрөмжийн тэсэлгээний хэрэгслийг цахилгааны хэлхээнээс салгаж, төхөөрөмжөөс салгаж авна. Төхөөрөмжийг задлах боломжгүй бол тэсэлж устгана.

Уул геологийн хүндрэлтэй нөхцөлд хийх тэсэлгээний ажил

288. Намагт гүйцэтгэх тэсэлгээний ажлын төсөлд шатамхай хийн тэсрэлтээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусгасан байна.

289. Цочир дамжуулах шижим ашиглан намагт тэсэлгээ хийхдээ шпурын өрөмдлөгийг даган цэнэглэж болно. Цооног, шпурт тэсэлгээний хэрэгсэлгүй боодолтой тэсрэх бодисыг нэг удаа хоёроос илүүгүйг хийнэ.

290. Устай орчны тэсэлгээний цахилгаан хэлхээг зөвхөн агаарт өлгөсөн утсаар холбохыг зөвшөөрнө.

291. Экскаватораар суваг татан тэсрэх бодисыг сувагт кранаар байрлуулан бульдозероор сувгийн цэнэгийг булах аргын үед экскаватор, кран хоорондын зайд нь экскаваторын утгалтын хамгийн их радиус болон краны эргэлтийн радиусын нийлбэрийг 1.1 дахин авсан, кран, бульдозер хоорондын зайд нь краны эргэлтийн радиусыг 1.1 дахин авснаас тус тус багагүй байна.

292. Сувгийн цэнэглэлтийг нэг хоногоос илүү хугацаанд хийх бол бүүстрнийг тэсэлгээ хийх өдөр цэнэгт байршуулна.

293. Уул-геологийн хүндрэлтэй нөхцөлд D ангилалын тэсрэх бодисыг цочир дамжуулах шижим буюу цахилгаан бус системээр өдөөх сувгийн цэнэглэлтийг малтальтын ажлыг дагуулан гүйцэтгэж болно. Цэнэглэлтийг олон шанагат экскаватораас 5 метр, нэг шанагат экскаватораас 10 метрээс багагүй зайд дагаж хийнэ.

Мөс тэслэх, усанд хийх тэсэлгээний ажил

294. Мөс, гол, нуур болон бусад усан сангийн доор хийх тэсэлгээний ажлыг төрийн захиргааны холбогдох байгууллагуудад танилцуулсан тэсэлгээний ажлын төсөл, паспортаар гүйцэтгэнэ. Эдгээр ажилд усанд шумбагч ажиллуулах бол тэдний аюулгүй ажиллагааны шаардлагыг мөрдлөг болгоно.

295. Цэнэгийг голын дундаас эрэг рүү нь, өндөр эрэгтэй талаас хаялагатай тал руу нь, урсгал сөрөх чиглэлд тэсэлвэл зохино.

296. Мөсөн түгжрээ задлах болон халуун масс бутлахаас бусад тохиолдолд галын болон цахилгаан галын өдөөлт хэрэглэхийг хориглоно.

297. Мөс бутлах тэсэлгээнд нэг тэсэлгээчин нэг удаа 10-аас илүүгүй асаах гуурсанд гал өгнө.

298. Онцгой тохиолдолд хөвж яваа мөс болон нягтарсан зайдын руу хамгаалалтын байгууламжаас эсхүл эрэг дээрээс цэнэг шидэн байршуулж болно. Цэнэгийг нэг нэгээр нь шиднэ.

299. Шидэх цэнэгийн асаах гуурсын урт нь ажиллах аюулгүй нөхцөл болон тэсэлгээчний аюулгүй зайд гарах хугацааг хангахуйцаар тооцсон байна.

300. Мөсөн бүрхүүлийг усан доорх цэнэгээр тэслэх үед цэнэгийг мөсний цоолго руу найдвартай бэхэлсэн уяа оосроор оруулна.

301. Хайлж буй мөсний ангал завсраар цэнэглэхийг хориглоно.

302. Цэнэглэхийн өмнө цоолго болон усны гүнийг шалгах хэрэгтэй.

303. Усан доорх тэсэлгээний ажилд оролцох ажилтны тоог төслөөр тогтооно. Цэнэгийг зөвхөн тэсэлгээчин байрлуулна.

304. Хэрэв нийт цэнэгийн жин 40 кг-аас давж байвал тэсэлгээний ажилд зориулан тоноглосон өөрөө хөвөгч хэрэгсэл ашиглана.

305. Галаар тэслэх аргын үед нэг оролтоор 5-аас илүүгүй асаалт хийнэ.

306. Цэнэгүүдийн хооронд дахь тэсэлгээний хэлхээнд усны урсгалын хүчинд тасрахааргүй бөх уяагаар нэмэлт бэхэлгээний холболт хийнэ.

307. Усан доорх цэнэгийн хэлхээг шалгах, хэлхээний төв шугамыг эх үүсвэрт холбох ажиллагааг зөвхөн хөвөх хэрэгслийг тэслэх газраас төслөөр тогтоосон аюулгүй (100 метрээс багагүй) зайд холдуулж, аюултай бүсийг хамгаалалтад авсны дараа гүйцэтгэнэ.

308. Цэнэг нь усны ёроол руу чөлөөтэй живж байхаар бүтэцтэй байна. Хөвөгч таних тэмдгийг цэнэг нэг бүрт сайтар бэхэлсэн байх ба завь онгоц буюу цэнэгт гал өгөх газраас харагдаж байх ёстой.

309. Цэнэгийг тэсэлгээний ажлын удирдагчийн шийдвэрээр ус руу буулгана.

310. Усан доор ил цэнэгээр тэсэлгээ хийх үед цэнэгийн хэмжээ 50 кг хүртэл бол 1000 метрийн, 50 кг-аас дээш бол 2000 метрийн радиусаас дотогш зайд шумбагч болон

бусад ажилчдыг усанд байхыг хориглоно. Гол дотор тэсэлгээний ажил хийхдээ дохио өгөх болон харуул байрлуулах зайлт тогтоосон аюултай бүсээс урсгалын дагуу дээш, доош 500 метрээс багагүйгээр нэмэгдүүлж авна.

311. Үзэгдэх орчин хязгаарлагдмал, салхины хурд 12 м/сек-ээс их, усны давалгаа 3 баллаас илүү үед усан доор тэсэлгээний ажил гүйцэтгэхийг хориглоно.

**Металл тэслэх, халуун биет тэслэх
тэсэлгээний ажил**

312. Металл тэслэх ажлыг батлагдсан төслөөр гүйцэтгэнэ.

313. Тэсэлгээгээр металл боловсруулах байр, талбайн бүтцийг цэнэгийн зөвшөөрөгдөх дээд хэмжээгээр тооцсон байна. Тийм байр талбайг Улсын комиссоор шалгуулан ашиглалтанд оруулж, жил бүр шалгуулан ашиглалтын хугацааг сунгуулж байна.

314. Металл боловсруулах тэсэлгээний цэнэг байрлуулах багажийг өргөх, шилжүүлэх механизм нь бие биенээсээ үл хамаарах 2 тоормостой, автоматаар зогсоох төгсгөлийн салгууртай байна. Ачаа өргөх механизм газардуулгатай, сайн тусгаарлалттай байна.

315. Металл боловсруулах цэнэгийг тусгайлан тоноглосон байранд бэлтгэнэ. Бэлтгэсэн цэнэгтэй байрны түлхүүр зөвхөн тэсэлгээчинд байна.

316. Дотор нь тэсэлгээний ажил хийх зориулалтаар хуягласан нүх бүр хоёр хоёр бие даасан гарцтай байна. Хуягласан нүхний хийц бүтэц, дээврийн жин нь тэсрэлтэд хөдлөхгүй, эвдрэхээргүй байна. Хуягласан нүх байгуулж болон засварлан ашиглалтанд оруулахын өмнө зөвшөөрөгдөх дээд хэмжээний цэнэгийн хэмжээг хоёр дахин өсгөсөн гурван удаагийн тэсрэлтээр бат бөхийг нь шалгана. Хуягласан нүхийг тэсэлгээ бүрийн дараа агааржуулж байна.

317. 80°C -ээс дээш температуртай шпурыг дулааны хамгаалалтын боодолгүй цэнэгээр цэнэглэхийг хориглоно.

318. Халуун биетийг тэслэхдээ зөвхөн D ангилалын тохирох тэсрэх бодисыг хэрэглэж болно. Цахилгаан тэсэлгээний аргыг хориглоно.

319. 80°C хүртэл температуртай шпур (цооног, ханцуй нүх)-ыг дулааны хамгаалалтгүй цэнэгээр цэнэглэж болох боловч өдөөх цэнэгийг нэмэлт картон цаасан боодлоор хамгаална.

320. Өдөөх цэнэгтэй гуурсыг халуун шпурт байлгаж туршсан байна. Хэрэв тэслүүр 5 минут бололгүй тэсэрч байвал боодлыг зузаатгана.

321. 80°C-аас дээш температуртай шпурыг нэг үргэлж дулаан тусгаарлах боодлой цэнэгээр цэнэглэнэ. Цэнэгийг 60 см-ээс богиногүй асаах гууртай, тэслүүртэйгээ нэг үргэлж дулаан тусгаарлах боодлой өдөөх цэнэгээр тэсэлнэ. Асаах гуурсын гал дамжуулах шижмийг өдөөх цэнэгийн боодол дотор болон шпурын цэнэгийн гадуурх нэгдсэн тусгаарлах боодол дотор мушгиж, гогцооруулж болохгүй.

322. 200°C-аас дээш температуртай шпурыг цэнэглэхийг хориглоно.

323. 80°C -аас дээш температуртай халуун биетийг ил цэнэгээр тэслэхийг хориглоно.

324. 80°C-аас доош температуртай 5 хүртэл шпурыг нэгэн зэрэг цэнэглэж тэсэлж болно. Харин 80°C -ээс дээш температуртай нэгээс илүү шпурыг зэрэг цэнэглэж тэслэхийг хориглоно.

325. Цэнэглэх, түгжих ажлыг 2 тэсэлгээчин тэсэлгээний ажлын удирдагчийн хяналттай гүйцэтгэнэ. Тэсэлгээний ажлын удирдагч шпурын температурыг хэмжиж шалгасны дараа цэнэглэх зөвшөөрөл өгнө. Хэрэв тэсэлгээчид 4 минутын хугацаанд бүх шпурыг цэнэглэж дуусаагүй бол тэсэлгээний ажлын удирдагч цэнэглэгээний ажлыг зогсоож, хүмүүсийг аюулгүй зайд гаргана.

Барилга байгууламж нураах тэсэлгээний ажил

326. Тэсэлгээний аргаар нураах ажлын тесөлд нураах объектын унах чиглэлийг тодорхойлж, бүрэн нураагүй тохиолдолд авах арга хэмжээг төлөвлөсөн байна.

327. Нурааж буй объектын биетийн хөндий хэсэгтэй холбогдсон шpur цооногийг цэнэглэхийг хориглоно.

328. Тэсэлгээний ажлын эхний дохиог цахилгаан тэслүүртэй өдөөх цэнэгийг байрлуулахын өмнө, хэрэв цочир дамжуулах шижим, цахилгаан болон цахилгаан бус тэслүүрийн систем хэрэглэж байгаа бол тэсэлгээний хэлхээг угсралын өмнө өгнө.

329. Тэсэлгээний ажлын удирдагч нь тэсэлгээчний хамт тэсэлсэн объектыг шалгасны дараа тэсэлгээний ажил дууссан дохио өгөх шийдвэр гаргана.

330. Тэсэлгээний аюултай бүсэд байгаа зуух, шугам хоолой болон бусад даралтат савны даралтыг тэдгээрийг ашиглагч байгууллагатай тохирсон хэмжээнд хүртэл бууруулсан байна.

Мод, хожуулын үндэс булгалах, ойн түймэр унтраах болон бусад тусгай тэсэлгээний ажил

331. Цэнэглэсэн хожуулд шpur өрөмдөх, нүх ухахыг хориглоно.

332. Хэд хэдэн тэсэлгээчин галын аргаар хожуул булгалах, мод унагах тэсэлгээ хийх бол ажил эхлэхийн өмнө тэсэлгээний ажлын удирдагч тэсэлгээчин бүрийн хөдөлгөөний чиглэлийг зааж өгнө.

333. Барьцалдаж хөлдсөн мод, гуалинг зөвхөн галын хамгаалалттай тэсрэх бодис хэрэглэн цахилгаан тэсэлгээний аргаар тэсэлж задлана. Тэсэлгээчнийг хураасан, овоолсон модны завсар унах, тэсрэлтээс гал түймэр үүсэхээс сэргийлэх арга хэмжээг урьдчилан авсан байна.

334. Голд түгжрэл үүсгэсэн мод задлах тэсэлгээг хэрхэн гүйцэтгэхийг тэсэлгээний ажлын удирдагч тогтооно.

335. Ойн түймэр унтраахад тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг нисдэг тэрэгнээс шидэж болох бөгөөд шидэх тэсэлгээний хэрэгслийг зориулалтын контейнерт савласан байна.

336. Хүлрийн болон газрын гүний түймэр унтраах тэсэлгээний ажлыг галтай ирмэгээс 10 метрээс ойргүй зайд гүйцэтгэнэ.

337. Барьцаалдаж хөлдсөн хүдэр, нүүрс, занар, баяжмал, металлын зоргодсыг нитроэфир агуулсан тэсрэх бодисоор тэслэхийг хориглоно. Цахилгаан тэсэлгээний аргаар металлын зоргодос тэслэхийг хориглоно. Аммиакийн шүү суурьтай бордоог тэсэлгээний аргаар бутлахыг хориглоно.

338. Давсыг цочир дамжуулах шижмийн тэсэлгээний аргаар буталж болно.

339. Ил, далд төв шугам хоолойн хамгаалалтын бүсэд хийх тэсэлгээний ажлыг тухайн шугам хоолой ашиглагч байгууллагад тэсэлгээний ажлын төслөө танилцуулж зөвшөөрөл авч гүйцэтгэнэ.

Газрын дээр бөөнөөр хийх тэсэлгээний ажил

340. Цэнэглэж буй нүхний уртаас үл хамааран хоёр буюу түүнээс олон тоотой цооног, тогоолсон болон камерын цэнэгийг тэсэлгээний нэг хэлхээнд холбосон, түүнчлэн малтарт дахь нэг цэнэгийн урт 10 метрээс багагүй байх үед хийх тэсэлгээг цэнэгийг бөөнөөр тэслэх тэсэлгээ гэнэ. Тэсэлгээний ажил гүйцэтгэгч байгууллага нь бөөнөөр тэслэх тэсэлгээний жишиг төсөл, паспорт боловсруулан мөрдэж ажиллана.

341. Өрөмдлөг тэсэлгээний ажлын жишиг төслийг тухайн ашигт малтмалын орд газрыг ашиглах батлагдсан төсөл, туршилтын болон үйлдвэрлэлийн тэсэлгээний ажлын үр дүн, шинжлэх ухаан техникийн судалгаа, ижил төстэй нөхцөл дэх үйлдвэрлэлийн тэсэлгээний ажлын туршлага болон энэхүү дүрмийн шаардлагад үндэслэн боловсруулна. Өрөмдлөг тэсэлгээний ажлын жишиг төсөлд:

а) аюултай бүсийн хамгийн их хүрээнд байгаа уурхайн талбайн хил хязгаар, барилга, байгууламж, шугам хоолой, цахилгаан дамжуулах шугамын обьектуудыг тусгасан дэвсгэр зураг, аюулгүй байдлыг хангах аюултай бүсийн тооцоо, хамгаалах арга;

б) чулуулгийн геологи, гидрогеологийн товч тодорхойлолт, тэдгээрийн хатуулаг, ан цавшилтын болон өрөмдөгдөх, тэслэгдэх шинж чанарын ангилал, технологийн нөхцөлүүд (ажлын талбайн өргөн, доголын өндөр);

в) өрөмдлөг тэсэлгээний ажлын аргачилал, параметрийн ерөнхий тооцоо;

г) шпур, цооногийн диаметр, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, өрөмдлөг тэсэлгээний ажлын механикуулалт, тэсэлгээний болон хяналтын багаж хэрэгслийн сонголтын үндэслэл;

д) тэсэлгээний арга;

е) тэсэлгээний хэлхээний схем, дараалал, удаашралын хугацаа;

ё) цэнэгийн болон өдөөх цэнэг (бүүстэр)-ийн бүтэц, байрлал;

ж) удаашралын хугацааг тооцох аргачлал болон удаашралын сонгосон хугацаанууд;

з) догол дээрх цооногийн байршлын параметр;

и) зарцуулалтын итгэлцүүр болон тэсэлгээний тооцооны үзүүлэлтүүд (тэсрэх бодисын нэгж зарцуулалт, тэсэлсэн уулын цулын 1 у.м. цооногт ноогдох хэмжээ);

к) тэсэлгээний бүсийг агааржуулах болон энэхүү дүрэмд заасан аюулгүй ажиллагааны бусад арга хэмжээг зааж, өрөмдлөг тэсэлгээний ажлыг аюулгүй зохион байгуулах шийдэл;

л) аюулгүйн зайд хэмжээг тооцох аргачлал, овор бутлах тэсэлгээний жишиг паспортыг тус тус тусгасан байна.

342. Бөөнөөр тэсэлгээ хийх талаар захиалагч, гүйцэтгэгч байгууллагын ажилтнууд болон тэсэлгээ хийж байгаа газарт ойр байгаа бусад байгууллага, шаардлагатай бол орон нутгийн захиргаа, хүн амд тэсэлгээний ажил гүйцэтгэгч байгууллага мэдээлж байх арга хэмжээг жишиг төсөлд заасан байна.

343. Тэсэлгээнд бэлтгэх, гүйцэтгэх журмыг тэсэлгээний ажил гүйцэтгэгч байгууллагын хариуцлагатай удирдагч, эсвэл тэсэлгээний ажил гүйцэтгэгч нь туслан гүйцэтгэгчээр ажиллаж байгаа тохиолдолд захиалагч, гүйцэтгэгч байгууллагын удирдлагууд хамтран батална. Захиалагч, гүйцэтгэгч байгууллагын ажилтнууд тэсэлгээний ажлын аюулгүй байдлыг хангах, тэсрэх материалыг харж хамгаалах асуудлаар хэн ямар үүрэг, хариуцлагатайг тэсэлгээнд бэлтгэх, гүйцэтгэх журамд тодорхой заасан байна.

344. Байгууллага нь тэсэлгээний ажил явуулах өдөр, цаг хугацааг тогтоосон байна.

345. Тэсэлгээний ажлын төсөл, паспортыг байгууллагын тэсэлгээний ажилд бэлтгэх, гүйцэтгэх батлагдсан журмын дагуу тэсэлгээний ажил гүйцэтгэгч байгууллагын тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагч, эсвэл түүний томилсон эрх бүхий ажилтан, харин тэсэлгээний ажил гүйцэтгэгч нь туслан гүйцэтгэгчээр ажиллаж байгаа тохиолдолд захиалагч, гүйцэтгэгч байгууллагуудын эрх бүхий тэсэлгээний хариуцлагатай удирдагчид хамтран баталсан байна.

346. Тэсэлгээний ажлын жишиг төсөлд үндэслэн тодорхой нөхцөлд хийх тэсэлгээний ажлын төсөл, паспортыг боловсруулна. Тэсэлгээний ажлын төсөл, паспорт (энэхүү дүрмийн хавсралт 7, 8, 9) нь:

а) техникийн тооцоог цооногийн байршил болон зургуудын хамт;

б) тэсэлгээний ажлын параметрүүдийн хүснэгт;

в) бөөнөөр тэслэх тэсэлгээний ажлын журмаас бүрдэнэ.

347. Техникийн тооцоо, цооногийн байршлын схем нь зураг, тооцооны бодолт, тайлбартай байна. Эдгээр баримт бичгийг уул геологи, гидрогеологийн бодит нөхцөл, маркшейдерийн хэмжилт, тэмдэглэл, өмнөх тэсэлгээний туршлагад үндэслэн боловсруулна.

348. Тэсэлгээний ажлын төсөл, паспортоор хийсэн өрөмдлөгийн дараа цооногуудад маркшайдерийн хэмжилт хийж бодит байршлыг доголын дэвсгэр зураг дээр тэмдэглэнэ. Тэсэлгээний ажлын параметруудыг дэвсгэр зураг дээр тэмдэглэж, тооцооны хүснэгтэд бичнэ. Цэнэглэлтийн явцад хүснэгтэд бодит хэмжээг тэмдэглэнэ.

349. Цооног өрөмдөж, маркшайдерийн хэмжилт хийсэн талбайг тэсэлгээний ажил гүйцэтгэгч актаар хүлээж авна.

350. Тэсэлгээний ажлын удирдагч нь ажилтнуудад тухайн тэсэлгээний ажлын баримт бичгийг танилцуулж, тэсэлгээнд бэлтгэх, гүйцэтгэх ажиллагааны горим, аюулгүй байдлыг хангах зайлшгүй арга хэмжээнүүдийг ойлгуулсан, холбогдох үүрэг даалгаврыг өгсөн байна.

351. Тэсэлгээний хэлхээг угсарч дууссаны дараа тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагч нь хэлхээний холболт паспортод төлөвлөсөнтэй тохирч байгаа, холболтуудыг зөв, найдвартай хийсэн, удаашруулагчийг зөв байрлуулсныг шалгаж, зөрчил илэрвэл арилгана. Хэрэв олон блок зэрэг тэсэлж байгаа бол тухайн блокийн ажиллагааг удирдахаар томилогдсон ажилтан (ахлах тэсэлгээчин) энэхүү шалгалтыг гүйцэтгэнэ.

352. Тэсэлгээний ажлын удирдагч болон тэсэлгээчид, түүнчлэн тусгай блокийн ажлын удирдагч (ахлах тэсэлгээчин) тэсэлгээчид харилцан бие биенээ ойлгосон, цэнэглэгээ, холболтын үед үүссэн аливаа зөрчлийг нуухгүй байх хэрэгтэй.

353. Тэсэлгээг хоёр болон түүнээс олон цэгээс гал өгч гүйцэтгэх бол тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагч болон гал өгөх цэгүүдэд ажиллаж буй ажлын удирдагч ахлах тэсэлгээчийн хооронд найдвартай, урьдчилан шалгагдсан радио холбоотой байна.

354. Тэсэлгээний хариуцлагатай удирдагч нь блок цэнэглэх, тэсэлгээнд бэлтгэх тэсэлгээний ажлын удирдагч (ахлах тэсэлгээчин) болон аюултай бүсээс хүн, техник гаргах, харуул хамгаалалт хариуцах ажилтнаас тэсэлгээнд бэлэн болсон мэдээллийг хүлээн авч, тэсэлгээний паспортод заасан аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн авсныг шалгаж, бүрэн хангагдсанд итгэсний дараа тэсэлгээний ажлын удирдагчид гал өгөх зөвшөөрөл өгнө.

355. Тэсэлгээний ажлын удирдагч нь тэсрэлт явагдсанаас хойш 15 минутаас багагүй хугацааны дараа тэсэлсэн блокийн шалгалтыг зохион байгуулна. Шалгалт хийж буй ажилтнуудыг тэсрэлтээс үүссэн хийнд хордохоос сэрэмжлүүлнэ.

356. Үзлэгээр цэнэгийн бааралт илрээгүй, хорт хийн ялгарал орчинд аюулгүй байвал тэсэлгээний ажлын удирдагч “Тэсэлгээний ажил дууссан” дохио өгүүлнэ. Энэ дохиогоор тэсэлгээний аюултай бүсийн харуулуудыг татан буулгана.

357. Тэсэлгээний дараа илэрсэн цэнэгийн бааралтыг бүртгэх, устгах ажиллагааг тогтоосон журмын дагуу гүйцэтгэнэ.

358. Өрөмдлөг тэсэлгээний ажлын параметрыг оновчлох, цаашид боловсронгуй болгох зорилгоор тэсэлгээний гүйцэтгэлийн үр дүнг бүртгэж, дүн шинжилгээ хийж байна.

ЗУРГАА. ГАЗРЫН ДООР ТЭСЭЛГЭЭНИЙ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД

ТАВИГДАХ НЭМЭЛТ ШААРДЛАГА

Үндсэн нөхцөл

359. Далд уурхайн малталаад цэнэглэлтийн ажил эхлүүлэхдээ мөргөцөгт өмнө нь тэсэлсэн уулын цулыг цэвэрлэн, мөргөцгийг агааржуулж, тэсэлгээний ажилтай холбогдолгүй ажилчдыг өрөмдлөг, тэсэлгээний паспортаар тогтоосон хамгаалалтын бүсээс гадагш гарган, тэсэлгээчний аюулгүй ажиллах нөхцөлийг нь хангасан байна.

360. Газрын доорх малталаад тэсэлгээний шпур, цооногийг цэнэглэх, тэслэх ажлыг тэсэлгээний ажлын удирдагчийн хяналтын дор хийж гүйцэтгэнэ.

361. Газрын доорх малталаадын мөргөцгүүдийг хоёр талаас нь угтуулан малтах буюу малталаадыг сэтэлж холбох үед тэсэлгээний ажлыг хийхдээ дараах нөхцөлүүдийг хангасан байна. Үүнд:

а) мөргөцгүүд хоорондоо 15 метр ойрсон үеэс эхлэн аль нэг мөргөцөгт тэсэлгээний ажил явуулах бол цэнэглэлт эхлэхийн өмнө тэсэлгээний ажилтай холбогдолгүй ажилчдыг дээрх малталаадуудаас аюулгүй зайд гарган, цэнэглэлт явагдахгүй малталаад руу орох аманд харуул тавина. Угтах малталаадуудад нэгэн зэрэг тэслэхийг хориглоно. Угтах малталаадуудын хоорондын зайл заавал тодорхойлж байна. Тэсэлгээ бүрийг тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагчийн олгосон даалгаврын хуудсаар гүйцэтгэх ба тэсэлгээний ажлын удирдагчийн биечилсэн хяналтын дор гүйцэтгэнэ;

б) тэсэлгээчин нь эсрэг талын мөргөцгөөс ажилчдыг аюулгүй зайнд гаргаж, мөргөцгийн аманд харуул гаргасны дараа цэнэглэлтийн ажлыг эхэлнэ;

в) тэсэлгээний ажил дууссаны дараа эсрэг мөргөцгийн аманд гарсан харуулыг зөвхөн тэсэлгээний удирдагчийн зөвшөөрлөөр буулгана;

г) угтуулан малталаад явуулж байгаа хоёр мөргөцгийн хоорондох цулын зайл нь 7 метр болсон үеэс зөвхөн хоёр малталаадын аль нэгийг зогсоож зөвхөн нэг мөргөцөгт нь нэвтрэлтийн болон тэсэлгээний ажил явуулна. Малталаад хоорондын зайл ойрсон тохиолдолд тэсэлгээний шпур, цооногийн уртаас 1 метрээс илүү урттай өрөмдлөг хийж малталаад хоорондын зайл хянана;

д) хий, тоосны аюултай нүүрс, хүдрийн уурхайд угтуулан малтаж байгаа хоёр мөргөцгийн хоорондох цулын зайл нь 3 метрээс бага болоход тэсэлгээ бүрийн өмнө хийн хэмжилт хийж, эдгээр малталаадуудыг тогтмол агааржуулж, тоосны тэсрэлтээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна.

е) хий, тоосны тэсрэлтийн аюултай нүүрсний уурхайн малталаадуудад тэсэлгээний ажлын удирдагч, ажилтнууд хийн хэмжилт хийхээс гадна сэтлэн холбох малталаад метаныг автомат хэрэгслээр хянана.

362. Нүүрсний уурхайд хоорондоо 15 метр ба түүнээс бага зайлтай зэрэгцүүлэн малталаад явуулж байгаа хос малталаадуудын нэгэнд тэсэлгээ хийхдээ нөгөө малталаадын ажилчдыг тэсэлгээний ажлын паспорт, төсөлд заасан аюулгүй зайд гаргаж харуул тавьсан байна. Тэсэлгээ хийж байгаа мөргөцгөөс 50 метр ба түүнээс илүү зайд хоцорч яваа зэрэгцээ малталаадын мөргөцгийн ажилчдыг гаргахгүй байж болно.

363. Газрын доорх тэсрэх материалын түгээх агуулах, хэсгийн тэсрэх материал түгээх цэгээс бүх чиглэлд 30 метр, эдгээр агуулах, цэгт ажилчид байрлаж байхад тэсэлгээний агуулахаас бүх чиглэлд 100 метрээс дотогш зайд тэсэлгээний ажил явуулахыг хориглоно. Энэ зайд тэсэлгээ хийх газарт хамгийн ойр байрлах тэсрэх материалтай цэг, агуулахаас тооцож тодорхойлно.

364. Тэслэхээр цэнэглэсэн газраас 20 метр хүртэлх зайд буталсан нүүрс, хүдэр, уулын цулыг зайлзуулаагүй, тэргэнцэр, мод материал малтальтын хөндлөн огтлолын талбайн 1/3-ээс их зайд эзэлсэн, чөлөөтөй гарц гарамгүй нөхцөлд тэсэлгээний ажил явуулахыг хориглоно.

365. Эгц уналтай нүүрсний давхаргыг хоршоолсон системээр ашиглахад цэвэрлэгээний мөргөцгийн малтальт нь тэсэлгээгээр бутлагдсан нүүрсийг хүлээн авах хангалтгай багтаамжтай, шаардлагатай хэмжээний агаарын урсгалтай, чөлөөтөй гарц гарамтай байна.

366. Малтальтад тэсэлгээний ажил явуулсны дараа мөргөцөгт ажилчдыг оруулах үед агаарын урсгалд хорт хийн агуулга нь (нүүрсхүчлийн хийн багтаамжаар тооцоолоход) 0.008%-иас ихгүй байх ёстой. Хорт хийн агуулга нь ийм хэмжээнд хүртэл цэвэршихэд малтальтыг агааржуулах хугацаа нь 30 минутаас багагүй байна. Тэсэлгээний хорт хийг шалгахдаа 1 литр азотын диоксидийг 6.5 литр нүүрстөрөгчийн оксидтой тэнцэтгэж авна.

367. Нүүрсний давхаргыг үечлэн ашиглалт явуулж байгаа цэвэрлэгээний аль нэг мөргөцөгт нь тэсэлгээний ажил явуулж байхад таазны бэхэлгээ, торон хучилтын дор түүнчлэн малтальтын үе хоорондын талбайд ажилчид байхыг хориглоно. Нүүрсний эгц босоо, налуу тогтоцтой давхаргын камер, цэвэрлэгээний мөргөцөг, түүний дээд догол, агаарын штрект тэсэлгээ хийг үед өрөмдлөг, тэсэлгээний ажлын паспортад тусгасан хорт хийн ялгаралаас ажилчдыг урьдчилан сэргийлэх, хамгаалах энэхүү дүрмийн шаардлагад заасан арга хэмжээнүүдийг авснаар тэсэлгээчнийг бохир агаарын урсгалтай малтальтад байрлуулж болно.

368. Хиймэл аргаар хөлдөөсөн чулуулагт буюу хийн даралттай бүсэд тэсэлгээний ажлыг зөвхөн тусгайлан боловсруулсан төслөөр гүйцэтгэнэ.

Уурхайн босоо их ам нэвтрэх болон гүнзгийрүүлэх тэсэлгээний ажил

369. Босоо амны малтальт нэвтрэх, гүнзгийрүүлэх тэсэлгээг зөвхөн газрын дээрээс буюу ашиглалт явуулж байгаа түвшнээс явуулна. Тэсэлгээний ажил гүйцэтгэж буй тэсэлгээчин нь цэвэр агаарын урсгалтай малтальтад байрласан байна.

370. Бүүстэр (галлагч)-ийг босоо амны малтальт, барилга байгууламжаас 50 метрээс ойргүй зайд, төсөлд заасны дагуу тоноглосон цэнэглэх байранд бэлтгэнэ. Цэнэглэх байрны байршлыг төслөөр тогтооно.

371. Бүүстэр (галлагч)-ийг ёроол нь онгойдог хөнөгөөр өргөж буулгахыг хориглоно.

372. Хөнөг хүлээн авах талбайгаас дээш өргөгдөхгүй автомат хязгаарлагчтай, хөмөрч асгадаг хөнөгөөр бүүстэр (галлагч)-ийг өргөж, буулгаж, тээвэрлэхийг

зөвшөөрнө. Бүүстэр (галлагч)-ийг өргөх, буулгах хөнөгийн хурд нь чиглүүлэгчтэй бол 2 м/сек, чиглүүлэгчгүй бол 1 м/сек-ээс ихгүй байна.

373. Босоо малталтаар угсарсан бүүстэр (галлагч)-ийг зориулалтын хайрцаг, цүнхтэйгээр тэсрэх бодисоос тусад нь тэсэлгээчин авч бууна.

374. Угсарсан бүүстэр (галлагч)-ийг босоо амаар буулгах үед мөргөцөгт зөвхөн тэсэлгээчин, усны насосны машинч зэрэг ажлыг нь зогсоох боломжгүй ажилтнууд байна. Шпур, цооногийг цэнэглэх үед нэвтрэлтийн тавцан дээр хөнөг хариуцагчаас бусад ажилчид байхыг хориглоно.

375. Босоо амны усны ундратаа ихтэй мөргөцөгт цахилгаан тэсэлгээний хэлхээний шугамыг усанд автагдахгүй өндөр (агаар)-т өлгөж байрлуулна. Энэ тохиолдолд цахилгаан тэслүүрийн утас нь агаараар өлгөсөн шугаманд нэмэлт залгаагүйгээр холбогдоно.

376. Тэсэлгээчин нь мөргөцгөөс бүх ажилчдыг (тусгай үүрэгтэй ажилтан, нэвтрэлтийн дүүжинт тавцангийн оператораас бусад) гаргасны дараа цахилгаан тэсэлгээний холболт, угсралтыг хийнэ.

377. Цахилгаан тэсэлгээний төв (магистрал) шугамын утас нь ус чийг нэвтрэхгүй бүрээстэй уян кабель байх бөгөөд малталтын ажил явуулдаг тавцангас доош унжихгүйгээр байрлуулсан байна.

378. Тэсэлгээний холболтыг хийж дуусаад, ажилчид газрын дээр гарсны дараа босоо малталтын амны хаалтуудыг онгойлгоно.

Газрын доор барилга байгууламж (тунель) барих үеийн тэсэлгээний ажил

379. Газрын доорх, дээрх барилга, байгууламжийн ойролцоо тэсэлгээний ажлыг явуулахдаа тухайн барилга, байгууламжийг ашиглаж байгаа албан байгууллага, газруудтай харилцан зөвшилцсөний үндсэн дээр батлагдсан зураг төслөөр хийж гүйцэтгэнэ.

380. Хот, суурин газрын нөхцөлд босоо ам нэвтрэх үед усны ундратаа ихтэй тохиолдолд бүүстэр (галлагч)-ийг бэлтгэхдээ газрын доорх босоо малталт нэвтрэх мөргөцгөөс дээших эхний эсвэл тусгайлан бэлдсэн тавцан дээр бэлдэж болно.

381. Цахилгаан тэсэлгээгээр хонгил (туннель) нэвтрэхдээ цэнэглэлтийн ажил эхлэхийн өмнө бүх тоног төхөөрөмжийн хүчдэлийг салгана. Хонгилын доторлогоо засал, хаалт хийх талбайд бүүстэр (галлагч)-ийг угсарч бэлдэхийг хориглоно.

382. Өгсөх босоо малталтаар дээд хэвтээ малталтыг сэтлэх үед түүний эсрэг талын малталтад нь зэрэгцүүлэн тэсэлгээ хийхийг хориглоно.

383. Туннелийн таазны тэсэлгээг өрөмдлөг, тэсэлгээний ажлын төслөөр явуулах бөгөөд туннелийн барилгын ажлыг гүйцэтгэгч байгууллагын удирдлагатай зөвшилцсөн байна. Туннелийн таазны хоёр талын жигүүрт нэгэн зэрэг тэсэлгээ хийхийг хориглоно.

Хий, тоосны аюултай нүүрсний болон хүдрийн далд урхайн тэсэлгээний ажлын онцлог

384. Тэсэлгээчин нь хий, тоосны тэсрэлтийн аюултай нүүрс, хүдрийн уурхайн малтарт, мөргөцөт тэсэлгээний ажил явуулахдаа шpur цэнэглэх тухай бүрт, түүнчлэн тэслэхийн өмнө, тэсэлгээний дараа малтарт, мөргөцөт үзлэг хийж, мөргөцгийн бүх отглолд метан хийн хуримтлалыг хэмжинэ. Хэмжилтээр тэсэлгээ хийх малталаас 20 метр зайд байрлалтай холбоос, салаа малтальтууд болон тэсэлгээний үед тэсэлгээчний хоргодах байранд метан хийн агуулга 1 хувь буюу түүнээс дээш байвал тэсэлгээний ажил хийхийг хориглоно. Хоргодах байранд тэсэлгээний хэлхээнд тэслэх (машин) хэрэгслийг залгаж тэслэхийн өмнө тухай бүрт нь метан хийн хэмжилт хийнэ.

385. Хий, тоосны тэсрэлтийн аюултай нүүрс, хүдрийн далд уурхайд мөргөцгийг нь тасралтгүй цэвэр агаараар агааржуулж, тоосны тэсрэлтийн аюулаас хамгаалах шаардлагатай бүх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн малталаад тэсэлгээний ажил явуулна. Метан хийн дээд зэргийн ялгаралтай малталаад очны хамгаалалттай цахилгааны эх үүсвэртэй тэсэлгээний багаж хэрэгсэл хэрэглэнэ. Метан хийн дээд зэргийн ялгаралтай малталаад:

-тоосны аюултай давхаргад ашиглалт явуулж байгаа, метан хийн харьцангуй элбэгшилт нь 10 м³/тн ба түүнээс их, хийн хамгийн дээд элбэгшилт нь 3 м³/мин ба түүнээс их бүх малтарт;

-тоосны аюулгүй давхаргад ашиглалт явуулж байгаа, метан хийн харьцангуй элбэгшилт нь 15 м³/тн түүнээс их, хийн хамгийн дээд элбэгшилт нь 3 м³/мин ба түүнээс их малтальтууд орно.

Доргиох тэсэлгээ, нүүрс буулгах малталаадын өргөтгөл, цэвэрлэгээний мөргөцөт тааз суулгах, овор ихтэй чулуу бутлах, тэсрээгүй баарсан цэнэгийг устгах зэрэг хүндрэл ихтэй тэсэлгээний ажлыг ээлж, хэсгийн аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтныг байцуулан, тэсэлгээний ажлын удирдагчийн хяналтан дор гүйцэтгэнэ.

386. Хийн ялгарал, тоосны тэсрэлтийн аюултай цэвэрлэгээний мөргөцөг, бэлтгэл малтарт болон бусад малталаад тэсэлгээний ажил явуулахдаа тэсэлгээний ажил захиалагч, гүйцэтгэгч байгууллагын баталсан журмыг мөрдөнө. Энэ журамд мөргөцөг, малталаадын нэр, тэсэлгээний хэрэгсэл, тэсрэх бодисын нэр төрөл, тэсэлгээний ажил явуулахаар тогтоосон хугацаа, шpur (цооног) цэнэглэх, ажилчдыг аюулгүй зайд гаргах, тэсэлгээ явуулах, мөргөцгийг агааржуулах, тэсэлгээчний хоргодах байр, малтальтуудад хэмжилт хийх хугацаа болон ажилчдын зорчих малталаадын цэвэр агаарын урсгалын бүдүүвчийг тусгана.

387. Дараах нөхцөлд өрөмдлөг, тэсэлгээний ажил гүйцэтгэхийг хориглоно. Үүнд:

а) бэлтгэл малталаадын мухар мөргөцөг дэх метан агуулагч нүүрсний давхарга доторх чулууны үеийг тэслэхдээ нүүрсний давхаргыг хэсэгчлэн өрөмдөх;

б) нүүрсний давхаргын цэвэрлэгээний мөргөцөт ажиллаж байгаа комбайн, харуулдан отглогч машины урд талын нүүрсний цулыг урьдчилан сийрэгжүүлэхийг хориглоно. Энэ заалт нь хүний оролцоогүй нүүрсний малтарт, усан тэсэлгээтэй мөргөцөг, түүнчлэн геологийн эвдрэлтэй бүсэд нүүрс, чулуулгийг нураан олборлоход хамаарахгүй.

388. Тэсрэх материалыг тэсэлгээний ажлын нөхцөлтэй уялдуулж сонгон авна. Тухайлбал, энэхүү дурмийн 6 дугаар заалт болон доорх шаардлагуудад дурдсан орчны хамгаалалтыг урьдчилан буй болгох нөхцөлүүдийг харгалзан сонголт хийнэ.

389. Хамгаалалтгүй II ангиллын тэсрэх бодисыг дараах нөхцөлд хэрэглэнэ. Үүнд:

а) хэвтээ, налуу малталт, уурхайн түвшинээс дээш, доош малтах босоо малталт, ашиглалт явагдаж байгаа түвшингээс уурхайн гол амыг гүнзгийрүүлэх үед дараах нөхцөлд:

-мөргөцөт нүүрсний давхарга, үе судал байхгүй, түүнчлэн метан хийн ялгаралгүй үед;

-босоо амны гүнзгийрэлт явуулж байгаа мөргөцгийг тэслэхийн өмнө малталтын улны өндөрлөг цэгээс дээш 20 см-ээс багагүй өндөрт усаар дүүргэсэн нөхцөлд;

-нүүрсний давхаргыг нээх малталтын хоцорч яваа мөргөцгийн аль нэг цэгээс нь нүүрсний давхарга руу (5 метрээс багагүй зайд) ойртох хүртэл болон нүүрсний давхаргыг нээх малталтын мөргөцөг нь давхаргыг огтлон, малталтын уртаар тооцоход 20 метрээс илүү зайд өнгөрсөн нөхцөлд;

-нүүрсний давхарга болон үе судлыг малталтаар огтлоод өнгөрсний дараа давхаргыг тусгаарлах ажиллагаа явагдаж буй цул хийцтэй бэхэлгээтэй малталтад.

б) газрын гадаргаас шурф буюу босоо малталт явуулж хий, тоосны тэсрэлтийн аюултай нүүрс, хүдрийн уурхайн давхаргыг нээх, түүнчлэн нүүрс, хий, чулуулгийн гэнэтийн шидэлт хаялтай нүүрсний давхаргыг энэ малталтын мөргөцөг нь дайран огтолж өнгөрөх дараах нөхцөлд:

-тэсэлгээ явуулах малталт мөргөцгийн улны хамгийн өндөрлөг цэгээс дээш 20 см-ээс багагүй өндөрт, малталтыг усаар дүүргэсэн байх. Босоо малталтыг хиймэл аргаар хөлдөөсөн чулуулгаар малтаж нэвтрэх буюу усны ундарга байхгүй нөхцөлд усанд авахуулах аргаас өөр арга хэрэглэх;

-босоо амнаас ажилчдыг гаргаж, 50 метр зайд гаргасны дараа газрын дээрээс гал өгч гүйцэтгэх.

в) чулуулгийн гэнэтийн хаялын аюултай малталтад доргиолтын тэсэлгээг хийхдээ мөргөцөт усан шүршилт, усан мананцарын хөшгийг хослуулан байрлуулсан нөхцөлд: Тэсэлгээг газрын гадаргаас эсвэл хоргодах байрнаас явуулна.

г) нүүрс хийн гэнэтийн хаялын аюултай цул нүүрсний давхаргын дээд таазны бэхэжсэн хатуу чулуулгийг бутлах тэсэлгээний ажлыг аюулгүй явуулах техникийн зааварчилгааг тэсэлгээний ажил гүйцэтгэгч байгууллага боловсруулж баталсан нөхцөлд:

д) шавар, чулуулгийн хольцтой шингэн цөмрөх аюул бүхий хэсгийн төмөр бэхэлгээний дээд таазны хамгаалалтанд нэмэлт арга хэмжээ авах зорилгоор цоногийн цэнэгийг хэрэглэх нөхцөлд:

е) механикжсан ажиллагаатай цэвэрлэгээний мөргөцгийн хатуулаг өндөртэй таазны чулуулгийг урьдчилан бутлах, таазыг суулгах, аргачлалыг зааврын дагуу сонгон авч хэрэгжүүлнэ.

390. Энэ дүрмийн 389-д заасан ажлуудыг гүйцэтгэхдээ чулуулгийн хатуулаг, тэсэлгээний нөхцөлөөс нь хамааруулж дор дурдсан тэсрэх бодисыг хэрэглэнэ. Үүнд:

-Хэвтээ, налуу малталтын үед а) заалтад заасан (их амны гүнзгийрэлтээс бусад) ба в) заалтад заасан $f=7$ хүртэл бат бэхтэй чулуулаг, түүнчлэн дурын бат бэхтэй хэцүү бутлагдах чулуулагт тротилоос илүү мэдрэмжтэй мэдрэмж дээшлүүлэх хольцгүй тэсрэх бодис хэрэглэнэ.

-Хэвтээ, налуу малталтын үед а) заалтад заасан (их амны гүнзгийрэлтээс бусад) ба в) заалтын $f=7-10$ бат бэхтэй чулуулагт гексоген буюу нитро-эфирын агуулгатай тэсрэх бодисыг зөвхөн цөмлөх шпур (цооног)-т хэрэглэж болно. Бусад бүх шпур (цооног)-т тротилоос илүү мэдрэмжтэй мэдрэмж дээшлүүлэх хольцгүй тэсрэх бодис хэрэглэнэ.

-Хэвтээ налуу малталтад чулуулгийн бат бэх нь $f=10$ буюу 10-аас их бол бүх төрлийн тэсрэх материал хэрэглэхийг зөвшөөрнө. Гол амны гүнзгийрэлтийн болон б), г), д) заалтад заасан малталтуудад ямарч тэсрэх бодис хэрэглэхийг зөвшөөрнө.

391. III ангиллын хамгаалалттай тэсрэх бодисыг дор дурдсан нөхцөлд хэрэглэхийг зөвшөөрнө.

а) чулуулгийн шидэлтийн аюултай, метан хийн ялгаралтай, тоосны тэсрэлтийн аюулгүй малталтын мөргөцөгт зөвхөн чулуулгийн дундуур малталт явуулахад;

б) ашиглаж байгаа түвшингөөс доош нь босоо амны малталтыг гүнзгийрүүлэхэд метан хийн ялгаралтай мөргөцөгт зөвхөн чулуулгийн дундуур малталт явуулахад;

в) нүүрс, хийн гэнэтийн хаялын аюултай давхаргыг нээх үед нүүрсний давхарга ил гаргах хүртэл чулуулгаар малтах малталтад усан хөшиг хэрэглэж байгаа үед болон малталтын мөргөцөг нүүрсний давхаргын хооронд малталтын огтлолын талбайн энгээр чулуулгаар хаагдсан үед хэрэглэнэ. Нүүрсний давхарга хүртэлх чулуулгийн үеийн зузаан эгц уналтай давхарга нээхэд 2 метр, хэвгий давхаргад 1 метрээс багагүй байна.

392. IV ангилалын хамгаалалттай тэсрэх бодисыг дор дурдсан нөхцөлд хэрэглэхийг зөвшөөрнө.

а) тоосны тэсрэлтийн аюултай боловч метан хийн ялгаралгүй, нүүрсний давхаргаар нэвтэрч байгаа малталтын нүүрс болон нүүрс чулуулгийн холимог мөргөцөгт;

б) хий, тоосны аюултай, тэсэлгээний ажлын үед метан хий дээд зэргийн ялгаралгүй, хэвтээ, налуу, доороос дээш нэвтэрч байгаа (10^0 хүртэл) босоо малталтуудын нүүрс, нүүрс чулуулгийн холимог үетэй мөргөцөгт;

в) ил гарсан нүүрсний давхаргыг нээх болон цааш нь 20 метрээс багагүй зайд үргэлжлүүлэх малталтын доргиолтын тэсэлгээнд, түүнд дотроо битүү цэнэгтэй үед;

г) чулуулгийн доогуур малтах чигжилтийн малталтад;

д) метан хийн харьцангуй хуримтлал нь $10 \text{ м}^3/\text{т-ээс}$ бага ялгаралтай малталтын дээд чулуулгийг сэтлэн малтах чигжилтийн малталтад;

е) нүүрс, хийн гэнэтийн хаялын аюултай давхаргаар нэвтрэх үед нүүрс чулуулгийн холимог малталтын чулуулаг дундуур түрүүлэн явуулж байгаа мөргөцөт чулуулаг тэслэхэд;

ё) тэсэлгээний явцад их хэмжээний метан хийн ялгаралтай, нүүрс, чулуулгийн холимог мөргөцөт нүүрсийг урьдчилан тэсэлгээ хийхгүйгээр авсан нөхцөлд $f=4$ -өөс дээш хатуулагтай хажуугийн чулуулгийг тэслэхэд;

ж) нүүрсний цэвэрлэгээний мөргөцгийн тэсэлгээнд;

з) уналын өнцөг нь 45° -аас их давхаргад уурхайн агаарын ерөнхий урсгалаар агааржуулах зориулалтын 500 мм-ээс багагүй голчтой, урьдчилан өрөмдсөн цооногоор босоо малталт нэвтрэх тэсэлгээнд.

393. V ангиллын хамгаалалттай тэсрэх бодисыг дор дурдсан нөхцөлд хэрэглэхийг зөвшөөрнө.

а) тэсэлгээний явцад метаны хий ялгаралт их хэмжээгээр нэмэгддэг хэвтээ, метан хийн агуулга их хэмжээгээр нэмэгддэг хэвтээ, налуу, доороос дээш (10^0 хүртэл) нэвтэрч байгаа малталтуудын нүүрсний болон нүүрс, чулуулаг холимог мөргөцөт. Холимог мөргөцгийн нүүрс болон чулуулагт нэг төрлийн тэсрэх бодис хэрэглэнэ;

б) уурхайн агаарын ерөнхий урсгалаар агааржуулах зориулалтаар урьдчилан цооног өрөмдөн нэвтэрч байгаа, метан хийн ялгаралтай, доороос дээш нэвтрэх малталтын (10^0 ба түүнээс дээш) нүүрс, нүүрс чулуулаг холимог мөргөцөт;

в) метан хийн дээд зэргийн ялгаралтайд хамарагдахгүй цэвэрлэгээний мөргөцгийн догол тэслэхэд;

г) метан хийн элбэгшил нь $10 \text{ м}^3/\text{т-ээс}$ их хуримтлалтай малталтын дээд чулуулагт чигжилтийн малталт явуулахад;

д) тэсэлгээний үед метан хийн дээд зэргийн ялгаралтай, малталтын холимог мөргөцөт тэсэлгээгүйгээр нүүрсийг урьдчилан малтаж авах нөхцөлд дээд ба хажуугийн $f=4$ -өөс бага хатуулаг бүхий тогтоцтой чулуулгийг тэслэхэд.

394. VI ангиллын хамгаалалттай тэсрэх бодисыг хэрэглэх нөхцөлүүд:

а) метан хийн дээд зэргийн ялгаралтай цэвэрлэгээний мөргөцгийн дээд доголд;

б) агааржуулах цооног урьдчилан өрөмдөөгүй, метан хийн ялгаралтай нүүрсний давхаргын доод түвшингээс дээш малтах 10^0 -аас их уналтай босоо малталтын мөргөцөт;

в) метан хийн ялгаралтай, нуралт, эвдрэлтэй уулын цул дундуур нэвтрэх түүнчлэн эвдрэлтэй уулын цулыг огтлох малталтын мөргөцөт. Энэ тохиолдолд өрөмдөх шпурын гүн 1.5 метр, нэг шпурт орох тэсрэх бодисын хэмжээ 0.6 кг-аас тус тус ихгүй байна;

г) цэвэрлэгээний мөргөцгийн араас малтагдаж байгаа агааржуулах малталтын хатуулаг нь $f=4$ ба түүнээс бага хатуулагтай чулуулгийн дээд хэсэгт тэсэлгээ хийхэд.

395. VII ангиллын хамгаалалттай тэсрэх бодисыг дараахь төрлийн зориулалтын тэсэлгээний ажилд хэрэглэнэ.

а) нүүрс буулгах зориулалтын босоо малталтад, саравчилан унжиж тогтсон цул чулууг бутлах тэсэлгээнд;

б) овор ихтэй чулуулгийг ил цэнэгийн аргаар бутлахад;

в) цэвэрлэгээний мөргөцгийн таазыг суулгах зориулалтаар бэхэлгээний тулгуур модон хөлийг тэслэхэд.

396. Тэсэлгээний ажил явуулахад (доргиох тэсэлгээнээс бусад) бүх малталтын мөргөцөгт хийх тэсэлгээний ажилд, түүнчлэн тусгай зориулалтаар тэсэлгээний ажлыг явуулахад хамгаалалттай дээд ангилалын тэсрэх бодисыг энэхүү дүрмийн 390-396-д заасан тэсрэх бодистой харьцуулан тэдгээрээс илүү дээд ангилалтай тэсрэх бодисыг хэрэглэнэ.

397. Хийн ялгаралтай буюу нүүрсний тоосны тэсрэлтийн аюултай малталт, мөргөцөгт тэсэлгээ хийхдээ зөвхөн хамгаалалттай агшин зуурын, богино хугацааны удаашруулах үйлчилгээтэй цахилгаан тэслүүрийг хэрэглэнэ. Ийм тэсэлгээг дараахь нөхцөлд явуулна.

а) богино удаашралтай цахилгаан тэслүүрүүдийн нийт удаашралын дээд хэмжээ нь тэдгээрийн ажиллагааны хугацааны алдааг оролцуулан тооцсоноор IV ангилалд 220 мс, V ба VI ангилалд 320 мс-ээс ихгүй байна;

б) нүүрсээр нэвтрэх бэлтгэл малталт болон цэвэрлэгээний малталтын комбайны доголын машинаар цөмлөхгүй мөргөцгийн бүх цэнэгийг тэсэлгээний машинаас нэг удаагийн гүйдэл өгөлтөөр тэслэнэ;

в) нүүрсний мөргөцгийн урт нь 5 метрээс их тохиолдолд түүнийг хэсгүүдэд хувааж, хэсэг тус бүрт тэсэлгээний ажлыг явуулахдаа энэхүү дүрмийн 403-т заасан шаардлагуудыг мөрдлөг болгоно.

г) нүүрсээр нэвтэрч байгаа бэлтгэл малталтын мөргөцгийн хажуугийн чулуулгийг бутлахад хөрс, нүүрсний шпурын цэнэгийг тус тусад нь болон нэгэн зэрэг (нэг мөргөцөгт буюу аль нэгэнд нь түрүүлж) тэсэлж болно. Малталтын эхний 5 метрээс илүүгүй урттай түрүүлэх орол үүсгэхээс бусад тохиолдолд тус тусад нь тэслэх ажлыг зөвхөн тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдлагчийн зөвшөөрлөөр нүүрсэнд нэг, чулуулагт нэг мөчлөгтэйгээр хийнэ.

398. Өөр өөр мөргөцөгт тэсэлгээний ажил явуулах тэсэлгээчин аль нэг мөргөцөгт нь их удаашралтай цахилгаан тэслүүр, доогуур ангиллын тэсрэх бодис хэрэглэх бол түүнд өөр өөр ангиллын тэсрэх бодис, хамгаалалттай, хамгаалалтгүй цахилгаан тэслүүр, түүн дотроо богино удаашралтай болон удаашралтай цахилгаан тэслүүрийг хольж нэгэн зэрэг олгохыг хориглоно.

399. Тэсэлгээний ажил явуулах үед тэсэлгээчний хоргodoх байрыг уурхайн цэвэр агаарын урсгалтай малталаад тэсэлгээ явуулах мөргөцгөөс дор дурдсанаас багагүй зайд байрлуулна.

а) хэвтээ, налуу (10° хүртэл) бэлтгэл малталаадын тэсэлгээ, овор ихтэй чулуулгийг ил цэнэгээр тэслэх, түүнчлэн цэвэрлэгээний мөргөцөгт таазыг тэсэлгээгээр суулгах үед 150 метр зайд;

б) налуу, түүнчлэн доороос дээш өгсөх (10° -аас дээш) бэлтгэл малталаад 100 метрт, гэхдээ хэвтээ малталаадын ам буюу малталаадууд огтлолцсон уулзвараас гадагш заавал 10 метрээс багагүй зайд;

в) 18° хүртэл налуу үетэй цэвэрлэгээний мөргөцгөөс 50 метр зайд;

г) 18° -аас их налуу үетэй цэвэрлэгээний мөргөцөгт 50 метрт, гэхдээ цэвэрлэгээний мөргөцөгтэй огтлолцсон малталаад тэдгээрийн уулзвараас 20 метрээс багагүй зайд;

д) камерын төрлийн цэвэрлэгээний мөргөцөг, түүнчлэн нүүрсний хамгаалалтын цулыг нураах тэсэлгээнд 200 метр зайд;

е) төмөр хавтан бэхэлгээтэй мөргөцөгт 50 метрт, гэхдээ хүн явуулын малталаас 20 метрээс ойргүй зайд;

ё) нүүрс, чулуулгийг буулгах босоо малталаад 150 метр зайд;

з) газрын гадаргаас босоо ам, шурф нэвтрэхэд 50 метр зайд.

400. Ямарч тохиолдолд тэсэлгээчний хоргodoх байр, харуул байрлах байр, бусад ажилчдын тэсэлгээний үед хоргodoх байрыг төсөл, паспортаар тогтоох бөгөөд тэсэлгээчийн ард байрлах харуулыг түүний хоргodoх байрнаас 10 метрээс, бусад ажилчдыг харуулын байрнаас гадагш 10 метрээс ойргүй зайд хоргodoхоор тооцоолон тэсэлгээний ажлын паспортад зургаар үзүүлэн тусгана.

401. Нүүрсний болон холимог чулуулгатай, 100 метрээс их урттай мухар малталаад тэсэлгээний ажил явуулах зориулалтаар тэсэлгээний хэлхээг тэсэлгээчний хорgodoх байран дахь тэсэлгээний станцтай холбох цахилгааны байнгын магистрал шугам байрлуулна.

402. Тэсэлгээний ажлын мөчлөг бүрийн, түүн дотроо нүүрс, чулуулгийг тус тусад нь тэслэх үеийн цэнэглэх, тэслэх ажиллагааг зөвхөн мөргөцгийг агааржуулж, метан хийн агуулгыг хэмжиж, буталсан нүүрс, чулуулгийг цэвэрлэж, тэслэх мөргөцөг ба түүнтэй залгаа 20 метрээс ойргүй зайд байрлалтай холбоо малталаадуудад тоосны тэсрэлтээс хамгаалах арга хэмжээг авсны дараа гүйцэтгэнэ. Тэсэлсэн нүүрсний орлын зузаан 2 метрээс илүүгүй байна.

403. Гэнэтийн хаялын аюулаас бусад хий, тоосны тэсрэлтийн аюултай давхаргын цэвэрлэгээний мөргөцгийг хэсэгчилэн хувааж тус тусад нь тэсэлгээ хийхийг зөвшөөрнө. Өмнөх хэсэгт цэнэглэсэн цэнэгийг тэсэлж, тэсэлгээгээр бутлагдсан нүүрсийг авч, мөргөцгийг бэхэлж, хийн ба нүүрсний тоосны тэсрэлтээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсны дараа аль нэг хэсэгт цэнэглэх, тэслэх ажиллагааг явуулна.

404. Нүүрс, чулуулгаар нэвтэрч буй бэлтгэл болон зүсэлтийн малталтыг бусад малталтаар отплохдоо, отплолцох уулзвараас 5 метрийн цаанаас шпурын гүний богиносгон, тэсрэх бодисын цэнэгийг багасгаж малталтын бэхэлгээ эвдрэх, таазны чулуулаг нурах, цахилгааны кабель, усны хоолой гэмтэхээс урьдчилан сэргийлнэ.

405. Хийн ялгаралтай бэлтгэл малталтын чулуулгийн ба холимог мөргөцөгт агшны болон богино удаашралтай цахилгаан тэслүүр хэрэглэхийг зөвшөөрнө. Энэ үед цахилгаан тэслүүрийн удаашралын дээд хэмжээг энэхүү дүрмийн 397-д заасан шаардлагад нийцүүлэн тогтооно. Мөргөцөгт бүлэг цэнэгийг тус тусад нь 3-аас илүүгүй удаа хувааж тэсэлж болно. Нэг удаагийн бүлэг цэнэгийг тэсэлж тэсэлгээний ажлын болон бусад ажлын аюулгүй байдлыг бүрэн хангасны дараа дараагийн бүлгийн цэнэглэлтийг эхэлнэ.

406. Метан хийн ялгаралгүй чулуулгаар нэвтрэх малталтын тэсэлгээнд агшны, богино удаашралтай, 2 секунд хүртэл удаашралтай цахилгаан тэслүүрийг тэсплэлтийн тооны болон алгасах цувралын хязгаарлалтгүй хэрэглэнэ.

407. Тэсрэмтгий хийн ялгарал, тоосны тэсрэлтийн аюултай (таазны нураалттай чигжилтийн малталтаас бусад) малталт мөргөцгийн тэсэлгээнд 60 мс-ээс ихгүй хязгаартай богино удаашралтай цахилгаан тэслүүрийг хэрэглэнэ. Удаашруулах үйлчилгээний хэлбэлзэл нь 60 мс-ээс ихгүй байна. Таазны нураалттай чигжилтийн малталтад зөвхөн агшны цахилгаан тэслүүр хэрэглэнэ.

408. II ангиллын хамгаалалтгүй тэсрэх бодис хэрэглэхийг зөвшөөрсөн, хийн ялгарал, тоосны тэсрэлтийн аюулгүй мөргөцөгт удаашралтай цахилгаан тэслүүр хэрэглэхийг зөвшөөрнө.

409. Хамгаалалтгүй тэсрэх бодис болон удаашралтай цахилгаан тэслүүр хэрэглэхийг зөвшөөрсөн нэг мөргөцөгт ажлын чадвараараа ялгаатай хамгаалалтгүй тэсрэх бодис эсхүл хамгаалалтгүй ба хамгаалалттай тэсрэх бодисыг хамтад нь хэрэглэж болно. Ажлын чадвар багатай тэсрэх бодисыг зөвхөн хэв засах хүрээний шпурт хэрэглэх тохиолдолд нэг тэсэлгээчинд хамтад нь тавьж олгохыг зөвшөөрнө.

Хий, тоосны аюултай нүүрсний давхарга болон нүүрсний үе рүү чиглэсэн тийм малталтыг, тэдгээртэй отплолцох уулзвараас 5 метрийн (шулуун зайгаар тооцсон) цаанаас эхлэн, отолж өнгөрсний дараахь 20 метр (малталтын уртаар тооцсон) хүртэл зайд зөвхөн агшны болон богино удаашралтай цахилгаан тэслүүрийг энэхүү дүрэмд заасан хий, тоосны аюултай мөргөцөгт мөрдөх шаардлагыг ханган хэрэглэнэ.

410. Тэсэлгээний нэг шпур, цооногт өөр өөр ангиллын тэсрэх бодисыг байрлуулах, тууш цэнэгт нэгээс илүү бортгон өдөөгч хэрэглэхийг хориглоно.

411. Нүүрс ба чулуулгийг тэслэхэд шпурын хамгийн бага гүн 0.6 метр байна.

412. Хоёр ба түүнээс дээш тооны боодолтой тэсрэх бодисын цэнэгийг шпурт тасалдуулахгүйгээр нэгэн зэрэг оруулж цэнэглэнэ. Бортгон өдөөгчийг араас нь тусад нь хийж болно.

413. Хий, тоосны аюултай нүүрсний болон хүдрийн мөргөцгийн шпурын цэнэгийг шавар, шавар элсний холимогоор цэнэгийн усан түгжилтийг хаах түгжилттэй хослуулан түгжинэ.

414. Нүүрс, чулуулгийн тэсэлгээний нүхний цэнэгийн хамгийн бага түгжээний хэмжээ нь бүх төрлийн түгжээний материалд дор дурдсан хэмжээтэй байна.

- а) шпурын гүн 0.6-1 метрт шпурын гүний хагастай тэнцүү;
- б) шпурын гүн 1 метрээс их бол 0.5 метр;
- в) цооногийн цэнэгийн тэсэлгээнд 1 метр байна.

415. Шpur дахь тэсрэх бодисын цэнэгээс гадарга хүртэлх зай нүүрсэнд 0.5 метрээс багагүй, чулуулагт болон овор хэтэрсэн чулуунд 0.3 метрээс багагүй байна. Нүүрсний тэсэлгээнд VI ангиллын тэсрэх бодис хэрэглэхэд дээрх зайлг 0.3 метр хүртэл багасгаж болно.

416. Зэрэгцээ байрлалтай шпурын цэнэгүүдийн хоорондын зай хүснэгт 2-д заасан үзүүлэлтүүдтэй тохирч байх ёстой.

Чулуулгийн хатуулаг $f > 10$ тохиолдолд зэрэгцээ байрлалтай шпурын цэнэг хоорондын зайг өрөмдлөг, тэсэлгээний ажлын төсөл, паспортаар тогтооно.

Хүснэгт 2. Зэрэгцээ шпурын цэнэгийг ойртуулах зөвшөөрөгдөх хэмжээ

| Тэслэх нөхцөл | Зэрэгцээ шпурын цэнэгүүдийг хооронд нь ойртуулах хамгийн бага зөвшөөрөгдөх зай, хэрэглэх тэсрэх бодисын ангилалаар, метр | | | |
|---------------|--|----------|------|-----|
| | II | III - IV | V | VI |
| Нүүрсэнд: | 0,6 | 0,6 | 0,5 | 0,4 |
| Чулуулагт: | хатуулаг $f < 7$ үед | 0,5 | 0,45 | 0,3 |
| | хатуулаг $f = 7-10$ үед | 0,4 | 0,3 | - |

417. Тоосны аюултай давхаргын нүүрсний мөргөцөгт нүүрс болон нүүрсийг хажуугийн чулуулгийн нураалттай хамт тэслэхийн өмнө мөргөцөгт болон тэслэх цэнэгээс 20 метр хүртэлх зай дахь мөргөцөгтэй холбогдсон малталтад суусан нүүрсний тоосыг занаржуулсан буюу зөвлрүүлэх хольцтой усаар шүршиж чийглэсэн байна. Тоосны тэсрэлтийн аюултай давхаргын цэвэрлэгээний мөргөцгийн нүүрсэнд тэсэлгээний ажлыг явуулахдаа мөргөцгийн догол болон хонгилыг занаржуулсан буюу зөвлрүүлсэн усаар шүршиж чийглэсэн байна.

418. Газрын тосны ялгаралтай нүүрсний уурхайд тэсэлгээний ажил явуулахдаа энэхүү дүрмийн 448-453 заалтын шаардлагыг тооцсон байна.

Доргиох тэсэлгээнд тавигдах нэмэлт шаардлага

419. Урьдчилсан болон нээлтийн үеийн судалгаагаар нүүрс, чулуулгийн, хийн гэнэтийн хаялын аюултай нь тогтоогдсон, аюултай гэсэн мэдээлэлтэй давхаргуудыг ашиглах үед хаялын аюулаас ажилчдыг хамгаалах зорилгоор доргиох тэсэлгээг тогтоосон дэглэмээр гүйцэтгэнэ. Үүнд:

а) хэвтээ, налуу (дээрээс доошоо малтах), 10⁰ хүртэл налуутай босоо малталтууд түүнчлэн цэвэрлэгээний мөргөцгийн нүүрсийг бутлахад;

б) 0.1 метрээс дээш зузаантай, гэнэтийн хаялын аюултай нүүрсний давхаргыг нээх үед;

в) урьдчилсан судалгаагаар хаялын аюултай үзүүлэлт тогтоогдсон буюу нээхийн өмнө мэдээлэл тогтоогдоогүй, аюултай байж болзошгүй нүүрсний давхаргыг нээх үед;

г) хаялын аюултай нь урьдчилсан судалгаагаар тогтоогдсон буюу хаялын аюулын судалгаа хийгдээгүй, 600 метр ба түүнээс их гүн дэх элсэнцэрийн давхаргыг нээх үед;

д) хаялын аюултай элсэн чулуулгийн давхаргад малталт явуулахад хэрэглэнэ.

Нүүрс болон хийн хаялын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор давхаргад болон давхаргын гадна талд түрүүлүүлэн торпедын тэсэлгээ хийхэд энэ дүрмийн доргиох тэсэлгээнд тавих шаардлагыг мөрдөнө.

Доргиох тэсэлгээгээр хаялаас урьдчилан хамгаалагдсан бүсийн хүрээн дэх нүүрсний давхаргыг нээх, түүнчлэн цэвэрлэгээний болон бэлтгэл малталтуудын тэсэлгээний ажилд доргиох тэсэлгээний онцгой дэглэм мөрдөхгүй.

420. Нүүрс, чулуулгийн гэнэтийн хаялын аюултай нүүрсний давхаргад малталт явуулах өрөмдлөг, тэсэлгээний ажлын паспортын үзүүлэлтүүдийг сонгохдоо нүүрс, чулуулгийг малталтын талбайн хөндлөн огтлолоор гүйцэд нураахаар тооцсон байна.

Доргиох тэсэлгээний дараа мөргөцөгт шаардлагатай хэв үүсээгүй бол, доргиох тэсэлгээг дахин хийж малталтын хэвийг гаргана.

Геологийн эвдрэлтэй малталтад нүүрс, чулуулгийн тэсэлгээг нэгэн зэрэг явуулна.

Холимог тогтоцтой мөргөцгийн нүүрсийг нь түрүүлүүлэн тэсэлж малтахад, чулуулгийн мөргөцгийн хоцролт 5 метрээс илүүгүй байна.

Зөвхөн 0.8 метр хүртэл зузаантай нүүрсний давхаргатай үед холимог тогтоцтой мөргөцөгт чулуулгийг нь түрүүлүүлэн тэслэхийг зөвшөөрнө.

421. Доргиох тэсэлгээний дараа машин, механизм, цохилтот гар өрмийн хэрэгсэл хэрэглэж малталтын хэв гаргахыг хориглоно.

422. Тэсэлгээний ажлын удирдагч нь доргиох тэсэлгээний ажил явуулах мөргөцөг тус бүрт тэсэлгээний ажил явуулах дэглэм, технологи, аюулгүй ажиллагааны зааврыг боловсруулж тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагчаар батлуулан мөрдөнө.

Тэсэлгээний үед доргиох тэсэлгээний ажлын удирдагчийн радио, утсан холбоогоор харилцсан яриа газрын гадарга дээр бичигдсэн байхаар зааварт тусгана.

423. Доргиох тэсэлгээний ажил явуулах өрөмдлөг, тэсэлгээний паспорт, заавартай тэсэлгээний ажлын удирдагч болон оролцох бүх ажилчид танилцаж, гарын үсэг зурсан байна.

424. Тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагч нь тэсэлгээний ажлын удирдагчийг томилж доргиох тэсэлгээний хугацаа, тэсэлгээний ажил явуулах журмыг баталсан байна. Доргиох тэсэлгээний ажлыг туслан гүйцэтгэгч мэргэжлийн байгууллага гүйцэтгэх бол захиалагч, гүйцэтгэгч хоёр талын хамтран боловсруулж, баталсан журмыг мөрдөнө.

Доргиох тэсэлгээний ажлын бүртгэлийн дэвтэр хөтөлнө.

Доргиох тэсэлгээ хийх газар, хугацааг газрын доор ажилладаг бүх ажилчдад тэсэлгээ эхлэхээс нэг ээлжээс багагүй хугацааны өмнө зарлан мэдээлнэ.

425. Тэсэлгээний аюултай бүсийг доргиох тэсэлгээний ажил явуулах малталтаас гарч байгаа бохир агаарын урсгалын чиглэл дэх бүх малталт болон мөргөцөгт ирж байгаа цэвэр агаарын урсгалын эсрэг чиглэл дэх тэсэлгээчний хоргodoх байр хүртэлх бүх малталтыг оруулан тогтооно.

Тэсэлгээ хийх малталтад шpur цэнэглэхийн өмнө аюултай бүсэд орсон уурхайн бүх малталтын цахилгааныг таслана. Тэсэлгээний дараа агаарын найрлагад метан хийн хэмжилт хийж, цахилгаан шугам, тоног төхөөрөмжид гэмтэл гарсан эсэхийг шалгасны дараа цахилгааныг залгана.

Доргиох тэсэлгээний үед нүүрсний давхрагын гэнэтийн хаялын аюултай бүсийн хэсгийн агааржуулалт, метан хийн найрлага болон гэнэтийн хаялын хяналтын автомат мэдрэгч зэрэг төхөөрөмжийн хүчдэлийг салгахгүй.

Усанд автах аюултай малталтад тэсэлгээний хэлхээг холбож эхлэх хүртэл хүчдэлийг салгахгүй.

426. Нүүрсний эгц уналтай, зузаан давхаргыг нээх үед давхаргын гадаргатай нийлсэн чулуулгийг цэвэрлэж нүүрсийг ил гаргахад доргиох тэсэлгээ хийж болно.

Давхаргатай нийлсэн заагийн чулуулгийг нэг удаагийн тэслэлтээр цэвэрлэнэ.

Доргиох тэсэлгээний горимд нээх малталтыг давхарга руу 4 метрээс дотогш ойртсон тохиолдолд шилжих бөгөөд давхаргаас хамгийн шулзуунаар 4 метрээс багагүй зайд холдсоны дараа энэ горимоос гарна.

Нүүрсний давхаргыг нээх малталт давхаргад ойртох, давхрагыг ил гаргах, огтлох, давхаргаас холдох гэсэн дарааллаар нээх ажиллагаа явагдана.

Гэнэтийн хаялын аюултай болон хаялын аюултай байж болзошгүй нүүрсний давхрагыг хэвтээ болон налуу малталтаар нээх үед тэсэлгээ хийх газраас тэсэлгээчний хоргodoх байр хүртэлх зайд дараахь хэмжээтэй байна. Үүнд:

- а) давхарга руу ойртох болон давхаргаас холдох үед - 600 метр;
- б) онцгой хаялын аюултай давхаргыг огтлох үед - газрын гадарга дээр;
- в) бусад тохиолдолд - 1000 метр.

Эдгээр зайлж байгаа мөргөцгөөс гарсан бохир агаарын урсгал цэвэр агаарын урсгалтай нийлэх цэгээс эхлэн цэвэр агаарын урсгалын эсрэг чиглэлд тооцно.

Ашиглалтад байгаа түвшинээс босоо амыг гүнзгийлэх үед гэнэтийн хаялын аюултай болон хаялын аюултай байж болзошгүй нүүрсний давхаргыг нээх тэсэлгээ хийх газраас хоргодах байр хүртэлх зайд дараахь хэмжээтэй байна. Үүнд:

а) отлох хэсэгт -гадарга дээр босоо амнаас 50 метр;

б) давхарга руу ойртох болон давхаргаас холдох үед ашиглалтад байгаа түвшинд бохир агаарын урсгалыг түвшинээс найдвартай тусгаарласан тохиолдолд 200 метрээс ойргүй зайд, хэрэв боломжгүй бол гадаргаас тэсэлнэ.

Гэнэтийн хаялын аюултай нүүрсний давхаргын нүүрсний болон холимог мөргөцөгт зөвхөн нүүрсний буюу нүүрс, чулуулагт нэгэн зэрэг, түүнчлэн нүүрсийг нь түрүүлүүлэн авахгүйгээр чулуулагт, хаялын аюултай чулуулгаар нэвтрэх малталтад болон тийм чулуулгийг нээх тэсэлгээ хийх мөргөцгөөс тэсэлгээчний хоргодах байр хүртэлх зайд 600 метр байна. Гэхдээ тэсэлсэн мөргөцгөөс гарсан бохир агаарын урсгал цэвэр агаарын урсгалтай нийлсэн газраас 200 метрээс ойргүй зайд байна. Тэсэлгээний ажилтай холбогдолгүй ажилчдыг тэслэх мөргөцгөөс 1000 метрээс ойргүй зайд цэвэр агаарын урсгалтай газар байрлуулна.

Гэнэтийн хаялын аюултай нүүрсний давхаргын нүүрсийг нь түрүүлүүлэн цэвэрлэсэн мөргөцгийн чулуулгийг тэслэх үед тэсэлгээчний хоргодах байр тэсэлсэн мөргөцгөөс гарсан бохир агаарын урсгал цэвэр агаарын урсгалтай нийлсэн газраас 200 метрээс ойргүй байна.

427. Доргиох тэсэлгээний ажил явуулах малталтад тэсэлгээний ажлын өмнө мөргөцгөөс 100 метр хүртэлх зайд дахь малталтын хөндлөн оттололын талбайн 1/3-ээс илүү зайд эзэлсэн тэргэнцэр болон бусад зүйлийг зайлцуулж, чөлөөлсөн байна.

428. Тэсэлгээний ажлын удирдагч нь доргиох тэсэлгээ хийхийн өмнө аюултай бусийн дотор байрлалтай агааржуулалтын тоног төхөөрөмж, түүнчлэн уурхайн өөр түвшин, хэсэгт хий нэвчихээс урьдчилан сэргийлж байрлуулсан тусгаарлах хаалтуудын бүрэн бүтэн байдлыг шалгана. Агааржуулалтын тоног төхөөрөмж гэмтэлтэй тохиолдолд тэсэлгээ хийхийг хориглоно.

429. Доргиох тэсэлгээ явуулах мөргөцөг дэх цэнэглэх зориулалтгүйгээр түрүүлүүлэн өрөмдсөн шпур, цооногийг цэнэглэх шпур, цооногийн гүнээс 1 метрээс багагүй урттайгаар шавар буюу шатдаггүй материалыар чигжиж бөглөнө. Цэнэглэх зориулалтгүй өрөмдсөн шпур, цооногийг цэнэглэж, тэслэхийг хориглоно.

430. Тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагч нь доргиох тэсэлгээний ажилд бэлтгэх, гүйцэтгэх ажлыг мөргөцөгт шууд удирдах тэсэлгээний ажлын удирдагчийг томилж, газрын дээрээс удирдана.

Тэсэлгээчин нь тэсэлгээний ажлын удирдагчийн хяналттайгаар мөргөцөгт доргиох тэсэлгээний ажлыг гүйцэтгэнэ.

Тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагч нь тэсэлгээний ажлын удирдагчид мөргөцөгт доргиох тэсэлгээ хийхийг зөвшөөрөгдсөн холбооны хэрэгсэл ашиглан газрын дээрээс өгнө.

431. Тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагч нь доргиох тэсэлгээний дараа мөргөцөг дэх метан хийн агуулгын мэдээлэл авч, мөргөцөгт үзлэг хийх зөвшөөрөл өгнө. Тэсэлгээний ажлын удирдагч нь тэсэлгээчний хамт доргиох тэсэлгээний ажил явагдсанаас хойш 30 минутаас багагүй хугацааны дараа мөргөцөг дэх метан хийн хуримтлал 2 хувиас бага үед үзлэг хийнэ.

432. Тэсэлгээний ажлын удирдагч нь доргиох тэсэлгээний дараа метан хийн хуримтлалыг хэмжин, мөргөцөг рүү ойртоходоо тэсэлгээчнээсээ 3 метрийн түрүүнд явна. Хэмжилтээр метан хийн агуулга 2 хувиас их байвал цэвэр агаарын урсгал руу яаралтай буцна.

Мөргөцөгт хийн гэнэтийн хаялын аюул гарсан тохиолдолд малталтыг хийгүйжүүлэх арга хэмжээг уурхайн удирдлага урьдчилан төлөвлөж, баталсан байна.

433. Бэлтгэл малталтын мөргөцөгт доргиох тэсэлгээний ажил явуулахын тулд зориулалтын кабельтай тэсэлгээний байнгын магистрал шугамыг байрлуулсан байна.

434. Нүүрсний ба холимог тогтоцтой мөргөцөг, хаялын аюултай чулуулгийн доргиох тэсэлгээнд цэнэгийг өдөөхдөө 220 мс-ээс ихгүй богино удаашралтай, хамгаалалттай цахилгаан тэслүүр хэрэглэнэ.

Нүүрсний давхаргыг ил гарган нээх доргиох тэсэлгээнд 320 мс-ээс ихгүй богино удаашралтай цахилгаан тэслүүр хэрэглэнэ.

435. Нэг болон хэд хэдэн цэнэг баарсан тохиолдолд тэдгээрийг тухайн доргиох тэсэлгээг гүйцэтгэсэн ээлжийн ажилтнууд устгана.

436. Нүүрсний давхаргыг доргиох тэсэлгээгээр нээх тэсэлгээнд дараахь нөхцөлийг ханган, шпурт хоёр үеэр тасалж байрлуулсан цэнэг хэрэглэж болно. Үүнд:

- а) цэнэгийг агшны болон богино удаашралтай цахилгаан тэслүүрээр өдөөх;
- б) тасалж байрлуулсан цэнэгтэй шпурын ёроолын цэнэгийн удаашралын хэмжээ амсар талын цэнэгийнхээс илүү;
- в) тухайн нөхцөлд ашиглахыг зөвшөөрсөн III, IY ангиллын тэсрэх бодисын цэнэгт тасалж байрлуулсан цэнэг хоорондын түгжээсний урт нь 0.75 метрээс багагүй, шпурын амсар талын цэнэгийн жин нь 1.2 кг-аас ихгүй. Хэрэв II ангилалын тэсрэх бодисын цэнэг хэрэглэвэл тасалж байрлуулсан цэнэг хоорондын түгжээсний урт нь 1 метрээс багагүй, шпурын амсар талын цэнэгийн жин нь 1 кг-аас ихгүй;
- г) тасалж байрлуулсан цэнэгтэй шпурын гүн 3 метрээс багагүй байна.

437. Нүүрсний давхаргыг нээх, огтлохдоо давхаргыг нээх зориулалттай малталтын мөргөцөг, нүүрсний давхарга хоорондын чулуулгийн зузаан нь давхарга хүртэлх хамгийн бага зайгаар тооцоход эгц уналтай давхаргад 2 метрээс багагүй, хэвтээ, налуу, эгц налуу уналтай давхаргад 1 метрээс багагүй байх үед доргиох тэсэлгээ хийнэ.

Босоо ба эгц налуу уналтай давхаргыг хөндлөн огтлохын өмнө давхаргыг нээх малталтын мөргөцөг болон угаагдаж үүссэн хөндийн хоорондох чулуулгийн зузаан

1.2 метрээс багагүй байна. Усан угаалгын дараа мөргөцөгт үлдсэн чулуулгийг тэслэхдээ шпурыг угаагдсан хөндий хүртэл 0.5 метр зай үлдэхээр дутуу өрөмдөнө.

438. Босоо болон эгц налуу уналтай, хаялын аюултай, нурамтгай давхаргаар нэвтэрч буй бэлтгэл малталтын мөргөцөгт доргиох тэсэлгээний ажлыг явуулахдаа хажуугийн чулуулгийг түрүүлж нураан, нүүрсний давхаргад бэхэлгээ тавина.

Өрөмдлөг, тэсэлгээний паспортод түрүүлж тавих бэхэлгээнээс 0.5 метрийн зайд тэсэлгээний шпурын дээд эгнээг байрлуулахаар тусгана.

439. Торпедлох цооногийн цэнэгийг тэслэхдээ аюулгүй ажиллагааны дараахь нэмэлт арга хэмжээг авна. Үүнд:

а) давхаргад торпедийн тэсэлгээ (усан тэсэлгээний боловсруулалт) хийхдээ-налуу өрөмдсөн цооногт тасралтгүй тэжээлтэй ус цутгах түүнчлэн полиэтилен савтай усыг тэсэлж тоосруулсан усан тоосролтын хөшгийг тохирсон норм зааврын дагуу хэрэглэх;

б) эхний (давхаргын гаднах) торпедын тэсэлгээ хийхдээ-кооногийг карбамид, калийн хлоридийн 3:1 харьцаатай чийглэсэн хольцын түгжээс буюу полиэтилен ууттай усан түгжээсийг нягтруулагчтай хэрэглэх түүнчлэн усан мананцарын болон усан хөшгийг тохирсон норм, зааврын дагуу хэрэглэх.

440. Онцгой хяналттай, агааржуулалттай малталтын нэг мөргөцгийн тэсэлгээгээр бусад мөргөцөг рүү явсан цахилгааны шугамыг гэмтээхүйц байрлалтай тохиолдолд:

а) бүх мөргөцгийн доргиох тэсэлгээний хэлхээнд гүйдлийг нэгэн зэрэг өгнө;

б) мөргөцгийг дараалан өөр өөр хугацаанд цэнэглэж тэслэх бол өмнөх тэсэлгээний ажлыг дуустан аюулгүй ажиллах нөхцөлийг хангаж дараагийн мөргөцөгт тэсэлгээ хийнэ.

441. Доргиох тэсэлгээнд нүүрсний шпурыг зөвхөн эргэлтэт өрмөөр өрөмдөнө. Чулуулгийн шпурыг цохилтот болон цохилтот эргэлтэт өрмөөр өрөмдөж болно.

Камуфлетийн тэсэлгээний арга

442. Уулын цохилтын аюултай давхаргын захын хэсгийн цохилтын аюулгүй байдлыг буй болгоходо камуфлетийн тэсэлгээний арга (битүү тэслэлт) хэрэглэнэ.

Камуфлетийн тэсэлгээ явуулахад дараахь дараалсан ажлуудыг мөрдлөг болгоно.

а) тэсэлгээ хийх малталтын захын хэсгийн уулын цохилтын аюулд үнэлэлт өгөх;

б) камуфлетийн тэсэлгээний үндсэн үзүүлэлт (шпурын урт, цэнэгийн жин, шпур хоорондын зайд)-ийг тодорхойлох;

в) камуфлетийн тэсэлгээний үр дүнг тодорхойлох.

Эдгээр нь нүүрсний уурхайн давхаргад ашиглалт явуулах аюулгүй ажиллагааны зааварчлагатай нийцсэн байна.

443. Камуфлетийн тэсэлгээний ажлыг тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагчийн баталсан тусгай төслөөр явуулна.

444. Уулын цохилтын аюултай нүүрсний давхаргын цэвэрлэгээний болон бэлтгэл малталтын мөргөцгийн түүнчлэн нүүрсний цулыг ашиглах тэсэлгээ хийхдээ ажилчдыг тэсэлгээ хийх мөргөцгөөс 200 метрээс багагүй зйтай, цэвэр агаарын урсгалтай малталтад байрлуулна.

445. Угтуулан хоёр талаас нь малтаж байгаа мөргөцөг хоорондын цулын зайд 15 метр болоход тэсэлгээний ажлыг нэг мөргөцөгт явуулж, нөгөө мөргөцөгт явуулахгүй.

446. Камуфлетийн тэсэлгээ хийх үед цооногийн урт нь 10 метр хүртэл байвал цэнэгийн дотоод түгжээсний уртыг төслөөр тодорхойлох ба цооногийн уртын хагасаас багагүй байна. Цооногийн урт нь 10 метрээс урт байвал цэнэгийн түгжээсийн урт 5 метрээс багагүй байна. Усан түгжээс түүн дотроо полиэтилен ууттай ус хэрэглэх үед нүхний амнаас 1 метрээс багагүй зайлшвалаар түгжинэ.

447. Уулын чулуулгийн цохилтын I, II зэрэглэлийн аюултай цэвэрлэгээний болон бэлтгэл малталт дахь нүүрс, чулуулгийн тэсэлгээний ажлыг тухайн хэсгийг цохилтын аюулгүй болгосны дараа явуулахыг зөвшөөрнө.

Газрын тосны уурхайд явуулах тэсэлгээний ажлын онцлог

448. Газрын тосны далд уурхайд тэсэлгээний ажил явуулахад дараахь шаардлагыг хангасан байна. Үүнд:

а) зөвхөн цэвэр агаарын урсгалтай, газрын тосны орд газрыг гүний уурхайгаар ашиглах аюулгүй ажиллагааны дүрмээр тогтоосон норм, хэмжээнээс тэсрэмтгий хийн хуримтлал нь хэтрээгүй мөргөцөгт;

б) III-аас дээш ангиллын, хамгаалалттай тэсрэх бодис хэрэглэх;

в) цэнэгийг агшны болон богино удаашралтай, хамгаалалттай цахилгаан тэслүүрээр өдөөх. Удаашралтын дээд хугацаа нь богино удаашралтай цахилгаан тэслүүрт 220 мс-ээс ихгүй байх;

г) бүтээгдэхүүн агуулсан давхаргад тэсэлгээ хийхдээ хамгаалалтын орчинг урьдчилан бүрдүүлсэн байх.

Ил цэнэг ба цочир дамжуулах шижмийг газрын тосны агуулгагүй, хийн ялгаралгүй, чулуулгаар нэвтрэх малталтын мөргөцөгт хэрэглэж болно.

449. Шпур цэнэглэх болон цэнэгийг тэслэхийн өмнө тэсэлгээ явуулах мөргөцөг түүнээс 20 метр хүртэл зайд байрлалтай холбоос малталт мөн тэсэлгээчний хордох байранд тэсрэмтгий хийн агуулгын хэмжилт хийнэ.

450. Тэсэлгээний ажлын удирдагч нь газрын тосны бүтээгдэхүүн олборлох давхаргад тэсэлгээ хийх тэсэлгээчний даалгаврын хуудсан дээр тэслэхийг зөвшөөрсөн тэмдэглэлийг бичгээр хийнэ.

451. Өрөмдсөн шпурээс хөнгөн газрын тос ба хийн ялгарал илэрч байвал шпурыг цэнэглэж, тэслэхийг хориглоно. Шпурыг шавраар бөглөнө. Хөнгөн газрын тосны ялгаралтай бүх малталь, мөргөцгөөс 20 метр зйтай талбайг тусгаарлаж ялгарал илэрсэн мөргөцөт элс асана.

452. Тэсэлгээний шпурыг цэнэглэх нөхцөл, тэсрэх бодисын цэнэгийн жин, түгжээсний урт нь дараахь шаардлагад нийцсэн байна. Үүнд:

- а) бүтээгдэхүүн олборлох давхаргад 1 метрээс богино шпур хэрэглэхийг хориглоно;
- б) 1-1.5 метр гүнтэй шпур дэх цэнэгийн урт нь шпурын гүний хагасаас ихгүй байх бөгөөд шпурын үлдсэн зайлт түгжээсээр дүүргэнэ;
- в) 1.5 метрээс илүү гүнтэй шпур дэх цэнэгийн урт нь шпурын гүний 2/3-оос ихгүй байх бөгөөд үлдсэн зайлт түгжээсээр дүүргэнэ;
- г) боодолтой тэсрэх бодисыг шпурт энэхүү дүрмийн 412-ын дагуу байрлуулна;
- д) хэд хэдэн нээлттэй гадаргуутай мөргөцөт цэнэгээс гадарга хүртэлх хамгийн бага эсэргүүцлийн шугамын хэмжээ нь газрын тосны бүтээгдэхүүн олборлох давхаргад 0.5 метрээс багагүй, чулуулгийн давхаргад 0.3 метрээс багагүй байна.

Шпурын цэнэг хоорондын хамгийн бага зайл нь энэхүү дүрмийн 416-д нийцсэн байна.

453. Бүтээгдэхүүн олборлох давхаргад мөргөцөг тус бүрт хоёр усан шүршүүр тоноглож, мөргөцгөөс 8 метрээс холгүй зйтай байрлуулан галын хоолойд холбоно. Цэнэгийг тэслэхээс 5 минутын өмнө усан шүршүүрийг ажиллуулж эхэлнэ.

Газрын доорх малтальтанд цэнэг бөөнөөр тэслэх тэсэлгээний
ажил гүйцэтгэхэд тавих аюулгүй ажиллагааны
нэмэлт шаардлага

454. Хүдрийн болон нүүрсний далд уурхайд бага хэмжээний тэсэлгээтэй харьцуулахад агааржуулах болон тэсэлгээний дараахь ажлыг сэргээхэд илүү их цаг хугацаа шаардагдах хэмжээний тэсэлгээний ажлыг бөөн тэсэлгээний ажил гэнэ. Бөөн тэсэлгээний ажлыг зориулалтаар нь технологийн, тусгай зориулалтын, туршилтын гэж ангилна. Үүнд:

- а) технологийн бөөн тэсэлгээний ажилд уулын цулыг бутлан нураах, цэвэрлэгээний мөргөцгийн тааз, хамгаалалтын цулыг дэд давхараар нураах зэрэг нэг маягаар олон давтагдан хийгддэг тэсэлгээ орно;
- б) тусгай зориулалтын бөөн тэсэлгээний ажилд блокийн камерын таазыг нураах, камер хоорондын хамгаалалтын цулыг давхарын өндөрөөр нь бутлах, блокод үүссэн хөндийг тэслэж дарах, аваарийн нөхцөлийг аюулгүй болгох зэрэг тэсэлгээ орно;
- в) туршилтын бөөн тэсэлгээний ажилд бөөн тэсэлгээний үеийн өрөмдлөг, тэсэлгээний ажлын хэмжээс, үзүүлэлтийг оновчлох чиглэлээр хийгдэж буй тэсэлгээ орно.

455. Бүх төрлийн бөөн тэсэлгээний ажлын нэг маягийн төсөл, паспортод дараахь зүйлсийг тусгана. Үүнд:

- а) тэсэлгээний ажил явуулах орд газрын уул-геологийн нөхцөлийн тодорхойлолт;
- б) өрөмдлөгийн болон тэсэлгээний техник, тоног төхөөрөмж болон тэсрэх материалыг сонгосон үндэслэл;
- в) өрөмдлөг, тэсэлгээний ажлын хэмжээ, үзүүлэлтийн өрөнхий тооцоо, тооцоолсон аргачлал;
- г) цэнэгийг өдөөх хэрэгслийн болон цэнэгийн бүтэц;
- д) тэсэлгээний ажилд хэрэглэгдэх багаж төхөөрөмж болон тэсэлгээний ба хяналт-хэмжилтийн багаж хэрэгслийг сонгож авсан үндэслэл;
- е) тэсэлгээний хэлхээний холболт түүнийг тооцоолсон аргачлал, агааржуулалтын хугацаа, аюултай бүсийн тооцоог тэсэлгээнд бэлдэх, тэсэлгээ явуулах үе шатуудаар хийсэн аргачлалын хамт;
- ё) тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааг хангахад тухайн байгууллагаас гаргасан шийдвэрээр хэрэгжүүлэх арга хэмжээ, тухайлбал хамгаалах хэрэгсэл, тухайн уул-техникийн нөхцөл дэх хориотой бүсэд аюулгүй ажиллагааны чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ зэрэг болно.

456. Технологийн нэг загварын төсөл болон тусгай зориулалтын мөн туршилтын бөөн тэсэлгээний ажлын төслийг тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагч батална. Тэсэлгээний ажлыг гэрээт байгууллага гүйцэтгэх бол төслийг захиалагч, гүйцэтгэгч байгууллагын хамтарсан шийдвэрээр томилогдсон тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагч тэсэлгээний ажлыг аюулгүй явуулах, тэсрэх материал хадгалах тухай журмыг батална.

457. Технологийн бөөн тэсэлгээний ажлын төслийн техникийн тооцоог энэхүү дүрмийн хавсралт №8-ийн дагуу хийж тэсэлгээний үзүүлэлтүүдийг хүснэгтээр гаргах ба тэсэлгээний ажлын тооцоолол, зохион байгуулалтын бичиг баримтууд болон зургуудыг хавсаргах бөгөөд тэсэлгээ явуулах зохион байгуулалт, ажилбарын дарааллыг энэхүү дүрмийн хавсралт 9-ийн дагуу гаргаж хавсаргасан байна.

Дээрх төслийн удиртгал хэсэгт бөөн тэсэлгээний ажлыг явуулах тухай шийдвэр, явуулах газар, эхлэх цаг хугацаа, тэсэлгээний ажлын удирдагчийн нэрийг заасан байна.

Төслийн техникийн тооцооны хэсэгт тэсэлгээний мэдээлэл, өгөгдлүүдийг эмх цэгцтэй гаргахаас гадна тодорхой үзүүлэлтүүдийг хүснэгтээр үзүүлнэ.

Төслийн тэсэлгээний ажил явуулах зохион байгуулалт, ажилбарын дарааллыг энэ тухай баталсан шийдвэрт тусгах бөгөөд үүнд тэсэлгээний ажлын зохион байгуулалтыг тэсэлгээний ажлын бэлтгэл үе, тэсэлгээ хийх ажилбар бүрээр гаргах ба мөн тэсэлгээний үед газрын доорх тухайн малталтад болон тэсэлгээний ажлын бүсэд ажилчдын аюулгүй байдлыг хангах арга хэмжээ зэргийг тусгасан байна.

Технологийн бөөн тэсэлгээний ажлын төсөлд тэсэлгээ явуулах хэсгийн малталт, блок, панель, түвшингийн план зураг болон шаардлагатай зүсэлтүүд ба цэнэглэх

малтальын байрлалын зураг, тэсэлгээний хэлхээний бүдүүвч зураг, малтальын агааржуулалтын бүдүүвч болон шаардлагатай тооцоо, тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагчийн баталсан бөөн тэсэлгээний ажил явуулахад техникийн бэлэн байдлын тухай акт бүрдүүлэх болон бөөн тэсэлгээний ажлыг бэлтгэж явуулахыг удирдах болон гүйцэтгэхээр томилогдсон ажилтнуудын нэрсийн жагсаалтыг хавсаргана.

458. Тусгай зориулалтын бөөн тэсэлгээний ажлын төсөлд энэхүү дүрмийн 454, 455-д заасан мэдээлэл, үзүүлэлтээс гадна:

- а) тэсэлгээ хийх объектын хэмжигдэхүүн ба байдал;
- б) цооногийн дагуух цэнэгийн байдал;
- в) блокийн босоо талын хананы, аль эсвэл таазны ил гарах гадаргын талбай;
- г) хажуугийн жижиг малтальтуудын болон зэрэгцээ блокуудын, мөн блокод орох малтальтуудын камер хоорондын цулуудын төлөв байдал;
- е) чулуулгийн нураалтын өндөр, завсрын блокуудын төлөв байдлыг тус тус тодорхойлсон байна.

Тусгай зориулалтын бөөн тэсэлгээний ажил хийхдээ газрын гадаргын топо зураг, гадарга дээр болон доор ойролцоо орших байгууламжууд, болзошгүй нурлын бүсийн зураг, ойролцоо усны хуримтлал, ус тээгч давхарга зэргийн нөлөөллийг тооцсон байна.

Тусгай зориулалтын бөөн тэсэлгээний ажлын төсөлд энэхүү дүрмийн хавсралт №8-д заасан баримт бичгээс гадна дараах зургуудыг хавсаргана. Үүнд:

- а) тэсэлгээний аюултай бүсийг тогтоож, харуулын байрыг тэмдэглэсэн ерөнхий дэвсгэр зураг;
- б) цэнэглэлтийн үеийн аюултай бүсийг тогтоож, харуулын байршилыг тэмдэглэсэн дээд болон доод тээврийн түвшний дэвсгэр зураг;
- в) уурхайн (зэрэгцээ уурхай)-н агааржуулалтын схем;
- г) тэсэлгээний чичирхийллийн бүсэд орсон объектыг тэсрэх цэнэгтэй холбосон шугамын дагуух геологийн зүсэлт.

Бөөн тэсэлгээний ажлын төсөл боловсруулах үеийн малталь болон объектын төлөв байдлыг тодорхойлсон зургийг маркшейдерийн ажлын стандарт, шаардлагын дагуу боловсруулж гаргана.

Тусгай зориулалтын бөөн тэсэлгээний ажлын баталсан төсөлд энэхүү дүрмийн хавсралт №9-д зааснаас гадна тодорхой нөхцөлийг тооцсон аюулгүй байдлыг хангах арга хэмжээ, түүнийг гүйцэтгэх журам, хугацааг заасан байна.

459. Туршилтын бөөн тэсэлгээний ажлын төслийг технологийн болон тусгай зориулалтын бөөн тэсэлгээний ажилд шаардлагатай асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор хийнэ.

460. Туршилтын бөөн тэсэлгээний ажил явуулах тухай шийдвэрийг байгууллагын удирдлага гаргана. Тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагчийг ийм төрлийн бөөн тэсэлгээний ажил явуулах тухай бүр томилно.

461. Дэд давхарга, блок, панелийг нураах тэсэлгээнд зориулсан цооног, шпурыг өрөмдөж, цэнэгийн хонгилыг малтаж дуусгаад, уулын цулд маркшайдерийн хэмжилт хийж, цэнэглэх цооног, шпур, хонгилын бодит байдлыг харуулсан дэвсгэр зураг, зүсэлтийг боловсруулна.

462. Бөөнөөр тэслэхээр бэлтгэсэн дэд давхарга, блок, панелийг байгууллагын баталсан бөөнөөр тэсэлгээ хийх журмын дагуу шалгана.

463. Тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагч нь бөөн тэсэлгээний ажил бэлэн болсон тухай акттай танилцаж, тэсэлгээнд оролцогч ажилтнуудад холбогдох бичиг баримт, гүйцэтгэх үүрэгтэй нь танилцуулж, тэсэлгээний ажилд оролцох, тэсрэх материалтай харьцах аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгнө.

Тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагч нь байгууллагын холбогдох албадын оролцоотойгоор тухайн тэсэлгээний ажлыг гүйцэтгэх дэглэм, хугацаа, ажилтнуудыг гүйцэтгэх үүргийг төслийн дагуу тодорхойлж, баримт бичгийг бүрдүүлнэ.

464. Тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагч нь бөөн тэсэлгээний ажил явуулах төслийг тухайн байгууллагын аврах нэгжид танилцуулж, аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө, аврах ажиллагааны журмыг зөвшилцэж тохиролцсон байна.

465. Цэнэглэлтийг аюулгүй ажиллагааны шаардлагыг чанд баримтлан гүйцэтгэнэ. Бөөн тэсэлгээний ажлын цэнэглэлтийн бодит үзүүлэлтүүдийг төслийн үзүүлэлтийн хүснэгтийн дагуу бөглөнө. Тэсрэх материал хүргэх, цэнэглэх ажилтнууд амь хамгаалах тусгаарлагч багтай байна.

466. Цэнэглэлтийн бүс, цэнэглэх төхөөрөмж байгаа газар дахь агаарын урсгалын хурд нь газрын доорх малталтуудыг агааржуулах шаардлагад нийцсэн байна.

467. Газрын доорх бөөн тэсэлгээний ажлын дараахь шалгалтыг авран хамгаалах үүрэгтэй баг гүйцэтгэж, уурхайн бүх малталтуудын агааржуулалтыг сэргээн хэвийн цэвэр агаарын урсгалтай болгосны дараа, тэсэлгээний ажлын удирдагч болон ажилтнуудыг малталаад орохыг зөвшөөрнө.

468. Тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагч нь аврах хамгаалах үүрэгтэй багаас бөөн тэсэлгээний ажлын дараахь үзлэг, хэмжилтийн үзүүлэлтүүд, бусад шаардлагатай мэдээллийг авсны дараа тэсэлгээ хийсэн бүс, жигүүрийн малталаад ажиллах ажилтнуудыг оруулах зөвшөөрлийг өгнө.

469. Бөөнөөр тэсэлгээний ажил явуулсан уулын малталаад эхний ээлжинд ажиллах тухайн хэсгийн удирдлага эсхүл түүний орлогч нь малтальтын аюулгүй байдлыг биечлэн шалгаж байна.

470. Бөөн тэсэлгээний ажил явуулсан бүс, жигүүрийн малталауд, тухайн бүсэд холбогдсон малталаудыг байгууллагын удирдлагын тогтоосон хугацаагаар хяналттай байлгана.

Тэсэлгээний ажлын удирдагч нь малталтын бэхэлгээ, хана, таазны тогтвортой байдал болон агааржуулалтад хяналт тавина. Малталтын даралт, нурал бүхий аюулын шинж илэрвэл ажилчдыг аюулгүй газарт гаргаж, уурхайн диспетчер, удирдлагад мэдэгдэнэ.

471. Бөөн тэсэлгээний ажлаар бутлагдсан уулын цулыг малтахдаа, түүний дотор тэсрэх материал байгаа, эсэхийг магадлан шалгаж байна.

472. Бөөн тэсэлгээний ажил явуулж буй хэсэгт ойр газрын гадарга дээр цөмрөл, нурал гарч болзошгүй бүсийг маркшейдерийн хэмжилтээр тогтоож, тойруулан хашаалж, хүн орохоос сэргийлнэ.

ДАЛД УУРХАЙН ХИЙН ЦЭНЭГЛЭГЧЭЭР МӨХЛӨГТ ТЭСРЭХ БОДИСЫГ ЦЭНЭГЛЭХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ШААРДЛАГА

Үндсэн нөхцөл

473. Газрын доорх малталтад шпур, цооног, хонгилыг хийн төхөөрөмжөөр цэнэглэхдээ цэнэглэгч машин, төхөөрөмжийг ашиглах заавар, тухайн төхөөрөмжөөр цэнэглэхэд тохирсон тэсрэх бодисыг хэрэглэх заавар, түүнчлэн цэнэглэгч төхөөрөмжийн үйлдвэрлэгчийн болон тэсэлгээний ажил гүйцэтгэгч байгууллагын боловсруулсан цэнэглэгч машин дээр ажиллах ажилтнуудын мөрдөх аюулгүй ажиллагааны шаардлага, зааварчилгаа, мөн энэхүү дүрмийг мөрдөж ажиллана.

474. Цэнэглэгч төхөөрөмж нь тэсрэх бодисын зарцуулалтыг хэмжих, шаардлагатай тохиолдолд тэсрэх бодисын тоосрол үүсгэхээс хамгаалсан чийгшүүлэх нэмэлт төхөөрөмжтэй, ажлын аюулгүй байдлыг хангах цэнэглэх ажиллагааны удирдлагын системтэй байна.

475. Бүтэцдээ нитроэфир, гексоген, тэн болон гадаад орчны үйлчлэлд гранулотол (тротил)-оос илүү мэдрэмтгий шинж чанартай мэдрэгжүүлэгч агуулсан мөхлөгт тэсрэх бодисыг хийн цэнэглэгчээр цэнэглэхийг хориглоно.

476. Хий, тоосны аюултай хүдэр болон нүүрсний далд уурхайд тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагчийн баталсан аюулгүй ажиллагааны нэмэлт шаардлагыг хангахаар бол мөхлөгт аммиакийн шүүний тэсрэх бодисыг хийн төхөөрөмжөөр цэнэглэж болно.

477. Мөхлөгт тэсрэх бодис болон түүний найрлагад орох бодисыг норгож, чийглэхгүйгээр хийн хоолойгоор хүлээн авах бункер, тэргэнцэр рүү дамжуулан тээвэрлэж болно. Ингэхдээ тоос дарах, статик цэнэг үүсэхээс хамгаалах арга хэмжээг заавал авах шаардлагатай.

478. Задгай, мөхлөгт тэсрэх бодисыг хүлээн авах бункер рүү хийн төхөөрөмжөөр дамжуулан тээвэрлэх зайд 20 метрээс их болон илгээх хэсэг болон хүлээн авах хэсэгт ажиллаж буй операторууд бие биендээ шууд харагдахгүй байрлалтай, мөн хоёр талын холбоогүй нөхцөлд хийн тээвэрлэлт хийхийг хориглоно.

Хийн цэнэглэгч төхөөрөмжид тавих шаардлага

479. Хийн цэнэглэгч төхөөрөмж ашиглагч байгууллага нь цэнэглэгч төхөөрөмжийн эвдрэл гэмтэлгүй ажиллагааг хариуцагч ажилтныг томилж, цэнэглэгч төхөөрөмжид засвар, үзлэг үйлчилгээ явуулах журмыг тогтоосон байх шаардлагатай.

480. Хийн цэнэглэгч төхөөрөмж нэг бүрт техникийн байдалд хийсэн үзлэг, түүний ажиллагааны үзүүлэлтийг бүртгэх дэвтрийг энэхүү бүлгийн хүснэгт 3-ын дагуу нээж, хөтөлнө. Техникийн үзлэгийн дэвтрийн хуудсыг дугаарлан үдэж, байгууллагын тэмдэг дарсан байна.

Хүснэгт 3. Цэнэглэгч төхөөрөмжийн ажиллагааны болон техникийн байдлын бүртгэлийн дэвтэр

Цэнэглэгч төхөөрөмжийн нэр _____
Эд бүртгэлийн дугаар _____

| Огноо | Ээлж | Цэнэглэгч төхөөрөмжийн техникийн байдлын ажлын өмнөх шалгалт түн дүнэлт | Шалгасан хүний нэр, гарын үсэг | Тоног төхөөрөмжийг ажиллуулахыг зөвшөөрсөн хяналтын ажилтны нэр, гарын үсэг | Ажилласан цаг | Цэнэглэсэн тэсрэх бодисын хэмжээ, кг | Ажиллах явцад тоног төхөөрөмжид гарсан гэмтэл | Цэнэглэсэн ажилтны нэр, гарын үсэг | Тайлбар |
|-------|------|---|--------------------------------|---|---------------|--------------------------------------|---|------------------------------------|---------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |

Бүртгэлийн дэвтэр хэсгийн даргад байна. Ажлын цагаар бүртгэлийн дэвтрийг цэнэглэгч машин дээр операторын хариуцлагад байлгана. Бүртгэлийн дэвтрийн хуудсыг дугаарлаж, байгууллагын аюулгүй ажиллагааны хяналтын алба баталгаажуулсан байна. Бүртгэлийн дэвтрийн хөтлөлт нь холбогдох ажилтанд техникийн паспорт хөтлөхгүй байх шалтгаан болохгүй.

481. Цэнэглэгч төхөөрөмжийн техникийн байдалд үзлэг, шалгалт хийж, тухай бүр үзлэгийн дэвтэрт тэмдэглэнэ. Үүнд:

- а) цэнэглэгч төхөөрөмжийг ашиглалтад оруулахын өмнө болон цэнэглэх ажиллагаа бүрийн өмнө;
- б) цэнэглэлт дууссаны дараа;
- в) ашиглалтын үйл ажиллагаанаас шалтгаалан цэнэглэгч төхөөрөмжийг удаан хугацаанд ажиллуулахгүй зогсоохоор хадгалалтанд тавихын өмнө буюу өөр байгууллагад шилжүүлэх үед;
- г) бүх төрлийн засвар хийсний дараа;
- д) тухайн цэнэглэгч төхөөрөмжийг эзэмшигч байгууллагын ажилтны ээлжит үзлэг шалгалт.

482. Цэнэглэгч төхөөрөмжийг засварт шилжүүлэх, оруулахын өмнө тэсрэх бодисын үлдэгдлийг цэвэрлэсэн төхөөрөмжийн эд ангиудыг угаан цэвэрлээд угсарсан байх шаардлагатай.

483. Цэнэглэгч төхөөрөмжийн засварын үед тухайн машиныг зохион бүтээгч байгууллагын зөвшөөрөлгүйгээр бүтэц, материалд нь ямар нэгэн өөрчлөлт оруулахыг хориглоно.

484. Цэнэглэгч төхөөрөмжид хийсэн засварыг түүний бүртгэлийн дэвтэрт тэмдэглэнэ.

485. Цэнэглэгч төхөөрөмжийн ашиглалт, засварын үйл ажиллагааны явцад тэсрэх бодистой харьцаж байгаа хэсгийн төмөр гадаргууг цохих, үрэх, хусах зэрэг үйлдэл хийхийг хориглоно.

Газардуулга хийх болон статик цэнэг үүсэхээс хамгаалахад тавих ерөнхий шаардлага

486. Бүх цэнэглэгч төхөөрөмжүүд ба тэсрэх бодис дамжуулах хоолойнуудыг газардуулсан байна. Цэнэглэгч төхөөрөмжийн эд ангийн хэлхээнүүд болон эд ангиуд хоорондоо цахилгаан үл дамжуулах жийргэвч, холбоосгүй байна. Нэг удаагийн шахалтандaa 5 кг хүртэл мөхлөгт тэсрэх бодис шахдаг, хэмждэг тоолууртай, 5 метр хүртэл урттай цэнэглэх металл хоолойтой, статик цэнэг үүсгэдэгүй материалыар бүтээгдсэн хийн цэнэглэгч төхөөрөмжид зориулалтын газардуулга хийхгүй байж болно.

487. Тротил, хөнгөн цагааны нунтгаар хүчитгэсэн мөхлөгт тэсрэх бодисыг урьдчилан чийгшүүлэхгүйгээр хийн цэнэглэгч төхөөрөмжөөр цэнэглэхийг хориглоно.

488. Бүх төрлийн цэнэглэгч төхөөрөмжид тэсрэх бодисын цэнэглэлтэнд усаар чийгшүүлэх ба түүнийг хянах багаж байрлуулан тоноглосон байж байна. Тэсрэх бодисыг зөвхөн цахилгаан дамжуулах шинж чанартай эсвэл статик цэнэг үүсгэхгүй материалыар хийгдсэн хоолой ашиглан даралттай хийгээр шахаж болно. Механикjuулсан цэнэглэлтэд ашиглах хоолойнууд нь 10^4 Ом/м-ээс ихгүй хувийн цахилгаан эсэргүүцэлтэй байна.

489. Энгийн найрлагатай мөхлөгт тэсрэх бодисоор шпурыг цэнэглэхэд 10^7 Ом/м-ээс ихгүй хувийн эзлэхүүний цахилгаан эсэргүүцэлтэй полиэтилин болон резинин хоолой (шланг) хэрэглэж болно.

490. Механикжсан цэнэглэгч төхөөрөмж хэрэглэхийн өмнө дамжуулах хоолойнуудын эсэргүүцлийг шалгана.

491. Механикжсан цэнэглэгч төхөөрөмжид үйлдвэрлэгчийн зөвлөсөн зориулалтын дамжуулах хоолойг ашиглах ба бусад зориулалтаар хэрэглэхийг хориглоно.

492. Өөр өөр төрлийн тэсрэх бодисыг хийн цэнэглэгч төхөөрөмжийн нэг хоолойгоор шахахыг хориглоно.

493. Газрын доорх малталтын агаарын харьцангуй чийглэг 70 хувиас дээш үед 7 метрээс уртгүй, цахилгаан дамжуулах чанартай металл цэнэглэх хоолой бүхий хийн цэнэглэгч төхөөрөмжөөр зориулалтын газардуулгагүйгээр шпурыг цэнэглэж болно.

494. 10^4 Ом/м-ээс дээш хувийн цахилгаан эсэргүүцэл бүхий чулуулагтай мөргөцөгт, агаарын харьцангуй чийглэг 70 хувиас бага үед, газардуулга бүхий цахилгаан дамжуулах шинж чанартай хоолой хэрэглэхийн зэрэгцээ, мөргөцөгт ус цацаж, цооногийг усаар угаан, газардуулга хийх газрыг нортосон байна. Мөргөцгийн агаарын харьцангуй чийглэгийг хийн цэнэглэгч хэрэглэж эхлэх үед тодорхойлж, цаашид улиралд нэгээс доошгүй удаа шалгаж байна. Хэмжилтийн үр дүн чулуулгийн цахилгаан эсэргүүцлийг бүртгэлийн дэвтэрт тэмдэглэнэ.

495. Цэнэглэлтийн өмнө бүх цэнэглэгч төхөөрөмж ба дамжуулах хоолой (энэ дүрэмд газардуулгагүй байж болохоор зааснаас бусад)-д хэсгийн газардуулга хийж, ерөнхий газардуулга болон цахилгаан төхөөрөмжүүдийн газардуулгын нэгдсэн байгууламжид холбосон байна. Хэсгийн газардуулгыг тухайн газардуулах байгууламжаас 20 метрээс ихгүй зайд байрлуулна.

496. Хэсгийн газардуулгын газардуулагчаар 2 мм-ээс багагүй зузаан, 0.06 м²-аас багагүй хөндлөн огтлолтой ган тууз буюу 25 мм-ээс багагүй голчтой, 0.3 метр урттай ган хоолой ашиглана. Ган туузан газардуулагчийг ус зайлцуулах сувганд буюу малтальтын уланд устай газарт гүнзгийрүүлж суулгана. Ган хоолойгоор хийсэн хэсгийн газардуулагчийг 0.25 метрээс багагүй гүнтэй шпурт байрлуулна.

497. Газардуулгын дамжуулагч холбоосоор 15 мм²-аас багагүй огтлолтой бөөрөнхий ган утас буюу ган татлага хэрэглэнэ.

498. Цэнэглэгч төхөөрөмж суурилуулсан өөрөө явагч машиныг цэнэглэлт хийх газрын хэсгийн газардуулгад холбон газардуулахаас гадна машин нь малтальтын уланд 25 см-ээс багагүй урттай хэсэг нь унаж байх газардуулгын гинжтэй байна.

499. Цэнэглэгч машин дээр газардуулгын утас холбох зориулалтын боолт, гайк (боолтны голч 8 мм-ээс багагүй)-тай байх бөгөөд газардуулгын утсыг цэнэглэх хоолойд 25 мм²-аас багагүй хөндлөн огтлолтой ган төмөр туузан хомуутаар мөн адил боолт, гайкаар бэхэлнэ.

500. Дамжуулах хоолойнд угсарсан металл муфтыг газардуулсан байна. Дамжуулах хоолойнд залгасан тусдаа хэсэг хоолой, түүнчлэн муфт, жийргэвч, шайбын цахилгаан эсэргүүцэл нь үндсэн дамжуулах хоолойныхоос их байж болохгүй.

501. Цэнэглэх системийн цахилгаан эсэргүүцлийг газардуулгын байгууламжтай харьцуулахад 10^7 Ом-оос ихгүй, харин газардуулгын байгууламж нь цэнэглэх системийнхээс 100 Ом-оос ихгүй байна.

502. Ажил эхлэхийн өмнө цэнэглэгч төхөөрөмж ба хоолойнуудын үзлэг, газардуулгын гинжин хэлхээний эсэргүүцлийн хэмжилтийг хийж, үзлэг, хэмжилтийн дүнг техникийн үзлэгийн дэвтэрт тэмдэглэнэ.

Тэсрэх бодисын тоосролтоос урьдчилан
сэргийлэх арга хэмжээ

503. Механикуулсан цэнэглэлтийн явцад тэсрэх бодис асгарах, орчны агаарт тархах, хүн хордуулах, тэсрэлтийн аюултай тоосролт үүсэх, түүнчлэн статик цэнэг үүсэхээс хамгаалах арга хэмжээг авах шаардлагатай.

504. Тэсрэх бодисын тоосролт, асгаралтыг багасгахын тулд дараахь арга хэмжээг авна. Үүнд:

а) цэнэглэх хоолойн хошууг цэнэглэж байгаа цооногийн төвд чиглүүлэх;

б) цэнэглэх хоолойн хошуу болон цооногт цэнэглэгдэж буй цэнэг хоёрын хооронд тоосролт хамгийн бага үсэх зохистой зайлбарих;

в) хийн төхөөрөмжөөр хөнгөн цагааны нунтаг ба тритол агуулсан мөхлөгт тэсрэх бодисыг цэнэглэхдээ цэнэглэх төхөөрөмжийн ашиглалтын заавар ба тэсрэх бодис хэрэглэх аргачлалыг удирдлага болгон ус буюу чийглэх шингэнийг нэмэх. Ингэхдээ тэсрэх бодисыг цэнэглэх машины бункертууд буюу цэнэглэх хоолойн эхний хэсэгт байхад нь ус, чийглэх шингэнийг тэсрэх бодист жигд тархахаар хуваарилан норгох буюу чийглэх;

г) тоос барих төхөөрөмж хэрэглэх.

505. Цэнэглэх төхөөрөмжийн бункерээс тэсрэх бодисын тоосжилтын хаял үүсэхээс зайлсхийх зорилгоор бункер дэх тэсрэх бодисын өндрийг 15-20 см-ээс багагүй тогтмол байлгана.

**Цэнэглэгч төхөөрөмжийг ашиглах үед мөрдөх аюулгүй
ажиллагааны шаардлага**

506. Цэнэглэгч төхөөрөмжийг бөөн тэсэлгээний ажил явуулах бүсэд тэсрэх бодис авчрахын өмнө урьдчилан байрлуулж, газардуулгыг хийнэ.

507. Цэнэглэх төхөөрөмжийг малталтад авч ирэхийн өмнө төхөөрөмжийг байрлуулах газрыг урьдчилан шалгаж, аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээг авсан байна.

508. Цэнэглэгч төхөөрөмжийг тэсрэх бодистой савыг буулгах, задлах, бункертуудийн ажиллагаанаас үүссэн тоосоор оператор болон орчныг бохирдуулахааргүй, цэвэр агаарын урсгалтай газарт байрлуулна.

509. Тэсрэх бодисыг тээвэрлэх, задлах, цэнэглэхдээ хүлээн авах бункертуудийн зүйл оруулахаас урьдчилан сэргийлнэ.

510. Цэнэглэлтийн явцад цэнэглэгч төхөөрөмж, хоолойн хийн даралтыг тэдгээрийн паспорт, техникийн нөхцөлд заасан үзүүлэлтээс хэтрүүлэхийг хориглох ба ямар ч тохиолдолд хэрэглэх зааварчилгааг баримтална. Шахах хийн даралтын дээд хэмжээг хамгаалалтын хавхлагаар хязгаарлах ба тасралтгүй ажиллагаатай машинд манометрээр хянана. Хийн хоолойны ажлын даралт нь цэнэглэгч төхөөрөмжийн паспорт, техникийн нөхцөлд зааснаас өндөр биш тохиолдолд хамгаалах хавхлагаар хязгаарлахгүй, манометрээр хянахгүй байж болно.

**Газрын доорх малталтад тэсэлгээний цооног, шпурыг тэсрэх бодисоор
цэнэглэх механикжсан төхөөрөмжийн ажиллагааны зохион
байгуулалт, тавих шаардлага**

511. Механикжуулсан цэнэглэлтийг өрөмдлөг, тэсэлгээний ажлын төсөл, паспорт, бөөн тэсэлгээ явуулах журам зэрэг техникийн баримт бичгийн дагуу явуулна.

512. Дээрх баримт бичигт цэнэглэх цооног, шпур, хонгилыг бэлдэх, тэсрэх материалыг ажлын байранд аюулгүй хадгалах, цэнэглэх малталтад гарсан ан, цав, хагаралыг булах, хаалт хашилт хийх зэрэг ажлын зохион байгуулалтын арга хэмжээг тусгасан байна. Мөн тэсрэх материалыг ажлын байранд хүргэх тээврийн хэрэгсэл, тэсрэх бодисыг цэнэглэх механикксан төхөөрөмжийн нэр төрөл, цэнэглэгч төхөөрөмжээр цэнэглэх ажиллагааны үед статик цэнэгийг зайлзуулах арга, тэсэлгээний хэлхээ холбох, тэсэлгээний аюулгүйн зайд, цэнэглэлтийн үед ажлыг нь зогсоох бусад малталтыг тусгасан байна.

513. Механикксан цэнэглэх төхөөрөмжийг эрх бүхий оператор ажиллуулна. Тэсэлгээний ажлын удирдагчийн шийдвэрээр операторыг өөр төрөл, загварын цэнэглэгч төхөөрөмж дээр шилжүүлэн ажиллуулах бол төхөөрөмжийн онцлог, бүтэц зохион байгуулалт, ашиглалтын заавар, өөр төрлийн тэсрэх бодисоор цэнэглэх бол түүний шинж чанар, тэсрэх бодистой харьцаж ажиллах, хэрэглэх аюулгүй ажиллагааны заавартай танилцуулж, гарын үсэг зуруулсан байх бөгөөд зайлшгүй шаардлагатай тохиолдолд нэмэлт сургалтад хамруулна.

514. Хийн цэнэглэгч төхөөрөмж дээр ажилладаг тэсэлгээчинд туслах тэсэлгээчин ажиллуулахыг зөвшөөрнө. Туслах тэсэлгээчин нь зааварчилгаа авсан байна. Тэсэлгээчин нь туслах тэсэлгээчинээр цэнэглэгч төхөөрөмжийн удирдлага болон тэсэлгээний өдөөх хэрэгсэл, бүүстертэй харьцах, цооног (шпур) цэнэглэхтэй холбогдолгүй ажлуудыг өөрийн шууд удирдлага хяналтын доор гүйцэтгүүлнэ.

515. Механикжуулсан цэнэглэгээний ажилд туслах ажил гүйцэтгэх ажилтан нь техникийн төсөлд тусгасан өрөмдлөг тэсэлгээний ба тэсэлгээний ажлын паспорт, бөөн тэсэлгээний журамтай танилцаж гарын үсэг зурсан байна.

516. Хийн цэнэглэгч төхөөрөмжээр цооног (шпур) цэнэглэхэд туслах ажил гүйцэтгэх тэсэлгээчин, туслах ажилтан нь тухайн төхөөрөмж дээр аюулгүй ажиллах арга барилтай танилцаж гарын үсэг зурсан, хувийн хамгаалах хэрэгслээр хангагдсан байна.

517. Далд уурхайн газрын доорх малталтанд механикксан төхөөрөмжээр цооног (шпур), хонгилыг тэсрэх бодисоор цэнэглэх ажлын хариуцлагатай удирдагч нь мэргэжлийн диплом болон тэсэлгээний нэгдсэн үнэмлэхтэй, тогтоогдсон журмын дагуу мэргэжлийн шалгалтанд хамрагдсан байна.

Хийн төхөөрөмжээр цэнэглэхийн өмнөх бэлтгэл ажиллагаа

518. Цэнэглэгч төхөөрөмжээр шпур, цооног, хонгил цэнэглэхийн өмнө дараах арга хэмжээг авна. Үүнд:

- а) малталтын хана, таазны аюулгүй байдалд үзлэг шалгалт хийж аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;
- б) цэнэглэгч төхөөрөмж, хоолой, тэсрэх материалыг байрлуулахад тохиромжтой аюулгүй байрлалтай газрыг сонгон тогтоох;
- в) ажлын байрны агааржуулалт, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангах;
- г) гал эсэргүүцэх хэрэгслийн бүрэн байдалд үзлэг хийх.

519. Ажил эхлэхийн өмнө цэнэглэгч төхөөрөмжийн техникийн байдалтай танилцаж төхөөрөмжийн дор дурдсан эд ангийг шалгасан байна. Үүнд:

- а) тоног төхөөрөмжийн холболт, эд ангийн бүрэн байдал;
- б) хий шахах хоолой болон тэсрэх бодисыг чийглэх тоноглолын эвдрэл гэмтэлгүй байдал;
- в) цэнэглэгч төхөөрөмжийн эд ангийг холбосон бэхэлгээ, боолтын чангалаа;
- г) цэнэглэгч төхөөрөмж, дамжуулах хоолойн газардуулгын бүрэн байдал;
- д) хөдөлгүүр, редукторын тосолгооны байдал;
- е) хяналт, хэмжилтийн багаж хэрэгслийн ажиллагааны бүрэн бүтэн байдал;
- ё) цэнэглэгч төхөөрөмжийн оператор болон шпур, цооног цэнэглэж буй ажилтны хоорондын зориулалтын холбооны хэрэгслийн найдвартай ажиллагаа;
- ж) тоног төхөөрөмжийн эргэлдэх ангийн хамгаалалт, торон хаалт хашлага нь бүрэн байх;
- з) цэнэглэгч төхөөрөмжийн эд ангийн бүх холбоосны тосны шүүрэлтгүй байдал;
- и) тоосноос хамгаалах тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг шалгана.

520. Үзлэг хийсний дараа цэнэглэгч төхөөрөмжийг ачаалалгүй ажиллуулж, цэнэглэх хоолойгоор агаар усны хольц үлээлгэн ажиллагааг нь шалгана.

521. Цэнэглэгч төхөөрөмжинд үзлэг хийсэн тухай бүртгэлийн дэвтэрт тэмдэглэл хийнэ.

522. Цэнэглэгч төхөөрөмж дээрх ажилчдад дохио өгөлгүйгээр түүнийг ажиллуулж эхлэхийг хориглоно.

523. Цэнэглэгч төхөөрөмжийн бүх хөдөлгөөнтэй эд анги ба эргэлдэх хэсэг нь хаалт, торон хашлагатай байх шаардлагатай.

524. Бөөн тэсэлгээний ажилд хэрэглэх тэсрэх бодисыг өрөмдлөг, тэсэлгээний ажлын төсөл, паспортод тооцсон тоо хэмжээгээр тэсэлгээ хийх малталтад хүргэнэ.

525. Тэсэлгээний ажлын удирдагч нь ажил эхлэхийн өмнөх бүхий л аюулгүй байдлыг хангасны дараа цэнэглэгч төхөөрөмжийн хүлээн авах бункерт тэсрэх бодисыг ачаалах, цэнэглэх ажиллагааг эхлүүлнэ.

526. Цэнэглэгч машины болон хийн цэнэглэгч төхөөрөмжийн бункерт тэсрэх бодисыг хийн хоолойгоор дамжуулан ачаалахдаа урьдчилан тохиролцсон дохио ашиглана. Үүнээс гадна цэнэглэгчдийг байгууллагын холбооны системийн шуурхай холбооны хэрэгслээр хангаж, диспетчертэй холбосон байна. Холбооны хэрэгслээр хангагдаагүй бол цооног цэнэглэхийг хориглоно.

Цэнэглэгч төхөөрөмжийн хүлээн авах бункерийг тэсрэх бодисоор ачаалах, түүнчлэн шпур, цооног, хонгил цэнэглэх үед тоног төхөөрөмжийн удирдлагын оператор болон тэсэлгээчийн хоорондын зай 20 метрээс их болон тэд бие биенээ шууд харахгүй байрлалтай нөхцөлд тэдгээрийг хоёр талаасаа шууд харилцах холбооны хэрэгслээр тоноглосон байна.

Цэнэглэгээний явцад тэсэлгээчин (оператор) нь бусад ажиллагсдынхаа ажиллагааг хянаж, харилцан холбоотой ажиллаж, тэднээс өгсөн аливаа дохионд анхааралтай хандаж, зохицуулж байна. Ойлгомжгүй өгөгдсөн ямар ч дохиог “зогс” гэсэн дохио гэж үзнэ.

527. Цэнэглэгч (машин) төхөөрөмжийн тэсрэх бодис дамжуулан цэнэглэх хоолойг байрлуулахдаа гэмтээх, бусад зүйлээр шахах болон огцом нугалахаас болгоомжилно. Тэсрэх бодис дамжуулах цэнэглэх хоолойн уртыг мөргөцгийн аль ч цэгт хүрч цэнэглэх боломжтой хамгийн богино хэмжээгээр тооцон авна. Цэнэглэх хоолойг босоо малтальтанд байрлуулахдаа малтальтын бэхэлгээнд найдвартай бэхэлнэ. Босоо малтальтад цэнэглэх хоолойг тогтоох бэхэлгээгүй бол малтальтын орох, гарах хэсгүүдэд бэхэлгээ хийж тогтооно.

528. Цооногт тэсрэх бодис шахахын өмнө цооногийн гүн болон цэвэр байдлыг шалгана. Хэвтээ, дээрээс доош өрөмдсөн босоо цооногийн устай эсэхийг шалгана. Шаардлагатай бол цооногийг үлээлгэнэ. Малтальт руу гарсан хэд хэдэн гарцтай шпур, цооног, хонгилыг урьдчилан битүүмжлэлгүй цэнэглэхийг хориглоно.

Аюултай бүс ба аюулгүйн зайд

529. Механикжсан төхөөрөмжөөр цэнэглэх үеийн хамгаалалтын бүсийг өрөмдлөг, тэсэлгээний ажлын төсөл, паспортаар тодорхойлох бөгөөд цэнэглэх төхөөрөмжөөс 50 метрээс ойргүй зайдтай байна. Хамгаалалтын бүсийн гадна, аюултай бүсийн дотор байж болох ажилчдын тоог бөөн тэсэлгээний ажил явуулах журмаар хязгаарлан тогтооно.

530. Өрөмдлөг тэсэлгээний ажлын төсөл, паспортоор цооног цэнэглэж байгаа газар, цэнэглэгч төхөөрөмж болон тэсрэх бодис дамжуулах хоолойноос тооцож тогтоосон аюултай бүсэд (гэхдээ 50 метрээс ойргүй зайд) цэнэглэгээний ажилтай шууд холбогдолгүй өөр төрлийн ажил явуулахыг хориглоно. Цооног цэнэглэж байгаа газар, цэнэглэгч төхөөрөмж, тэсрэх бодис дамжуулах хоолой болон тэсрэх бодис байрлуулсан газраас хоёр тийш 50 метр зайд контактны шугамын хүчдэлийг салгаж, залгуур дээр “Залгахыг хориглоно! Цэнэглэгээ хийж байна” гэсэн анхааруулах хуудас өлгөж харуул гаргасан байна.

531. Өрөмдлөг, тэсэлгээний ажлын төсөл, паспортаар цооног цэнэглэж байгаа газар цэнэглэх ажилтай шууд холбогдолгүй өөр ажил гүйцэтгэхийг хориглоно.

532. Шпур, цооног, хонгилыг нэг ээлжээс илүү хугацаагаар цэнэглэх тохиолдолд ажил хүлээлцэх, хадгалах, бүртгэх дэглэмийг бөөн тэсэлгээний ажлын журамд тусган мөрдөнө.

533. Хийн цэнэглэгч төхөөрөмжөөр цэнэглэх тэсрэх бодисыг хадгалах байрыг гал унтраах хэрэгслээр хангасан байна. Үүнд:

-2 ширхэг 10 литрийн нунтаг галын хорыг цэнэглэгч төхөөрөмжөөс 2 метр, хураасан тэсрэх бодисоос 2 метр зайд тус тус цэвэр агаарын урсгалтай талд байрлуулсан байх.

534. Цэнэглэгч төхөөрөмж болон цэнэглэх байранд тэсрэх бодисыг хадгалах тохиолдолд, цэнэглэгч төхөөрөмжийг түүний бункер дэх тэсрэх бодисоос ойролцоо хураасан тэсрэх материалд тэсрэлт дамжихгүй байх аюулгүй зайд байрлуулна. Аюулгүй зайд бөөн тэсэлгээний ажлын төслөөр тогтооно.

535. Цэнэглэгч төхөөрөмжийн дэргэд төсөл, паспортаар тооцсон хэмжээний тэсрэх бодисыг байрлуулахыг зөвшөөрөх бөгөөд энэ нь цэнэглэгч төхөөрөмжийн ээлжийн хүчин чадлаас ихгүй байна.

536. Тэсрэх бодисын супарсан сав, баглаа, боодол, хайрцгийг цэнэглэгч төхөөрөмж байрлаж байгаа газраас 8 метрээс багагүй зайд хураана. Цэнэглэх ажил дууссаны дараа супарсан уут саванд үзлэг, цэвэрлэгээ хийгээд газрын дээр гаргаж устгана.

**Цэнэглэгч төхөөрөмжийн техник, технологийн
аюулгүй ажиллагаа**

537. Цэнэглэгч төхөөрөмжийг ажиллуулах журам, дохио өгөх арга, дохионы утгыг аюулгүй ажиллагааны зааварчилгад заасан байна. Цэнэглэх ажиллагааны явцад дараахь үйлдлийг хориглоно. Үүнд:

- а) найрлагандаа тротил, хөнгөн цагааны нунтагтай тэсрэх бодисыг нэгэн зэрэг цэнэглэх буюу хоёр түүнээс олон төрлийн тэсрэх бодисыг хольж цэнэглэх;
- б) цэнэглэгч төхөөрөмжид будгаар будсан буюу 10^6 Ом/см-ээс их хувийн цахилгаан эсэргүүцэлтэй цахилгаан дамжуулдаггүй материалыар хийсэн цэнэглэх хоолой хэрэглэх;
- в) тэсрэх бодис шахах төв шугамд цахилгаан дамжуулах шинж чанарыг нь шалгаагүй хоолой хэрэглэх;
- г) цэнэглэх мөргөцгийг даралттай хийгээр хангах төв шугамын хийн урсгалыг тасрахгүй байх баталгаагүй нөхцөлд хэрэглэх;
- д) агааржуулаагүй малталтад цэнэглэлт явуулах.

538. Цэнэглэгч төхөөрөмжийг механик үйлчлэлд өндөр мэдрэмтгий тэсрэх бодисыг гар аргаар цэнэглэх ажилтай зэрэгцүүлэн нэг мөргөцөгт гүйцэтгэхийг хориглоно.

539. Цэнэглэх үед асгарсан тэсрэх бодисыг цуглувалж механикжсан цэнэглэгч төхөөрөмжид хийж цэнэглэхийг хориглоно. Цэнэглэх үед асгарсан тэсрэх бодисыг цуглувлан тогтоосон журмын дагуу устгана.

540. Хийн цэнэглэгч төхөөрөмж ажиллаж байгаа малталт руу орохын өмнө цэнэглэлтийн ажлыг зогсоож, бүрэн агааржуулсан байна.

541. Бие даасан компрессортой хийн төхөөрөмжөөр цэнэглэх үеийн шахалтат хийн температур болон цэнэглэгч төхөөрөмжийн зангилаа, эд ангиудын халалт нь $+60^{\circ}\text{C}$ -аас ихгүй байна.

542. Шпурыг даралттай хий ашиглан нунтаг материалаар түгжих үед хийн даралт 0.6 МПа-аас ихгүй байна.

543. Цооногийн цэнэгийг завсарын бүүстэр (галлагч)-ээр өдөөж болох бөгөөд завсарын бүүстериийн тэсрэлтийн хурд нь үндсэн цэнэгийн тэсрэх бодисын тэсрэлтийн хурдаас багагүй байна.

544. Галлагч буюу завсарын бүүстериийг шпур, цооног хонгилд гар аргаар байрлуулна. Ингэхдээ чигжилт, цэнэглэлтийн хоолойг ашиглаж болно.

545. Цахилгаан тэсэлгээний үед цэнэгийг шпур, цооногийн аман талаас шулуун өдөөлтөөр тэсэлнэ. Шпур, цооногийг хийн цэнэглэгч төхөөрөмжөөр цэнэглэж дуусан, төхөөрөмжийг цэнэглэх байрнаас гаргаж, холдуулсны дараа цахилгаан тэслүүртэй галлагчийг цэнэгт байрлуулна.

546. Хийн төхөөрөмжөөр цэнэглэлт хийж байгаа мөргөцөгт цахилгаан тэслүүр байлгахыг хориглоно.

547. Цэнэгийг шпур, цооногийн ам болон ёроолоос нь цахилгаан бус тэслүүр, цочир дамжуулах шижим ашиглан өдөөхийг зөвшөөрнө. Тэсрэх бодисыг цэнэглэх явцад бортгон өдөөгчийг хөдөлгөх, тэслүүрийг тэсрэх бодисын урсгалын хөдөлгөөнөөр гэмтээхээс хамгаална. Тэслүүрийг бортгон өдөөгчид далд ортол нь суулгасан байна. Ямар ч тохиолдолд тэслүүрийн үзүүрийн хонхорхойг цэнэг рүү чиглүүлсэн байна.

548. Хэвтээ болон доош уналтай өрөмдсөн, усны шүүрэлтэй шпур, цооногийг цэнэглэсний дараа, цэнэгээс дээш амсар хүртэлх хоосон зайд ус шүүрүүлэх материалыаар чигжиж дүүргэнэ. Ийм тохиолдолд цэнэгийг усанд тэсвэртэй тэсрэх бодистой бортгон өдөөгч буюу цочир дамжуулах шижмээр өдөөнө.

Цэнэглэлт дууссаны дараах үеийн аюулгүй ажиллагааны шаардлага

549. Цэнэглэлтийн ажил дууссаны дараа цэнэглэгч төхөөрөмжийг даралттай хийгээр үлээлгэх буюу усаар угааж цэвэрлэнэ. Хүлээн авах бункерийн болон цэнэглэгч төхөөрөмжийн дотор талын тэсрэх бодисыг сайтар цэвэрлэнэ.

550. Тэсрэх бодисын үлдэгдэл нь сайн цэвэрлэгдэхгүй бол цэнэглэх төхөөрөмжийг зориулалтын байранд халуун усаар эсвэл уураар угааж цэвэрлэнэ. Төхөөрөмжийн дотор үлдсэн тэсрэх бодисыг металл багаж хэрэгслээр хусаж цэвэрлэхийг хориглоно.

551. Цэнэглэгч төхөөрөмжийн тоноглол ба тэсрэх бодис дамжуулах хоолойг тусдаа байранд хадгална.

Осол, аюул үүсэх байдал илэрсэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ

552. Тэсэлгээчин нь цэнэглэгч төхөөрөмжийн ажиллагаанд осол, аюул гарч болзошгүй шинж илэрвэл ажлаа яаралтай зогсоож мөргөцөтгөт ажиллаж буй ажилчдад анхааруулж, тэсэлгээний ажлын удирдагчид мэдэгдэнэ.

553. Даралттай хий тасарсан тохиолдолд оператор нь бүх залгах тоноглуудыг хаана.

554. Цэнэглэгч төхөөрөмжийн удирдлага дээр ажиллаж буй болон мөргөцөтгөт цэнэглэлт хийж буй тэсэлгээчийн хооронд холбоо тасарсан тохиолдолд бүх тэсэлгээчин ажлаа зогсооно.

555. Хийн системд саатал, бөглөрөл үүссэн болон цэнэглэгч төхөөрөмжид гэмтэл гарсан тохиолдолд цэнэглэлтийг зогсоож, хийн даралтыг буулгаж, цэнэглэх хоолойг цэнэглэгч төхөөрөмжөөс салган, гэмтлийг арилгах арга хэмжээ авна. Цэнэглэх хоолойн бөглөрлийг гаргахдаа эхлээд хоолойг цооногоос гарган бэхэлж даралтат хийгээр (тэсрэх бодисгүйгээр) үлээлгэнэ. Бөглөрөл гарахгүй тохиолдолд усаар угааж гаргана.

556. Цэнэглэгч машинд засвар, тосолгоо, үйлчилгээ хийх, цэвэрлэх, түүнчлэн гаднаас мөргөцөтгөт хий шахах хоолой, усны төв шугам ба цэнэглэх хоолойн гэмтлийг арилгах ажлыг зөвхөн цэнэглэгч төхөөрөмжийн ажиллагааг зогсоосон нөхцөлд, ус болон хийн хоолойг даралтгүй болгож байж гүйцэтгэнэ.

**ДОЛОО. ТЭСРЭХ БОДИСЫГ ҮЙЛДВЭРЛЭХ БА ХЭРЭГЛЭЭНД БЭЛТГЭХ
ҮЙЛДВЭР, МЕХАНИКЖУУЛСАН ЦЭГИЙН АШИГЛАЛТЫН АЮУЛГҮЙ
АЖИЛЛАГААНЫ ШААРДЛАГА**

557. Энэхүү дүрмээр үйлдвэрлэлийн зориулалттай энгийн ба эмульсийн тэсрэх бодис үйлдвэрлэх, тэдгээр тэсрэх бодисыг үйлдвэрлэхэд орох завсрын найрлага, хольц, эмульс үйлдвэрлэх суурин ба зөөврийн үйлдвэр (цаашид “үйлдвэр” гэх) болон үйлдвэрийн гаралтай тэсрэх бодисыг хэрэглээнд бэлтгэх (үйлдвэрийн гаралтай тэсрэх бодисыг задлах, цэнэглэгч машинд ачих) байр байгуулах, тэдгээрийн ашиглалтад тавих шаардлагыг тогтооно. (Энэ заалтад Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор нэмэлт орсон)

558. Газрын дээр болон далд уурхайд байрлах үйлдвэрлэлийн зориулалттай энгийн ба эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх бодисыг ашиглалтад бэлтгэх байруудад энэхүү дүрмийг мөрдөнө.

559. Зөөврийн цэнэглэгч машины эзэмшигч байгууллага нь уг машины ашиглалт, аюулгүй ажиллагааны зааврыг үйлдвэрлэгчийн ашиглалтын заавар болон энэхүү дүрмийн шаардлагыг үндэслэн боловсруулж мөрдөнө.

560. Тэсрэх бодисын үйлдвэрт дараахь төрлийн тэсрэх бодис үйлдвэрлэхийг зөвшөөрнө. Үүнд:

а) мөхлөгт аммиакийн шүүг шингэн, хатуу болон хуурай нефтийн бүтээгдэхүүн, нунтаг эсвэл өөр гарал үүслийн үл тэсрэх шатамхай материалтай хүйтэн аргаар хольсон механик хольц;

б) мөхлөгт аммиакийн шүүг хайрслаг тротил, шингэн, хатуу болон хуурай нефтийн бүтээгдэхүүн, нунтаг эсвэл өөр гарал үүслийн үл тэсрэх шатамхай материалтай хүйтэн аргаар хольсон механик хольц;

в) аммиакийн шүүний уусмал, эсвэл кальцийн болон натрийн шүү, карбамидын нэмэлттэй аммиакийн шүүний уусмал дээр суурилсан цийдмэг буюу эмульсийг нунтаг болон шингэн үл тэсрэх шатамхай материалтай найруулсан хольц;

г) тэсрэх бодисын төрөл дээрхээр хязгаарлагдахгүй бөгөөд бусад төрлийн тэсрэх бодис үйлдвэрлэх тохиолдолд тухайн тэсрэх бодис үйлдвэрлэх технологийг ашиглана. (Энэ дэд заалтыг Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор нэмсэн)

561. Хий, тоосны аюулгүй далд уурхайд тэсрэх бодисыг үйлдвэрлэх, бэлтгэх байрыг энэ зорилгоор тусгайлан бэлтгэж төхөөрөмжилсөн малталтад байрлуулна.

562. Газрын гадарга дээрх тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх байрыг тэсрэх материалын агуулахын талбайд эсвэл тэсрэх материалын агуулахын хориотой бүсэд байгуулж болно. Ингэхдээ тэсрэх бодис үйлдвэрлэх болон бэлтгэх байрыг тэдгээрт нэг агшинд байж болох тэсрэх бодисын дээд хэмжээг идэвхтэй цэнэгээр авч тэсрэлт дамжуулахгүй зайл ачиж буулгах тавцан, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулах хүртэл тооцон, тэсрэх материалыг тээвэрлэх, ачиж буулгах зам талбайгаас аюулгүй зайд байрлуулахыг зөвшөөрнө. Тэсрэх бодисыг бэлтгэх байр болон тэсрэх бодисын үйлдвэр нь өөрийн хашаатай байна.

Ажилчдын гүйцэтгэж буй ажилтай нь холбоотой аюулгүй ажиллагааны тэмдэг, тэмдэглэгээ, болзошгүй аюулыг анхааруулсан зурагт хуудас, мөн үйлдвэрийн бүсэд тээврийн хэрэгсэл болон явган хүний хөдөлгөөний чиглэл заасан схем, анхааруулах тэмдгүүдийг үзэгдэх орчин, гэрэлтүүлэг сайтай газарт барилга байгууламжийн хана, ажлын байранд болон тоног төхөөрөмж дээр байрлуулна.

563. Тэсрэх бодисын үйлдвэр болон тэсрэх бодис бэлтгэх байрыг нэг талбайд хамт байрлуулж болно. Ингэхдээ барилга байгууламжийн хоорондын зайл энэхүү дүрмийн 9 дүгээр бүлэгт заасан шаардлагаар тогтооно.

564. Тэсрэх бодис бэлтгэх байр, тэсрэх бодисын үйлдвэрийн барилгын хоорондын зайл, мөн түүнчлэн үйлдвэр, тэсрэх материалын агуулахын хоорондын зайл тэдгээрийн хооронд тэсрэлт дамжихгүй байх нөхцөлөөр тооцож тогтооно.

565. Далд уурхайн малталтын дээр тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх байр байрлуулах бол газрын гадаргыг цөмрөхөөс сэргийлэх (дүүргэж чижих, нураах) арга хэмжээг урьдчилан авсан байна.

566. Газрын гадарга дээрх тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх байрыг уулын ажил явагдаж байгаа малталтын дээр, мөн асга, часны нуралтын аюултай уулын хажууд байрлуулахыг хориглоно.

567. Хүлрийн хурдасын давхаргатай газар тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх бодис бэлтгэх байрыг байрлуулах шаардлагатай бол хүлэр шатах тохиолдолд гал түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор үйлдвэрийн хашааг хүлрийн давхаргын захаас 200 метрээс багагүй зайд байрлуулах ба галын байгууллагатай зөвшилцэж, гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

568. Тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх байрын гадуур тойруулан хамгаалалтын хашаа барьж, харуул хамгаалалттай байлгана. Хашаа, харуулын байрыг дүрмийн шаардлагаар тооцоолсон зураг төслийн дагуу барина.

569. Тэсрэх бодис бэлтгэх, дахин боловсруулах үйлдвэрийн болон эмульсийн үйлдвэрийн барилга байгууламжаас гадагш аюулгүйн зайд тэсрэх материалын агуулахын агаарын цохилтын долгионы үйлчлэлийг тооцох аргаар тодорхойлно. Ингэхдээ тэсрэх бодисын болон эмульсийн жинг тротилын эквивалентаар харьцуулж тооцно.

570. Тэсрэх бодисын үйлдвэрийг барьж байгуулах талбайг газрын гадаргын тогтоц, гидрографийн нөхцөл, мөн цаашид өргөтгэх боломжийг харгалзан сонгоно. Схем дээр үйлдвэрийн үндсэн болон туслах барилга байгууламжуудыг тэсрэх бодис бэлтгэх, үйлдвэрлэх технологийн процессыг аюулгүй, үр ашигтай гүйцэтгэх нөхцөлийг хангасан байрлалтай, мөн зам талбай, орц, гарцыг хөдөлгөөнд зохицтой, аюулгүй байхаар байрлуулсан байна.

571. Далд уурхайд тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх цэгийг далд уурхай дахь тэсрэх материалын агуулахын бүсэд байрлуулахыг зөвшөөрөх ба энэ тохиолдолд үйлдвэрийн бүх хонгилыг цэвэр агаарын урсалаар агааржуулна. Үйлдвэрээс гарсан агаарыг цэвэр агаарын урсгалтай малтарт руу оруулахыг хориглоно.

572. Тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх цэгийг усгүй, тогтвортой чулуулагтай газар байрлуулах ба дараахь байгууламжуудаас дор дурдсанаас багагүй зайдтай байна. Үүнд:

- а) хүн тээврийн вагоны зогсоол, уулын цул ачих цэгээс 50 метр;
- б) уурхайн босоо ам, босоо амны байгууламжаас болон уурхай руу бүхэлд нь болон ихэнх хэсэг рүү нь цэвэр агаарын урсгалыг зохицуулдаг агааржуулалтын хаалганаас 100 метр;
- в) газрын гадаргаас 30 метр;
- г) ажилчид байнга явдаг малталаас 25 метрээс багагүй байна.

573. Тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх цэг нь ажилчдад зориулсан үндсэн ба туслах хаалгатай байх бөгөөд тэдгээрт үндсэн болон туслах орцуудыг тоноглон ашиглаж болно. Аль нэг орцыг нь савтай шатах тослох материал оруулах болон хадгалах зориулалтаар ашиглаж болох бөгөөд, хажуугаар нь ажилчид чөлөөтэй нэвтрэх зайд гаргасан байна.

574. Үйлдвэрийн барилга байгууламж, ажлын тасалгаануудын харагдахуйц газарт галын анхан шатны багаж хэрэгсэл, гал унтраагуурын байрлалыг заасан тэмдэглэгээ, галын дохиоллын системийг ажиллуулах товчуур мөн үйлдвэрлэлийн аюулын зэрэглэлийг заасан тэмдэг, тэмдэглэгээг байрлуулна.

575. Тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх талбайд ил гол гаргахыг хориглоно.

576. Үйлдвэрийн аюултай бүсийн хүрээнд зөвхөн үйлдвэрийн болон туслах барилга байгууламж тэдгээрт хамаарах шугам сүлжээ байрлана.

577. Газрын дээрх, тухайн байгууллагатай холбоогүй хий, газрын тосны шугам хоолойноос тэсрэх бодис үйлдвэрлэх барилга байгууламж хүртэлх зайд холбогдох

норм, дүрмээр тодорхойлох бөгөөд агаарын долгионы цохилтын аюулгүй бүсээс багагүй байна.

578. Аюулгүйн зайлгийн тооцохдоо үйлдвэрийн бүсэд байрлах тэсрэх бодисын хамгийн их хэмжээг авч тооцох ба аваарын нөхцөлд нэгэн зэрэг тэсрэх магадлалыг авч үзнэ.

Хуурай болон уусмал байдлаар байгаа аммиакийн шүү, кальцийн шүү, нитрит натри зэргийг тооцохгүй. Үйлдвэрийн эмульсжуулэгч аппарат болон цэнэглэгч машины хооронд тэсрэлт дамжихаас хамгаалах төхөөрөмжтэй буюу эмульсжуулэгч аппаратаан эвдрэлээс үүссэн металлын хэлтэрхийг цэнэглэгч машины эмульсийн саванд орохоос хамгаалах төхөөрөмжтэй бол цэнэглэгч машин дахь эмульсийг тооцоонд оруулахгүй.

Зөөврийн сав (цэнэглэгч машин)-тай эмульсийг үйлдвэрийн талбайд тэсрэлт дамжихгүй байх аюулгүйн зайлгийн тооцсон зайнд байрлуулж болно.

579. Тэсрэх бодисын үйлдвэр, бэлтгэх байрнаас хүн тогтмол ажилладаггүй туслах барилга, байгууламж хүртэлх зайл мөн тухайн туслах барилга байгууламж хоорондын зайлгийн норм ба дүрэмд заасны дагуу тооцно.

580. Аммиакийн шүү хадгалах байр нь мөхлөгжүүлсэн аммиакийн шүүг үйлдвэрлэлд бэлтгэх (шигших, бутлах, шүүний уусмал бэлтгэх) тасалгаатай үргэлж байж болно. Шүү хадгалах байрыг бэлтгэлийн тасалгаанаас ханаар тусгаарлана.

581. Тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх байрыг галын дохиоллоор тоноглосон, холбооны нэгдсэн сүлжээтэй байхын зэрэгцээ харуул хамгаалалт нь бие даасан холбооны сүлжээтэй байна. Далд уурхайд байрлах тэсрэх бодисын суурин үйлдвэр нь уурхайн диспетчертэй холбоо барих төхөөрөмжтэй байна.

582. Тэсрэлтийн болон галын аюултай тоос, уур, хий гарах нөхцөл бүхий ажлын байранд ашиглах холбооны хэрэгсэл, чанга яриг зэрэг нь стандартын шаардлага хангасан байна.

583. Утсан холбоо бүхий чанга яригчийг тэсрэлт, галын аюулгүй ажлын байранд ашиглаж болно.

584. Үйлдвэрийн тэсрэх, шатах аюултай ажлын байр нь галын аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу тоноглосон галын дохиолол, телефон утастай байна.

585. Үйлдвэрийн барилга байгууламж, түүний гаднах тоноглол, төхөөрөмжийг аянгын шууд болон хоёрдогч үйлчлэлээс хамгаалах тооцоог энэхүү дүрмийн шаардлагын дагуу хийнэ.

Аянгын хамгаалалтаар тоноглогдсон барилгад холбогдсон бүх төрлийн харилцаа холбоо, дохиоллын сүлжээг (утсан болон агаарын кабель) агаарын шугамаар гүйцэтгэхийг хориглоно.

586. Сүлжээний гол хэсгүүдийг утасны сувгийн системд байрлуулж, түгээлтийн сүлжээг хамгаалалттай кабелиар хийнэ.

587. Тэсрэх бодисын үйлдвэрийн барилга нь 2-оос доошгүй хаалга, гарцтай байх бөгөөд галын болон тэсрэлтийн аюул үүссэн тохиолдолд ажилчдыг гаргах, нүүлгэн шилжүүлэх боломжоор хангагдсан байна.

588. Шатамхай бодис, галын болон тэсрэлтийн аюултай бодисын тоосжилт үүсч болзошгүй барилгад байнга хянаж байх боломжгүй нүх, цоорхой бүхий хийц эдлэл ашиглахыг хориглоно.

589. Үйлдвэрийн барилгын шал нь зайд завсаргүй, ус зайлцуулах сувагтай байна. Исэлдүүлэгч бодис бэлтгэх, түүгээр тэсрэх бодис үйлдвэрлэх, хадгалах байрны шал болон барилгын хийцийг хүчилд тэсвэртэй будгаар будаж хамгаална.

590. Тэсрэх бодис, хагас боловсруулсан бүтээгдэхүүн эсвэл тэсрэх бодисын хольцууд байрлах барилга байгууламж, ажлын байр бүрийн ачааллын нормыг баталгаажуулж, хүснэгт хэлбэрээр хийж эдгээр барилга байгууламжид болон ажлын байранд байрлуулсан байна. Галын болон тэсрэлтийн аюултай бүтээгдэхүүн байрлуулах газрыг шалан дээр тод будгаар ялган зааж тэмдэглэсэн байна.

591. Туршилтын болон тэсрэх материалын хаягдал, үйлдвэрлэлийн гологдлыг устгах талбайг тэсрэх бодис үйлдвэр, түүний ойролцоо хүн ам оршин суух газар, авто зам, инженерийн шугам сүлжээнд аюул учруулахгүй зайд, байрлалыг тооцон сонгож байгуулна.

Объектоос тэсрэх материалыг тэсэлж, шатааж устгах талбай хүртэлх зайд төслөөр тооцно.

Тэсрэлтийн аюултай бүтээгдэхүүнийг талбайд хүргэх аюулгүй зам, гарцыг мөн урьдчилан тооцсон байна. Тухайн талбайн эргэн тойрны 10 метр зайд өвс ургамал, гадны гаралтай шатамхай материалыг бүрэн цэвэрлэнэ.

592. Талбайг хашаагаар хамгаалж, хашаанаас гадагш 25 метрийн зайд анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ тавьсан анхааруулах бүстэй байна.

593. Талбайг хүлэржсэн газарт байршуулахыг хориглоно.

594. Туршилт, устгалын ажлыг гүйцэтгэхдээ аюулгүй байдлыг хангах ажиллах шаардлагатай.

595. Туршилт хийх, эсвэл устгалын ажлыг гүйцэтгэх үеийн аюулгүй байдлыг хангах зорилгоор талбайг дараахь байдлаар тоноглоно. Үүнд:

а) хоргодох байр;

б) тэсрэх материалыг хамгаалах байр;

в) хоргодох эсвэл хамгаалах байрны хаалга нь шатаах эсвэл тэсэлгээ хийх газрын эсрэг чиглэл рүү харсан байна.

596. Тэсрэх материалын хаягдал, үйлдвэрлэлийн гологдлыг шатааж, тэсэлж эсвэл уусгаж устгаж болно.

597. Аюул ослын магадлал өндөртэй туршилт устгалын ажлыг байгууламжаас аль болох зйтай, талбайн төв хэсэгт хийнэ.

598. Талбайг харилцаа холбооны хэрэгсэл болон дуут дохиогоор тоноглох, тэсрэх материал тээвэрлэх замын асуудлыг зураг төсөлд тооцож шийдсэн байна.

599. Тэсрэх материал тээвэрлэх замыг дараахь зайнд тооцож хийнэ. Үүнд:

а) тэсрэх бодисын үйлдвэрээс 15 метрээс багагүй;

б) хэрэв зам нь тухайн үйлдвэрт орж, гарах зориулалттай бол үйлдвэрийн барилгаас 3 метрээс багагүй;

в) ил галын эх үүсвэр бүхий газар, эсвэл ил галтай ажил гүйцэтгэдэг газар (дархан, гагнуур, уурын зуух г.м), мөн шатахууны болон шатах тослох материалын агуулах зэргээс 50 метрээс багагүй;

г) үйлдвэрийн орчин, бүсэд байрлах туслах барилга байгууламжаас 15 метрээс багагүй;

д) барилгын норм дүрмээр хол зайд байхыг шаардаагүй бусад барилга байгууламжаас 6 метрээс багагүй.

600. Тэсрэх бодис бэлтгэх, дахин боловсруулах байранд энэхүү дүрмийн 166 дугаар зүйлийн шаардлагын дагуу тоноглосон тээврийн хэрэгсэл орохыг зөвшөөрнө.

601. Үйлдвэрийн ачаа хүлээж авах, ачих төхөөрөмж, байгууламж руу хольж цэнэглэгч машин, түүнчлэн тэсрэх материал болон эмульс үйлдвэрлэхэд ордог хольц, бүрэлдэхүүн хэсгүүдийг тээвэрлэх зориулалтаар тусгайлан тоноглож, ашиглахыг зөвшөөрсөн автомашин, ачиж буулгах төхөөрөмжид орох зөвшөөрөл олгоно.

602. Тэсрэх бодисын тоосжилттой байж болох барилга байгууламжид төмөр замын вагон тавих зүтгүүрийг 10 метрээс дотогш ойртуулахыг хориглоно.

603. Вагоныг хөдөлгөхийн өмнө хаалгыг нь хааж түгжсэн байна. Аюултай ачаатай төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний хурд үйлдвэрийн талбайд 15 км/цагаас илүүгүй байна. Аюултай ачаатай вагоныг огцом түлхэх, татах, огцом зогсоохгүйгээр холбож, салгаж найруулна.

604. Тэсрэх бодис бэлтгэх байр руу тэсрэх бодис ачсан нэг вагон (задгай вагон, платформ)-ыг ачааг нь үйлдвэрлэлийн шугаманд шууд буулгахаар тавьж болно.

605. Аккумулятор цэнэглэх байрыг тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх байрнаас 50 метрээс багагүй зайд байрлуулна.

606. Үйлдвэрлэлийн технологийн процессын удирдамжид үйлдвэрлэлийн болон галын аюулгүй ажиллагаа, үйлдвэрлэлийн ариун цэвэр эрүүл ахуйг сахих, үйлдвэрлэлийн хорт хаягдлыг барих, статик цахилгаанжилтаас хамгаалах ажиллагааны шаардлагуудыг тусгасан байна.

607. Дээр дурдсанаас гадна үйлдвэрлэлийн технологийн процессын удирдамжид дараах асуудлуудыг тусгасан байна. Үүнд:

- а) үйлдвэрлэлийн процессын иж бүрэн механикжуулалт, автоматжуулалт;
- б) үйлдвэрлэлийн процессын өгөгдсөн дараалал, түүнчлэн тоног төхөөрөмжийн ажиллагааны горимыг хангах тоног төхөөрөмж, удирдлагын механизм;
- в) үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, аппаратураас оч дөл авалцаж шатах, тэсэрч дэлбэрэх аюултай хий, уур, тоосны ялгаралтыг гаргахгүй байх буюу хамгийн бага түвшинд байлгахаар битгүүмжлэх;
- г) тоосромтгой түүхий эд, материалыг шилжүүлэн зөөх, тээвэрлэхэд хаалт, таглаатай тоног төхөөрөмж ашиглах;
- д) үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас ялгараах хорт хий, хаягдлыг агаарт цацагдахаас өмнө шүүх, цэвэрлэх тоног төхөөрөмж ашиглах;
- е) технологийн процесст эргэлтийн ус ашиглах;
- ё) ашигласан усыг гадагшлуулахын өмнө тунадасыг цуглуулах, устгах;
- ж) хаягдал дахь хорт бодисын агуулгыг зөвшөөрөгдөх хамгийн бага хэмжээнд хүргэх, бүрмөсөн устгах асуудлуудын шийдлийг тусгасан байна.

608. Нэг барилга дахь үйлдвэрлэлийн технологийн процесс, фаз нь өөр өөр аюулын зэрэглэлтэй бол процесс, фаз тус бүрт нь тохирсон гал тархахаас хамгаалах тоноглол, хэрэгслээр төхөөрөмжилнө (галын хамгаалалттай хана, зайд завсарыг бөглөх, хамгаалалт хийх г.м.).

Тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх үйлдвэрийн технологийн процессын удирдамж боловсруулахдаа хорт хийн ялгаралт, хамт хадгалж болохгүй бодис бүтээгдэхүүн зэргээс шалтгаалж тусгаарласан байранд байрлуулах шаардлагатай технологийн дамжлагыг тодорхойлж, уг баримт бичигт тусгана.

Натрийн нитритийн усан уусмал бэлтгэх байр нь исэлдүүлэгч уусмал болон хольцуудыг бэлтгэх байрнаас тусгаарлагдсан, тусдаа байранд өөрийн гэсэн орох хаалга, ачих талбайтай байна.

609. Орчны агаарын температурт талсжих эсвэл хөрөх онцлогтой бодис боловсруулах сав, тоног төхөөрөмж, мөн бүтээгдэхүүн дамжуулах шугам хоолой, агуулах савыг дулаан алдагдахаас хамгаалж, халаах төхөөрөмжөөр төхөөрөмжилнө.

610. Тэсрэлтийн болон галын аюултай тоос ялгаруулдаг байр тасалгаанд шугам хоолойг барилга руу оруулахдаа халаалтын системийн сувагт тоос нэвтрэн орж хуралдахаас сэргийлж, хоолой орсон хэсгийг чигжиж битүү хамгаалалт хийнэ.

611. Технологийн тоног төхөөрөмжийг зарцуулах ба хадгалах савтай холбосон шингэн дамжуулах хоолойнууд нь аль болох цөөн нугаралттай байх ба төсөлд тэдгээрийн бүрэн шавхагдах нөхцөлийг тооцсон байна.

612. Тэсрэх бодис, исэлдүүлэгч бодисын сав баглаа боодлыг ээлжийн хугацаанд үйлдвэрийн барилгын гадна талын цонхгүй хэсэгт, саравчин доор түр хадгалж болно. Хэрэв ажлын байранд түр хадгалах бол аваарийн гарц, замыг хаахгүйгээр тусгайллан байр гаргаж, 2 цагийн хэрэглээг хангах хэмжээгээр хадгалахыг зөвшөөрнө.

613. Тээврийн хэрэгслийг үйлдвэрийн барилгын дэргэд зөвхөн ачилт, буулгалтын ажлын үед түр зогсохыг зөвшөөрнө.

614. Тэсрэх материалын агуулах болон тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх ажиллагаа явагдаж байгаа үйлдвэрийн байрнаас бусад байранд бага хэмжээний болон урсгал засвар хийх зориулалттай засварын (гагнуурын төхөөрөмжгүй) байр, мөн жижүүрийн засварчин, цахилгаанчин түр байрлах байр байж болно. Эдгээр нь үйлдвэрлэлийн байрнаас галаас хамгаалах ханаар тусгаарлагдсан, тусдаа өрөөнд байрлана.

615. Тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх ажиллагаа явуулж байгаа байрны тэсрэх бодисын нийт ачаалал нь вагон, хольж цэнэглэгч машин, бусад тээврийн хэрэгсэл, нөөцийн саванд байгаа нийт тэсрэх бодисын хэмжээг оролцуулаад 60 тн-оос хэтрэхгүй байна. Энэ тохиолдолд нөөцийн савны ачаалал нь цэнэглэгч машины даацаас нэг дахин их байна.

616. Нэг талбайн тусгаарлан хуваарилсан хэсгүүдэд тэсрэх материалыг турших ба устгах ажлыг гүйцэтгэж болно. Туршилт ба хаягдлын устгалыг нэгэн зэрэг гүйцэтгэхийг хориглоно.

617. Тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх байрны төслийг боловсруулахдаа дахин боловсруулалтад орж байгаа материалын аюултай цахилгаанжилт үүсэхээс сэргийлэх арга хэмжээг тооцно.

618. Тэсрэх бодис бэлтгэх эсвэл дахин боловсруулах ажил явагдаж буй барилга байгууламжид радио идэвхт эх үүсвэрийг нь тэсрэлтэд тэсвэртэй чингэлэгт байрлуулсан, тэсрэлтийн хамгаалалтаараа тохирох маркийн радиоизотоптой багаж хэрэглэхийг зөвшөөрнө.

619. Бүх ангилалын тэсрэлтийн аюултай орчин, температурын бүх ангилал, группын бүсээс гарах хаалганы гадна талд ба хашааны хаалга, гарцны гадна тоос, чийгний хамгаалалттай цахилгаан тоноглол тавьж болно.

620. Тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх байранд төрөл бүрийн утасгүй мэдрэгчүүд байрлуулахыг зөвшөөрнө. Энэ тохиолдолд хоёрдогч төхөөрөмжийг агаарт нь тэсрэх бодисын агууламжгүй байранд байрлуулах ба түүнийг мэдрэгчүүдтэй оч үүсгэх аюулгүй хэлхээгээр холбоно.

621. Дэлгэц, камерын систем, шингэний хавхлагын цахилгаан соронзон хөдөлгүүр, гал унтраах автомат системийн блок болон бусад гүйдэл хүлээн авагч хөдөлгөөнт төхөөрөмжүүд, мөн хөдөлгөөнгүй гүйдэл хүлээн авагчийн хэсгийн хэлхээг холбоход резинен эсвэл пластик бүрээстэй (эсвэл шлангтай) бүх ангилалын тэсрэлтийн аюултай орчинд ашиглах зориулалтын уян зэс голтой кабель хэрэглэж болно. Механик үйлдлээр кабелийг гэмтээж болзошгүй хэсэгт түүнийг төмөр хоолой дотор байрлуулах, булан төмрөөр хаах болон бусад ийм төрлийн хамгаалалт хийнэ.

Оч үүсгэх аюулгүй хэлхээг хамгаалалтгүй кабелиар хийж болно.

622. Ислдүүлэгч бодис болон тэдгээрийн уусмалтай үйл ажиллагаа явагддаг үйлдвэрийн барилгад импульсийн болон командын зэс хоолой ашиглахыг хориглоно. Мөн цайран хамгаалалттай, хар тугалган гадарга нь ил гарсан кабель хэрэглэхийг хориглоно.

Ислдүүлэгч уусмал бэлтгэх процессыг автоматаар хянах түвшин хэмжигч, температур хэмжигчээр болон үйл ажиллагаанд ямар нэгэн алдаа үүсвэл дохио өгөх дохиоллын автомат системээр тоноглоно.

623. Бүх ангиллын тэсрэлтийн аюултай бүсэд, хэрэв орчин нөхцөл нь пластмасс материалыг гэмтээхгүйгээр бол пластмасс импульсийн хоолой хэрэглэж болно.

624. Тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх орчинд тэсрэлтийн болон галын аюултай бүтээгдэхүүн зөөж тээвэрлэх төхөөрөмж, өргөгч, тээвэрлэгч машинуудыг тэсрэлтээс хамгаалах зориулалтаар тоноглосон байна.

625. Бүх ангиллын тэсрэлтийн аюултай бүсэд байрлах машин механизмыг хөдөлгөөнд оруулах цахилгаан хөдөлгүүрийг аюултай бүсийн гадна байрлуулж, ханаар нэвтэрсэн хөдөлгүүрийн голд сальникан нягтруулга хийсэн бол тэсрэлтийн хамгаалалтгүй байхыг зөвшөөрнө.

626. Тэсрэлтийн болон галын аюултай үйлдвэрийн байр, түүний гадна орчинд ажил гүйцэтгэдэг тээвэрлэх төхөөрөмж, ачаа өргөгч болон тээврийн хэрэгслүүдэд дараах зүйлсийг урьдчилан тооцсон байна. Үүнд:

- а) цахилгаанаас болон бусад зүйлээс оч үүсгэдэггүй байх;
- б) тосолгоо хийгддэг холбоосуудыг битүүмжилж, тэдгээрт ачиж тээж буй бүтээгдэхүүн орохоос хамгаалсан байх;
- в) ачиж тээж буй бүтээгдэхүүний үлдэгдэл нь хөдөлгөөн багатай хэсэгт нь удаан хэвтэх, хуримтлагдах, бүрхүүл үүсэх, завсарт хавчуулагдахаас хамгаалах;
- г) машин тоног төхөөрөмжийг үйлдвэрлэхдээ тэдгээрийн хийц, материал нь технологийн процессын онцлог, техникийн аюулгүй байдлын шаардлага, тээвэрлэх бүтээгдэхүүний аюултай үлчлэлээс хамгаалахаар тооцсон байх.

627. Галын болон тэсрэлтийн аюултай бодис тээвэрлэх дамжуурга (туузан, гинжин, шурган) нь хий эргэх, татах хөтлөх анги тасрах, шураг чигжрэх зэрэг эвдрэл, гэмтэл, саатал гарсан үед зогсоох хамгаалалтын төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

628. Галын болон тэсрэлтийн аюултай бодис тээвэрлэх дамжуургын замын налуу эсвэл босоо хэсэгт дамжуургын татах хөтлөх анги болон тээвэрлэж буй ачааг өөрөө хөдөлгөөнд орохоос хамгаалах төхөөрөмжтэй байна.

629. Тэсрэх бодисыг нэг барилгаас нөгөөд дамжуургаар шилжүүлэхдээ тэдгээр бүтээгдэхүүнийг хэсэг хэсгээр (ширхэгээр) нь нэг барилгаас нөгөөд тэсрэлт дамжихгүй байх зайнд байрлуулна.

630. Тэсрэх бодисыг нэг барилгаас нөгөөд шаталт, тэсрэлт зогсоох хамгаалах тоноглол бүхий хийн төхөөрөмж ашиглан тээвэрлэж болно. Хадгалах байр болон бусад барилгын хооронд хийн төхөөрөмжөөр тэсрэх бодисыг тээвэрлэхийг хориглоно.

631. Тэсрэлтийн болон галын аюултай бүтээгдэхүүнийг шилжүүлэн зөөхөд ашигладаг өргөгч машин механизмын хөдөлгөөнийг удирдах удирдлага нь газарт байрлана.

632. Үйлдвэрлэлийн бүсэд байрлах төмөр зам нь уурхайн ерөнхий шугамаас цахилгааны тусгаарлалттай байна.

Тэсрэх бодисыг үйлдвэрээс мөргөцөгт хүргэхэд энэ зорилгоор тусгайлан тоноглогдсон уурхайн тээврийн хэрэгслийг ашиглана.

Тэсрэх бодисын суурин үйлдвэрээс доод түвшинд тэсрэх бодисыг хүргэхэд зориулан тоноглосон цооногийн тусламжтайгаар буулгаж болно. Буулгахдаа доод түвшинд байрлах, тэсрэх бодисыг задгайгаар тээвэрлэх эсвэл хадгалах тусгайлан тоноглогдсон бункерт эсвэл вагонд (цэнэглэх-тээвэрлэх машинд) ачаална.

Доод түвшинд байрлах буулгах байрыг хэсгийн тэсрэх бодис хадгалах, түгээх камерын шаардлагын дагуу тоноглосон байна.

Технологийн процессын явцад тэсрэлтийн аюултай бодисын тоос, уур ялгардаг тэсрэлтийн аюултай барилга байгууламжид ашиглах зориулалтын тээврийн хэрэгслийн (туузан дамжуулагч, транспортер, элеватор) механик эд ангиуд нь оч үүсгэдэггүй байна.

633. Ачаа тээвэрлэх үеийн хөдөлгөөний хурд, өсгөх (бууруулах) хурдатгал нь үйлдвэрлэлийн технологийн процессын удирдамжид зааснаас хэтрэхгүй байна. Хэрэв эдгээр үзүүлэлтийг заагаагүй бол тухайн өргөх, тээвэрлэх төхөөрөмжийн техникийн өгөгдлийг баримтална.

634. Химиин бодисыг үйлдвэрлэгчийн ашиглалтын зааврын дагуу хадгална.

635. Шуудайтай (зөөлөн чингэлэгтэй) амиакийн, натрийн болон кальцийн шүүг исэлдүүлэгчийн нэг агуулахад хамтад нь хадгалж болох ба дэр тавиур дээр өрж нэг нэг тасалгаанд тус тусад нь эгнээгээр буюу тусдаа тасалгаануудад хадгална.

636. Эгнээ хооронд тоног төхөөрөмж явах зайд 1.3 метрээс, эгнээ хоорондуур хүн явах зайд 1 метрээс, тоног төхөөрөмж явах гол зам 2 метрээс багагүй байна.

637. Шуудай (зөөлөн чингэлэг)-г нуруулдаж хураасан эгнээний өндөр 2.6 метрээс, өргөн 5 метрээс ихгүй байна.

638. Мөхлөгт амиакийн шүүг бункер, цамхагт агуулахад задгайгаар, хатуу хучлагатай задгай талбайд бүх төрлийн чингэлэгтэй хадгалж болно. Агуулах ба талбайг зориулалтын ачих, буулгах механизмаар тоноглосон байна.

639. Исэлдүүлэгч бодис хадгалах байр нь татах яндантай байна.

640. Амиакийн натрийн болон кальцийн шүүг бункер болон ёроолоороо буулгагчтай хадгалах савнаас бусад шаландаа гүнзгийрүүлэн ухсан хонхор, сувагтай

тасалгаанд задгайгаар хадгалахыг хориглоно. Агуулах нь хуурай байх ба дээвэр, шалны хэсгээр чийг орохоос хамгаалагдсан байна. Шүүний агуулахыг жилд нэгээс доошгүй удаа цэвэрлэх ба шаардалагатай бол шал, хананы завсар зайлж битүүлж засварлана.

641. Аммиакийн натрийн болон кальцийн шүү хадгалах агуулах нь цаг тутмын агаарын солилцоо хангах ердийн байгалийн агааржуулалттай байна.

642. 200 м² болон түүнээс их талбай бүхий аммиакийн натрийн болон кальцийн шүү хадгалах агуулахыг галын дохиоллын автомат системээр тоноглоно. Шүүний агуулахад ил гал гаргахыг хориглоно.

643. Аммиакийн шүүг задгайгаар хадгалах бункер, цамхагт агуулахын дамжуулан тээвэрлэх төхөөрөмжийн дээд гүүр (талбай) нь захаараа 0.14 метрээс багагүй өндөр битүү хашлагатай, битүү шалтай байна.

644. Шүүг хадгалах явцад байнгын хяналтын системтэй байх ба задралын шинж тэмдэг буюу халалт, азотын ислийн эсвэл аммиакийн онцлог хүчтэй үнэр гарч байгаа эсэх зэргийг тогтмол шалгана.

645. Задгай шүүтэй агуулахад дотоод шаталтын хөдөлгүүртэй сэрээт ачигч, авто тээврийн хэрэгсэл оруулахыг хориглоно.

646. Шүүтэй ажиллах тоног төхөөрөмжийн тосолгооны цэг, хэсгүүд хамгаалалттай байх ба тос, түлшээр шүү болон шүүний уусмалыг бохирдуулахгүй байхаар хийгдсэн байна. Санамсаргүй тохиолдлоор асгарсан сэрээт ачигчийн аккумуляторын шингэн хүхрийн хүчлээр бохирдсон аммиакийн шүүг агуулахаас яаралтай гаргах ба шүү асгарсан газрыг цэвэрлэж усаар угаана.

647. Дагтаршиж хатуурсан шүүг тэсэлж сийрэгжүүлэхийг хатуу хориглоно.

648. Карбамидыг шуудайтай болон контейнерт хадгалахыг зөвшөөрнө.

Карбамид, полиакриламид, карбоксиметилцеллюлозыг тус тусын поддон дээр, тус тусад нь эгнээ болгон хамт нэг агуулахад хадгалж болно.

649. Тэсрэх бодисын үйлдвэрийн бүсэд аюулгүйн зайлг тооцоходоо аммиакийн шүүг оролцуулахгүй.

650. Шатамхай металлын нунтагийн агуулахыг үрэлт болон цохилтод оч үүсгэдэггүй, шатамхай бус материалаар хийнэ. Шатамхай металлын нунтагийн агуулах дор зоорь хийх, шаланд хонхор нүх гаргахыг хориглоно.

651. Шатамхай металлын агуулах нь хур тунадас, хөрсний ус нэвтрэх болон хураасан савлагаатай металл дээр нарны шууд тусгал тусахаас хамгаалсан байна.

Зуны улиралд гадна агаарын температур өндөр (35°C, түүнээс их) байх үед агуулахыг өглөө, оройн цагаар заавал агааржуулна. Цаг агаарын хуурай нөхцөлд, агуулахын доторх агаарын чийгшил нь гаднах агаарын чийгшилээс харьцангуй их үед агуулахыг агааржуулна.

652. Агуулахад зөвхөн ачиж буулгах ажлыг гүйцэтгэх бөгөөд савлагаатай металл (хөнгөн цагааны нунтаг)-ыг суллах, дамжуулж савлах болон гал гаргах, бусад ажил гүйцэтгэхийг хориглоно.

653. Натрийн нитритийг тусдаа агуулахад дэр тавиур дээр, шуудайтай хадгална.

Натрийн нитритийг шүү болон бусад материалтай хамт хадгалахыг хориглоно.

654. Гал унтраах автомат систем нь заавал гар унтраалгатай байна. Гал унтраах автомат систем ажиллах үед үйлдвэрт ажиллаж байгаа ажилчид, технологийн процессыг зайнаас удирдах хэсэгт болон галын хэсэгт мэдээлэх дохио ажиллана.

Технологийн процессыг зайнаас удирдах үед гал унтраах систем автоматаар ажиллах буюу зайнаас удирдах хяналтын самбараас ажиллуулна.

Гал унтраах систем ажиллах үед технологийн тоног төхөөрөмж болон бусад цахилгаан төхөөрөмжийг автоматаар унтраах шийдлийг үйлдвэрлэлийн технологийн процессын удирдамж боловсруулагч тодорхойлсон байна.

655. Агаар сэлгэлтийн сорох хоолой огцом эргэлтгүй, алгуур, шулуун хэлбэртэй байна. Агаар сэлгэлтийн хоолой нь сорох тал руугаа налуу байх ба тоос буухыг багасгах зорилгоор хэвтээ хэсгийн урт нь бага, мөн хуримтлагдсан тоосыг цэвэрлэх зориулалтын нээгдэж хаагддаг цонх, нээлхийтэй байна. Нээлхийний таглааны эд ангийг үрэлт цохилтоос оч үүсгэдэггүй материалыаар хийнэ.

656. Тоос барих төхөөрөмжийн агааржуулалтын системийн элементүүдийг шатамхай бус, тоостой агаарт агуулагдах тэсрэх бодис ба түүний бүрэлдэхүүн хэсгүүдтэй химийн урвалд ордоггүй материалыаар хийнэ.

657. Агаар сэлгэгчийн сувгийн агаарын хурдыг түүнд тоос суулгахгүй байхаар тооцно, гэхдээ 10 м/сек-ээс багагүй байна.

658. Агаар сэлгэлтийн төхөөрөмжөөс гадагш хаягдах тэсрэлтийн болон галын аюултай тоос агуулсан агаарыг зөвшөөрөгдөх дээд хэмжээнд хүртэл цэвэрлэнэ.

659. Агааржуулалтын системд тэсрэмтгий бодисын тоос хуримтлагдах магадлалтай хэсэг бүрээс бие даасан хавхлага хийнэ.

Тусгаарлагдсан өрөөнд байрлах исэлдүүлэгчийн болон шатамхай металлын тоос сорох янданг агааржуулалтын нэгдсэн системд холбоыг хориглоно.

660. Агааржуулалтын нэгдсэн системийн сорох болон тэсрэх бодисын тоос ихээр ялгардаг өрөөний сорох системийн сэнс, шүүлтүүр, хаалт зэрэгт тэсрэлтийн хамгаалалттай агааржуулалтын төхөөрөмж ашиглана.

661. Тэсрэх бодис болон түүний бүрэлдэхүүн хэсгийн тоос ялгардаг технологийн процесс явагдах үйлдвэрийн өрөөний агаар сэлгэлтийг агаар сэлгэх төхөөрөмжийн ажиллагаа зогссон үед түүнд тэсрэлтийн аюултай тоос нэвтрэхгүй байхаар хаалт хийсэн нөхцөлд ердийн агаар сэлгэлтээр шийдэж болно.

662. Галын болон тэсрэлтийн аюултай үйлдвэрлэлийн процесс явагддаг барилгын агааржуулалтын төхөөрөмжийг нэг барилгаас нөгөөд гал дамжуулахгүй байхаар хийнэ.

663. Тэсрэлтийн аюултай барилга нь байгалийн агаар сэлгэлттэй бол цагт нэгээс доошгүй удаа агаар сэлгэлт хийх нөхцөлөөр хангагдсан байна.

664. Үйлдвэрлэлийн хэрэгцээний дулаан хангамжийн эх үүсвэр, халаалт, агаар сэлгэлт зэргийг өөрийн халаалтын уурын зуух, эсвэл цахилгааны эх үүсвэрээр хангаж болно. Хэрэв зуухнаас 135°C -ээс дээш температуртай уур, 100°C -ээс дээш температуртай ус нийлүүлдэг бол объект, барилга бүрт температур даралтыг шаардлагатай хэмжээнд бариулах дулааны зангилаатай байна.

Тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх бодис бэлтгэх байрны ашиглалтын шаардлага. Техникийн болон технологийн баримт бичгүүд

665. Тэсрэх бодисын үйлдвэрийн технологийн процессын удирдамжид дараахь баримт бичгүүд багтана. Үүнд:

- а) уг удирдамжийг боловсруулахад ашигласан баримт бичгийн жагсаалт;
- б) үйлдвэрлэж (бэлтгэж) байгаа тэсрэх бодис, түүхий эд, ба туслах материал, хагас боловсруулсан бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн процессын явцад үүсэх шатамхай хий ба химиин бүтээгдэхүүний шинж чанар, тэдгээрийн хоруу чанар (зөвшөөрөгдөх дээд хэмжээг заах), тэсрэлтийн болон галын аюултай шинж чанар, тэдгээртэй харьцах дүрэм, заавар;
- в) үйлдвэрлэлд ашиглаж буй бодисын цахилгааны (хувийн цахилгаан эсэргүүцэл) ба цахилгаан статик цэнэгт мэдрэмтгий шинжийн (дөл авалцах хамгийн бага энерги) үзүүлэлтүүд, статик цахилгаанжилтаас хамгаалах хэрэгслийн тодорхойлолт;
- г) технологийн горимоор ажиллах дарааллын дагуу бичсэн технологийн процессын тайлбар, схемүүд, тэдгээрийг хянах хэмжих хэрэгсэл, дээж авах журам, хугацаа, хагас боловсруулсан болон бэлэн бүтээгдэхүүнийг хадгалах болон тээвэрлэх шаардлага;
- д) технологийн процессын удирдлага ба хяналтын схем;
- е) түүхий эд материалыг үйлдвэрлэлд оруулах зөвшөөрөл (оролтын хяналт);
- ё) технологийн үндсэн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн товч тодорхойлолт;
- з) тоног төхөөрөмжийг ажилд бэлтгэх дараалал;
- ж) тоног төхөөрөмжийн болзошгүй гэмтэл ба тэдгээрийг засч запруулах арга хэмжээ;
- и) тоног төхөөрөмжийг цэвэрлэх, угаах дараалал;
- к) гологдлын төрлүүд, тэдгээрийг засах болон урьдчилан сэргийлэх аргууд;
- л) үйлдвэрлэлийн хаягдлыг дахин ашиглах, устгах журам;

м) хаягдал ус болон хийн хаягдлыг цэвэрлэх, хоргуйжүүлэх арга, хэрэгсэл;

н) үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны шаардлага, галын аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуйн шаардлага.

666. Технологийн процессын удирдамж, түүний өөрчлөлтийг төслийн баримт бичиг, хэрэглэх тоног төхөөрөмжийн ашиглалтын зааврыг үндэслэн тэсрэх бодисын үйлдвэрийг хариуцагч байгууллага өөрөө боловсруулна. Технологийн процессын удирдамж нь тухайн үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийн үндсэн хэсэг байна.

Үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг үндэслэн боловсруулсан үйлдвэрийн үйл ажиллагааны технологийн горим, түүний өөрчлөлтийг ашиглагч байгууллагын техникийн хариуцлагатай удирдагч батална.

Батлагдсан үйлдвэрийн үйл ажиллагааны технологийн горим нь байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх баримт бичиг болно.

667. Технологийн горимд 5 жил тутамд хяналт хийнэ. Хяналтын удирдамжийг ашиглагч байгууллагын техникийн хариуцлагатай удирдагч батална.

668. Ашиглагч байгууллагын техникийн хариуцлагатай удирдагчийн зөвшөөрлөөр үйлдвэрийн технологийн горимын баримт бичигт өөрчлөлт оруулна.

669. Тэсрэх бодисын үйлдвэрлэлийн бүтцийн нэгж хэсгийн технологийн болон засварын ажил гүйцэтгэгч ажилтнуудын ажлын байр бүрт аюулгүй ажиллагааны заавартай байна.

670. Тухайн ажлын байранд гүйцэтгэх ажил өөрчлөгдөх бүр аюулгүй ажиллагааны зааврыг хянаж, өөрчилнө.

671. Тэсрэлтийн болон галын аюултай байранд ажиллах ажилчдын тоог технологийн горимд заасан байна.

672. Технологийн тоног төхөөрөмжийг ажиллуулаагүй үед зааврын дагуу тэдгээрээс тэсрэх бодисыг цэвэрлэх ба цахилгааны эх үүсвэрээс салгаж, үйлдвэрийн хаалгыг хааж цоожлон, лацдаж харуулд хүлээлгэж өгнө. Хэрэв зарим тоног төхөөрөмжийг ажлын нөхцөлд үлдээх шаардлагатай бол байнгын хяналтад байлгана.

673. Ажлын ээлжийн төгсгөлд үйлдвэрлэлийн хаягдлыг (бохирдсон түүхий эд, асгарсан бодис) үйлдвэрийн байрнаас гаргаж, хог хаягдлын цэгт түр хадгалах эсвэл устгалд оруулна. Хаягдлыг устгах давтамжийг технологийн горимд тусгасан байна.

Хаягдлыг цуглуулах сав нь бүтээгдэхүүний сав баглаа боодлоос ялгагдах тэмдэгтэй байна. Савлах цэгийг тэмдэгжүүлсэн байна. Хоорондоо урвалд орох бодисын хаягдлыг нэг саванд хамт хийхийг хориглоно.

674. Үйлдвэрийн байранд тухайн үйлдвэрлэлд хэрэглэгддэггүй багаж хэрэгсэл, материал хадгалахыг хориглоно.

675. Тоног төхөөрөмж, барилгын хана, агааржуулалтын хоолой, ялангуяа тоног төхөөрөмжийн доргилт, цохилттой хэсэгт, шалан дээр, халуун гадаргуутай тоног төхөөрөмж дээр бүтээгдэхүүний тоос болон исэлдүүлэгч уусмалын тоосонцорын хуримтлал үүсгэхгүй байна. Тоос болон уусмалыг ажлын үед тогтмол цэвэрлэнэ.

Үйлдвэрийн байр, тоног төхөөрөмжийг тоос, уусмал, бүтээгдэхүүний үлдэгдлээс цэвэрлэх цэвэрлэгээний хугацаа болон аргыг технологийн баримт бичиг, горимд тусгасан байна.

676. Тэсрэх бодисын үйлдвэрлэлийн үед ашиглах ажлын ширээний тавцан гөлгөр гадаргуутай, зайд завсаргүй, ирмэгийн хашлагатай, илүү гарч цухуйсан оворгүй, цахилгаан дамжуулах материалыаар бүрсэн, газардуулгатай байна.

677. Тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх бодис бэлтгэх байранд өдөөх, тэслэх хэрэгсэл, галт зэвсэг, галын эх үүсвэр (шүдэнз, асаагуур) оруулахыг хориглоно. Тэсрэлтийн аюултай байранд цахилгаанаар халаагч хэрэгсэл ашиглахыг хориглоно.

678. Ажиллагаагүй болсон бүх төрлийн аппарат, тоног төхөөрөмж, холбоос деталь, багаж хэрэгсэл, тэсрэх бодистой харьцаж байсан хэрэгслийдийг засварлах эсвэл устгахын өмнө бохирдоос маш сайн цэвэрлэж, угаах ба шаардлагатай бол шатааж устгана. Цэвэрлэгээ хийсэн талаар акт үйлдэж баримтжуулна.

Тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх тоног төхөөрөмжид тавих шаардлага

679. Галын болон тэсрэлтийн аюултай үйлдвэрийн бүх тоног төхөөрөмжийг газардуулсан байна. Газардуулгын үзлэг шалгалт, туршилтыг цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалтын зааварт (дүрэмд) тодорхойлсон хугацаанд хийнэ.

680. Хөндлөн огтолол нь 6 мм-ээс багагүй дамжуулагч утсаар хийсэн газардуулагчийг цэнэглэгч машинаас газардуулагч төхөөрөмжид боолтоор холбосны дараа цэнэглэгч машинд тэсрэх бодис (хольцуудыг) ачаална. Газардуулагчийн утас, холбогч гадаргууг зэврэхээс хамгаалсан байна.

681. Тоног төхөөрөмжийн бүтэц хэсгүүд, ялангуяа үрэлттэй хэсгүүдийн хооронд бүтээгдэхүүн орох зайд завсаргүй хийгдсэн байна.

682. Тоног төхөөрөмжийн эд ангиуд, фланц, люк зэргийг холбох жийргэвчүүдийг тухайн ашиглагдаж буй химиин бодист тэсвэртэй, уян материалыаар хийсэн байна.

683. Тэсрэх бодисын үйлдвэрийн тоног төхөөрөмж нь тэсрэх бодис болон исэлдүүлэгч (исэлдүүлэгчийн уусмал) дээр тос, тосолгооны материал дусах, гоожих боломжгүйгээр хийгдсэн байна.

684. Бүх тоног төхөөрөмж, савны дотор үзлэг, цэвэрлэгээ хийх боломжоор хангагдсан байна.

685. Удаан хугацаанд хадгалахад задрал үүсдэг бодис бэлтгэдэг тоног төхөөрөмж, мөн тэдгээр бодисыг дамжуулах шугам хоолой зэргийн аль нэг хэсэгт бүтээгдэхүүний үлдэгдэл, зогсонгийн байдал үүсэх боломжгүйгээр хийгдсэн, гадаргуу нь гөлгөр, наалдсан бодисоос хялбар цэвэрлэгддэг байна. Дулаан тусгаарлах.

материал нь галд тэсвэртэй, харьцаж байгаа химиин бодисуудад химиийн идэвхгүй шинж чанартай байна.

Тоног төхөөрөмжийн хийц хэсгүүд нь тэсрэх бодис болон түүний хольц хэсгүүд, хагас боловсруулсан бутээгдэхүүнтэй харилцан үйлчлэлд ордоггүй материалыаар хийгдсэн байна. Ислэлдүүлэгчтэй харьцах боломжтой тоног төхөөрөмжүүд болон тэдгээрийн деталь хэсгийг зэс, цайр, хар тугалга, тэдгээрийн хайлшаар үйлдвэрлэхийг хориглоно. Тоног төхөөрөмжийн зарим хэсэг, тухайлбал галын болон тэсрэлтийн аюултай бодистой харьцдаг хэсгүүдийг цохилт болон үрэлтэд оч хаяхгүй материалыаар хийнэ.

686. Тэсрэх бодистой тоног төхөөрөмжийн дотор эргэх гол байрладаг бол, тэрхүү голын холхивчуудыг тоног төхөөрөмжийн гадна талд байрлуулсан байна. Холхивчийг тэсрэх бодисоос тусгаарлаж байгаа хана, холхивч хоёрын хоорондын зاي 40 мм-ээс багагүй байна.

687. Алсын зайнаас удирдлагатай тоног төхөөрөмж нь түүнийг ажлын байрнаас ажиллуулах, унтраахад зориулсан давхар удирдлагатай байна.

688. Ашиглалтад оруулж (хүлээн авч) байгаа тоног төхөөрөмж, хянах хэмжих хэрэгсэлүүд, аппаратуудыг тэсрэх материалтай харьцан ажиллах зөвшөөрөл олгохын өмнө хоосон байдлаар, орлуулах загвар ашиглан шалгаж, ажиллахыг зөвшөөрөх тухай акт үйлдэнэ.

Статик цахилгаанаас хамгаалах аргууд

689. Шигших, тээрэмдэх, бутлах, холих аппаратуудаас бутээгдэхүүн ачих, буулгах, хийн болон вакуум шахуургаар тээвэрлэх зэрэг процессын үед статик цахилгаан цэнэг үүсэх болон хуримтлагдах өндөр магадлалтай. Технологийн процессын удирдамж болон технологийн процессын заавар боловсруулагч нь үйлдвэрлэх бутээгдэхүүний төрөл бүрээр статик цахилгааны аюулгүй байдлыг хангах технологийн процессын зөвшөөрөгдөх параметрүүдийг тогтоож баримт бичигт тусгасан байна.

690. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны онцлогоос хамаарч цахилгаан статик цэнэг үүсэх аюулаас сэргийлэхийн тулд дараахь арга хэмжээнүүдийг урьдчилан тооцсон байна. Үүнд:

- а) цахилгаан дамжуулах тоног төхөөрөмж, хэлхээнд газардуулга хийх;
- б) саармагжуулагч хэрэглэх;
- в) антистатик ремень (тууз) хэрэглэх;
- г) хоорондоо хүрэлцэх эерэг, сөрөг цэнэгээр цахилгаанждаг материалыудыг хослуулж сонгох;
- д) орчны агаарыг чийгшүүлэх;
- е) тоног төхөөрөмжид цахилгаан дамжуулагч материал ашиглах;
- ё) ажлын тусгай хувцас хэрэглэх.

691. Статик цахилгаан цэнэг үүсэх идэвхжилийг багасгахын тулд дараахь шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

- а) агаарт дэгдсэн шингэн болон хатуу тоосонцорыг цэвэрлэх, технологийн хувьд боломжтой бол шингэнийг уур-хий тоосонцорын хатуу болон шингэн хольцын бохирдоос цэвэрлэх;
- б) шатамхай орчны агууламжийг тэсрэлтийн аюултай хязгаарын үзүүлэлтэд хүргэхгүй байх;
- в) бодисыг цацах, нунтаглах, тоосруулах зэрэг технологийн процесст шаардагдаагүй үйлдлийг хориглох;
- г) шугам хоолой, шланг, форсунк, хошуунаас гарах уур, хий конденсацлагдахгүй, талсжихгүй байх;
- д) технологийн процессоор зөвшөөрөгдсөн бол агаарын харьцангуй чийгшлийг 65%-иас багагүй байлгах;
- е) тээвэрлэлт, боловсруулалтын хурдыг бууруулж, тоос-уур хийн холимог ба шингэний урсгалын хийлралтыг багасгах.

692. Статик цахилгаан цэнэг үүсч, хуримтлагдах боломжтой технологийн бүх тоног төхөөрөмж /шингэн, хий, уур, хуурай материалыг дамжуулах, боловсруулахад зориулагдсан аппаратууд, емкость савнууд, шугам хоолой, ажлын ширээ тавцангийн гадаргуу, савлах болон юулэх төхөөрөмж зэрэг/-ийг металл /төмөр/ эсвэл цахилгаан дамжуулах материалаар хийж, газардуулсан байна.

693. Бүтээгдэхүүнийг нунтаглах, холих, цацах, дамжуулах процесс явагддаг аппаратууд, емкость савнууд, холбоосууд, шугам хоолойнууд, мөн тусдаа байрлаж үндсэн системийн тоног төхөөрөмжтэй шугам хоолойгоор холбогдсон машин, төхөөрөмжийг тэдгээртэй холбогдсон байгууламжууд ерөнхий газардуулгын хэлхээнд холбогдсон эсэхээс үл хамааран барилгын дотоод газардуулгын хүрээнд тус тусад нь салаалж газардуулна.

Хэд хэдэн тоног төхөөрөмж, аппарат, шугам хоолойг цуваа холбоосоор газардуулахыг хориглоно.

Статик цахилгаанаас хамгаалах газардуулгыг цахилгаан тоног төхөөрөмжийн газардуулгатай нэгтгэн холбохыг зөвшөөрнө.

Газардуулах холбоосууд, тэдгээрийг холбох аргыг техникийн баримт бичигт зааж өгнө. Үйлдвэрийн барилга бүрт газардуулгын схем зураг хийсэн байна.

694. Цахилгаан дамжуулах материалаар (метал биш) хийсэн тоног төхөөрөмжийн дотор гадаргууд хамгийн зйтай орших дурын цэгийн дотор газардуулгын хүрээтэй харьцуулсан газардуулгын эсэргүүцэл нь 10^6 Ом-оос ихгүй байна. Зөвхөн статик цахилгаанжилтаас хамгаалах зориулалтын газардуулгын төхөөрөмжийн эсэргүүцэл 100 Ом-оос ихгүй байна.

695. Газардуулгын холбоосууд болон газардуулгын хүрээ нь тэдгээрт үзлэг шалгалт хийх боломжтой ил байрлалтай байна. Ингэхдээ тэдгээрийн механик үйлчлэлд болон химиин бодисын нөлөөлөлд орохгүй байх нөхцөлийг хангасан байна.

696. Технологийн тоног төхөөрөмжийнг статик цэнэгээс хамгаалах газардуулгын дамжуулагч утасны тоног төхөөрөмжид болон газардуулгын дотоод хүрээнд холбох хэсгийг 15 мм өргөн хөндлөн улаан зураасаар тэмдэглэсэн байна.

697. Газардуулгын хүрээний элементүүдийг хооронд нь болон газардуулагчийг газардуулгын хүрээ ба газардуулж буй тоног төхөөрөмжид гагнаж холбоно. Гагнуур хийж холбох боломжгүй бол найдвартай болтон холбоосоор холбоно. Ингэхдээ газардуулагч утасны голын үзүүрт битүү цагираг гагнаж буюу давтаж холбосон байна. Болтон холбоосыг зэврэлтээс хамгаалсан байна.

698. Бие биенээсээ 0.1 метр хүртэл зайд зэрэгцээ байрлах дамжуулах хоолойнуудыг 20 метр тутамд хооронд нь тушиж холбоно. Дамжуулах шугам хоолойнууд хоорондоо болон төмөр шат, барилгын хийц хэсэгтэй 0.1 метрээс бага зайд оттолцох бол тэдгээрийг мөн хооронд нь тушиж холбоно.

Агааржуулалтын металл хоолойнуудыг 20 метр тутамд хөнгөн цагааны хайлشاар хийсэн 5 мм-ээс багагүй диаметртэй дамжуулагч, 24 mm^2 -ээс багагүй хөндлөн оттоллой лент ашиглан газардуулна.

699. Газардуулсан их биеэсээ хөндийрч гэмтэх боломжтой машин тоног төхөөрөмжийн эргэлдэх хөдөлгөөнтэй цахилгаанждаг эд анги нь газардуулга холбох зориулалтын цахилгаан гүйдэл баригч төхөөрөмжтэй байна. Бодисын цахилгаанжилт эрчимтэй явагддаг хэсэг бүхий төхөөрөмж болон доргиурт тоног төхөөрөмжийн хөдөлгөөнтэй хэлхээг 2-оос доошгүй цэгт газардуулна.

Хуурай бүтээгдэхүүнийг шатах шингэний ууртай төхөөрөмжийн нээлхийрүү цаас, полиэтилен, полихлорвинил болон бусад цахилгаанжих төрлийн материалаар хийсэн уут, шуудайнаас шууд асгаж хийхийг хориглоно. Энэ тохиолдолд цахилгаан дамжуулдаг материалыаар хийсэн, аль болох бага тоосжилт үүсгэдэг зориулалтын юулэх төхөөрөмж ашиглана.

Хуурай бодисоос дээж авах буюу технологийн үзүүлэлт хэмжихээр төхөөрөмжөөс дээж авахдаа дээж авагч багаж, төхөөрөмжийг заавал бодисын тоосжилт буусны дараа оруулна.

700. Үйлдвэрлэлийн нөхцөлд ашиглагч байгууллагын техникийн удирдагчийн баталсан хуваарийн дагуу жилд 2-оос доошгүй удаа цахилгаанжилтын үзүүлэлтийн хэмжилт хийнэ.

Тэсрэх бодисын үйлдвэрт тэсрэх материалыг хадгалах,
бүртгэх үйл ажиллагаа

701. Тэсрэх материалын үйлдвэрийн хог хаягдалтай харьцахдаа тэсрэх материалыг хадгалах болон бүртгэх журмыг нэгэн адил дагаж мөрдөнө.

702. Үйлдвэрлэсэн тэсрэх бодисын нийт хэмжээг түүнийг үйлдвэрлэхэд зарцуулагдсан бүрэлдэхүүн хэсгийн орцуудын хэмжээгээр тодорхойлно.

703. Тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх байранд холин цэнэглэгч машинд ачилт хийсний дараа түүний ачилт, буулгалтын нээлхийнүүдийг хааж лацадсан байна.

704. Шатамхай металл агуулаагүй тэсрэх бодис, эмульс ачсан холин цэнэглэгч машиныг харуул хамгаалалттай, тусгаарласан зориулалтын талбайд эсвэл цэнэглэгч машиныг ачих байранд 2 хоногоос хэтрэхгүй хугацаанд байлгаж болно. Цэнэглэгч машинд байх тэсрэх бодисын хэмжээг бүртгэж, машины ачих буулгах нээлхийг лацдах ба харин хадгалах байр нь энэхүү дүрмийн 673-ын шаардлагыг хангасан байна.

НАЙМ. ТЭСРЭХ МАТЕРИАЛЫН АГУУЛАХ БАЙГУУЛАХ, АШИГЛАХАД ТАВИХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ШААРДЛАГА

705. Тэсрэх материалыг энэхүү дүрмийн шаардлагыг хангасан, зориулалтын байр, тасалгаанд хадгална. Тэсрэх материал хадгалах агуулах, байрыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хамтран актаар ашиглалтад оруулна.

706. Аюултай байдлын зэрэглэлийн ангиллаар ялгаатай тэсрэх материалыг тус тусад нь хадгална. Дор дурдсан тэсрэх материалыг нэг агуулахад хадгалж болно. Үүнд:

- а) D ангиллын утаат болон С ангиллын утаагүй дарийг тэдгээрийн аль илүү мэдрэмтгий чанарт тавигдах шаардлагыг хангасны үндсэн дээр;
- б) G ангиллын гал дамжуулах шижим болон дарийг асаах хэрэгсэл, дохионы, дарьт патрон, дохионы пуужинг В, С болон D ангиллын тэсрэх материалтай хамт;
- в) D ангиллын цочир дамжуулах шижим, цочир дамжуулах туузыг В хамтатгах ангиллын ердийн тэслүүр, цахилгаан тэслүүр болон пиротехникийн релетэй хамт;
- г) S ангиллын өдөөх хэрэгслийг В ангиллын өдөөх хэрэгсэлтэй хамт;
- д) S ангиллын кумулятив цэнэгийг D ангиллын кумулятив цэнэгтэй хамт;

707. Байнгын болон түр, түгээх агуулахыг эзэмшигч байгууллага нь энэхүү дүрмийн Хавсралт 15-ын дагуу агуулахын паспорттай байна. Агуулахын паспортын нэг хувийг агуулахад хадгална.

708. Судалгааны болон сургалтын байгууллага нь ашиглах, хадгалахыг нь зөвшөөрсөн тэсрэх материалтай хамт (жишээ нь: нэг сейфэнд) шинээр бэлтгэсэн тэсрэх материалыг хамт хийж хадгалахыг хориглоно.

709. Агуулахад байгаа тэсрэх материалтай задалсан хайрцаг савыг таглаж, онгойлгосон уутны амыг боосон байна.

710. Тэсрэх материалтай агуулахыг цоожилж, дугаартай, нэг удаагийн лацаар лацадсан байна.

711. Тэсрэх материал хадгалах зориулалтаар газрын дээр нэг талбайд цогцоор байгуулсан агуулах, чингэлэг, болон туслах зориулалтын барилга байгууламжууд (бүхэлд нь тэсрэх материалын агуулах, агуулах-үйлдвэрийн цогцолбор гэх), далд уурхай дахь тэсрэх материал түгээх агуулах зэрэг нь тэсрэх материал хадгалах, үйлдвэрлэх, бэлтгэх бусад байрыг “Тэсрэх материалын агуулах, түүний зураг төсөл,

агуулахын аюулгүйн бүс тогтоолгох, ашиглахад тавигдах шаардлага"-ын дагуу батлагдсан төслөөр байгуулж, тоноглон, энэхүү дүрмийн шаардлагын дагуу ашиглана. Харин далд уурхайн тэсрэх материал түгээх цэг нь паспорттай, төсөлгүй байж болно. (Энэ заалтыг Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан)

712. Тэсрэх материалын агуулахыг байрлалын хувьд газрын дээрх (ил), хагас далдлагдсан, далдлагдсан, газрын доорх гэж ангилна. Газрын дээрх гэж агуулахын суурь нь газрын гадарга дээр ил байрласан, хагас далдлагдсан гэж газрын хөрсөнд суулгаж агуулахын дээврийн хормой нь газрын хөрснөөс доош суулгаж барьсан, далдлагдсан агуулах гэж агуулахын дээрх хөрсний зузаан газрын хөрснөөс доош 15 метрээс илүүгүй гүнтэй, газрын доорх гэж агуулахын дээрх хөрсний зузаан нь 15 метрээс их гүнд байрласан агуулахуудыг тус тус хэлнэ.

713. Агуулах нь ашиглалтын хугацаанаас хамааран байнгын, түр (3 жил хүртэл), богино хугацааны (1 жил хүртэл) байна. Түр агуулахыг комисс зөвшөөрсөн тохиолдолд дахин хугацааг нь сунган ашиглах боломжтой. Агуулахыг ашиглахгүй болсон талаарх мэдээллийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

714. Тэсрэх материалын агуулахыг зориулалтаар нь төв болон түгээх гэж ангилна.

715. Улирлын чанартай болон хөдөлгөөнтэй ажилд зориулж тэсрэх материал, аммиакийн шүүг контейнерт хадгалж болно. Контейнерүүдийг тэсрэх материалын агуулахын хэсэг болгож, эсвэл тусад нь дан контейнерүүдээс бүрдсэн тэсрэх материалын агуулах байдлаар тоноглож болно. Контейнерүүд нь бүрэн бүтэн байх ба дугаарлагдсан, лацтай байна. Тэсэлгээний хэрэгслийг контейнерт хадгалахдаа тэдгээрийг агуулахад хадгалахад тавигдах шаардлагыг мөрдөж хадгална.

716. Аммиакийн шүүг тэсрэх материалын агуулахын тусгай байр, талбайд хадгална.

717. Тэсрэх материалын агуулахад хадгалж буй аммиакийн шүүнд бусад тэсрэх материалын нэгэн адил бүртгэл хөтөлнө. Тэсрэх материалын агуулахын паспортом аммиакийн шүүний хадгалалтыг тусгайлан заасан байна.

718. Агуулахад хадгалах болон тэсрэх бодис үйлдвэрлэх цэгт байгаа аммиакийн шүүг тэсрэх материалын агуулахын аюулгүйн бүсийн тооцоонд оруулж тооцохгүй.

719. Тэсрэх материалын агуулахын болон ачих, буулгах зориулалтын бункерүүдэд хадгалсан задгай аммиакийн шүүг 10 хоногоос илүү хугацаанд хөдөлгөөнгүй байлгаж болохгүй.

720. Далдлагдсан болон газрын доорх түгээх агуулах болон тэсрэх материал түр хадгалах малталтуудын багтаамжийг төслөөр тодорхойлно. Ингэхдээ нүүрсний болон занарын далд уурхай дахь түгээх агуулахын багтаамжийг тэсрэх материал түр хадгалах хонгил, хайрцгуудын хэмжээг оруулахгүйгээр тэсрэх бодисын 7 хоногийн, тэсэлгээний хэрэгслийн 15 хоногийн хэрэглээнээс хэтрэхгүйгээр тооцно. Хонгил агуулахад 2 тн-оос, хайрцагт агуулахад 400 кг-аас хэтрэхгүй тэсрэх бодис хадгална.

Далд малтарт дахь хэсгийн түгээх агуулахад 2 тн-оос илүүгүй тэсрэх бодис, түүнд тохирсон тэсэлгээний хэрэгсэл, тусгай хэсгийн түгээх цэгт 1 тн-оос илүүгүй тэсрэх бодис, түүнд тохирсон тэсэлгээний хэрэгсэл хадгалж болно.

721. Судалгааны байгууллага, лаборатори, сургалтын байгууллага нь судалгааны зориулалтаар ашиглах тэсрэх материалыг сейфэнд хадгалж болно. Тэсрэх материалыг нэг байранд бие биенээсээ тэсрэлт дамжихгүй зайд байрлуулсан сейфэнд төрөл төрлөөр нь тусад нь хадгална. Нэг сейфэнд тэсрэх бодис 10 кг-аас, тэслүүр 500 ширхгээс, цочир дамжуулах болон гал дамжуулах шижим тус бүр 300 метрээс илүүгүй хэмжээтэй байна.

722. Агуулахаас тэсэлгээчинд тэсрэх материал тавьж олгох болон зарцуулагдаагүй тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, буудлагын аппаратыг тэднээс буцааж хүлээж авах байр нь 25 см-ээс багагүй зузаан шатдаггүй (бетон, тоосго г.м.) битүү ханатай, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлд зориулсан хоёр тусдаа тасалгаатай байх бөгөөд агуулахын хаалганаас 20 метрээс ойргүй зайд байрлана. Энэ байр нь тэсрэх материал тавьж олгох үүдний өрөөтэй байна.

Тэсрэх материал тавьж олгох байранд бүх төрлийн тэсрэх материалын хэмжээ 3000 кг-аас, тэслүүрийн тоо 10000 ширхгээс илүүгүй байна. Тэслүүртэй хайрцгийг хананы дагуух тавиур дээр байрлуулна. Энэ байранд тэсрэх материал хадгалахыг хориглоно.

723. Төв агуулахаас тавьж олгох цочир дамжуулах шижимтэй галлагчийг тусгай байранд бэлтгэнэ.

724. Байнгын болон түр тэсрэх материалын агуулахаас тэсрэх материал тавьж олгох, зарцуулагдаагүй тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг хүлээн авах ажиллагааг тусгай байр болон агуулахын үүдний тасалгаанд гүйцэтгэнэ. Энд детонатор тавьж олгох зөвлөвчлөн бүрсэн, эсвэл 3 мм-ээс нимгэнгүй, 10^5 Ом/м-оос ихгүй эсэргүүцэлтэй хагас дамжуулагч резинэн хавтангаар бүрсэн, тавцангийнхаа ирмэгт хөвөөтэй ширээ болон цочир дамжуулах шижим, гал дамжуулах шижим огтлох ширээтэй байна. Цахилгаан детонаторыг статик цахилгаанжилтын нөлөөнөөс хамгаалах зорилгоор ширээг газардуулсан бөгөөд түүний эсэргүүцэл нь 100 Ом-оос илүүгүй байна. Эдгээр байранд тэсрэх материал хадгалахыг хориглоно.

725. Тэсрэх материалын агуулахын тасалгаануудын шал зайд завсаргүй, тэгшхэн, ханыг будсан байна. Тасалгаанууд нь агаар өөрөө орж, гарах агааржуулалтын сувагтай, цас, борооны ус орохоос хамгаалагдсан байна.

726. Тэсрэх материалын агуулахын тасалгаануудад тавцантай байх ба хураасан тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг хананаас 20 см, шалнаас 10 см-ээс багагүй өндөрт байрлуулна. Уут, шуудай, хайрцагтай тэсрэх бодисыг поддон, тавиур дээр чөлөөтэй тоолох боломжтойгоор өрж хураана. Хураалтын өндөр 2 метрээс илүүгүй байна.

Поддон, тавиур болон шуудай байрлуулах зарчмыг агуулахын паспортод заасан байна. Ачих, буулгах механикжсан төхөөрөмж хэрэглэх тохиолдолд хураалтын өндөр 2.6 метрээс ихгүй, хураасан эгнээ, шуудайнуудын хооронд 1.3 метр, поддон, тавиурын хооронд 1 метрээс багагүй зайдтай байна.

727. Уут, хайрцагтай тэсрэх материалыг давхарлаж хураахдаа үйлдвэрлэгчийн зааврыг баримтлана. Задалсан уут, хайрцагтай В, С ангиллын тэсрэх материалыг давхарлалгүй хураана. Ийм тэсрэх материалтай тавиурын дээд давхарын өндөр 1.7 метр, бусад материалынх 2 метрээс илүүгүй өндөртэй байна. Давхар тавцангийн хооронд байрлуулсан тэсрэх материалын уут хайрцагнаас дээд тавцан хүртэлх завсар 4 см-ээс багагүй байна. Тэсрэх материалыг тавиур дээр чөлөөтэй тоолох боломжтойгоор хураана. Тэсрэх материалтай хамт холбогдолгүй бусад зүйл шатамхай болон химийн идэвхитэй материал хадгалахыг хориглоно. Тавиурын төмөр хадаас боолтны толгойг суулгаж далдалсан байна. Тавиурын тавцангийн банзнуудын хоорондын зайд 3 см-ээс илүүгүй байх бөгөөд, доод тавцангийнх завсаргүй байна. (Энэ заалтад Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор 6 дахь өгүүлбэрийг нэмсэн)

728. Агуулах дахь тэсрэх материалтай тавиур болон хураасан эгнээ бүрт тэсрэх материалын нэр, тоо хэмжээ, үйлдвэрлэсэн огноо, баталгаат хугацааг тэмдэглэсэн хуудастай мэдээлэх самбарыг шууд харагдахуйц газар байрлуулна.

729. Цахилгаан тэслүүр, цахилгаан асаах гуурс, дөллөгч болон тэдгээрийг агуулсан тэсрэх материалыг зөвхөн үйлдвэрлэгчийн, эсвэл зориулалтын сав баглаатай хадгална.

730. Асаах болон хяналтын (гал дамжуулах шижмийн хяналтын хэрчим) гуурсыг тэдгээрийг бэлтгэхэд зориулсан тусгай байранд бэлтгэнэ. Энэ байр нь тэсрэх бодис бэлтгэх байрнаас галд тэсвэртэй ханаар тусгаарлагдсан, галд тэсвэртэй будгаар өнгөлсөн дотортой байна. Далд уурхайд асаах гуурсыг зориулалтын хонгилд бэлтгэнэ.

Олон хүн асаах гуурс зэрэг бэлтгэх үед ширээ хүн бүрийг хооронд нь тусгаарлах модон таславчтай байна. Асаах болон хяналтын гуурс бэлтгэх, хадгалах байрны шал зөвлөн дэвсгэртэй байна. Бэлтгэсэн хяналтын гуурсыг дотор талыг нь зөвлөвчилсөн, металл болон металл бүрээстэй модон хайрцаг, шүүгээ, дайзанд хийж түгээх агуулахад хадгална. Хайрцаг, шүүгээ нь таглаа, хаалгатай байна.

731. Аммиакийн шүүнд суурилсан тэсрэх бодистой агуулахын температур 30°C-ээс ихгүй байна.

732. Агуулахад тэсрэх материал ачиж буулгахад ашиглах өргөх механизмын даац нь өргөх нэгж сав баглаатай тэсрэх материалын бохир жингээс багагүй байна. Кран зэрэг өргөх механизмын ган татлагын дамар давхар тормозтой байна.

733. Тэсрэх материалын агуулах дотор ажиллах дотоод шаталтын хөдөлгүүртэй техник нь яндангийн хийг саармагжуулагч болон очны хамгаалагчтай байна. Харин цахилгаан тоног төхөөрөмж (цахилгаан ачигч, телфер гэх мэт) ашиглах бол цахилгааны аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байна.

734. Агуулахын өрөө тасалгаанд засвар хийхдээ тэсрэх материалыг бүрэн чөлөөлж цэвэрлэсэн байна. Тэсрэх материалтай тасалгаанаас капитал ханаар тусгаарлагдсан тасалгаанд засвар хийж болно.

735. Газрын дээрх тэсрэх материалын байнгын агуулах нь дараахь шаардлагыг хангасан байна. Үүнд:

-үерээс хамгаалах, ус зайлцуулах сувагтай байх;

- байнга цэвэрлэж зассан (авто зам, төмөр зам гэх мэт) замтай байх;
 - тэсрэх материал хадгалах байр, агуулахыг байрлуулахдаа тэдгээрийн нэг бүрт чөлөөтэй хүрэх замтай байх нөхцөлийг хангасан байх;
 - агуулах хоорондын, агуулах ба бусад барилга байгууламжийн хоорондын зайд нь галын аюулгүй байдлын норм болон энэхүү дүрмийн IX бүлгийн шаардлагыг хангасан байх;
 - агуулахын талбай нь хашаатай байхын зэрэгцээ хашаанаас гадагш 50 метрээс багагүй зайд хамгаалалтын хориотой бус тогтоож, түүний хүрээгээр анхааруулах тэмдэг тавьсан байна.
736. Агуулахын талбайд (агуулахын хашаанд) дараахь барилга байгууламжууд байна.
- тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цөмлөх болон буудлагын төхөөрөмжийн агуулахууд;
 - тэсрэх материалтай болон аммиакийн шүүтэй чингэлгүүд байрлуулсан талбай;
 - тэсрэх материал тавьж олгох байр;
 - ачаа буулгах тавцан, тэсрэх материал ачих, буулгах, хадгалах зориулалтын байгууламж;
 - мөхлөгт болон эмульсийн тэсрэх бодис бэлтгэх цэг, түүхий эдийг хадгалах байр (тусгаарласан хашаатай);
 - үйлдвэрийн тэсрэх бодисыг механижуулсан цэнэглэлтэнд бэлтгэх цэг, лаборатори;
 - харуулын цамхаг, ~~харуулын нөхөйн хөнүүр~~, гэрэлтүүлэг, камерын цамхаг; (*Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон*)
 - гал эсэргүүцэх хэрэгслийн самбар;
 - шалган нэвтрүүлэх байр (хаалганы гадна талд); (*Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор нэмэлт орсон*)
 - аянгаас хамгаалах байгууламж.
737. Агуулах, үйлдвэрийн аюултай бүсийн хүрээнд дараахь барилга байгууламжууд байж болно. (*Энэ заалтад Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон*)
- тэсрэх материал турших, устгах, сав баглаа шатаах талбай, харуулын байр;
 - агуулахын ажилчдын захиргаа үйлчилгээний байр;
 - механижуулсан тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний байр;

- уурын зуух, газрын тосны бүтээгдэхүүн агуулах сав;
- усан хангамж, бохирын шугам хоолой, насосны станц;
- бууруулах трансформаторын дэд станц;
- сав баглааны сарай, саравч.

Тэсрэх материалын агуулахад хамааралгүй объектууд (барилга байгууламж, хүн ам оршин суух газар) нь энэхүү дүрмийн IX бүлгийн шаардлагын дагуу тооцож тогтоосон аюултай бүсийн гадна байрлана.

738. Агуулахаас хашаа хүртэлх зайд 30 метрээс багагүй байна. Уулархаг газарт энэ зайлгээний төслийн ойттуулж болно. (Энэ заалтад Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон)

Хашааг өргөст тор, тоосго, чулуу, төмрөөр хийнэ. Хашааны өндөр 2 метрээс багагүй байна. Тоосго, чулуу, төмрөөр хийсэн хашааны дээгүүр 0.5 метрээс багагүй өндөртэй 4 үе шулуун эсвэл 1 үе мушгиа өргөст тор татна. Хашаа нь машины болон явган хаалгатай, цоожтой байна.

739. Агуулахын талбай, хориотой бүс дэх мод, бут сөөг, ургамлыг огтолж, хуурай өвс, навч шилмүүсийг цэвэрлэсэн байна.

740. Байнгын агуулахын тэсрэх материал хадгалах байрыг шатдаггүй материалыаар тоноглосон байна. Тэсрэх материал хадгалах байрны дээврийг шатдаггүй материалыаар хийх буюу гадна дотроос нь шатдаггүй материалыаар бүрсэн байна.

741. Тэсрэх материал хадгалах байрны шалыг мод, цемент бетоноор хийсэн байна. Модон шалыг шатдаггүй будгаар будсан байна.

742. Тэсрэх материалыг цөөн тоогоор тавьж олгох зориулалттай хадгалах байрууд үүдний тасалгаа (тамбур)-тай байна. Тамбурыг шатдаггүй материалыаар тоноглох бөгөөд 2x2 метрээс багагүй талбайтай байна. Гаднаас тамбур руу орох, түүгээр дамжин хадгалах байр руу орох гадагшаа онгойдог хоёр хаалгатай байх бөгөөд гадна хаалгыг зэвэрдэггүй төмрөөр бүрсэн байна. Ачих, буулгах тоног төхөөрөмж ашигладаг хадгалах байр нь тамбургүй байж болно. Чингэлэг агуулахын үүдний тасалгааны талбайг 2x1 метр хүртэл багасгаж болно.

743. Тэсрэх материал хадгалах байрны хаалганы тоог нэг тасалгааны хамгийн алс цэгээс хаалгаар гарах зайд 15 метр, хэрэв ачих, буулгах тоног төхөөрөмж хэрэглэдэг бол 25 метрээс ихгүй байхаар тус тус тооцож тогтооно.

744. Тэсрэх материал хадгалах байрны цонхыг 15 мм-ээс багагүй диаметртэй бөөрөнхий төмрөөр 150x150 мм хэмжээтэй тор үүсгэн, үзүүрүүдийг хана руу 80 мм-ээс багагүй гүн суулган бэхэлнэ. Торыг цайвар өнгөөр будна. Наран тал руу харсан цонхны шилийг цайвар өнгөөр будна. Цонхны гэрэл нэвтрүүлэх талбай болон шалны талбайн харьцаа 1:25 -1:30 байна.

745. Тэсрэх материал хадгалж байгаа болон үйлдвэрлэж байгаа байрнаас хамгаалах барилга байгууламж хүртэлх зайлгээний дүрмийн IX бүлэгт заасан

аргачлалын дагуу тооцож, хамгаалалтын далан байгуулна. Далантай агуулахын аюулгүйн зайлхагас далдалсан агуулахтай адилтгаж тооцно.

746. Даланг зөвхөн нарийн ширхэгтэй бутармаг хөрсөөр байгуулна.

747. Далан нь агуулахад хураалттай тэсрэх материалын өндрөөс 1.5 метрээр өндөр байна. Далангийн нуруу дээгүүрээ 0.8 метрээс багагүй өргөнтэй байна. Суурийн өргөн нь түүнийг байгуулсан бутармаг чулуулгийн асгаралтын өнцгөөр тогтоогдоно.

748. Далангаар бүтэн тойруулж хамгаалахдаа агуулахын хаалга руу орох, гарах машин зам байгуулахын тулд даланг тасархай байгуулж, гарц гаргана. Гэхдээ гарцын зурvasыг зэрэгцээ давхар далангаар хаана.

749. Цахилгаан тоног төхөөрөмж (хуваарилах байгууламж, дэд станц, ослын үеийн тэжээлийн эх үүсвэр), тэдгээрийн категори, найдвартай ажиллагаанд тавих шаардлагыг нормативын баримт бичгийг үндэслэн төслөөр тогтоосон байна.

750. Тэсрэх материалын агуулахын хүчний болон гэрэлтүүлгийн цахилгаан тоног төхөөрөмжүүд нь гүйдлийн шүүрлийн болон богино холболтын хамгаалалттай, түүнчлэн хүн цахилгаанд цохиулахаас хамгаалсан байна. Тэсрэх материалын агуулахын цахилгаан тоног төхөөрөмжийн газардуулгыг төслийн дагуу хийнэ.

751. Агуулах, тэсрэх материал хадгалах байрууд, зам талбай нь гэрэлтүүлэгтэй байна. Хашааны дагуу гэрэлтүүлэгтэй байж болно.

752. Агуулахын гэрэлтүүлэг 220В-оос доош хүчдэлтэй байна. Ослын гэрэлтүүлгийг төслөөр тодорхойлно. Ослын гэрэлтүүлэгт хуурай батарейтай, металл гэр, резинэн хамгаалалттай уурхайн гэрэлтүүлэг ашиглаж болно. Тэсрэх материал хадгалах байранд цахилгаан шугамаас тэжээлтэй зөөврийн гэрэл хэрэглэхийг хориглоно. Хэрэв байгалийн гэрэлтэй өдрийн цагаар тэсрэх материал тавьж олгодог бол агуулах цахилгаан гэрэлтүүлэггүй байж болно.

753. Агуулахыг хамгаалалттай цахилгаан гэрлээр гэрэлтүүлж болох бөгөөд цахилгааны хэлхээ нь шаталт дамжуулдаггүй, резинэн бүрхүүлтэй байна.

754. Тэсрэх материал агуулж байгаа тасалгаануудын шалан дээрх гэрлийн тусгал ажлын байранд хэвийн ажиллах шаардлага хангасан байх бөгөөд тэсэлгээний хэрэгсэлтэй харьцах тасалгааных 30 лк-ээс багагүй байна.

755. Залгуур, гал хамгаалагч, хуваарилах самбарыг барилгын гадна талд буюу тусгаарласан тасалгаанд хаалт, таглаатай хайрцганд байрлуулна. Дэргэд нь гал унтраах хэрэгсэлтэй байна.

756. Тэсрэх материалын агуулах нь ашиглагч байгууллага болон онцгой байдал, цагдаагийн байгууллагатай холбоо барих хэрэгслээр хангагдсан байна. Харуулын нэгжүүд хоорондоо холбогдох холбооны хэрэгсэлтэй байна. Холбооны хэрэгслийг тэсрэлтийн аюултай өрөө тасалгааны гадна байрлуулна. Агуулах, тэсрэх материал хадгалах байруудыг төслийн дагуу хамгаалалтын болон галын дохиоллоор тоноглож болно.

757. Агуулахын хашаанд ил гал гаргах эх үүсвэр байлгах, тоног төхөөрөмжийг хэт халаах, оч хаяулах болон хараа хяналтгүй ажиллуулахыг хориглоно.

758. Бүх агуулахыг нэр төрөл, тоо ширхэг, байршлыг нь төслөөр тогтоосон гал унтраах хэрэгслээр тоноглосон байна.

759. Ой хээрийн түймрээс сэргийлж, агуулахын эргэн тойрны 5 метр газрын ургамлыг хусаж цэвэрлэсэн байна. Хашаанаас гадагш 10 метр зайд 1.5 метрээс багагүй өргөн амтай, 0.5 метрээс багагүй гүнтэй канав татсан байна. Хад, элс, хайргархаг хөрсөнд галын зурvas татах шаардлагагүй.

760. Агуулах бүрт галын аюулын үед авах арга хэмжээ, гал унтраах хэрэгсэл ашиглах заавар өлгөсөн байна. Ажилтан заавартай танилцаж гарын үсэг зурсан байна.

761. Тэсрэх материал ачих, буулгахад ашиглах дотоод шаталтын хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэл, ачих, буулгах механизмын яндан нь оч баригчтай байна.

762. Тэсрэх материалын агуулахууд нь энэхүү дүрмийн X бүлэгт заасан шаардлагын дагуу тоноглосон аянгаас хамгаалах байгууламжтай байна.

763. Түр агуулахын зориулалтаар тоноглосон төмөр чингэлэг болон тусгайлан барьсан байрыг ашиглаж болно. Эдгээр байрууд нь агааржуулалттай, бороо цас, халалтаас хамгаалагдсан байх ёстой.

764. Түр агуулах нь:

- а) мод, бетон шалтай байж болно;
- б) модон шал, хана, таазыг галд тэсвэртэй бодисоор өнгөлсөн байна;
- в) 2 метрээс багагүй өндөртэй хашаатай байна;
- г) усан сангүй байж болно;
- д) хуурай батарейтай уурхайн гэрэл ашиглаж болно;
- е) тамбургүй байж болно.

Түр агуулахад энэхүү дүрмийн 763, 764-д зааснаас бусад байнгын агуулахад тавих бүх шаардлагыг дагаж мөрдөнө.

765. Богино хугацаанд гүйцэтгэх тэсэлгээний ажилд ашиглах тэсрэх материалыг тэсэлгээний ажил хийх газрын ойролцоо газарт байрлах ашиглалтгүй барилга байшин, нүхэн байгууламж, төмөр чингэлэг, авто машин, чиргүүлд хадгалж болно.

766. Тэсрэх материалын богино хугацааны агуулах нь энэхүү дүрмийн 763, 764-д заасан шаардлагыг хангасан байна. Ингэхдээ аянга зайлцуулагчтай, хадгалах байрны гэрэлтүүлэгтэй, холбооны хэрэгсэлтэй, суваг (түймрээс хамгаалах зурvas)-тай байхыг шаардахгүй. Агуулахын хориотой бүсийн модыг унагаж цэвэрлэсэн байхыг шаардахгүй. Хашааг тэсрэх материал хадгалах байрны хананаас 20 метрээс ойргүй зайд байрлуулахыг зөвшөөрнө. Хашааны өндөр 2 метрээс намгүй байна. Харуулын байрыг хашаанаас 15 метрээс багагүй зайд байрлуулна.

Хориотой бүсийн өргөн 20 метрээс багагүй байна. Богино хугацааны агуулахын байрны модон ханыг гадна дотноос нь галд тэсвэртэй бодисоор өнгөлсөн, дээвэр тааз, шал нь шатдаггүй материалтай буюу мөн галд тэсвэртэй бодисоор өнгөлсөн байна.

767. Тэсрэх материал ачсан вагоныг сэлгээ, хөдөлгөөнд оруулахын өмнө бүх нээлхий, хаалгыг бөхөлж түгжсэн, лацадсан, доторх хайрцаг, сав баглааг хөдөлгөөнгүй байрлуулсан, бэхэлсэн байна.

768. Байршил нь тогтмол бус, хөдөлгөөнтэй ажилд хэрэглэх тэсрэх материалыг тусгайлан тоноглосон автомашин, чиргүүлд (хөдөлгөөнт агуулах) хадгалж болно. (Энэ заалтын зарим хэсгийг Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор хассан)

769. Хөдөлгөөнт агуулах нь автомашин, чиргүүл дээр салахгүйгээр бат бөх бэхэлсэн битүү бүхээг байна.

Энэ дүрмийн 769-д заасан агуулах нь автомашин, чиргүүл дээр салахгүйгээр бат бөх бэхэлсэн битүү бүхээг байна. Бүхээг хийхэд мод хэрэглэвэл түүнд галд тэсвэртэй уусмал шингээсэн байна. Бүхээгийг оч үүсдэггүй, ачсан зүйлтэйгээ урвалд ордоггүй материалыаар доторлоно. (Энэ заалтад Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор 2 дахь өгүүлбэрийг нэмсэн)

Тэсэлгээний хэрэгслийн хайрцгийг зөвлөн зүйл (эсгий, резин, пролон)-ээр доторлоно.

Тэсрэх материалыг бүхээгт түүний баруун хажууд гаргасан хаалгаар ачиж, буулгана. Бүхээг ардаа хаалгатай бол, хаалга онгойход жолоочид шууд мэдэгдэх дохиололтой байна.

Бүхээг дэх тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цөмлөх буудлагын төхөөрөмж хадгалах тасалгааны хаалга нь цоож онгойсон ч хаалга нээгдэхгүй давхар түгжээ тээглүүртэй байна.

Бүхээгний урд хэсгийн дээр хамгаалалттай гэрэлтүүлэг байрлуулна. Гэрэлтүүлгийн цахилгааны утас хамгаалалтын бүрээстэй байх бөгөөд бүхээгийн гаднаас холбосон байна. Бүхээг дотуур цахилгааны утас татаж байрлуулахыг хориглоно.

Бүхээгний цонх төмөр тортой байх бөгөөд урд талын цонх нь жолоочийн бүхээгний арын цонхтой нэг түвшинд байна.

Тэсрэх материалын хөдөлгөөнт агуулахаар тоноглох авто тээврийн хэрэгсэл нь тэсрэх материал тээвэрлэх тээврийн хэрэгсэлд тавих шаардлагыг хангасан байна.

770. Судалгаа, сургалтын байгууллагад тэсрэх материалыг сейфтэй тасалгаанд буюу агуулахын тасалгаанд хадгална. Тасалгаа нь шатдаггүй хана, таазтай, зэргэлдээ өрөөнөөсөө 25 см-ээс багагүй зузаантай бетонон буюу тоосгон ханаар тусгаарлагдах бөгөөд зэргэлдээ өрөөнд нь хүн тогтмол байрлах ажлын байр байлгахыг хориглоно. Тасалгааны хаалгыг 45 минутаас багагүй хугацаанд галд тэсвэрлэх материалыаар хийсэн байна.

Тэсэлгээний хэрэгсэл хадгалах сейфийг зөвлөн материалыар доторлосон, газардуулсан байх бөгөөд тэсрэх бодистой сейфээс 2 метрээс ойргүй зайд байрлуулна. Тасалгааг хамгаалалтын болон галын дохиоллоор тоноглоно.

771. Далд уурхайд тэсрэх материалыг зориудаар тоноглосон малтарт болон камер, хайрцагуудад хадгална. Тэдгээрийн аль нэгэнд нь тэсрэлт үүсэхэд бусдад нь тэсрэлт дамжихгүй байхаар байрлалтай байна.

Далд уурхайн газрын доорх тэсрэх материалын агуулах нь тэсрэх материалын хадгалах камер, хайрцаг байрлуулсан малтарт, түүн рүү орох, гарах хонгил, туслах камераудаас бүрдэнэ. Туслах камерт:

- цахилгаан детонатор шалгах, дугаарлах;
- тэсрэх материал тавьж олгох;
- тэсэлгээний механикжуулсан тоног төхөөрөмж байрлуулах;
- цүнх, дайз хадгалах;
- цахилгаан хуваарилах байгууламж ба галаас хамгаалах хэрэгсэл байрлуулах камерауд орно.

Эдгээр камераудыг агуулах руу хүрэх замд мухар малтальтад байрлуулж болно. Газрын доорх болон далдалсан тэсрэх материалын агуулахад тэсэлгээний багаж, шалгах хэмжих тоног төхөөрөмж, цүнх, дайзыг зориулалтын тавиур, шүүгээнд хадгална. Тэсрэх материалын агуулах бүр диспетчертэй шууд холбоотой байна.

Газрын доорх агуулахын ачих, буулгах ажилд тэсрэлтийн хамгаалалттай аккумуляторын болон бусад төрлийн механикжуулсан тоног төхөөрөмж ашиглаж болно. Хэсгийн тэсрэх материалын агуулахыг байгууллагын баталсан зааврын дагуу ашиглана.

772. Газрын доорх агуулахын байршил нь дараах нөхцөлийг хангасан байна.

а) тэсрэх материалын агуулахын дурын цэгээс босоо ам болон босоо амны орчмын малтарт, түүнчлэн агааржуулалтын хаалга хүртэлх зайд (байгууламжуудад эвдрэл гарвал далд уурхай болон түүний ихэнх хэсэгт нь өгөгдөх цэвэр агаарын урсгалыг хаах аюултай тул) камерын агуулахын хувьд малтальтын дагуу 100 метрээс багагүй;

б) тэсрэх материалын агуулах дахь хамгийн ойрын камераас хүн байнга зорчдог малтарт хүртэлх зайд камерын агуулахын хувьд 25 метрээс багагүй;

в) агуулахаас газрын гадарга хүртэлх зайд камерын агуулахын хувьд 30 метрээс багагүй;

г) тэсрэх материал хадгалах камер байрлуулсан малтарт нь үндсэн малтальтуудтай бие биетэйгээ тэгш өнцөг үүсгэж уулзсан гурваас цөөнгүй шулуун болон муруй малталтаар холбогдоно.

Агуулахтай холбогдох малтарт нь 2 метрээс багагүй урттай, 4 м²-аас багагүй хөндлөн огтлолтой мухар малталтаар төгссөн байна.

д) ачих тоног төхөөрөмж ашиглах тэсрэх материалын агуулахын үндсэн малтальтын хэмжээ нь тэдгээрийг 90° эргэх хөдөлгөөн хийх боломжтой байх ба ажлын механизмаа эцсийн хэмжээнд нь сунгасан ачаатай үедээ, түүнчлэн малтальтын муруй хэсэгт тоног төхөөрөмжийн хоёр талд 60 см-ээс багагүй зайд үлдэж байх өргөнтэй, малтальтын таазны гэрэлтүүлэг хүртэл 50 см-ээс багагүй зайд үлдэх өндөртэй байна.

е) агуулах нь хүнд зориулсан хоёр гарцтай байна. Метро, туннель болон хайгуулын малталь нэвтрэхэд 1 тн-оос ихгүй багтаамжтай агуулах нэг гарцтай байж болно.

ё) метро, туннель болон хайгуулын малталь нэвтрэхэд тэсрэх материалын агуулахын хамгийн ойрын камераас уурхайн босоо ам, хүн явах зориулалтын болон тэжээлийн үндсэн шугам (ус шүүрүүлэлтийн шугам, агааржуулалтын хоолой, кабель)-үүд бүхий малталь хүртэлх зайд 15 метрээс багагүй;

з) тэсрэх материалын агуулах төмөр замтай холбоотой бол, уурхайн төмөр замаас агуулахын хэсгийн зам төмрийг цахилгаан дамжихгүйгээр тусгаарласан байна.

Тэсрэх материал хадгалах байрууд болон орцуудын хооронд тэсрэлт дамжихаас хамгаалсан төмөр хаалгатай бол камерыг байрлуулсан малтальтыг үндсэн малтальттай цөөн малтальтаар холбож болно. Эдгээр хаалганы байршил болон бүтцийг зураг төслөөр тодорхойлсон байна.

Тэсрэх материалын агуулахыг төв малталь болон налуу малталь, хүн явах зориулалтын малтальтуудын хооронд байрлуулахыг хориглоно.

773. Тэсрэх материалын агуулах байрлуулах малтальт үл шатах бэхэлгээтэй байна. Бат бөх чулуулагтай малтальтад бэхэлгээгүй байж болно.

774. Агуулахын бүх малтальтын агаарыг цагт дөрвөн удаа сэлгэж байх тооцоогоор цэвэр агаарын урсгалаар агааржуулж байна. Агуулахын малтальтаас гарч буй агаарын урсгалыг малтальтуудын чиглэлд цэвэр агаарын урсгалтай хольж явуулахыг хориглоно.

775. Газрын доорх тэсрэх материалын агуулах нь гал унтраах ердийн эсвэл автомат төхөөрөмжтэй байна. Агуулах бүрийн орцоос 10 метрийн зайд галын шугаманд хаалт тавьж, гал унтраах хошуу байрлуулна. Агуулах руу орох малтальтын эхэнд галын хамгаалалтын хаалга байрлуулна.

776. Далд уурхайн агуулах руу орох малтальтад ашиглах цахилгаан тоног төхөөрөмж нь хий, тоосны аюултай уурхайд тэсрэлтийн хамгаалалттай, бусад уурхайд ердийн байна. Агуулахын болон түүн рүү орох малтальтын гэрэлтүүлгийн кабель нь шатдаггүй бүрээс хамгаалалттай байна.

Гэрэлтүүлгийн шугамын хүчдэл 220В-оос илүүгүй, хэлхээ нь гүйдлийн шүүрлийн хамгаалалттай байна.

Агуулах руу орох малтальт болон туслах камеруудыг таазанд, агуулахыг хаалганы дээрх цонхны гадна байрлуулсан гэрэлтүүлгээр гэрэлтүүлнэ.

777. Далд уурхайн агуулахын хамгаалалтын автомат дохиолол нь уурхайн диспетчертэй холбоотой байна.

778. Тоосны дэлбэрэлтийн аюултай нүүрсний болон шатдаг занарын уурхай дахь тэсрэх материалын агуулахын орох малталт, түгээх камеруудын хоёр талд шаталтад идэвхгүй занарын болон усан хөшиг байрлуулна. Эдгээр малталаад хуралдсан тоосыг тогтмол хугацаанд цэвэрлэж байхын зэрэгцээ идэвхгүй занараар занаржуулах арга хэмжээ авч байна.

779. Агуулахын орох хаалга болон тэсрэх материал түгээх камерын дэргэд холбооны хэрэгсэлтэй байна.

780. Далд уурхайн түгээх камерт тэсрэх материал хадгалах, хамгаалахад далд уурхайн агуулахын нэгэн адил шаардлага тавина. Түгээх камерт тэсрэх бодис, өдөөх хэрэгслийн бие биенээсээ 25 см-ээс багагүй зузаантай бетонон буюу тоосгон таславчаар тусгаарлан хадгална. Түгээх камерт тэсэлгээчинд материал тавьж олгох байрыг тоноглосон байна.

781. Түгээх камерыг хүмүүс вагонд суух, буух газар болон уулын цул ачиж буулгах газраас 200 метрээс ойргүй зайд байрлуулна.

1000 кг хүртэл багтаамжтай түгээх камерыг тухайн түвшингийн малтальг өргөсгөн 25 см-ээс багагүй зузаантай бетонон болон тоосгон ханаар тусгаарлан байгуулж, уурхайн агааржуулалтын шинэ урсгалаар агааржуулна. 1000 кг-аас дээш багтаамжтай түгээх камерыг хүн тогтмол явдаг малталаас 25 метрээс ойргүй зайдай газарт тусгайлан байршуулж, газрын доорх тэсрэх материалын агуулахад тавих шаардлагын дагуу агааржуулна.

782. Түгээх камер нь шатдаггүй бэхэлгээтэй, байнгын гэрэлтүүлэгтэй байна. Түгээх камер руу орох малталт 5 метрээс багагүй зайд шатдаггүй бэхэлгээтэй байна.

Түгээх камер руу орох малталаат галын хамгаалалтын металл хаалга болон тэсрэх материал хүлээж авах, тавьж олгох цонхтой төмөр торон хаалгатай байна. Хаалганууд нь найдвартай түгээтэй байна.

Тэсрэх материал хураах зориулалтын тавиуртай байна. Тэсэлгээний гал өгөх машин, шалгах хэмжих тоног төхөөрөмж, бусад хэрэгслийг хайрцагт хийж хадгална. Үйлдвэрийн сав баглаатай тэсрэх бодисыг өрж хурааж болно.

Телефон болон гал унтраах багаж хэрэгслийг түгээх агуулах руу агаарын урсгал орох талд байрлуулна.

783. Уурхайн хэсгийн тэсрэх материал хадгалах цэг нь дотор нь тэсрэх материал хадгалах цоожтой, зориулалтын металл шүүгээ буюу чингэлэг байрлуулсан, төмөр тоороор тусгаарлан хашсан малталаат буюу малталаатын хэсгээс бүрдэнэ. Цэгийн хаалга нууц цоожтой байна.

784. Хэсгийн тэсрэх материал хадгалах цэгийн шүүгээ, чингэлгээр металл сейф, 2 мм-ээс багагүй зузаантай төмөр хавтангаар хийсэн хайрцаг, төмөр таглаатай уурхайн тэргэнцэр зэргийг ашиглаж болно. Тэсрэх материал агуулсан эдгээр савыг таславчаар тусгаарласан малталаад буюу догонд байрлуулна.

785. Хэсгийн тэсрэх материал хадгалах цэгт тэсрэх материалыг хамтад нь хадгалах бол тэдгээрийг хадгалах шүүгээ чингэлгийг тэсрэх бодис болон цочир

дамжуулах шижим, шалгах хэмжих тоног төхөөрөмж, тэсэлгээний хэрэгсэлтэй цүнх, дайзанд зориулан 3-аас доошгүй хэсэгт хуваан таславч хийж, тэсэлгээний хэрэгслийн таславчийг зөвлөн материалаар доторлоно.

786. Хэсгийн тэсрэх материал хадгалах цэгт тавьсан металл шүүгээг газардуулсан байна. Шилжих эсэргүүцлийн хэмжээ 2 Ом-оос хэтрэх ёсгүй. Хувийн нэгж эсэргүүцэл өндөртэй чулуулагт шилжих эсэргүүцлийн хэмжээг төслөөр тогтооно.

787. Тэсэлгээ хийх газрын ойролцоо ээлжийн хэрэгцээний тэсрэх материал хадгалах зориулалтын металл хайрцааг, чингэлэг нь энэхүү дүрмийн 785, 786-д заасан шаардлагыг хангасан байх бөгөөд далд цоожтой байна.

788. Далдалсан агуулах руу орох малталтын ам гадагш онгойдог давхар хаалгатай байна. Гаднах нь металл буюу металл бүрээстэй модон, доторх нь төмөр төрон хаалга байна.

789. Хэрэв далдалсан агуулахын орцоос тэсрэх материал хадгалах ойрын камер хүртэл 15 метрээс илүү зйтай байвал, агуулах хоёр гарцтай байна. Агуулахыг далд уурхайн агуулахад тавих шаардлагын дагуу агааржуулна.

790. Далдалсан агуулахын аманд малталтаас 1.5 метр өндөр хамгаалалтын далан байгуулна. Далангийн нурууны урт нь дээгүүрээ малталтын өргөнөөс 3 дахин их, нурууны өргөн нь дээгүүрээ 0.8 метрээс багагүй байна. Далангийн суурийн өргөнийг чулуулгийн нурлын өнцгөөр тогтооно.

791. Тэсрэх материал хадгалах камер болон орох малталт нь шатдаггүй материал буюу шатдаггүй бодис шингээсэн модон бэхэлгээтэй байна.

792. Тэсрэх материалын далдалсан агуулахын цахилгаан тоног төхөөрөмж нь энэхүү дүрмийн 776-д заасан шаардлагыг хангасан байна. Далдалсан агуулахын гэрэлтүүлгийг гаднаас нь асааж унтраана.

793. Байнгын цахилгааны эх үүсвэргүй бол байгууллагын удирдлагын зөвшөөрснөөр уурхайн аккумуляторын гэрэлтүүлэг хэрэглэж болно.

794. 10 метрээс зузаан хөрсөн хучлагатай далдалсан агуулахад аянга зайлцуулагч хийхгүй.

795. Агуулах доторх зам төмөр, төмөр хоолойг газрын гадаргад гарсан хэсгээс нь цахилгаан дамжихгүйгээр тусгаарлана.

796. Тэсрэх материалын далдалсан агуулахын гарц хамгаалалтын хашаатай байна.

797. Агуулахын гарц, агааржуулалтын ам, нөөц гарцууд нэгдсэн буюу тус тусдаа харуул хамгаалалттай байна.

798. Байнгын далдалсан агуулахад тавих бусад шаардлагууд газрын гадарга дээрх агуулахынхтай нэгэн адил байна.

Тэсрэх материалын бүртгэл, тооцоо

799. Хадгалахаар авчирсан тэсрэх материалыг агуулахад оруулж бүртгэлд авна.

800. Байгууллага нь тэсрэх материалыг агуулахын бүртгэлд авах, гаргах, тэсэлгээнд олгох, буцааходаа “Тэсрэх материалын агуулахын бүртгэлийн дэвтэр”-ийг энэхүү дүрмийн хавсралт 10-т заасан загварын дагуу заавал хөтөлнө.

801. Тэсрэх материалын агуулахын бүртгэлийн дэвтрийг дугаарлаж үдсэн байхаас гадна байгууллага, санхүүгийн албаны тэмдгээр баталгаажуулсан байна. Агуулахын бүртгэлийн дэвтрийг агуулахын нярав хүлээн авсан, олгосон тэсрэх материалын нэр төрөл тус бүрээр нь, тухай бүр бүртгэл хөтөлнө.

802. Агуулахаас тэсрэх материалыг өөр байгууллагад шилжүүлж буй байгууллагын санхүүгийн алба “Зарлагын баримт” үйлдэж хүлээн авагчид өгөх бөгөөд уг хуудас нь Мэргэжлийн хяналтын байгууллагын “Тэсрэх материал тээвэрлэх хуудас”-ын хамт агуулахаас тэсрэх материал гаргах баримт болно. Агуулахын нярав нь дээрх баримт бичгийг үндэслэн тэсрэх материалыг өөр байгууллагад олгохдоо зарлагын падааныг хоёр хувь үйлдэж нэг хувийг агуулахад үлдээж, хоёр дахь хувийг хүлээн авагчид олгоно. Зарлагын падаанд тэсрэх материалын нэр төрөл, үйлдвэрлэгч, ашиглах хугацаа, сери дугаарыг тэмдэглэсэн дагалдах хуудсыг хавсаргана.

803. Тэсрэх материалыг тухайн байгууллагын нэг агуулахаас нөгөөд шилжүүлэх тохиолдолд байгууллагын тэсрэх материал олгох зөвшөөрлийг үндэслэн нярав зарлагын падаан, дагалдах хуудсын хамт хоёр хувь үйлдэж, нэг хувийг агуулахад үлдээж, хоёр дахь хувийг хүлээж авах агуулахад илгээнэ.

804. Түгээх агуулахад даалгаврын хуудасны дагуу олгосон тэсрэх материалыг агуулахын бүртгэлийн дэвтэрт бүртгэж байна. Тэсэлгээчний даалгаврын хуудсыг энэхүү дүрмийн хавсралт 13-т заасан загварын дагуу бөглөнө.

805. Агуулахаас тэсрэх материал олгох, хүлээж авах баримт бичигт олгосон, хүлээж авсан болон хүргэлт тээвэрлэлтийн ажилтан, тэсэлгээний ажлын удирдагч зэрэг тэсрэх материал хүлээлцэхэд оролцсон ажилтнуудын албан тушаал, нэрийг гаргацтай бичиж, гарын үсгээр баталгаажуулна.

Газрын доорх хэсгийн хадгалах байруудад хүргэсэн тэсрэх материалын хөдөлгөөнийг агуулахын бүртгэлийн дэвтэрт тусгана.

806. Нярав нь тэсэлгээчинд тэсрэх материал тавьж олгохдоо тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл дээрх үйлдвэрлэгчийн тэмдэглэсэн бүтээгдэхүүний марк, хувийн дугаарыг “Тэсрэх материалын агуулахын бүртгэлийн дэвтэр”-т тэмдэглэж үлдээнэ.

807. Нярав нь түгээх агуулахаас тэсэлгээний ажилд зориулан тэсрэх материалыг байгууллагын тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагчийн баталсан “Даалгаврын хуудас”-ыг үндэслэж тавьж олгох ба даалгаврын хуудасны нэг хувийг авч үлдэнэ. Тэсэлгээний ажлын удирдагч даалгаврын хуудсанд гарын үсэг зурна.

Үүнээс гадна даалгаврын хуудсанд хий, тоосны аюултай нүүрсний болон хүдрийн уурхайд тэсэлгээний болон агааржуулалтын албаны удирдлага гарын үсэг зурах ба уурхайн тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагч батална.

808. Тэсэлгээний ажлын дараа тэсэлгээг гүйцэтгэсэн тэсэлгээчин тэсрэх материалын бодит зарцуулалтын хэмжээг даалгаврын хуудсанд тусгаж, тэсэлгээний ажлын удирдагч гарын үсэг зурж баталгаажуулна.

Тэсэлгээчин тэсэлгээний ажил дууссаны дараа үлдсэн тэсрэх материалыг даалгаврын хуудасны хамт өөрийн биеэр тэсрэх материалын агуулах (түгээх камер, хэсгийн хадгалах байр)-нд хүргэж өгнө.

Өмнө нь авсан тэсрэх материалын тооцоогоо хийгээгүй тэсэлгээчинд тэсрэх материал нэмж олгохгүй.

809. Бүртгэлийн дэвтэргт харандаагаар бичих, засвар оруулах, тэмдэглэгээг арилгах зэргийг хориглох ба тоон үзүүлэлтэд аливаа засвар хийхээр бол шинээр өгөгдөл оруулж, засвар нэг бүр дээр тайлбар бичиж тэмдэглэгээ хийсэн хүн гарын үсгээ зурж баталгаажуулна. Байгууллага нь 801-808-д дурдсан орлого, зарлагын бүртгэлийн дэвтрийг 3-аас доошгүй жил хадгалах ёстой.

810. Тэсрэх материалын агуулах дээр тэсрэх материалыг олгоход даалгаврын хуудас, дагалдах бичигт гарын үсэг зурж зөвшөөрөл өгөх эрх бүхий болон тэсрэх материалын бодит зарцуулалтыг нотолж зурсан албан тушаалтны гарын үсэгний хуулбар тус тус хадгалагдаж байх ёстой. Гарын үсэгний хуулбарыг байгууллагын удирдлага баталсан байна. Тэсрэх материалыг олгох баримтанд өөр хүн гарын үсэг зурсан бол олгохыг хориглоно.

811. Тэсрэх материал түгээх камерын бүртгэл нь тэсрэх материалын агуулахын бүртгэлтэй ижил байна.

812. Төмөр замын өртөө болон бусад өөр тээврийн хэсэг дээр ирсэн тэсрэх материалыг хүлээн аваходаа байгууллагын удирдлага нь хүлээн авах ажиллагааг хариуцсан ажилтнаа томилж, хамгаалалтын багийн хамт явуулах үүрэг хүлээнэ.

813. Байгууллага нь тэсрэх материалыг агуулахын бүртгэлд авах, хасах тооцог агуулахын эрхлэгчээс явуулсан агуулахын бүртгэлийн дэвтрийг үндэслэж хийнэ.

814. Тэсрэх материалын бүртгэл тооцоо, хадгалалт хамгаалалт, бэлэн байдалтай холбоотой агуулахын мэдээлэл үнэн зөв эсэхийг байгууллагын удирдлагын тушаалаар томилогдсон албан тушаалтан сар бүр нягталж шалгана. Баглаа боодол нь гэмтээгүй лац бүрэн сав хайрцаг, уут, чингэлгийг нээж онгойлгохгүй байж болно.

815. Нээж онгойлгосон хайрцагтай цахилгаан тэслүүр, ердийн тэслүүр, пиротехникийн реле болон бусад тэсэлгээний хэрэгслийн тоо хэмжээг агуулахын үүдний өрөө, эсвэл тусгай камерт, эсвэл агуулахын гадна тоолж шалгана. Ингэхдээ тэдгээрийг тогтоосон шаардлага хангасан ширээн дээр тавьж тоолно.

816. Шалгалтын үр дүнд илэрсэн тэсрэх материалын илүүдэл, дуталтын талаар тухайн байгууллагын удирдлага болон мэргэжлийн хяналтын байгууллага, орон нутгийн цагдаагийн байгууллагад даруй мэдэгдэнэ.

ЕС. ТЭСЭЛГЭЭНИЙ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ, ТЭСРЭХ МАТЕРИАЛ ХАДГАЛАХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ ЗАЙ. ТЭСЭЛГЭЭНИЙ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ, ТЭСРЭХ МАТЕРИАЛ ХАДГАЛАХ АЮУЛГҮЙ ЗАЙГ ТОДОРХОЙЛОХ ЗААВАР

817. Тэсрэх материалтай харьцах, тэсэлгээний ажлын үед хүнд осол гэмтэл учруулахгүй байх аюулгүй зайд төсөл, паспортаар тогтоосон байна. Аюул, осол үүсгэж болох хүчин зүйлүүдээс хөнөөл үүсгэх хамгийн их зайд аюулгүйн зайд гэж үзнэ.

818. Тэсрэх материалтай харьцах, тэсэлгээний ажлын үеийн тэсрэх бодисын хэмжээг тэсрэлтээс үүсэх чичирхийллийн үйлчлэлээс барилга, байгууламжид эвдрэл гэмтэл учруулахгүй байхаар тооцсон байна.

819. Газрын гадарга дээр тэсрэх материал бүхий хэд хэдэн агуулах, үйлдвэр, бэлтгэх байр, байгууламжийг нэгнээс нөгөөд нь тэсрэлт дамжихгүй зйтай байхаар тооцож байршуулна.

820. Тэсрэх материалын агуулах, үйлдвэрт үүсч болох тэсрэлтийн агаарын цохиг долгионы хөнөөлт үйлчлэлээс хүн, барилга, байгууламжийг хамгаалах аюулгүйн зайлт тоогоож мөрдөнө. Энэхүү аюулгүйн зайлт тэсрэх материалын агуулах, үйлдвэрийн байрнаас хүн байрлах байр болон хамгаалагдах объект хүртэл тооцно.

821. Газрын гадарга дээрх тэсэлгээний ажлын үед хүнд аюулгүй байх зайн хэмжээ нь энэ бүлгийн хүснэгт 4-т зааснаас багагүй байна.

**Хүснэгт 4. Газрын гадарга дээр тэсэлгээний ажил явуулахад
хүн байрлуулах аюулгүй зайлт**

| № | Тэсэлгээний ажлын төрөл, арга | Аюултай бүсийн радиусын зөвшөөрөгдөх хамгийн бага хэмжээ, метр |
|----|--|--|
| 1. | Ил гадаргад тэслэх аргууд: | |
| | 1.1. Ил цэнэгийн, | 300 |
| | түүнээс кумулятив цэнэгийн | Тэслээр |
| | 1.2. Шпурын цэнэгийн | 200 <*> |
| | 1.3. Тогоолсон шпурын цэнэгийн | 200 <*> |
| | 1.4. Бага камерын цэнэгийн (ханцуй нүхний) | 200 <*> |
| | 1.5. Цооногийн цэнэгийн | 200-аас багагүй <**> |
| | 1.6. Тогоолсон цооногийн цэнэгийн | 300-аас багагүй |
| | 1.7. Камерын цэнэгийн | 300-аас багагүй |
| 2. | Бул чулууг доогуур нь ухаж цэнэглэсэн тэсэлгээнд | 400 |
| 3. | Хожуул булгалах тэсэлгээнд | 200 |
| 4. | Хөрсөнд ойн түймрээс хамгаалах зурvas татах тэсэлгээнд | 50 |
| 5. | Намаг дээрх даланг суулгах тэсэлгээнд | 100 |
| 6. | Усны ёроол гүнзгийрүүлэх ажлын: | |
| | 6.1. Гадаргуу дээрээ мөсгүй усан сангийн тэсэлгээнд: | |
| | Хадархаг биш хөрсөнд | 100 |
| | Хадархаг хөрсөнд: | |
| | шпурын цэнэгтэй | 50 |
| | 100 кг хүртэл жинтэй ил цэнэгтэй | 200 |
| | 100 кг-аас дээш жинтэй ил цэнэгтэй | 300 |

| | | |
|-----|--|--|
| | 6.2. Мөсөн хучаастай усан санд тэсэлж буй хөрсний шинж чанараас үл хамааран | 200 |
| 7. | Мөсөн замын тэсэлгээнд: 7.1. 1 метр хүртэл зузаантай мөс 7.2. 1-2 метр зузаантай мөс 7.3. Мөсөн түгжрээ 7.4. Зайр 7.5. 2 метрээс илүү зузаантай мөсөнд болон мөсөн түгжрээнд 300 кг-аас дээш жинтэй цэнэгээр тэслэхэд | 100 200 200 50 300 |
| 8. | Металл тэслэх ажилд: 8.1. Ил талбайд 8.2. Хамгаалалттай нүхэнд 8.3. Үйлдвэрийн дэвсгэр газар дахь талбайд 8.4. Халуун биет тэслэхэд 8.5. Металл эд хэвэнд цохих тэсэлгээнд | Төслөөр 30 Төслөөр <***> 30 25 |
| 9. | Барилга байгууламж нураахад | 100 |
| 10. | Барилга байгууламжийн суурь бутлахад | Төслөөр |
| 11. | Шпурт цэнэгийн тогоо үүсгэх буудлагад | 50 |
| 12. | Цооногт цэнэгийн тогоо үүсгэх буудлагад | 100 |
| 13. | Газрын тос, хийн болон гүний усны цооногт торпедлох, буудлага-тэслэлтийн ажил гүйцэтгэхэд | 50 <****> |
| 14. | Чичирхийлийн хайгуулын тэсэлгээнд: Газрын гадарга дээр болон шурфт Цооногт | 100 30 |
| 15. | Барилгын талбай дээрх тэсэлгээний ажилд | Төслөөр <***> |

<*> Уулын хажуу налуу гадарга дээр тэсэлгээ хийхэд налуугийн доош чиглэлд аюултай бүсийн радиусыг 300 метрээс багагүй зайд авна.

<**> Аюултай бүсийн радиусыг түгжээстэй цооногийн цэнэгээр авна.

<***> Төсөлд ажилчдын аюулгүй байдлыг хангах талаар онцгой арга хэмжээ авахыг заасан бүлэг тусгана.

<****> Торпедлох болон перфорацийн тэсэлгээнд буудлагын аппаратыг цооногт 50 метрээс илүү гүнд буулгасаны дараа аюултай бүсийн радиусыг 10 метр хүртэл багасгаж болно.

822. Цооногийн цэнэгийн аргаар тэсэлгээ хийх үед чулуулгийн бутармагийн шидэгдэх аюулгүй зайд.

Чулуулгийг бутлахаар тооцсон цооногийн цэнэгийг тэслэхэд шидэгдэх чулуулгийн бутармагийн хүнд аюултай байх зайд ($r_{ш}$)-г дараахь томьёогоор тодорхойлно.

$$r_{ш} = 1250 * \eta_d \sqrt{\frac{f}{1+\eta_t}} * \frac{d}{a}, \text{метр} \quad (1)$$

| | |
|----------|--|
| η_d | кооногийг тэсрэх бодисоор дүүргэлтийн коэффициент |
| η_t | кооногийн түгжээсний коэффициент |
| f | чулуулгийн бат бэхийн коэффициент (М.М.Протодьяконовын ангилалаар) |
| d | кооногийн диаметр, метр |
| a | кооног ба эгнээ хоорондын зайд, метр |

Цооног дүүргэлтийн коэффициент (η_d)-ыг цэнэгийн урт ($L_{цэн}$)-ыг цооногийн нийт урт (L)-д харьцуулан олно.

$$\eta_d = \frac{L_{цэн}}{L}$$

Түгжээсний урт ($L_{түг}$)-ыг цооног дахь цэнэгийн дээд талаас цооногийн амсар хүртэлх хоосон зайн урт ($L_{x,z}$)-д харьцуулж түгжээсний коэффициент (η_d)-ыг тодорхойлно.

$$\eta_t = \frac{L_{түг}}{L_{x,z}}$$

Цооногт байрласан цэнэгээс дээших хоосон зайн дүүртэл түгжсэн тохиолдолд $\eta_t = 1$, түгжээс хийлгүй тэслэхэд $\eta_t = 0$ байна.

Чулуулгийн бат бэхийн коэффициент (f)-ыг дараахь томьёогоор тодорхойлно.

$$f = \frac{\sigma_{ш}}{100}$$

$\sigma_{ш}$ чулуулгийн зөв хэлбэртэй сорьцыг нэг тэнхлэгээр шахах стандарт хэмжилтийн бат бэхийн хязгаарын үзүүлэлт, кгс/см² (1 кгс/см² = 98066.5 Па)

Барилгын нормын ангилалтай чулуулагт тэсэлгээний ажил гүйцэтгэхэд чулуулгийн бат бэхийн шинж чанарын үзүүлэлт нь тодорхойгүй бол бат бэхийн коэффициент (f)-ийг дараахь томьёогоор тодорхойлно.

$$f = \left(\frac{F}{2.5} \right)^2$$

F -хөрс чулуулгийн бүлгийн дугаар (барилгын нормоор)

a, η_d, η_t коэффициентуудын утга нь харилцан адилгүй, ижил диаметртэй хэд хэдэн цооногийг тэслэх үеийн аюулгүйн зайнг (1) томьёогоор тодорхойлохдоо a, η_t коэффициентыг хамгийн багаар, харин η_d коэффициентыг хамгийн ихээр нь авч тооцно. Хэрэв тэслэх талбай нь янз бүрийн бат бэхтэй чулуулгаас тогтсон бол чулуулгийн бутармагийн шидэгдэх зайд ($r_{ш}$)-г тооцохдоо чулуулгийн бат бэхийн коэффициент (f)-ийн хамгийн их утгыг авна. Хоорондоо ойрхон эсвэл зэрэгцээ байрлуулсан хос

цооногийн цэнэгүүдийг тэслэхдээ цооногийн диаметр (d)-ын оронд тэдгээрийн эквивалент диаметр (d_e)-ыг:

$$d_e = d * \sqrt{N_{\text{ход}}}$$

томуёогоор тооцож авна.

$N_{\text{ход}}$ -бүлэг дэх хос цооногийн тоо

Аюулгүйн зайлгүйн зайлгүйн тодорхойлоходо өрөмдлөг, тэсэлгээний ажлын явцад гарч болох a, η_d, η_t хэмжээсүүдийн төслийн үзүүлэлтээс гажих хэлбэлзлэлийг тооцох хэрэгтэй. Иймээс аюулгүйн зайлгүйн зайлг (1) томуёогоор тодорхойлоходо тодорхой нөөцтэйгээр, өөрөөр хэлбэл a, η_t -коэффициентыг хамгийн багаар, харин η_d коэффициентыг хамгийн ихээр тооцох нь зүйтэй.

823. Уулархаг газрын хажуу налууд, түүнчлэн тэсэлгээ хийж буй газрын гадаргын дээд талын өндөржилт нь аюултай бүсийн хил орших хэсгээс 30 метрээс дээш өргөгдсөн тохиолдолд тэсэлгээ хийхэд газрын налуу тал руу шидэгдэх чулуулгийн бутармагийн аюултай бүсийн зайл (r_w)-г дараахь томуёогоор өсгөн тооцно.

$$R_w = K_r * r_w \quad (2)$$

R_w -уулын хажуу руу болон тэслэх талбайн дээрээс тооцоход 30 метрээс дээш өндөржилттэй талбайгаас чулуулгийн доошоогоо шидэгдэх аюултай зайл
 K_r -газрын гадаргын хэлбэр, өндөржилтийг тооцох коэффициент

Уулын налууд тэсэлгээ хийхэд дараахь томуёогоор тодорхойлно.

$$K_r = 1 + t g \beta \quad (3)$$

β -уулын хажуу налуугийн хэвтээ тэнхлэгт харьцах өнцөг, градус

Хэрэв аюултай бүсийн хилээс дээш тэсэлгээ хийх талбайн дээд талын өндөржилтийн хэмжээ мэдэгдэж байвал, өндөржилт тооцох коэффициент (K_r):

$$K_r = 0.5 * \left(1 + \sqrt{1 + \frac{4*H}{r_w}} \right) \quad (4)$$

H -өндөржилтийн хэмжээ, метр

(1), (2) томуёогоор тооцсон аюултай бүсийн хязгаарын аль нэг чиглэлд налуу хажуутай бол чулуулгийн бутармагийн өнхрөлтийг тооцож аюулгүйн бүсийн хэмжээг нэмнэ. Түүнчлэн салхины хүчээр чулуулгийн бутармагийн шидэгдэлт нэмэгдэхийг тооцно.

Тооцоогоор гарсан аюултай бүсийн зайн хэмжээ бутархай тоогоор илэрхийлэгдвэл өсгөж дараагийн бүхэл тоо болгон авна.

824. Аюулгүйн зайн тоон утгыг их тал руу нь 50 метрээр бүхэлчилж авна. Ингэж тооцоолсон аюулгүйн зайн нь энэхүү бүлгийн хүснэгт 4-т заасан хамгийн бага зайнанаас багагүй байна.

825. Тэсэлгээ хийх газраас тоног төхөөрөмж, барилга байгууламж хүртэлх аюулгүй зайд тухайн орчны тодорхой нөхцөлийг тооцон төслөөр тогтооно.

826. Шидэлттэй тэсэлгээний үеийн чулуулгийн бутармагийн шидэгдэх аюулгүй зайд энэхүү бүлгийн хүснэгт 2-т заасан цэнэгийн тэсрэлтийн үйлчилгээний үзүүлэлт (n) болон хамгийн бага эсэргүүцлийн шугамын хэмжээ (W)-нээс хамааруулан тодорхойлно.

827. (W) ба (n)-ийн утга нь харилцан адилгүй бүлэг цэнэгийг тэслэхэд аюултай бүсийн радиусыг энэхүү бүлгийн хүснэгт 2-ыг ашиглан тодорхойлох бөгөөд n -ийн хэмжээ адил байвал хамгийн их W -г, W нь адил байвал хамгийн их n -ийг тус тус тооцооны үзүүлэлтээр авна. Хэрэв хоёулаа өөрчлөлтэй бол W , n хоёрын үзүүлэлтээр аюултай бүс нь хамгийн их байх нөхцөлөөр тооцно.

828. W болон n -ийн утга нь эрс ялгаатай, 0.5 км болон түүнээс илүү урттай малтарт үүсгэх тэсэлгээний аюултай бүсийн хэмжээг тухайн малтальтын янз бүрийн хэсэгт өөр өөрөөр авна.

829. Төвлөрүүлсэн, ердийн сийрэгжүүлэх ($W_{\text{сийрг}}$) цэнэг тэслэх үед ($n < 1$) чулуулгийн бутармагийн шидэлтийн аюултай бүсийн радиусыг дараахь байдлаар тооцно.

Тухайн цэнэгүүдээс хамгийн их утгатай W_{max} -г сонгож авна. Энэ цэнэгийг $n = 1$ ердийн бутлалтын цэнэг гэж үзэн, түүний нөхцөлт хамгийн бага эсэргүүцлийн шугамын хэмжээ $W_{n=1}$ -г тодорхойлно. Нөхцөлт улны эсэргүүцлийн шугамын хэмжээг тооцдог тогтсон $W_{n=1}=5W_{\text{сийрг}}/7$ тэгшитгэлийн дагуу $W_{n=1}=5W_{max}/7$ гэж үзнэ.

Тооцож гаргасан $W_{n=1}$ -ийн утга нь бутармагийн шидэгдэлтийн ажилчдад аюултай бүсийг тооцох гарааны үзүүлэлт болно. Ингээд энэхүү бүлгийн хүснэгт 2-т тооцож гаргасан нөхцөлт улны эсэргүүцлийн хэмжээ $W_{n=1}$ -д харьяалах эгнээнээс $n = 1$ үзүүлэлтэй цэнэгт тооцох аюултай бүс r_w -ийн утгыг авна.

830. $n \leq 2$ байхад чулуулгийн бутармагийн шидэлтийн хамгийн өндөр зайд тодорхойлоходоо түүнийг энэхүү дүрмийн 817-829-д заасан шаардлагад харгалзах утгатай тэнцүү гэж авна. $n > 2$ үед гарсан утгыг 1.4 дахин ихэсгэж авна.

831. Бөөн цэнэгээр нэг удаа тэсэлгээний ажил хийх үед газрын хөрсний доргилт, барилга байгууламжид аюулгүй байх зайд дараахь томьёогоор тодорхойлно.

$$r_{a,3} = K_X * K_B * \alpha \sqrt[3]{Q}; \text{ м} \quad (5)$$

$r_{a,3}$ тэсэлгээ хийх газраас хамгаалах барилга, байгууламж хүртэлх зайд, метр
 K_X барилга, байгууламжийн суурин хөрсний шинж чанарыг тооцох коэффициент. Үүний утгыг хүснэгт 6-ын дагуу сонгож авна.

K_B барилга, байгууламжийг барьсан байдал, түүний төрлөөс хамаарах коэффициент. Үүний утгыг хүснэгт 7-т үзүүлэв.

α тэсэлгээний нөхцөл байдлаас хамаарах коэффициент. Үүний утгыг хүснэгт 4-д үзүүлэв.

Q тэсрэх бодисын цэнэгийн жин, кг

Хүснэгт 5. Тэсэлгээ хийх газраас хамгаалах барилга, байгууламж хүртэлх аюулгүй зайд

| Хамгийн бага эсэргүүцлийн шугам, W , м | Цэнэгийн тэсрэлтийн үйлчилгээний үзүүлэлт (n)-ээс хамаарах аюултай бусийн радиус, $r_{a,3}$, метр | | | | | | | |
|---|---|------|------|---------|---|-----|------|---------|
| | Хүнд | | | | Машин механизм, барилга байгууламжид | | | |
| | n | | | | n | | | |
| | 1.0 | 1.5 | 2.0 | 2.5-3.0 | 1.0 | 1.5 | 2.0 | 2.5-3.0 |
| 1.5 | 200 | 300 | 350 | 400 | 100 | 150 | 250 | 300 |
| 2.0 | 200 | 400 | 500 | 600 | 100 | 200 | 350 | 400 |
| 4.0 | 300 | 500 | 700 | 800 | 150 | 250 | 500 | 550 |
| 6.0 | 300 | 600 | 800 | 1000 | 150 | 300 | 550 | 650 |
| 8.0 | 400 | 600 | 800 | 1000 | 200 | 300 | 600 | 700 |
| 10.0 | 500 | 700 | 900 | 1000 | 250 | 400 | 600 | 700 |
| 12.0 | 500 | 700 | 900 | 1200 | 250 | 400 | 700 | 800 |
| 15.0 | 600 | 800 | 1000 | 1200 | 300 | 400 | 700 | 800 |
| 20.0 | 700 | 800 | 1200 | 1500 | 350 | 400 | 800 | 1000 |
| 25.0 | 800 | 1000 | 1500 | 1800 | 400 | 500 | 1000 | 1000 |
| 30.0 | 800 | 1000 | 1700 | 2000 | 400 | 500 | 1000 | 1200 |

Тайлбар: Уулын хажуугийн налуу болон өндөржилттэй хэсэгт тэсэлгээ хийх үед аюултай бусийн зайн хязгаарыг энэхүү журмын дагуу ихэсгэж бүхэл тоогоор нь авна.

Тэсэлгээний үед барилга байгууламжийн аюулгүй байдал нь үйл ажиллагаа хэвийн явуулах нөхцөлийг алдагдуулсан эвдрэл гэмтэл гаралтад байгаагаар тодорхойлогдоно. Тэсэлгээний үед зарим барилга байгууламжид үүсч болох хөнгөн гэмтлийн магадлал нь ойролцоогоор 0.1 байж болно.

Хүснэгт 6. Барилга байгууламжийн суурийн хөрсний шинж чанарыг тооцох коэффициент (K_x)

| Хамгаалах байгууламжийн суурийн хөрс | K_x |
|---|-------|
| Хагарал эвдрэлд ороогүй хадан чулуу | 5 |
| Хагарал эвдрэлтэй зөвлөн хөрсний гүн биш үеэр хучигдсан хадан чулуу | 8 |
| 10 метрээс дээш зузаантай усны нэвтчилтгүй элс, шаврын хөрс | 12 |
| Усны давхарга бүхий хөрс ба усны тувшин өндөртэй хөрс | 15 |
| Намагжсан хөрс | 20 |

Тайлбар: Хөрсний талаар мэдээ, тодорхойлолт бага тохиолдолд хөрсний чанараар ойролцоо утгын хамгийн дээд хэмжээг авна.

Хүснэгт 7. Барилга байгууламжийг барьсан байдал, түүний төрлөөс хамаарах коэффициент (K_B)

| Барилга, байгууламжийн төрөл, байгуулалтын онцлог | K_B |
|--|-------|
| Төмөр бетон буюу төмөр хийцийн каркастай үйлдвэрлэлийн зориулалттай ганц барилга, байгууламж | 1 |
| Тоосго, түүнтэй адилтгах материалыар баригдсан 2-3 давхар ганц барилга, байгууламж | 1.5 |
| Бага зэрэг суурин газар | 2 |

Тайлбар: Барилга байгууламжаас 100 метрээс дотогш зайд хийх тэсэлгээний ажлын үед тэсрэлтийн чичирхийллийн үйлчлэл нь орчны шинжтэй байна. Иймд (5) томьёогоор тодорхойлсон цэнэгийн зөвшөөрөгдөх хэмжээ нь буурч гарна. Шаардлагатай бол энэ хэмжээг ихэсгэж авахыг зөвшөөрнө.

Хүснэгт 8. Тэсэлгээний нөхцөл байдлаас хамаарах коэффициент (α)

| Тэсэлгээний нөхцөл | (α) |
|--|--------------|
| Битүү цэнэгийн болон сийрэгжүүлэх тэсэлгээ | 1 |
| Буталж шидэх үйлчилгээтэй тэсэлгээ | 0.8 |
| Хагас гүнзгийрэлттэй цэнэгийн тэсэлгээ | 0.5 |

Тайлбар: Устай буюу ус нэвчсэн хөрсөнд цэнэгийг байрлуулсан бол K_B коэффициентын утгыг 1.5-2 дахин өсгөж авна. Газрын гадарга дээр ил цэнэг тэслэхэд чичирхийллийн үйлчлэлийг тооцох шаардлагагүй.

Барилга байгууламжийн газрын чичирхийллийн аюулгүй байдал нь тэсэлгээгээр түүний үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг алдагдуулсан эвдрэл гэмтэл гаралгүй байгаагаар тодорхойлогдоно. Тэсэлгээний үед зарим барилга байгууламжид үүсч болох хөнгөн гэмтлийн магадлал нь ойролцоогоор 0.1 байна.

832. Барилга, байгууламжаас хамгийн ойр ба хол орших зайн зөрүү нь 20 хувь байхад Q жинтэй тэсрэх бодисын N тооны хэсэг цэнэгийг бөөнөөр нь нэгэн зэрэг удаашралгүйгээр тэслэх үед аюулгүй зайл дараахь томьёогоор тодорхойлно.

$$r_{a.3} = N^{\frac{1}{6}} * K_X * K_B * \alpha * \sqrt[3]{Q}; \text{метр} \quad (6)$$

Зайнуудын зөрүү их бөгөөд дараахь нөхцөл хангагдаж байвал хамгаалах байгууламж чичирхийллийн аюултай бүсийн гадна байна гэж үзнэ.

$$(K_X * K_B * \alpha)^3 \sum_{i=1}^N \frac{q_i}{r_i^3} \leq 1 \quad (7)$$

N цэнэгийн тоо

q_i бүлэг цэнэгүүдийн жин, кг

r_i бүлэг цэнэгүүдээс хамгаалах байгууламж хүртэлх зайл, метр

833. Q жинтэй N тооны цэнэгийг нэг агшинд тэслэхгүй, цэнэг бүрийн хооронд 20 мс-ийн зайлтай удаашрагчаар тэсэлгээ хийх тохиолдолд аюулгүй зайл дараахь томьёогоор тодорхойлно.

$$r_{a.3} = \frac{K_X * K_B * \alpha}{N^{\frac{1}{4}}} * \sqrt[3]{Q} \quad (8)$$

Хэрэв q_i жинтэй захын цэнэгээс хамгаалах байгууламж хүртэлх r_i зайл нь 20 хувиас их буюу дараахь нөхцөл хангагдсан бол хамгаалах байгууламжийг чичирхийллийн аюултай бүсийн гадна байна гэж үзнэ.

$$\left(\frac{K_X * K_B * \alpha}{N^{\frac{1}{4}}} \right)^3 * \sum_{i=1}^N \frac{q_i}{r_i^3} \leq 1 \quad (9)$$

Хэрэв i дугаар цэнэгийн $\frac{q_i}{r_i^3}$ гэсэн үзүүлэлтийн утга нь тэслэгдэх бүх хэсгүүдийн доторх хамгийн их цэнэгийнхээс 3 дахинаас бага бол цэнэгийн тоо (N)-г тогтооходоо түүнийг тооцохгүй байж болно.

Тэслэгдэх хэсэг цэнэг бүрийн хооронд 20 мс-ээс бага хугацаатай удаашруулагч хэрэглэн тэсэлгээ хийх нөхцөлд түүнийг хэсэг бүрийн нийт хэмжээнд багтах тусдаа цэнэг гэж тооцно.

$r_{a,3}$ -ийг ийм нөхцөлд (8), (9) томьёогоор тодорхойлох бөгөөд N нь хэсгийн тоо болно.

834. Энэхүү дүрмийн 831-833-д заасан томьёог ашиглан тодорхойлсон аргыг зөвхөн эвдрэл гэмтэлд ороогүй, техникийн нөхцөлийн хувьд шаардлага хангаж байгаа барилга, байгууламжийн аюулгүй зайлт тогтооход хэрэглэнэ. Хэрвээ барилга, байгууламж нь гэмтэлтэй (хана нь ан цавтай, суурь нь суусан г.м) бол (5), (9) дүгээр томьёогоор тооцоолсон аюулгүй зайлт өсгөж тооцно. Энэ өсгөх хэмжээг тусгай мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн гаргана. Хэрвээ мэргэжлийн байгууллагын дүгнэлт байхгүй бол аюултай зайлт 2 дахинаас доошгүй өсгөж тооцоолох хэрэгтэй.

Дээр дурдагдсан аюулгүй зайлт тодорхойлох аргууд нь цамхаг, өндөр барилга, олон нийтийн зориулалтын ордон зэрэг барилга болон нарийн хийц зохион байгуулалттай байгууламж (гүүр, радиогийн болон зурагт радиогийн цамхаг, ус дулааны холбогдолтой байгууламж г.м)-д хамаарахгүй бөгөөд тийм байгууламжийн аюулгүй зайлт тусгай мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор гүйцэтгэнэ.

Энэхүү дүрмийн 831-834 заалтуудад авч үзээгүй:

-сунаж байрлуулсан бүлэг цэнэгийн чичирхийллийн чиглэл;

-олон удаагийн давталттай тэсэлгээнээс барилга байшинд үүссэн гэмтэл гарсан тохиолдол;

-1000 тн ба түүнээс их тэсрэх бодисоор хийсэн томоохон хэмжээний тэсэлгээний чичирхийллийн онцлог зэрэг хүчин зүйлүүд байвал мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор тодорхойлох нь зүйтэй.

835. Газрын гадарга дээр хийх тэсэлгээний үед үүсэх агаарын долгионы цохих үйлчлэлийн барилга байгууламжид аюулгүй зайлт дараах томьёонуудаар тодорхойлно.

$$r_{a,3} = K_{\text{ц}} * \sqrt[3]{Q} \quad (10)$$

$$r_{a,3} = k_{\text{ц}} * \sqrt{Q} \quad (11)$$

$r_{a,3}$ аюулгүй зайлт, метр

Q цэнэгийн жин, кг

$K_{\text{ц}}$, $k_{\text{ц}}$ цэнэгийн жин, байрлал, түүнчлэн барилга байгууламжид үүсч болох гэмтлийг хүлцэх аюулын зэргээс хамаарах пропорционалийн коэффициент (Энэхүү бүлгийн хүснэгт 6)

(10), (11) томьёог тэсрэх бодис бэлтгэж байгаа байр, байгууламж, тэсрэх материал хадгалж байгаа агуулах (байр, талбай), тэсрэх материалыг дахин боловсруулж буюу ачиж, буулгаж байгаа газар, тэсрэх материал ачсан тээврийн хэрэгслийн зогсоол, түүнчлэн ил цэнэг тэсэлж байгаа болон шидэлтэй тэсэлгээ хийж байгаа газраас хамгаалах байгууламж хүртэлх аюулгүй зайлт тодорхойлоход хэрэглэнэ.

(10) томьёог 1-3 зэргийн эвдрэлийг хүлцэх 10 тн-оос их хэмжээний ил цэнэгт болон 1-2 зэргийн эвдрэлийг хүлцэх өөрийнх нь өндөрөөр гүнзгийрүүлсэн 20 тн-оос дээш хэмжээтэй цэнэгийн үед хэрэглэнэ. (11) томьёог 1-3 зэргийн эвдрэлийг хүлцэх 10 тн-оос бага хэмжээний ил цэнэгт болон 1-2 зэргийн эвдрэлийг хүлцэх өөрийнх нь өндөрөөр гүнзгийрүүлсэн 20 тн-оос бага хэмжээтэй цэнэгийн үед, мөн харгалзах хэмжээний шидэлтийн цэнэгийн үед хэрэглэнэ. Түүнээс гадна (11) томьёог 4-5 зэргийн эвдрэлийг хүлцэх үед цэнэгийн хэмжээ, байрлалыг харгалзахгүйгээр хэрэглэнэ.

Хүснэгт 9. Тэсэлгээний ажлын үеийн агаарын цохих долгионы үйлчилгээний аюулгүй зайд тооцох ($K_{ц}$, $k_{ц}$) коэффициентийн холбогдох утга

| Эвдрэлийн зэрэг | Байж болох эвдрэл | Ил цэнэг | | | Цэнэгийн өндрийн хэмжээгээр гүнзгийлэн байрлуулсан цэнэг | | | $n = 3$ |
|-----------------|--|------------|-------------|-------------|--|------------|----------|-------------------------------------|
| | | Q , тн | $k_{ц}$ | $K_{ц}$ | Q , тн | $k_{ц}$ | $K_{ц}$ | |
| 1 | Гэмтэлгүй | <10 >10 | 50-150 - | - 400 | <20 >20 | 20-50 - | - 200 | 3-10 - |
| 2 | Цонхны шил тохиолдлоор хагарах | <10 >10 | 10-30 - | - 60-100 | <20 >20 | 5-12 - | - 50 | - 1-2 |
| 3 | Цонхны шилний бүрэн эвдрэл, хаалга, жаазны гэмтэл, шаваас, дотоод хөнгөн хаалтуудын эвдрэл | <10 >10 | 5-8 - | - 30-50 | - - | - 2-4 | - - | - 0.5-1 |
| 4 | Дотор таславч, жааз, хаалга, сарай зэргийн эвдрэл | - | 2-4 | - | - | 1-2 | - | Тэсэлгээний хонхрын хязгаарт эвдрэх |
| 5 | Бат бэх бус чулуун ба модон байшингийн эвдрэл төмөр замын бүрэлдэхүүн онхолдох | - | 1.5-2 | - | - | 0.5-1 | - | - |

836. Хүснэгт 9-г ашиглахдаа дараахь зарчмыг баримтална.

а) эвдрэлийн зэрэг, коэффициентын тоон утгыг сонгон авахдаа нөхцөл байдлыг бүх талаас нь бүрэн тусгаж тооцоолох, аюулгүйн зэрэглэлийг тогтооход хүндрэлтэй бол холбогдох мэргэжлийн байгууллага, хамгаалах барилга байгууламжийг эзэмшигч болон мэргэжлийн хяналтын байгууллагын төлөөлөгчдийг оролцуулан шийдвэрлэнэ;

б) тэсрэх материалын агуулахыг байгуулах газрыг сонгоход ойр орчмын барилгад үүсч болох эвдрэлийн зэрэг, коэффициентын тоон утгыг уг байгууламжийн зориулалт, ач холбогдлыг харгалзан тогтооно;

Ерөнхий нөхцөлд тэсрэх материалын агуулахаас хүн ам бүхий хот, суурин, авто ба төмөр зам, үйлдвэрийн байгууламж, тэсрэх болон шатах аюултай материалын агуулах, улсын чанартай байгууламжийн аюулгүй зайд эвдрэлийн 3 дугаар зэрэглэлд багтаан тооцно;

Зайдуу сондгой орших барилга болон бусад 2 дугаар зэргийн ач холбогдолтой байгууламж, бага хөдөлгөөнтэй авто ба төмөр зам, бат бэх байгууламж (төмөр ба төмөр бетонон гүүр, ган ба төмөр бетон цамхаг, элеватор г.м), усан замд ойрхон өндөр эрэг

дээр байрласан тэсрэх материалын агуулах, түүнтэй адилтгах байгууламжийн аюулгүйн зайл эвдрэлийн 4 дүгээр зэрэглэлд багтаан тооцно;

в) цахилгаан дамжуулах шугам нь агаарын долгионы цохилтод тэсвэртэй байгууламжид орох учир түүний аюулгүй зайл тэсэлгээгээр шидэгдэх чулуулгийн бутармагийн радиусаар тодорхойлно;

г) эвдрэлийн 1, 2 дугаар зэрэглэлд багтах байгууламжийн хувьд шороон далангаар халхлагдсан агуулахыг ил цэнэгээр тооцно. Эвдрэлийн 2 дугаар зэрэгээс дээших зэрэглэлд багтах байгууламжийн хувьд шороон далангаар халхлагдсан агуулахыг өндрийнх нь хэмжээгээр гүнзгийлэн байрлуулсан цэнэгтэй адилтган тооцно;

д) энэхүү бүлгийн хүснэгт 6-д заасан эвдрэлийн зэрэг, коэффициентын тоон утгыг аюулгүйн зайл нь тодорхойлох барилга байгууламжийн байдлаас шалтгаалан хүснэгтэд заасан хязгаараас сонгон ашиглана. Байгууламжийн байдал сайн бол коэффициент нь бага, байгууламжийн байдал муу бол их байхаар коэффициентыг тооцож авах зарчмыг баримтална;

е) аюулгүй зайл тодорхойлох тооцоонд тэсрэх бодисын шинж чанарыг харгалзахгүй.

837. Хамгаалж байгаа барилга, байгууламж долгионы цохилтын замд байгаа хаалт, хамгаалалтын цаана (өтгөн ойн цаана, гувээ толгодын хормойд г.м) оршиж байгаа нөхцөлд дээрх томьёогоор тодорхойлсон аюулгүй зайл багасгаж болох боловч багасгасан зайл нь 2 дахин авснаас хэтрэхгүй байна.

838. Нарийн жалга, хавцал хоолойд буюу барилгуудын гудамж дунд хийгдэх тэсэлгээний үед тооцоогоор гарсан аюулгүй зайл 2 дахин ихэсгэж авна.

839. Тэсэлгээ хийж байгаа газрын цаад талд $1.5\sqrt{Q}$ радиусын хүрээн дотор хана, далан маягийн хаалт, хамгаалалт байгаа бол түүний эсрэг талын аюулгүй зайл (10) томьёогоор тооцоходоо 1.3 дахин, (11) томьёогоор тооцоходоо 1.4 дахин ихэсгэж авна.

840. Агаарын цохих долгионы үйлчлэлийг бууруулахын тулд дараахь арга хэмжээ авч болно.

а) ил цэнэгийг хөрсөөр дарж хучих. Ил цэнэгийн өндрөөс 5 дахин илүү хөрсөөр ил цэнэгийг бүрэн хучсан тохиолдолд аюулгүй зайл 4 дахин багасгаж болно. Тэгэхдээ хучилт хийж байгаа хөрсөнд том, хүнд чулуу, хайрга, төмөр зэрэг зүйлс байж болохгүй;

б) цонхны шилийг рамнаас нь салган авах, цонхыг онгойлгож бэхлэх, цонхыг гадна талаас нь бат бэх хаалтаар хаах г.м;

в) шуудайтай буюу хайрцагтай элсээр хаалт хийх.

841. Тэсрэх материал болон түүнтэй адилтгах материал хадгалах агуулах барих газрыг сонгох болон тэсрэх материалын агуулахын ойролцоо бусад байгууламжийн байршлыг сонгоходоо агаарын долгионы цохилтын аюулгүй зайл энэхүү бүлгийн хүснэгт 7-г ашиглан тогтооно.

Хүснэгт 10. Тэсрэх бодисын агуулах болон түүнтэй адилтгах хадгалах байгууламжаас төрөл бүрийн объект хүртэлх агаарын цохих долгионы үйлчлэлийн зөвшөөрөгдөх хэмжээ

| № | Аюулгүйн зайл нь тооцох жишиг объектын жагсаалт | Тэсрэх материал хадгалах байр (талбай), агуулах болон түүнтэй адилтгах байрны байрлалын нөхцөл | Тооцоо хийх томъёо | Тэсрэх бодисын (кг) хэмжээнээс хамааран объект хүртэл зөвшөөрөгдөх хамгийн бага зайл, метр | | | | | | | | | | | |
|---|---|--|--|--|-----------------|-------------------|-------------------|-----------------|---------------------|---------------------|-------------------|---------------------|-----------------|-------------------|---------------------|
| | | | | 500 | 10 ³ | 2·10 ³ | 4·10 ³ | 10 ⁴ | 1.5·10 ⁴ | 2.5·10 ⁴ | 5·10 ⁴ | 7.5·10 ⁴ | 10 ⁵ | 2·10 ⁵ | 2.5·10 ⁵ |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 |
| 1 | Зайдуу, сондгой орших байшин барилгүүд, хөдөлгөөн багатай авто ба төмөр зам, агаарын цохилтыг эсэргүүцэх онцгой бат бэх (төмөр бетон, ган гүүрүүд, элеватор, нүүрс угаах цогцолбор г.м) байгууламжууд | Гүнзгийрүүлсэн (далангаар хашсан) | $r_{a,3} = \sqrt{Q}$ | 20 | 30 | 40 | 65 | 100 | 120 | 160 | 220 | 270 | 320 | 450 | 500 |
| | | ил барьсан | $r_{a,3} = 2\sqrt{Q}$ | 45 | 60 | 90 | 130 | 200 | 240 | 320 | 450 | 550 | 630 | 900 | 1000 |
| 2 | Хүн ам бүхий суурин, төмөр ба авто гол замууд, томоохон усан зам, завод фабрикууд тэсрэх ба галын аюултай материалын агуулахууд, улсын ач холбогдол бүхий байгууламжууд | Гүнзгийрүүлсэн (далангаар хашсан) | $r_{a,3} = 2\sqrt{Q}$ | 45 | 60 | 90 | 130 | 200 | 240 | 320 | 450 | 550 | 630 | 900 | 1000 |
| | | ил барьсан | $r_{a,3} = 5\sqrt{Q}$ Энд $Q \leq 10 \text{ т}$ $r_{a,3} = 30\sqrt[3]{Q}$ Энд $Q > 10 \text{ т}$ | 100 | 160 | 220 | 320 | 500 | 740 | 880 | 1100 | 1250 | 1400 | 1750 | 1900 |
| 3 | Зөвхөн шиллэсэн эд ангиудаас эвдрэл үүсч болох объектууд | Гүнзгийрүүлсэн (далангаар хашсан) ил барьсан | $r_{a,3} = 10\sqrt{Q}$ Энд $Q \leq 10 \text{ т}$ $r_{a,3} = 60\sqrt[3]{Q}$ Энд $Q > 10 \text{ т}$ | 220 | 320 | 450 | 630 | 1000 | 1500 | 1750 | 2200 | 2500 | 2800 | 3500 | 3800 |

842. Ил цэнэг, цооногийн цэнэгийг тэслэх үед агаарын цохих долгионы хүч шил, шилэн эдлэлд үйлчлэх аюулгүй зайд тодорхойлох. Энэ нь тухайн төслийн шаардлагаар шил гэмтээхгүй аюулгүйн зайд тодорхойлно.

843. Барилгын нормын чулуулгийн ангиллын VI-VIII бүлэгт багтах чулуулгат ил цэнэг болон цооног (шпур)-ийн сийрэгжүүлэх цэнэгээр нэгэн зэрэг тэсэлгээ хийх үед агаарын цохих долгионы хүч шил, шилэн эдлэл дээр үйлчлэх аюулгүй зайд дараах томъёонуудаар тодорхойлно.

$$r_{a_3} = 200 * \sqrt[3]{Q_3} \quad \text{энд } 5000 > Q_3 \geq 1000 \text{ кг} \quad (12)$$

$$r_{a_3} = 65 * \sqrt{Q_3} \quad \text{энд } 2 \leq Q_3 < 1000 \text{ кг} \quad (13)$$

$$r_{a_3} = 63 * \sqrt[3]{Q_3^2} \quad \text{энд } Q_3 \leq 2 \text{ кг} \quad (14)$$

Q_3 эквивалент цэнэгийн жин, кг;

Барилгын чулуулгийн нормын ангиллын IX ба түүнээс дээш бүлгийн чулуулгат тэсэлгээ хийхэд энэхүү дүрмийн 12, 13, 14 дүгээр томъёогоор тодорхойлсон аюултай бүсийн зайд 1.5 дахин ихэсгэх ба хэрэв V ба түүнээс доош бүлэгт аюултай бүсийн зайд 2 дахин багасгаж болно.

Эквивалент цэнэгийн жинг тодорхойлоходоо:

а) $h_{цэн}$ өндөртэй, $h_{түг}$ зузаан хөрсний үеэр хучиж нэгэн зэрэг тэслэх ил цэнэгүүдэд:

$$Q_3 = k_{ил} * Q \quad (15)$$

Q цэнэгийн нийлбэр жин, кг;
 $k_{ил}$ хучсан хөрсний зузаан, ил цэнэгийн өндрийн $h_{түг}/h_{цэн}$ харьцаанаас хамаарах коэффициент. Үүнийг хүснэгт 10-ын дагуу тодорхойлно.

Хүснэгт 11. Ил цэнэгийг хөрсөөр хучиж тэсэлгээ хийх үеийн эквивалент цэнэгийн жинг тооцоолох ($k_{ил}$) коэффициентын холбогдох утга

| $h_{түг}/h_{цэн}$ | 0 | 1 | 2 | 3 | 4 |
|-------------------|---|-----|-----|-----|------|
| $k_{ил}$ | 1 | 0.5 | 0.3 | 0.1 | 0.03 |

б) өөрийнх нь диаметрийг 12 дахин авснаас бага урттай цэнэг ($l_{цэн} < 12d$) бүхий N цооног (шпур)-ын бүлэг цэнэгийг нэгэн зэрэг тэслэхэд

$$Q_3 = P * l_{цэн} * k_{түг} * N \quad (16)$$

P 1 м урт цооног (шпур)-т орох цэнэгийн багтаамж, кг;
 $l_{цэн}$ цэнэгийн урт, метр;
 $k_{түг}$ утга нь түгжээний урт $l_{түг}$ -ийг цооног (шпур)-ын диаметр d -т харьцуулсан харьцаанаас хамаарах коэффициент (Түгжээсгүй үед цооногийн цэнэггүй хэсгийн урт $l_{цо}$ -ыг диаметр d -д харьцуулсан харьцаанаас хамаарна.)

Энэ коэффициентын утгыг хүснэгтэд 12-д үзүүлэв.

Хүснэгт 12. (l_t/d) буюу ($l_{цо}/d$) харьцаанас хамаарах (K_t) коэффициентын утга

| | | | | | |
|-------------|---|------|------|-------|-------|
| $l_{түг}/d$ | 0 | 5 | 10 | 15 | 20 |
| $K_{түг}$ | 1 | 0.15 | 0.02 | 0.003 | 0.002 |
| $l_{цо}/d$ | 0 | 5 | 10 | 15 | 20 |
| $K_{түг}$ | 1 | 0.3 | 0.07 | 0.02 | 0.004 |

в) өөрийн нь диаметрийг 12 дахин авснаас их урттай цэнэг ($l_{цэн}/12d$) бүхий N цооног (шпур)-ын бүлэг цэнэгийг нэгэн зэрэг тэслэх үед:

$$Q_3 = 12 * P * d * k_{түг} * N \quad (17)$$

844. Цэнэгийг цочир дамжуулах шижмээр өдөөж тэслэх нөхцөлд, хэлхээнд орсон бүх цочир дамжуулах шижим дэх тэсрэх бодисын жинг энэхүү дүрмийн 15, 16, 17 томьёогоор тодорхойлсон Q_3 -ийн утга дээр нэмж тооцно.

845. Хором удаашралтай тэсэлгээнд Q_3 ба N -ийн тоон утгад нэг бүлгийн цэнэгийн эквивалент жин ба цэнэгийн тоог тооцно.

Хэд хэдэн бүлэг цэнэгийн удаашралтай тэсэлгээнд хамгийн их жинтэй бүлэг цэнэгийг Q_3 тооцоонд авна. Тэсэрч байгаа бүлэг цэнэгүүдийн хоорондын хором удаашруулах хугацаа нь 50 мс-тэй тэнцүү буюу их байвал аюулгүй зайлг энэхүү дүрмийн 12, 13, 14 дүгээр томьёогоор тодорхойлно.

Хором удаашралтын хугацаа 30-50 мс байвал энэхүү дүрмийн 12, 13, 14 дүгээр томьёогоор тооцоолсон аюулгүй зайлг 1.2 дахин, хором удаашралтын хугацаа 20-30 мс байвал 1.5 дахин, 10-20 мс байвал 2 дахин тус тус өсгөж авна.

846. Агаарын хэм хасах үед тэсэлгээний ажил хийхэд энэхүү дүрмийн 12, 13, 14 томьёогоор тооцсон аюулгүй зайлг 1.5 дахин ихэсгэж авна.

847. Эмнэлэг, хүүхдийн байгууллага, шилэн ханатай барилга болон олон хүн нэгэн зэрэг цуглардаг газрын ойролцоо тэсэлгээ хийх үеийн аюулгүй зайлг тодорхойлоход мэргэжлийн байгууллага, ажилтны туслалцаа авсан байна.

848. Агаарын цохих долгионы хүнд үйлчлэх аюулгүй зайлг тодорхойлох.

Ил цэнэгээр тэсэлгээ хийхэд агаарын цохих долгионы хүнд аюулгүй хамгийн бага зайлг доорх томьёогоор тодорхойлно.

$$r_{min} = 15 \cdot \sqrt[3]{Q} \quad (18)$$

Q -тэсрэх бодисын ил цэнэгийн жин, кг;

(18) томьёог зөвхөн тэсэлгээний ажил явуулж байгаа хүний зайлшгүй шаардлагаар тэсэлж буй газарт хамгийн ойртож болох зайлг тодорхойлоход ашиглана. Бусад бүх тохиолдолд (18) томьёогоор тодорхойлсон зайлг 2-3 дахин ихэсгэж хэрэглэнэ. Зориулалтын хоргодох байртай үед тэсэлгээ хийхэд (18) томьёогоор бодож тооцсон зайлг 1.5 дахин хүртэл багасган тооцож болно.

849. Тэсрэлтээр үүсэх детонаци дамжихгүй байх аюулгүй зайд тодорхойлох.

Газрын гадарга дээр байгаа тэсрэх материал бүхий нэг объектоос (идэвхтэй цэнэг гэх) тэсрэх материал бүхий нөгөө объектод (идэвхгүй цэнэг гэх) тэсрэлт дамжихгүй байх зайд r_d -г доорх томьёогоор тодорхойлно.

**Хүснэгт 13. Тэсрэлт дамжихгүй байх аюулгүй зайд тооцох
(K_d) коэффициентын утга**

| Тэсрэх материал | Байр-лал | 40% хүртэл нитро эфир агуулсан болон нироэфиргүй аммиакын шүүний тэсрэх бодис (Цочир дамжуулах шижим агуулсан бүтээгдэхүүн) | | 40% ба түүнээс дээш нитроэфирийн агууламжтай тэсрэх бодис | | Тротил | Тэслүүр |
|---|--------------|---|---------------|---|---------------|-----------------------|---------|
| | | Ил | Гүнз-гийл-сэн | Ил | Гүнз-гийл-сэн | | |
| Идэвхтэй цэнэг | | Идэвхгүй цэнэг | | Идэвхгүй цэнэг | | Идэвхгүй цэнэг | |
| 40% хүртэл нитро эфир агуулсан болон нироэфиргүй аммиакын шүүний тэсрэх бодис (Цочир дамжуулах шижим агуулсан бүтээгдэхүүн) | Ил | 0.8 | 0.5 | 1.1 | 0.8 | 1.3 | 1 |
| | Гүнз-гийлсэн | 0.5 | 0.3 | 0.8 | 0.5 | 1 | 0.6 |
| 40% ба түүнээс дээш нитроэфирийн агууламжтай тэсрэх бодис | Ил | 1.6 | 1 | 2.3 | 1.6 | 2.5 | 2 |
| | Гүнз-гийлсэн | 1 | 0.6 | 1.6 | 1 | 2 | 1.3 |
| Тротил | Ил | 1.3 | 1 | 1.6 | 1.3 | 1.9 | 1.4 |
| | Гүнз-гийлсэн | 1 | 0.6 | 1.3 | 0.9 | 1.4 | 0.8 |
| Тэслүүр | Ил | 0.4 | 0.25 | 0.75 | 0.5 | 0.7 | 0.6 |
| | Гүнз-гийлсэн | 0.25 | 0.2 | 0.5 | 0.4 | 0.6 | 0.4 |

$$r_d = K_d * \sqrt[3]{Q} * \sqrt[4]{b} \quad (19)$$

K_d -тэсэлгээний нөхцөл, тэсрэх материалын цэнэгийн төрлөөс хамаарах коэффициент;

Q -тэсрэх бодисын идэвхтэй цэнэгийн жин, кг;

b -идэвхгүй цэнэгийн бага талын шугаман хэмжээ (хураалтын өргөн), метр;

850. Байгууламжуудын тэсрэлт дамжуулахгүй байх аюулгүй зайд тооцох K_d коэффициентыг (хүснэгт 14) тодорхойлоходоо, цэнэгтэй дараахь байдлаар адилтган үзнэ. Үүнд:

а) далангаар хашсан агуулахыг өөрийнх нь өндрийн хэмжээгээр газрын хөрсөнд гүнзгийлэн суулгасан цэнэгтэй адилтгах;

б) газрын гадарга дээрх далан хамгаалалтгүй тэсрэх материалын ил агуулах болон тэсрэх материал хураасан талбайг ил цэнэгтэй адилтгах.

851. Тэсрэх материалын хоёр агуулахын хоорондын аюулгүйн зайд (19) томьёогоор тодорхойлохдоо, агуулах бүрийг ээлж дараалан идэвхтэй цэнэгт тооцон бодоод, тэдгээрийн хамгийн их тоон утгыг авна. Нэг, нэг тэнхлэг дээр байрласан урт хэлбэрийн агуулахад тэсрэх материал хадгалах тохиолдолд тэдгээрийн хоорондын аюулгүй зайд ямарч тохиолдолд, аль өргөн агуулахын нь өргөнийг 2 дахин авснаас багагүй байна. Ямар ч байрлалтай агуулах (талбай)-ын хоорондын аюулгүй зайд нь, галын аюулгүй байдлын дүрмээр тогтоосон аюулгүй зайнас багагүй байна.

Хэрэв зураг төсөл боловсруулах явцад тэсрэх материалын агуулахын хоорондын зайд (19) томьёогоор тооцож гаргаснаас багасгах зайлшгүй шаардлагатай бол тийм агуулахын аюулгүй зайд агуулахуудад байвал зохих нийт тэсрэх материалын нөөцөөс хамааруулан тооцно.

Үндсэн агуулахуудаас бага багтаамжтай онцгой аюултай объектуудыг (тэсэлгээний хэрэгслийн агуулах, тэсрэх бодис задлах, бэлтгэх байр, тэсрэх бодистой бункер гэх мэт) тэдгээрт үүссэн тэсрэлт үндсэн агуулах тус бүрт тэсрэлт дамжуулахгүй байх зайд байрлуулж болно. Энэ зайд (19) томьёогоор тодорхойлох бөгөөд онцгой аюултай байгууламжид байгаа тэсрэх материалыг идэвхтэй цэнэгээр тооцно.

852. Тэсрэлт дамжихгүй байх аюулгүй зайд мөн энэхүү бүлгийн хүснэгт 14-ийг ашиглан тодорхойлж болно.

Хүснэгт 14. Тэсрэх бодисын агуулахуудын хооронд тэсрэлт дамжихгүй байх аюулгүй зайн зөвшөөрөгдөх (r_d) хэмжээний утга

| Идэвхтэй цэнэг | K_d | Идэвхгүй цэнэг | Тэсрэх материалын жинг тн-оор (тн) илэрхийлсэн багтаамжтай агуулахын тэсрэлт дамжуулахгүй байх аюулгүй зайн утга (метр) | | | | | |
|---|-------|---|---|----|----|-----|-----|-----|
| | | | 10 | 25 | 60 | 120 | 240 | 420 |
| 40% хүртэл нитроэфир агуулсан аммиакийн шүүний тэсрэх бодис | | 40% хүртэл нитроэфир агуулсан аммиакийн шүүний тэсрэх бодис | | | | | | |
| Ил | 0.8 | Ил | 20 | 27 | 36 | 45 | 56 | 68 |
| Ил | 0.5 | Гүнзгийлсэн | 12 | 17 | 22 | 28 | 35 | 43 |
| Гүнзгийлсэн | 0.5 | Ил | 12 | 17 | 22 | 28 | 35 | 43 |
| Гүнзгийлсэн | 0.3 | Гүнзгийлсэн | 7 | 10 | 14 | 17 | 21 | 26 |
| 40% хүртэл нитроэфир агуулсан | | Тротил | | | | | | |

| | | | | | | | | |
|-------------------------------|-----|---|----|----|----|-----|-----|-----|
| аммиакийн шүүний тэсрэх бодис | | | | | | | | |
| Ил | 1.3 | Ил | 32 | 43 | 58 | 73 | 91 | 110 |
| Ил | 1 | Гүнзгийлсэн | 25 | 33 | 44 | 56 | 70 | 85 |
| Гүнзгийлсэн | 1 | Ил | 25 | 33 | 44 | 56 | 70 | 85 |
| Гүнзгийлсэн | 0.6 | Гүнзгийлсэн | 15 | 20 | 27 | 34 | 42 | 51 |
| Тротил | | 40% хүртэл нитроэфир агуулсан аммиакийн шүүний тэсрэх бодис | | | | | | |
| Ил | 1.3 | Ил | 32 | 43 | 58 | 73 | 91 | 110 |
| Ил | 1 | Гүнзгийлсэн | 25 | 33 | 44 | 56 | 70 | 85 |
| Гүнзгийлсэн | 1 | Ил | 25 | 33 | 44 | 56 | 70 | 85 |
| Гүнзгийлсэн | 0.6 | Гүнзгийлсэн | 15 | 20 | 27 | 34 | 42 | 51 |
| Тротил | | Тротил | | | | | | |
| Ил | 1.9 | Ил | 46 | 63 | 84 | 106 | 133 | 160 |
| Ил | 1.4 | Гүнзгийлсэн | 34 | 46 | 62 | 78 | 98 | 118 |
| Гүнзгийлсэн | 1.4 | Ил | 34 | 46 | 62 | 78 | 98 | 118 |
| Гүнзгийлсэн | 0.8 | Гүнзгийлсэн | 20 | 27 | 36 | 45 | 56 | 68 |

Тайлбар: Тооцоог энэхүү дүрмийн (19) томьёогоор $b = 1.6$ метр гэж хийв.

853. Идэвхгүй цэнэг нь төрөл бүрийн тэсрэх материалаас бүрдэж байгаа бол (жишээ нь: аммонит, тротил г.м) аюулгүй зайд тооцоходоо цэнэгийн бүрэлдэхүүнд орж байгаа тэсрэх материалаас тэсрэлтийн цочир хүлээж авахдаа аль илүү мэдрэмтгийгээр нь K_d -г сонгож авна.

854. Тэсэлгээний үед ялгарах хортой хий, тоосны үүлэнцэр тархалтынхаа дагуу хүн, амьтныг хордуулах үйлчлэлтэй. 200 тн-оос их жинтэй тэсрэх бодисын цэнэгээр нэгэн зэрэг шидэлттэй тэсэлгээ хийх үед, тэсрэлтийн хийн үйлчлэлийн аюулыг тооцон, агаарт тархах хорт хийн агуулга хүрээнээс нь гадагш эрүүл ахуйн зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрэхгүй байх аюулгүй зайд $r_{хий}$ -г нүүрстөрөгчийн ислээр жишин бодож тогтооно.

855. Хорт хийн тархалтын аюулгүй зайд ($r_{хий}$)-г салхигүй үед болон салхины чиглэлд хөндлөн тархах нөхцөлд доорх томьёогоор тодорхойлно.

$$r_{хий} = 160 * \sqrt[3]{Q}, \text{ м} \quad (20)$$

Q -тэсрэх цэнэгийн нийт жин, тн;

Хорт хийн салхины эсрэг чиглэлийн тархалтын аюултай бүсээр (20) томьёогоор тодорхойлсон зайд авна. Хорт хийн салхины дагуу тархалтын аюултай бүс ($r_{хий1}$) -ийг доорх томьёогоор тодорхойлно.

$$r_{xh1} = 160 * \sqrt[3]{Q(1 + 0.5V_c)}, \text{ м} \quad (21)$$

V_c -тэсэлгээ хийхийн өмнөх салхины хурд м/сек.

Далд уурхайн тэсэлгээний ажлын үеийн агаарын
цохилтын долгионы аюулгүй зайд

856. Далд уурхайд тэсэлгээний ажлын үед агаарын цохилтын долгионы (АЦД) цохилтоор хүн гэмтээхгүй, барилга байгууламж, технологийн тоног төхөөрөмжид эвдрэл учруулахгүй байх аюулгүй зайд тодорхойлохын тулд агаарын цохилтын долгионы илүүдэл даралтын утгыг тодорхойлно.

857. Барилгын нормын ангиллаар VI-VIII группын чулуулгийн (хатуулгийн коэффициент $f=8-12$) хувьд агаарын цохилтын долгионы илүүдэл даралтыг дараахь томьёогоор тодорхойлно:

$$\Delta P = \left(3410 \frac{Q_e}{R \sum S} + 794 \sqrt{\frac{Q_e}{\sqrt{R \sum S}}} \right) \cdot e^{-\frac{\beta R}{d}}, \quad (22)$$

ΔP -агаарын цохилтын долгионы илүүдэл даралт, кПа;

Q_e -нэгэн зэрэг (нэг агшинд) тэсэrsэн эквивалент цэнэгийн жин, кг;

эквивалент цэнэгийн жинг (Q_e) тэсэлгээний ажил гүйцэтгэх аргаас хамааруулан (ил цэнэгийн, шпурын ба цооногийн цэнэгийн тэсэлгээ гэх мэт) энэхүү дүрмийн 842-ын дагуу тооцно;

R -цэнэгээс тооцоо хийх цэг хүртэлх агаарын цохилтын долгион малталтаар тархах зайд, метр;

$\sum S$ -агаарын цохилтын долгионы даралтыг нь тооцож байгаа тэсрэх бодисын цэнэгтэй нийлж байгаа малталтуудын хөндлөн огтлолын талбайн нийлбэр, м^2 ;

e -натурал логарифмын суурь, $e = 2,71$;

d -малталтын шилжүүлсэн диаметр;

$$d = 1,12\sqrt{S}, \text{ метр} \quad (23)$$

β -ажлын гадаргуугийн тэгш бус байдлын коэффициент. Төрөл бүрийн хатуулагтай гадаргуугийн тэгш бус байдлын коэффициентын тоон утга β -г энэхүү дүрмийн хүснэгт 16-д үзүүлсэн болно.

Барилгын нормын IX болон түүнээс дээш группын чулуулгийг (хатуулгийн коэффициент $f=12-20$) тэслэх үед (22) томьёогоор тодорхойлсон агаарын цохилтын долгион дахь даралтын утгыг 1.5 дахин өсгөх ба харин V болон түүнээс доош чулуулгийг ($f<8$) тэслэх үед радиусыг 2 дахин багасгаж авна.

Агаарын цохилтын долгионы илүүдэл даралтын тоон утга нь хүнд болон хамгаалагдах объектуудад хувьд зөвшөөрөгдөх хамгийн их утгаас хэтэрч болохгүй.

Агаарын цохилтын долгионы илүүдэл даралтын зөвшөөрөгдөх хамгийн их даралт нь ажилчдын хувьд $0.1 \text{ кг}/\text{см}^2$ (10 кПа) байна.

Агаарын цохилтын долгионы илүүдэл даралтын зөвшөөрөгдөх хамгийн их даралтын утгыг зарим объектын хувьд энэхүү дүрмийн хүснэгт 15-д үзүүлсэн болно.

Хэрэв тооцоолсон хэсэг дэх даралт нь зөвшөөрөгдөх хамгийн их утгаас их бол аюултай бүсийн хамгаалалтын постыг холдуулж, тооцоог дахин хийнэ.

Хүснэгт 15. Зарим байгууламжид зөвшөөрөгдөх агаарын долгионы цохилтын илүүдэл даралтын утга

| № | Байгууламжийн нэр | Эвдэж гэмтээх үйлчлэлтэй даралтын утга, кПа |
|-----|---|---|
| 1. | Шилэн эд | 2 |
| 2. | Модон хаалт | 10 |
| 3. | Агааржуулалтын хоолой | 15 |
| 4. | Цахилгаан тоног төхөөрөмж | 20 |
| 5. | Цахилгааны сүлжээ | 30 |
| 6. | Орчны агааржуулалтын вентилятор | 40 |
| 7. | Лебедка (1 тн хүртэл жинтэй) | 40 |
| 8. | Тоосгон хаалт (0.2 ... 0.4 метр зузаантай) | 50 |
| 9. | Нээлхий, агаарын хоолой | 60 |
| 10. | Цахилгаан тэрэгний агаарын шугам | 80 |
| 11. | Вагонеток: | |
| | - тэсрэлтийн чиглэлийн дагуу байрлалтай | 140 |
| | - тэсрэлтийн чиглэлд хөндлөн байрлалтай | 50 |
| 12. | Малтальтын машин | 140 |
| 13. | Модон бэхэлгээ | 80 |
| 14. | Аркан төмөр бэхэлгээ | 150 |
| 15. | Бетон хаалт | 200 / 400 |
| 16. | Төмөр бетон хана (0.25 метр зузаантай) | 280 / 350 |
| 17. | Төмөр зам | 700 |

Хүснэгт 16. Далд уурхайн малталтын дотор гадаргуугийн тэгш бусын коэффициент

| Малталтын бэхэлгээний нөхцөл | Тэгш бусын коэффициент β |
|--|--------------------------------|
| Бэхэлгээгүй | |
| Суналын дагуу нэвтэрсэн | 0.02 / 0.25 |
| Суналд хөндлөн нэвтэрсэн үед цохилтын долгионы хөдөлгөөний чиглэл: | |
| - чулуулгийн уналын эсрэг | 0.04 / 0.045 |
| - чулуулгийн уналын дагуу | 0.022 / 0.028 |
| Тэгш бус ултай, нээлхийнүүдтэй малталт | 0.045 / 0.063 |
| Бэхэлгээтэй: | |
| - бетонон | 0.010 / 0.015 |
| - бүрэн бус раман бэхэлгээтэй | 0.025 / 0.034 |
| - төмөр аркан бэхэлгээтэй | 0.04 / 0.06 |
| - торкрет бетонон | 0.02 / 0.025 |
| - төмөр аркан бэхэлгээтэй хүдэр буулгах люктай | 0.05 / 0.07 |

Тайлбар: Агаарын цохилтын долгионыг төрөл бүрийн бэхэлгээтэй малталтаар нэвтрэх үеийн тэгш бусын дундаж коэффициент (β_{dy})-ыг дараахь томьёогоор тодорхойлно.

$$\beta_{dy} = \frac{(\beta_1 R_1 + \beta_2 R_2 + \cdots + \beta_n R_n)}{R}$$

$\beta_1, \beta_2, \beta_n$ - цохилтын долгион нэвтэрч буй малталтын тэгш бусын коэффициент;




R_1, R_2, R_n ($\beta_1, \beta_2, \beta_n$) - коэффициентод харьялах малталтын урт, метр.

858. Хэрэв агаарын цохилтын долгион малталтаар тархах зам нь орчны эсэргүүцэлтэй бол (22) томьёогоор тодорхойлсон илүүдэл даралтын тоон утгыг орчин тус бүрийн эсэргүүцэлд харгалзах бууруулах (хүчитгэх) коэффициентод хуваана. Орчны эсэргүүцлийн бууруулах (хүчитгэх) коэффициентын тоон утгыг энэхүү дүрмийн хүснэгт 17-д үзүүлсэн болно.



Нэвт болон мухар малталтад агаарын цохилтын долгионы даралтыг бууруулах коэффициентыг ашиглаж болно.

Хэрэв мухар малталтын урт нь долгионы туулах замын 1/4-ээс богино байвал орчны эсэргүүцлийг тооцохгүй. Түүнчлэн алгуур мурийж буй малталтад бууруулах коэффициентийг тооцохгүй.

Хүснэгт 17. Агаарын цохилтын долгион малталт дахь орчны эсэргүүцлийг нэвтрэх үеийн даралт өөрчлөгдхөк коэффициент

| Орчны эсэргүүцлийн төрөл | Сулралтын коэффициент | | | | | |
|---|-----------------------|---|------|------|------|------|
|  | | Малталтын огтолол ижил үед $Z = \frac{\Delta P_1}{\Delta P_3}$ | | | | |
| | | α^0 | 45° | 90° | 135° | 175° |
| | | Z | 2.3 | 2.7 | 3.1 | 3.4 |
| | | $\delta = \frac{\Delta P_1}{\Delta P_2}$ | | | | |
| | | α^0 | 45° | 90° | 135° | 175° |
| | | δ | 1.5 | 1.25 | 1.2 | 1.1 |
|  | | Янз бүрийн огтоллой малталтад: $E = \frac{S_3}{S_1}; Z = \frac{\Delta P_1}{\Delta P_3}$ | | | | |
| | | E | 1 | 0.8 | 0.6 | 0.4 |
| | | Z | 2.7 | 2.4 | 2.2 | 1.9 |
| | | $\delta = \frac{\Delta P_1}{\Delta P_2}$ | | | | |
| | | E | 1 | 0.8 | 0.6 | 0.4 |
| | | δ | 1.25 | 1.2 | 1.15 | 1.1 |
|  | | $E = \frac{f}{F}; Z = \frac{\Delta P_1}{\Delta P_2}$ | | | | |
| | | E | 1 | 0.8 | 0.6 | 0.4 |
| | | Z | 1 | 1.13 | 1.35 | 1.9 |
| | | $E = \frac{f}{F}; \theta = \frac{\Delta P_1}{\Delta P_2}$ | | | | |
| | | E | 1 | 0.8 | 0.6 | 0.4 |
| | | | | | | 0.2 |

| | | | | | | | |
|--|---|------|-----|------|------|------|-----|
| | θ | 1.9 | 2.1 | 2.5 | 3.3 | 6.0 | |
| | $E = \frac{f}{F}; \theta = \frac{\Delta P_1}{\Delta P_2}$ | E | 1 | 0.8 | 0.6 | 0.4 | 0.2 |
| | θ | 1.9 | 1.4 | 1.25 | 1.0 | 0.75 | |
| | <p>Малтальтын оглол ижил үед:</p> | | | | | | |
| | $\theta' = \frac{\Delta P_1}{\Delta P_3} = 4.0; \theta = \frac{\Delta P_1}{\Delta P_2} = 1.3$ | | | | | | |
| | $E = \frac{f}{F}; \theta = \frac{\Delta P_1}{\Delta P_2}$ | E | 1 | 0.8 | 0.6 | 0.4 | 0.2 |
| | θ | 1.2 | 1.0 | 0.91 | 0.77 | 0.7 | |
| | $E = \frac{f}{F}; Z = \frac{\Delta P_1}{\Delta P_3}$ | E | 1 | 0.8 | 0.6 | 0.4 | 0.2 |
| | K | 4 | 3.3 | 2.9 | 2.5 | 2.0 | |
| | $\delta = \frac{\Delta P_1}{\Delta P_2}$ | E | 1 | 0.8 | 0.6 | 0.4 | 0.2 |
| | δ | 1.65 | 1.5 | 1.3 | 1.2 | 1.1 | |
| | $E = \frac{f}{F}; \Omega = \frac{\Delta P_1}{\Delta P_2}$ | | | | | | |

| | | | | | | |
|---|----------|-----|------|------|-----|------|
|  | E | 1 | 0.8 | 0.6 | 0.4 | 0.2 |
| | Ω | 1 | 0.92 | 0.85 | 0.8 | 0.75 |
| $E = \frac{f}{F}; \theta = \frac{\Delta P_1}{\Delta P_2}$ | | | | | | |
|  | E | 1 | 0.8 | 0.6 | 0.4 | 0.2 |
| | θ | 1.2 | 1.3 | 1.65 | 2.0 | 3.0 |

859. Тэсрэх бодисын цэнэгтэй (цэнэглэгч машинд, цэнэглэсэн цооногт, камерт, шпурт байгаа) холбогдож байгаа бүх нэвт малталтад агаарын цохилтын долгионы даралтыг тусад нь тооцно.

860. Харуул хамгаалалтын байрны байршил дахь агаарын цохилтын долгионы даралтыг тооцохдоо тэсрэх бодисын дээд хэмжээг дараахь байдлаар тооцно. Үүнд:

- а) хийн болон шингэний цэнэглэлтийн үед цэнэглэгч машины бункерт байх, цооног, камерын цэнэглэлтэд байх тэсрэх бодисын хамгийн их хэмжээг;
- б) цооног камерт орох бортгон өдөөгч суулгах үед нэг шпур, цооногийн цэнэгийн дээд хэмжээг;
- в) тэсэлгээний цахилгаан болон цахилгаан бус хэлхээний холболтын үед тэсрэх бодисын цэнэгийн бүх жинг.

861. Агаарын цохилтын долгионы ажилчдад нөлөөлөх аюултай бүсийн хилийг тооцохдоо цэнэгийн удаашралтыг харгалзахгүйгээр тэсэлгээний ажилд хэрэглэгдэж байгаа бүх тэсрэх бодисын хэмжээгээр тооцно.

862. Агаарын цохилтын долгионы даралтыг газрын доорх барилга байгууламж, шугам сүлжээний бүрэн бүтэн байдлыг үнэлэх, тэсрэлтийг тархахаас хамгаалах байгууламжийн хэмжээсийг тооцоход нэгэн агшинд тэсрэх тэсрэх бодисын дээд хэмжээгээр тооцно. Хэрэв зэрэгцээ бүлэг цэнэгүүдийн хоорондын удаашрал нь 50 м/с болон түүнээс дээш байвал хамгийн их цэнэгээр, удаашрал нь 50 м/с-ээс бага байвал бүх нийлбэр дүнгээр тооцно.

Аюулгүй зайд тодорхойлох жишээ

863. Цооногийн цэнэгийн тэсрэлтээр үүсэх чулуулгийн бутармагийн шидэлтийн аюулгүй зайд тодорхойлох жишээ.

Ил уурхайн хөрсний чулуулгийг сийрэгжүүлэх зориулалтаар тэслэх дараахь хэмжээстэй бүлэг цооногийн цэнэгийн чулуулгийн бутармагийн шидэлтийн радиус ($r_{ш}$)-ыг тодорхойлъё.

Үүнд: тэслэх чулуулгийн бат бэхийн коэффициент $f=12$, доголын өндөр $H=8$ метр, цооногийн диаметр $d=0.15$ метр, цооногийн эгнээний тоо 3. Цооногийн торлолтын хэмжээсүүд: эгнээндэх цооног хоорондын зайд 4.5 метр, эгнээ хоорондын зайд 5 метр, цэнэгийн урт $l_{ц}=6$ метр, цооногийн гүн $L=9.5$ метр.

$$\eta_3 = \frac{6}{9.5} = 0.63$$

Цооногийн дээд хэсгийг амсарт нь хүртэл түгжээсээр дүүргэнэ. $L_{x,3} = L_{түг} = 3.5$ м; $\eta_{түг} = 1$

Цооногийн цэнэг дүүргэлтийн коэффициент:

$$\eta_д = \frac{6}{9.5} = 0.63$$

Цооног хоорондын зайд $a = 4.5$ метрээр авна. (822-р заалтаар)

(1) томьёогоор $r_{ш}$ -ийн тооцооны утгыг олбол:

$$r_{ш} = 1,250 * 0.63 * \sqrt{\left[\left[\frac{12}{(1+1)} * \frac{0.15}{4.5} \right] \right]} = 325.5 \text{ метр}$$

Тодорхойлсон аюулгүй зайн тооцооны утга нь $r_{a,3} = 350$ метр байна.

Хэвтээ тэнхлэгт $\beta=30^\circ$ -ийн өнцөг үүсгэсэн налуутай уулын хажуу дээрх хөрсний чулуулгийг тэслэхэд үүсэх чулуулгийн бутармагийн газрын уруу шидэгдэх аюулгүй зайд тодорхойлъё. Аюултай бүсийн радиусын тооцооны утга $r_{a,3} = 250$ метр.

(3) томьёогоор газрын гадаргын хэв байцыг тооцох коэффициентыг тодорхойлбол:

$$k_r = 1 + tg 30 = 1.58$$

(2) томьёогоор бутармагийн шидэлтийн зайд тодорхойлбол:

$$r_{ш} = 250 + 1.58 = 394 \text{ метр}$$

(2) томьёогоор тодорхойлсон аюулгүйн зайн тооцооны утга нь $r_{a,3} = 400$ метр байна.

Аюултай бүсийн хязгаараас 50 метрээс дээш өндөржилттэй талбайд хөрсний чулуулгийг сийрэгжүүлэх зориулалтаар бүлэг цооногийн цэнэгийг тэслэхэд, чулуулгийн бутармагийн газрын уруу шидэгдэх аюулгүй зайлт тодорхойлъё. Аюултай бүсийн радиусын тооцооны утга $r_{a,3} = 200$ метр.

(4) томьёогоор газрын гадаргын хэв байцыг тооцох коэффициентыг тодорхойлбол:

$$k_r = 0.5 * \left[1 + \sqrt{\frac{[1 + (4 * 50)]}{200}} \right] = 1.21$$

(2) томьёогоор тодорхойлсон бутармагийн шидэгдэлтийн аюулгүйн зайн тооцооны утга:

$$r_{\text{ш}} = 200 * 1.21 = 248 \text{ метр}$$

Эцэст нь аюулгүй зайлт $r_{a,3} = 250$ метрээр авна.

864. Тэсэлгээний ажлын үед тэсэрсэн чулуулгийн бутармагийн шидэлтийн аюултай бүсийн радиус ($r_{a,3}$)-ыг тодорхойлох жишээ.

Хамгийн бага эсэргүүцлийн шугам $W=8-11.4$ метр болон тэсрэлтийн үйлчлэлийн үзүүлэлт $n=2$ бүхий шидэлттэй үйлчлэх зориулалттай бүлэг цэнэгийн чулуулгийн бутармагийн шидэлтийн аюултай бүсийн радиус ($r_{a,3}$)-ыг тодорхойлъё.

Тооцоо хийхийн тулд хамгийн бага эсэргүүцлийн шугамын үндсэн үзүүлэлтээр $W_{\text{max}}=11.4$ метрийг авч, их тал руу нь бүхэлчлэн $W=12$ метрийг авна.

Энэхүү дүрмийн IX бүлгийн хүснэгт 5-аас тэсрэлтийн үйлчлэлийн үзүүлэлт $n=2$ баганаас $W=12$ хэвтээ мөрөнд тохирох чулуулгийн бутармагийн шидэлтийн аюултай бүсийн радиусыг авна.

$$r_{a,3}=900 \text{ метр.}$$

Уртынхаа дагуу ижил бус гүнтэй суваг үүсгэхээр шидэлттэй үйлчлэх зориулалттай бүлэг цэнэгийн чулуулгийн бутармагийн шидэлтийн аюултай бүсийн радиус ($r_{a,3}$)-ыг тодорхойлъё.

Тэсэлгээний ажлын тэслэөр тэсрэлтийн үйлчлэлийн $W=7-8$ метр цэнэгт $n=2.5$, $W=9-12$ метр цэнэгт $n=2$ үзүүлэлтүүдийг авчээ.

Эхлээд $W=9-12$ метр, $n=2$ цэнэгийн чулуулгийн бутармагийн шидэлтийн аюултай бүсийн радиус ($r_{a,3}$)-ыг тодорхойлно. Энэхүү дүрмийн хавсралт 21-ийн хүснэгтээс тухайн үзүүлэлтүүдэд хүнд аюултай бүсийн утга $r_{a,3}=900$ метр болохыг тогтооно.

Дараа нь $W=7-8$ метр, $n=2.5$ үзүүлэлттэй цэнэгийнхийг тодорхойлно. Мөн хүснэгтээс тухайн үзүүлэлтэд $r_{a,3}=1000$ м болохыг тогтооно.

Тодорхойлсон утгуудыг харьцуулан тэсэлгээний ажлын төслөөр тэсрэлтээс үүсэх чулуулгийн бутармагийн шидэлтийн аюултай бүсийн радиус $r_{a,3}=1000$ метрээс багагүй байхаар тогтооно.

Зам өргөтгөхийн тулд $W=11\text{-}16$ метр хамгийн бага эсэргүүцлийн шугамтай доголыг бүлэг камерын сийрэгжүүлэх цэнэгээр тэсэлж нураах шаардлагатай.

Чулуулгийн бутармагийн шидэлтийн аюултай бүсийн радиус ($r_{a,3}$)-ыг тодорхойлохын тулд тооцоонд $W_{max}=16$ метр хамгийн бага эсэргүүцлийн шугамтай цэнэгийг авч, тухайн цэнэгийн нөхцөлт хамгийн бага эсэргүүцлийн шугамын хэмжээ $W_{ne}=12$ метр тодорхойлно.

$W_{ne}=5 \cdot W_{max}/7=5 \cdot 16/7=11.4$ метр буюу их тал руу нь бүхэлтгэн $W_{ne}=12$ метр болно.

Энэхүү бүлгийн хүснэгт 2-оос $W=12$ метр хэвийн бутлалттай тэсэлсэн чулуулгийн бутармагийн шидэлтийн аюултай бүсийн радиус ($r_{a,3}$)-ын утгыг $n=1$ үед олно. $W=12$ метр үед $r_{a,3}=500$ метр болохыг тогтооно.

865. Хамгаалах байгууламжаас тодорхой зайд байрлалтай тэсрэх бодисын агуулахын багтаамжийг тодорхойлох жишээ.

Байрлаж буй газраас нь 900 метр зайд төмөр бетон барилгатай элеватор, 1400 метр зайд ажилчдын хотхон байрлах тэсрэх бодисын агуулахын хамгийн их багтаамжийг тодорхойльё. Газрын дээр ил байрлалыг авч үзье.

Энэхүү дүрмийн IX бүлгийн хүснэгт 10-ын 2-р зүйлээс ажилчдын хотхонаос 1400 м зайд байрлах далан хамгаалалтгүй тэсрэх бодисын агуулахад 100 тн-оос их тэсрэх бодис хадгалж болохгүйг тогтооно. Харин IX бүлгийн хүснэгт 10-ын 1-р зүйлээс элеваторын аюулгүй байдлыг хангасан харьцангуй их тэсрэх бодис хадгалж болохоор байгаа ч, тэсрэх бодисын агуулахын багтаамжийг ажилчдын тосгоны аюулгүй байдлыг хангах нөхцөлөөр сонгож авна.

866. Ил гадаргуу дээрх тэсэлгээний ажлын үед агаарын цохих долгионы цонхны шилэнд аюулгүй бүсийн радиусыг тодорхойлох жишээ.

84 кг түгжээсгүй, ил цэнэгийн тэсрэлтийн үеийн агаарын цохих долгионы аюултай бүсийн радиусыг тодорхойльё. Тэслэх чулуулаг нь барилгын нормоор. IV бүлэгт багтдаг шохойн чулуу.

Цэнэгийн жин $Q_3=84$ кг (<1000 кг) тул аюултай бүсийн радиус тодорхойлох (13) томьёог ашиглана.

Агаарын температур нэмэх үед:

$$r_{a,3}=65^*\sqrt{Q_3}=65^*\sqrt{84}=596 \text{ метр.}$$

Агаарын температур хасах үед аюултай бүсийн радиусыг 1.5 дахин өсгөж (энэхүү дүрмийн 846 зүйлийг харах) $r_{a,3}=894$ метр гэж авна.

Нийт жин нь 25,228 кг, бүлэг цооногийн цэнэгийг тэслэх үеийн агаарын долгионы цохилтын аюултай бүсийн радиусыг тодорхойльё. Цооног бүрт ижил

хэмжээтэй цэнэгүүдийг 3 хэсэг болгон хооронд нь 25 м/с-ын удаашралттай тэсэлнэ. 1-р хэсэг нь 20, 2-р хэсэг нь 40, 3-р хэсэг нь 10 цооногтой. Цооногийн диаметр 0.22 метр, гүн 15 метр, түгжээний урт 4.4 метр. Тэслэх чулуулаг нь барилгын нормоор Х бүлэгт багтаж боржин. Тэсэлгээний ажлыг агаарын хасах температурт гүйцэтгэнэ. Хэсгүүдийг хооронд нь 25 м/с-ын удаашралттай тэслэх учраас тооцоонд хамгийн олон болох $N=40$ цооногтой хэсгийг авна. Цэнэгийн урт 10.6 метр буюу цооногийн диаметрийг 12 дахин авснаас их тул эквивалент цэнэгийг (17) тодорхойлно. Тооцооны параметрийн утга дараахь байдалтай болно.

$$P = 34 \text{ кг/метр}$$

$$\frac{l_{\text{тыг}}}{d} = 20$$

$$K_{\text{тыг}} = 0.002$$

Эквивалент цэнэг:

$$Q_3 = 12 * P * d * K_{\text{тыг}} * N = 12 * 34 * 0.22 * 0.0002 * 40 = 7.2 \text{ кг}$$

(13) томьёог ашиглан аюултай бүсийн радиусыг тодорхойлно. Энэхүү дүрмийн 843 зүйлийн дагуу Х бүлгийн боржингийн аюултай бүсийн радиусыг 1.5 дахин өстөх ёстой. Чулуулгийн хатуулаг, хэсгүүдийн хоорондын удаашралт (Энэхүү дүрмийн 845 зүйлийг харах) ба агаарын хасах температур (энэхүү дүрмийн 846 зүйлийг харах)-ыг тооцон тодорхойлбол:

$$r_{a.3} = 65 * 1.5 * 1.5 * 1.5 * \sqrt[4]{7.2} = 589 \text{ метр}$$

867. Тэсрэлт дамжихгүй байх аюулгүй зайн тооцооны жишээ.

120 тн тротил хадгалах зориулалттай далан хамгаалалттай агуулах болон 240 тн гранулит хадгалах зориулалттай далан хамгаалалтгүй агуулахуудын хоорондын тэсрэлт дамжихгүй байх аюулгүй зайлт тодорхойлъё.

Энэхүү дүрмийн хавсралт 24-ийн хүснэгтээс гранулитын агуулахаас хамгаалалтын далантай тротилын агуулахад тэсрэлт дамжихгүй байх аюулгүй зайлт тооцох коэффициентын утга $K_d = 1$ болохыг тогтооно. Мөн адилхан тротилоос гранулитод тэсрэлт дамжихгүй байх аюулгүй зайлт тооцох коэффициентын утга $K_d = 1$, ($b=1.6$ метр) байна. Агуулахуудад төрөл бүрийн тэсрэх бодис хадгалдгийг харгалзан тэсрэлт дамжихгүй байх аюулгүй зайлт r_d -г агуулах тусад нь тооцож их утгыг нь авна. Гэхдээ энэ жишээний хувьд тэсрэлт дамжихгүй байх аюулгүй зайлт тооцох коэффициент K_d -ын утга ижил тул их багтаамжтой агуулахыг нь идэвхтэй цэнэгээр авч тооцоход хангальтай. Энэ тохиолдолд тэсрэлт дамжихгүй байх аюулгүй зайлт:

$$r_d = K_d * \sqrt[3]{Q} * \sqrt[4]{b} = 1 * \sqrt[3]{240000} * \sqrt[4]{1.6} = 70 \text{ метр}$$

Тэсрэх материалын агуулахын талбайд 120 тн тротилын далан хамгаалалтгүй агуулах, 500,000 цахилгаан детонаторын (ердийн детонаторын) далан хамгаалалтгүй агуулах байрлуулах шаардлагатай болжээ. Агуулахуудын хооронд тэсрэлт дамжихгүй байх аюулгүй зайлт тодорхойлъё.

Цахилгаан детонаторт агуулагдах тэсрэх бодисын жинг (кг) тооцно.

$$Q_{\text{дет}} = q_{\text{дет}} * n$$

$q_{\text{дет}}$ 0.0015 кг, нэг детонатор дахь цэнэгийн жин;
 n цахилгаан детонаторын тоо.

$$Q_{\text{дет}} = 0.0015 * 500,000 = 750 \text{ кг}$$

Энэхүү дүрмийн 851-ийн дагуу цахилгаан детонатортай агуулахыг идэвхтэй цэнэгээр авъя. Энэхүү дүрмийн IX бүлгийн хүснэгт 13-аас хамгаалалтын далангүй детонаторын ил цэнэгээс хамгаалалтын далангүй тротилын ил цэнэгт тэсрэлт дамжихгүй байх аюулгүй зайл тооцох коэффициент $K_d=0.7$ ($b=1.6$ метр) болохыг тогтооно. Галын аюулгүй зайл болон агуулахуудын байршлыг тооцохгүйгээр тэсрэлт дамжихгүй байх аюулгүй зайл тодорхойлбол:

$$r_d = 0.7 * \sqrt[3]{750} * \sqrt[4]{1.6} = 8 \text{ метр}$$

420 тн багтаамжтай, одоо ашиглаж байгаа граммонитын далан хамгаалалтгүй ил агуулах ба төлөвлөж байгаа 40 тн тротилын далан хамгаалалттай агуулахын хооронд тэсрэлт дамжихгүй байх аюулгүй зайл тодорхойльё. Агуулахын талбай нь тротилын агуулахыг граммонитын агуулахаас зөвхөн 45 метрээс илүүгүй зайд байрлуулах боломжтой.

420 тн граммонитын агуулахыг идэвхтэй цэнэгээр авч, энэхүү дүрмийн IX бүлгийн хүснэгт 13-аас тэсрэлт дамжихгүй байх аюулгүй зайл тооцох коэффициентын утга $K_d=1$, болохыг тогтоож, $b=1.6$ метр үед тэсрэлт дамжихгүй байх аюулгүй зайл тооцвол:

$$r_d = 1 * \sqrt[3]{420,000} * \sqrt[4]{1.6} = 85 \text{ метр}$$

Хэрэв 40 тн тротилын агуулахыг идэвхтэй цэнэгээр авбал ($K_d=1$, $b=1.6$ метр) тэсрэлт дамжихгүй байх аюулгүй зайл:

$$r_d = 1 * \sqrt[3]{40,000} * \sqrt[4]{1.6} = 39 \text{ метр}$$

Энэхүү дүрмийн 851-ийн дагуу агаарын долгионы цохилтын үйлчлэлийн аюулгүй зайл, газрын чичирхийллийн аюулгүй зайл тэсрэх материалын агуулахуудын шинэчилсэн нийт багтаамжаар дахин тооцсоны дараа тротилын агуулахыг граммонитын агуулахаас 39 метр зайд байрлуулж болно.

868. Хорт хийн үйлчлэлийн аюулгүй зайл тодорхойлох жишээ.

Нийлбэр жингээрээ $Q=1000$ тн жинтэй шидэлтийн зориулалттай бүлэг камерын цэнэгийн тэсрэлтээс үүсэх хорт хийн үйлчлэлийн аюулгүй зайл тодорхойльё.

Салхины хурд тэсэлгээний өмнө $V_c=3$ м/сек.

(20) томьёогоор салхины хөндлөн чиглэлд хорт хийн тархалтын аюулгүй зайд ($r_{хий}$)-г тодорхойлно.

$$r_{хий} = 160 * \sqrt[3]{Q} = 160 * \sqrt[3]{1000} = 1,600 \text{ метр}$$

Салхины эсрэг чиглэлд хорт хийн тархалтын аюулгүй зайд мөн $r_{хий} = 1600$ метр байна. Салхины дагуу чиглэлийн аюулгүй зайд (21) томьёогоор тооцвол:

$$r_{хий} = 160 * \sqrt[3]{1000} * (1 + 0.5 * 3) = 4,000 \text{ метр}$$

**АРАВ. ТЭСРЭХ МАТЕРИАЛЫН АГУУЛАХЫН АЯНГЫН ХАМГААЛАЛТЫН
ТӨХӨӨРӨМЖИЙН ТӨСӨЛ ЗОХИОХ, БАЙГУУЛАХ,
АШИГЛАХ ЖУРАМ**

869. Тэсрэх материалын агуулахуудын аянгын хамгаалалтыг төслийн дагуу байгуулна.

870. Газрын гадарга дээрх тэсрэх материалын байнгын, түр болон ил, хагас далдлагдсан, далдлагдсан (хучлага хөрсний зузаан 10 метрээс бага бол) агуулах болон тэсрэх материал бэлтгэх барилга байгууламж, цахилгаан тэслүүр бүхий өдөөгч бэлтгэх газрыг аянгын шууд цохилт, аянгын хоёрдогч үйлчлэлээс заавал хамгаалсан байна.


Тэсэлгээний ажил эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын тэсрэх материал бэлтгэх, хадгалах газрыг энэхүү журмын дагуу аянга зайлцуулагчаар хамгаалан тоноглосон байна.

871. Контейнер (чингэлэг)-тэй тэсрэх материалыг түр хадгалах, буулган шилжүүлэхэд зориулсан талбай болон тэсрэх материалтай тээврийн хэрэгсэл зогсох газрыг аянгын шууд цохилтоос хамгаалсан байна.

872. Аянга цахилгаантай бороотой үед аянганы хамгаалалтын газардуулагч төхөөрөмж байрласан бүсэд хүн явахыг хориглоно. Алхамын хүчдэлийн аюулыг бууруулах зорилгоор цагирган ба сарнисан цацрагийн хэлбэртэй тархаан байрлуулсан далдалж байрлуулсан газардуулагчийг хэрэглэнэ.

873. Энэхүү дүрмийн 870-д заасан барилга байгууламжийн аянгын шууд цохилтын хамгаалалт нь аянга хүлээн авагч, гүйдэл зайлцуулагч, газардуулагчаас бүрдсэн тусдаа байрласан савхан аянга зайлцуулагч, эсхүл тросон (зэл хэлбэрийн) аянга зайлцуулагч байна. (энэхүү дүрмийн Х бүлэг, Зураг 1, 2).

Зураг 1. Савхан аянга зайлцуулагч




I -А цэгээс газардуулагч хүртэлх аянгын гүйдлийг дамжуулах утасны урт
S_b -хамгаалж буй байгууламжаас гүйдэл зайлцуулагч хүртэлх хамгийн бага зөвшөөрөгдөх зайд

S₃-газардуулагчаас байгууламжийн металл бүтэц хүртэлх хамгийн бага зөвшөөрөгдөх зайд

- 1 -хамгаалж буй байгууламж
- 2 -металл бүтэц

Зураг 2. Тросон аянга зайлцуулагч



I -аянга зайлцуулагчийн урт;
L₁, L₃ -аянгын гүйдлийг дамжуулах утасны урт
L₂ -хамгаалж буй байгууламжийн өндөр;
S_{b1}-тросон аянга зайлцуулагчийн А цэгээс байгууламж хүртэлх хамгийн бага зөвшөөрөгдөх зайд;
S_{b2}-гүйдэл зайлцуулагчийн С цэгээс байгууламж хүртэлх хамгийн бага зөвшөөрөгдөх зайд;
S₃ -газардуулагчаас байгууламжийн металл бүтэц хүртэлх хамгийн бага зөвшөөрөгдөх зайд


- 1 -хамгаалж буй байгууламж
- 2 -металл бүтэц

874. Аянгын шууд цохилтоос хамгаалж байгаа барилга байгууламжид агаараар цахилгааны шугам татахыг хориглоно.

875. Хамгаалж байгаа барилга байгууламжаас савхан аянга зайлцуулагчийн гүйдэл зайлцуулагч (энэхүү дүрмийн X бүлэг, Зураг 1, А цэг) хүртэлх хамгийн бага


зөвшөөрөгдөх зайд газардуулагчийн импульсийн R_i эсэргүүцлээс хамааруулан сонгож авна (Х бүлэг, Зураг 3).

Зураг 3. Хамгаалж буй байгууламжаас савхан аянга зайлцуулагч хүртэлх хамгийн бага зөвшөөрөгдөх зайд




Хамгаалж байгаа байгууламжаас тросон аянга зайлцуулагч (энэхүү дүрмийн Х бүлэг, Зураг 2, А, С цэг) хүртэлх хамгийн бага зөвшөөрөгдөх S_{b1} ба S_{b2} зайд энэхүү дүрмийн Х бүлэг, Зураг 4 ба 5-д үзүүлсэн график дахь хамаарлын дагуу тодорхойлно.

Зураг 4. Хамгаалж буй байгууламжаас тросын хэцийн дундаж цэг хүртэлх хамгийн бага зөвшөөрөгдөх зайд



Зураг 5. Хамгаалж байгаа байгууламжаас тросон аянга зайлцуулагч хүртэлх хамгийн бага зөвшөөрөгдөх зайд



876. Хамгаалж байгаа байгууламж руу аянгын өндөр хүчдэл дамжуулахгүйн тулд аянгын шууд цохилтын хамгаалалтын газардуулагчийг байгууламж руу орж

байгаа газар доорх металл бүтэц (шугам сүлжээ, цахилгааны эсвэл холбооны шугам, кабель утас)-ээс S_3 зйтай алслуулан байрлуулна. Энэ зайлг дараахь харьцаагаар тодорхойлно.

Савхан аянга зайлцууллагчийн хувьд $S_3 = 0.5R_i$, метр; Энд R_i аянгын шууд цохилтын хамгаалалтын газардуулагч бүрийн импульсийн эсэргүүцэл, Ом.

Хамгаалж байгаа байгууламж руу газар доогуур металл хоолой ба кабель ороогүй тохиолдолд S_3 зйтай алслуулан байрлуулна. Энэ зайлг дараахь харьцаагаар тодорхойлно:

Савхан аянга зайлцууллагчийн хувьд $S_3 = 0.5R_i$, метр; Энд R_i – аянгын шууд цохилтын хамгаалалтын газардуулагч бүрийн импульсийн эсэргүүцэл, Ом.

Хамгаалж байгаа байгууламж руу газар доогуур металл хоолой ба кабель ороогүй тохиолдолд S_3 зайлг 3 метрээс багагүйгээр авна. Харин хамгаалж байгаа зэргэлдээ байгууламж руу металл бүтэц орсон газар хүртэлх зайл 50 метрээс их байвал S_3 зайлг 1 метр хүртэл багасгаж болно.

877. Аянга зайлцууллагч тус бүр нь өөрийн газардуулагчтай байна. Савхан ба тросон аянга зайлцууллагч бүрийн газардуулагчийн эсэргүүцэл нь 10 Ом-оос ихгүй байна. Хувийн цахилгаан эсэргүүцэл нь 500 Ом.м ба түүнээс дээш хөрсөнд энэхүү дүрмийн 875, 876-д заасан зйтайгаар хамгаалж байгаа байгууламжаас аянга зайлцууллагч хүртэл алслуулан, газардуулагч бүрийн импульсийн эсэргүүцлийг 40 Ом хүртэл нэмэгдүүлэхийг зөвшөөрнө. Хөрсний хувийн эсэргүүцэл нь 500 Ом.м-ээс, харин импульсийн R_i эсэргүүцлийн утга нь 25 Ом-оос их үед S_3 ба S_b зайлг 1 метр хүртэл багасгахыг зөвшөөрнө.

1000 Ом.м ба түүнээс дээш хөрсний хувийн цахилгаан эсэргүүцэлтэй бүс нутагт тэсрэх материалын агуулах нь хэд хэдэн агуулахаас бүрдэж байвал аянга зайлцууллагч бүрийн газардуулагчийг газардуулагчийн нэгдсэн системд нэгтгэхийг зөвшөөрнө. Газардуулагчийн системийн импульсийн эсэргүүцэл нь төслийн тооцоогоор тодорхойлогдоно. Газардуулагчийн системийн холбож байгаа утасны хамгийн их зөвшөөрөгдөх уртыг хөрсний хувийн цахилгаан эсэргүүцлээс хамааруулан дараахь хүснэгт 18-д харуулав.

Хүснэгт 18. Газардуулагчийн системийн холбож байгаа утасны хамгийн их зөвшөөрөгдөх уртыг хөрсний хувийн цахилгаан эсэргүүцлээс

| Хөрсний хувийн цахилгаан эсэргүүцэл, (Ом.м) | 1000 | 2000 | 3000 | 5000 | 10000 | 20000 |
|--|------|------|------|------|-------|-------|
| Газардуулагчуудыг холбож буй утасны зөвшөөрөгдөх урт, (метр) | 100 | 150 | 200 | 250 | 350 | 450 |

Тус тусдаа байрлаж байгаа газардуулагчийг холбож байгаа утас нь хамгаалж буй байгууламжаас энэхүү дүрмийн 875 ба 876-д заасан зйтгаар алслагдсан байна.

878. Нэлээд урт, том талбайтай металл бүтэц бүхий барилга байгууламж (агуулах)-тай эсхүл тэсрэх материал нь металл хайрцагт хадгалагдаж байгаа тохиолдолд тэдгээрээс үүсч болох цахилгаан статик индукцээс хамгаалахын тулд

байгууламжийн дээвэр дээр цахилгаан хураах газардуулагчийн шаардлага хангасан металл торыг хийх ба барилга доторх бүх металл бүтэц газардуулгатай байна.

Аянгын хоёрдогч үйлчлэлийн хамгаалалтын газардуулагчийг агуулахын гадна талд 0.5 метр гүнд, түүний сууриас 0.5-1 метр зйтай агуулахын эргэн тойрон газарт байрлуулсан, хүрээ хэлбэртэй хийнэ.

Үйлдвэрийн давтамжтай гүйдлийг сарниулах газардуулагчийн хүрээний эсэргүүцэл 10 Ом-оос ихгүй байна. Эсэргүүцлийг багасгах зорилгоор газар дор байрлуулсан бүх төрлийн хоолой (цэвэр, бохир усны болон дулааны шугам сүлжээний хоолой гэх мэт)-г газардуулагчид холбохыг зөвшөөрнө. 500 Ом.м ба түүнээс дээш хувийн цахилгаан эсэргүүцэлтэй хөрсөнд газардуулагчийн төхөөрөмжийн эсэргүүцлийг нормчлохгүй.

Аянгын шууд цохилтын болон хоёрдогч үйлчлэлийн хамгаалалтын газардуулагч нь өөр хоорондоо энэхүү дүрмийн 876, 877-д зааснаас багагүй зайд алслагдан байрласан байна.

Барилга байгууламжийн дээвэр дээр металл тор хийх замаар цахилгаан статик индукцийн хамгаалалтыг хийх үед бүх металл зүйлсийг аянгын хоёрдогч үйлчлэлийн хамгаалалтын газардуулагчдад хамгийн ойр зайгаар холбож өгнө.

Барилга байгууламж нь төмөр дээвэртэй бол, барилгын ханыг тойруулан 25 метр хүртэлх зайд босоо гүйдэл зайлцуулагчийг байрлуулах замаар дээврийг аянгын хоёрдогч үйлчлэлийн хамгаалалтын газардуулагчид холбоно. Аянга зайлцуулагчийн дээд үзүүрийг дээвэртэй, харин доод үзүүрийг газардуулагчид холбож өгнө. Хэрэв цахилгаан дамжуулдаггүй материалаар хийсэн дээвэртэй барилга байгууламжийн дээвэр дээгүүр 6 мм-ээс багагүй диаметртэй ган утсаар 5x5 метр хэмжээтэй төмөр торон хэлхээ хийж гүйдэл зайлцуулагчаар газардуулагчид холбоно.

879. Цахилгаан соронзон индукцээс хамгаалахын тулд агуулахын талбайд байгаа бүх дамжуулах хоолой, хуягласан кабель зэрэг зүйлийг задгай хүрээ үүсгэхгүйн тулд 10 см-аас бага зайд ойртсон газар бүрд, эсвэл зэрэгцээ оршиж байвал 15-20 метр тутамд өөр хооронд нь бат бэх холбож өгнө. Мөн ийм холболтыг барилга байгууламжийн ган бүтэц, каркас, тоног төхөөрөмж, кабелийн бүрээс зэрэг металл зүйлүүд ойр байрлах бүрд хийж өгнө. Энэ үед дамжуулах хоолойн холбогдох хэсэг, мөн холбогч эрэг, шураг зэрэгт холболт хийнэ. Цахилгаан эсэргүүцэл нь холболт тус бүр дээр 0.05 Ом-оос хэтрэхгүй байна. Хэрэв энэ нөхцөл биелэхгүй бол 16 мм²-аас багагүй хөндлөн огтлолтой ган утсаар нэмэлт богино холболтыг хийнэ.


880. Агуулах руу цахилгаан шугам орж байгаа нөхцөлд түүгээр өндөр потенциал бүхий хүчдэл зөөгдөж орохоос хамгаалж, аянга хамгаалагчийг дараах хэлбэрээр хийнэ.

а) хуягласан кабель газар дор байрласан үед кабелийн металл хуяг, бүрхүүлийг аянгын хоёрдогч үйлчлэлийн хамгаалалтын газардуулагчид, харин уг газардуулагч байхгүй үед 10 Ом-оос ихгүй импульсийн эсэргүүцэлтэй тусгай газардуулагчид холбоно. Кабель нь аянга зайлцуулагчийн газардуулагчаас энэхүү дүрмийн 876-д заасан зайд алслагдсан байна;

б) хуяггүй кабелийн үед энэхүү дүрмийн 881 а-д заасан газардуулагч холбох замаар хийнэ;

в) агаарын шугамд холбосон кабельтай үед тэдгээрийн холбогдож байгаа хэсэг дээр кабелийн металл хуяг, бүрхүүл болон тулгуурын дэгээг 10 Ом-оос ихгүй импульсийн R_{i1} эсэргүүцэлтэй тусгай газардуулагчид холбож өгнө (энэхүү дүрмийн Х бүлэг, Зураг 6)

Зураг 6. Агуулах руу аянганы өндөр потенциалын хүчдэлийн зөөгдөлтийн хамгаалалтын бүдүүвч



Үүнээс гадна кабелийн судал, газардуулагдаж байгаа элемент холбогдох шилжилтийн хэсэгт электрод хоорондын 2-3 мм зйтай агаарын далд завсрыйг хийж өгөх эсвэл нам хүчдэлийн цэнэг шавхуургыг тавьсан байна. Агаарын шугам кабельд шилжих тэр хэсгээс хамгийн ойр оршиж байгаа тулгуур дээрх тусгаарлуур босоо дэгээг 20 Ом-оос ихгүй импульсийн R_{i2} эсэргүүцэлтэй газардуулагчид холбосон байна. 500 Ом.м ба түүнээс дээш хувийн цахилгаан эсэргүүцэлтэй хөрсөнд газардуулагчийн импульсийн R_i , R_{i1} , R_{i2} эсэргүүцлийн хэмжээг 40 Ом хүртэл өсгөхийг зөвшөөрөх ба харин олон жилийн цэвдэгтэй болон хадархаг хөрсөнд төсөл, тооцооны дагуу авна.


881. Цахилгаан статик, эсвэл цахилгаан соронзон индукцийн үйлчлэлд мэдрэмжгүй тэсрэх бодис (аммиакийн шүүгээр хийгдсэн тэсрэх бодис, цочир дамжуулах шижим гэх мэт) хадгалагдаж байгаа агуулахад аянгын хоёрдогч үйлчлэлийн хамгаалалт байх шаардлагагүй.

Аянга зайлцуулагчийн хамгаалалтын бүс

1. Ганц савхан аянга зайлцуулагч

h өндөртэй ганц савхан аянга зайлцуулагчийн хамгаалалтын бүс нь h_0 оройтой дугуй конус байна. $h_0 < h$ байна. Газрын гадаргын түвшинд r_0 радиустай хамгаалалтын дугуй талбай үүсгэнэ. (Энэ бүлгийн 7 дугаар зураг.)

Зураг 7. Ганц савхан аянга зайлцуулагчийн хамгаалалтын бүс



1 ба 2 – хамгаалалтын бүсийн хязгаар.

Хамгаалж буй байгууламжийн өндрийн түвшинд хамгаалалтын бүсийг хэвтээ хавтгайгаар огтолж r_x радиустай хамгаалалтын дугуй талбай үүсгэнэ.

Ганц савхан аянга зайлцуулагчийн хамгаалалтын бүс нь доорх хэмжээтэй байна.

$$h_0 = 0.85 \cdot h$$


$$r_0 = (1.1 - 0.002 \cdot h) \cdot h$$

$$r_x = (1.1 - 0.002h) \cdot [h - h_0/0.85] \quad (1)$$

2. Хос савхан аянга зайлцуулагч

2.1. Адилхан h өндөртэй хос савхан аянга зайлцуулагчийн хамгаалалтын бүсийг энэ бүлгийн зураг 8-д харуулав.

Зураг 8. Хос савхан аянга зайлцуулагчийн хамгаалалтын бүс



1, 2, 3 хамгаалалтын бүсийн хязгаар

Хамгаалалтын бүсийн захын хэсгүүдийг ганц савхан аянга зайлцуулагчийн нэгэн адилаар тодорхойлно. Тэдгээрийн h_0 , r_0 , r_{x1} , r_{x2} хэмжээсийг энэ бүлгийн (1) дүгээр томьёогоор тодорхойлно.

Хос савхан аянга зайлцуулагчийн хамгаалалтын бүс нь дараахь хүрээ хэмжээтэй байна.

$$L \leq h \text{ үед } h_c = h_0; r_{cx} = r_x; r_c = r_0 \quad (2)$$


$$L > h \text{ үед } \{h_c = h_0 - (0.17 + 3 \cdot 10^{-4} \cdot h) \cdot (L - h)$$

$$\{r_{cx} = r_0 \cdot [(h_c - h_x) / h_c]; r_{cx} = r_0 \quad (3)$$

Хамгаалалтын бүс нь $L \leq 3h$ үед үйлчилнэ. Харин $L > 3h$ үед хос савхан аянга зайлцуулагчийг тус бүрд нь ганц савхан аянга зайлцуулагч гэж үзнэ.

2.2. Адил биш h_1, h_2 өндөртэй хоёр савхан аянга зайлцуулагчийн хамгаалалтын бүсийг энэ бүлгийн 9 дүгээр зурагт харуулав.

Зураг 9. Адил биш өндөртэй хос савхан аянга зайлцуулагчийн хамгаалалтын бүс



1 ба 2 хамгаалалтын бүсийн хязгаар

Хамгаалалтын бүсийн захын хэсгүүдийг ганц савхан аянга зайлцуулагчийн хамгаалалтын бүсийн нэгэн адилаар тодорхойлно. Тэдгээрийн $h_{01}, h_{02}, r_{01}, r_{02}, r_{x1}, r_{x2}$ хэмжээсүүдийг (1) томьёогоор тооцоолно. Харин бусад хэмжээсийг дараахь томьёогоор тодорхойлно.


$$r_c = (r_{01} + r_{02})/2; \quad h_c = (h_{c1} + h_{c2})/2; \quad r_{cx} = r_c \cdot [(h_c - h_x)/h_c] \quad (4)$$

Энд h_{c1}, h_{c2} нь (2) болон (3) томьёогоор бодогдоно. Адил биш өндөртэй хос савхан аянга зайлцуулагчийн хамгаалалтын бүс нь $L \leq 3h_{min}$ үед үйлчилнэ.

3.Олон савхан аянга зайлцуулагч

Ижил өндөртэй олон савхан аянга зайлцуулагчийн хамгаалалтын бүсийг зэргэлдээ орших савхан аянга зайлцуулагчуудыг хос болгон авч, хамгаалалтын бүсүүдийг тогтоосон хүрээгээр тодорхойлно. (Энэ бүлгийн 10 дугаар зураг.)

Зураг 10. Олон савхан аянга зайлцуулагчийн хамгаалалтын бүс




L_1, L_2, L_3 -аянга зайлцуулагчуудын хоорондох зайд;
1, 2 -хамгаалалтын бүсийн хязгаар.

h_x өндөртэй нэг эсхүл хэд хэдэн байгууламжийг 99.5%-ийн найдвартайгаар аянгаас хамгаалах үндсэн нөхцөл нь бүх хос болгон авч байгаа аянга зайлцуулагчийн хувьд $r_x > 0$ байх тэнцэтгэл биш биелснээр хангагдана. r_x нь энэ бүлгийн (2) ба (3) томьёогоор тодорхойлогдоно.

4. Дан хэцэн аянга зайлцуулагч

Дан хэцэн аянга зайлцуулагчийн хамгаалалтын бүсийг зураг 11-д харуулав.

Зураг 11. Дан хэцэн аянга зайлцуулагчийн хамгаалалтын бүс



1, 2 хамгаалалтын бүсийн хязгаар

Энд h – тросон хэцний хамгийн их унжилтын цэг дэх өндөр. Тулгуурын тодорхой $h_{\text{тул}}$ өндрийн үед унжилтын хэмжээг тооцон, 35-50 мм^2 хөндлөн огтлолтой ган тросын өндрийг тросын урт $L < 120$ м байхад $h = h_{\text{тул}} - 2$ м, харин $L = 120-150$ метр байхад $h = h_{\text{тул}} - 3$ метр гэж тус тус тодорхойлно.

Дан хэцэн аянга зайлцуулагчийн хамгаалалтын бүс нь доорх хэмжээтэй байна.

$$h_0 = 0.85 \cdot h ;$$


$$r_0 = (1.35 - 0.0025 \cdot h) \cdot h ;$$

$$r_x = (1.35 - 0.0025 \cdot h) \cdot [h - (h_0 / 0.85)] \quad (5)$$

5. Хос хэцэн аянга зайлцуулагч

Хос хэцэн аянга зайлцуулагчийн хамгаалалтын бүсийг энэ бүлгийн зураг 12-т харуулав.

Зураг 12. Хос хэцэн аянга зайлцуулагчийн хамгаалалтын бүс



1, 2, 3 хамгаалалтын бүсийн хязгаар; 4- хэц

Түүний r_0 , h_0 , r_x хэмжээсүүдийг (5) томьёогоор, харин бусад хэмжээсүүдийг доорх томьёогоор тооцно.

$$L \leq h \quad \text{γед} \quad h_c = h_0 ; \quad r_{cx} = r_x ; \quad r_c = r_0 \quad (6)$$

$$L > h \quad \text{γед} \quad \begin{cases} h_c = h_0 - (0.14 + 5 \cdot 10^{-4}h) \cdot (L - h) ; \\ r_x = (L/2) \cdot [(h_0 - h_x)/(h_0 - h_c)] ; \quad r_c = r_0 ; \quad r_{cx} = r_0 \cdot [(h_c - h_x)/h_c] \end{cases} \quad (7)$$

Хамгаалалтын бүс нь $L \leq 3h$ γед үйлчилнэ.

882. Аянга зайлцуулагч нь аянга хүлээн авагч, гүйдэл зайлцуулагч, газардуулагчаас бүрдэж тулгуурт бэхлэгдэнэ.

а) Аянга зайлцуулагчийн тулгуурыг дурын маркийн төмөр, төмөр бетон болонmodoор хийж болно (энэ бүлгийн зураг 13). Төмөр тулгуурыг зэрэлтээс хамгаалсан байна. Төмрийн хоорондоо холбогдох гадаргууг будаж болохгүй. Модон тулгуурыг ялзралтаас хамгаалсан байна.

б) Савхан аянга зайлцуулагчийн тулгуурыг шонгийн механик бат бэхээр, харин тросон аянга зайлцуулагчийн тулгуурыг тросын таталт, тросонд үзүүлэх салхины ачааллыг нэмж тооцсон шонгийн механик бат бэхээр тус тус тооцно. Аль ч тохиолдолд нь аянгын гүйдлийн динамик хүчийг тооцохгүй.

в) Савхан аянга зайлцуулагчийн тулгуур 1-ийн дээд үзүүрт 1.5 метрээс ихгүй урттай аянга хүлээн авагч металл саваа 2-ыг бэхэлнэ (энэ бүлгийн зураг 13). Аянга хүлээн авагч нь газардуулагч 4-тэй гүйдэл зайлцуулагч 3-аар холбогдож, тулгуурт П хэлбэрийн даруулга хадаас 5-аар бэхлэгдэнэ. Томоохон агуулахад нарийн нийлмэл хийцтэй тулгуур хэрэглэнэ.


Модон тулгуурын эдэлгээний хугацааг нэмэгдүүлэх зорилгоор түүнийг рельсэн (зам төмөр) эсхүл төмөр бетон хөлтэй хийнэ.

Хүснэгт 19. Модон баганын хэмжээс

| | | | | | | | | |
|---|-----|-----|-----|-----|-----|------|------|------|
| Аянга зайлцуулагчийн өндөр, метр | 9 | 11 | 13 | 14 | 16 | 18 | 20 | 22 |
| Модон баганын бүрэлдэхүүн хэсгүүдийн өндөр, метр: | | | | | | | | |
| - дээд хэсгийн а. | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| - доод хэсгийн б. | 5.5 | 6.5 | 7.5 | 8.5 | 9.5 | 10.5 | 11.5 | 12.5 |

Модон баганын хэмжээсийг хүснэгт 19-д үзүүлэв.

Зураг 13. Модон тулгууртай савхан аянга зайлцуулагчийн хийц



а -хос хөлтэй, б-нэг хөлтэй

г) Ургаа модыг аянга хүлээн авагчийн тулгуур болгон ашиглахыг хориглоно.

д) Савхан аянга зайлцуулагчийн аянга хүлээн авагч ган хийцийн хөндлөн огтлолын талбай 100 мм^2 -аас багагүй байна. (энэ бүлгийн зураг 14)


Аянга хүлээн авагчийн урт 0.2 метрээс багагүй байна. Аянга хүлээн авагчийг цайрдах, тугалга гүйлгэх, будах зэргээр зэврэлтээс хамгаална.

е) Тросон аянга зайлуулагчийн аянга хүлээн авагчийг 35 mm^2 -аас багагүй хөндлөн огтлолтой олон багцтай зэврэлтээс хамгаалсан ган трессоор хийнэ.

ё) Аянга хүлээн авагч нь гүйдэл зайлуулагчтай гагнаасаар, харин гагнаас хэрэглэх боломжгүй бол 0.05 Ом-оос илүүгүй шилжилтийн эсэргүүцэлтэй боолтон холболтоор холбоно.

Байгууламжийн металл дээврийг гүйдэл зайлуулагчтай холбоходо хавчаар хэрэглэж (Х бүлэг, Зураг 15) болно. Холболтын гадаргуугийн талбай нь гүйдэл зайлуулагчийн огтлолын талбайг 2 дахин авснаас багагүй байна.

Зураг 14. Аянга хүлээн авагчийн хийц



а ,б металл утсаар хийсэн;

в хоолойгоор;

г туузан металлаар;

д булан төмрөөр;

1 гүйдэл дамжуулагч

з) Гүйдэл зайлуулагч, богино холболт, газардуулагч зэргийг хийх хэлбэржүүлсэн гангийн хэмжээг хүснэгт 20-д зааснаас багагүй хэмжээтэй хийнэ.

Хүснэгт 20. Гүйдэл зайлуулагч, богино холболт, газардуулагч зэргийг хийх хэлбэржүүлсэн гангийн хэмжээ

| Төрөл | Гүйдэл зайлуулагчийг байрлуулах газар | |
|---|---------------------------------------|------------|
| | Барилгын гадна талд агаараар | Газар дээр |
| Дугуй гүйдэл зайлуулагч болон богино холболтын диаметр, мм | 6 | — |
| Дугуй босоо электродын диаметр, мм | — | 10 |
| Дугуй хэвтээ электродын диаметр, мм* | — | 10 |
| Квадрат болон туузан гангаар хийгдсэн тэгш өнцөгтийн хөндлөн огтлолын: талбай, mm^2 зузаан, мм | 48 4 | 160 4 |
| Булан гангаар хийгдсэний хөндлөн огтлолын: талбай, mm^2 зузаан, мм | — — | 160 4 |
| Ган хоолойн хананы зузаан, мм | — | 3.5 |

*Эдгээрийг зөвхөн газардуулагчийг далдлах, барилгын доторх потенциалыг тэгшигтгэх зорилгоор хэрэглэнэ.

Газардуулагч төхөөрөмж

883. Электрод (гадас)-ын хөрсөн дэх байрлал, хэлбэрээр газардуулагчийг доорх байдлаар ангилина. Үүнд:

а) далдлагдсан газардуулагч-Энэ газардуулагчийг барилгын суурийн тойргийн дагуу үргэлжилсэн элемент, эсвэл хүрээ хэлбэртэй шуудууны ёроолоор тавигдсан туузан (40x4 мм хөндлөн огтлол бүхий талбайтай), эсхүл дугуй (20 мм диаметртэй) хэлбэрийн гангаар хийнэ. Цахилгааны хувийн эсэргүүцэл $\rho \geq 500$ Ом.м байх хөрсөнд далдлагдсан газардуулагчаар төмөр бетонон шон, мөн бусад төрлийн төмөр бетонон суурийн арматурыг ашиглаж болно;

б) хэвтээ газардуулагч-Энэ газардуулагчийг газрын гадаргаас 0.6-0.8 метрийн гүнд хэвтээгээр, эсвэл гүйдэл зайлцуулагчаар холбогдсон нэг цэгээс салбарласан хэд хэдэн цацрагаар хэвтээ байрласан туузан (40x4 мм огтлолтой), эсхүл дугуй (20 мм хөндлөн огтлолтой) гангаар хийнэ;

в) босоо газардуулагч-Энэ газардуулагчийг босоо эрэгдэж оруулсан ган савх (32-56 мм диаметртэй), эсвэл шигтгэж оруулсан булан гангаар (40x40 мм) хийсэн электродоор гагнаж хийнэ. Эрэгдэж бэхэлсэн босоо газардуулагчийн электродын урт 3-5 метр, харин шигтгэж гагнасан электродын урт 2.5-3 метр байна. Босоо газардуулагчийн дээд үзүүр нь газрын гадаргаас 0.5-0.6 метрийн гүнд суусан байна;

г) хосолсон газардуулагч-Энэ газардуулагчийг босоо ба хэвтээ газардуулагчийг нэг ерөнхий системд нэгтгэх замаар хийнэ. Гүйдэл зайлцуулагчийн холболт нь хосолсон газардуулагчийн хэвтээ хэсгийн дунд хийгдсэн байна. Хосолсон газардуулагчаар 0.5-0.6 метр гүнтэй суулгасан тор эсвэл босоо электродтой торыг хэрэглэнэ. Торны алхам 5-6 метрээс багагүй байна.

884. Газардуулагчийн электрод (гадас)-ын өөр хоорондоо болон гүйдэл зайлцуулагчтай холбосон бүх холболтыг гагнасан байна. Гагнаасын урт нь туузан гангийн өргөнөөс 2 дахин, дугуй гангийн диаметрээс 6 дахин их байна.

Зөвхөн түр газардуулгад болон энэхүү дүрмийн 878-д заасны дагуу гүйцэтгэсэн газардуулгын тусдаа хүрээнүүдийг хооронд нь холбоод боолтон холбоос хийхийг зөвшөөрнө. Газардуулагчийн холбоосын хөндлөн огтлолын талбай энэхүү дүрмийн IX бүлгийн хүснэгт 20-д зааснаас багагүй байна.





885. Газардуулагчийн төслийг зохиохдоо хөрсний нэгэн төрлийн бус байдлыг тооцно.





886. Газардуулагчийн хийцийг хөрсний хувийн эсэргүүцэл болон бүтцээс хамаарсан импульсийн шаардагдах эсэргүүцэл, тэдгээрийг байрлуулах ажлын тохиromжтой байдал зэргээс хамааруулан сонгоно. Газардуулагчийн төрөлжсөн хийц ба түүний үйлдвэрийн давтамжтай гүйдэл сарних эсэргүүцлийн R_{\sim} утгыг хүснэгт 21-д үзүүлэв.

Хувийн эсэргүүцэл нь 500 Ом.м-ээс бага хөрсөнд хэвтээ, эсхүл босоо төрлийн газардуулагч ашиглана. Нэгэн төрлийн бус цахилгаан дамжуулах чадвартай хөрсөнд буюу хөрсний дээд давхаргын хувийн эсэргүүцэл нь доод түвшингээс бага хөрсөнд хэвтээ газардуулагчийг, харин хөрсний доод давхаргын цахилгаан

дамжуулах чадвар нь дээд давхаргынхаас илүү тохиолдолд босоо газардуулагчийг хэрэглэнэ.

Хүснэгт 21. Газардуулагчийн төрөлжсөн хийц ба түүний үйлдвэрийн давтамжтай гүйдэл сарних эсэргүүцлийн утга

| Зураг | Төрөл | Материал | Хөрсний хувийн эсэргүүцэл, Ом.м, | | | |
|---|---|---|-------------------------------------|-----|-----|------|
| | | | 50 | 100 | 500 | 1000 |
|  | Босоо савх | Ган булан төмөр 40x40x4мм | | | | |
| L = 2 метр | 19 | 38 | 190 | 380 | | |
| L = 3 метр | 14 | 28 | 140 | 280 | | |
| Ган саваа Ф=10-20мм | | | | | | |
| L = 2 метр | 24 | 48 | 240 | 480 | | |
| L = 3 метр | 17 | 34 | 170 | 340 | | |
| L = 5 метр | 14 | 28 | 140 | 280 | | |
|  | Хэвтээ түүзэн | Ган тууз 4x40мм | | | | |
| L = 2 метр | 22 | 44 | 220 | 440 | | |
| L = 5 метр | 12 | 24 | 120 | 240 | | |
| L = 10 метр | 7 | 14 | 70 | 140 | | |
| L = 20 метр | 4 | 8 | 40 | 80 | | |
| L = 30 метр | 3.2 | 6.5 | 35 | 70 | | |
|  | Дундаждаа гүйдлийн оролтой хэвтээ түүзэн | Ган тууз 4x40мм | | | | |
| L = 5 метр | 9.5 | 19 | 95 | 190 | | |
| L = 10 метр | 5.85 | 12 | 60 | 120 | | |
| L = 12 метр | 5.4 | 11 | 54 | 110 | | |
| L = 24 метр | 3.1 | 6.2 | 31 | 62 | | |
| L = 32 метр | Хэрэглэгд-дэггүй | | 24 | 48 | | |
| L = 40 метр | Хэрэглэгд-дэггүй | | 20 | 40 | | |
|  | Хэвтээ гурван цацрагтай | Ган тууз 4x40мм | | | | |
| L = 6 метр | 4.6 | 9 | 45 | 90 | | |
| L = 12 метр | 2.6 | 5.2 | 26 | 50 | | |
| L = 16 метр | 2 | 4 | 20 | 40 | | |
| L = 20 метр | 1.7 | 3.4 | 17 | 34 | | |
| L = 32 метр | Хэрэглэгд-дэггүй | | 14 | 28 | | |
| L = 40 метр | Хэрэглэгд-дэггүй | | 12 | 24 | | |
|  | Хосолсон хоёр савхан | Ган булан төмөр 40x40x4мм, Ган тууз 4x40мм: | | | | |
| C=3м; L = 2.5 метр | 7 | 14 | 70 | 140 | | |
| C=3м; L = 3 метр | 6 | 12 | 60 | 120 | | |
| C=6м; L = 2.5 метр | 5.5 | 11 | 55 | 110 | | |
| C=6м; L = 3 метр | 4.5 | 9.1 | 45 | 90 | | |
| Ган саваа Ф10x20мм, Ган тууз 4x40мм: | | | | | | |
| C=3м; L = 2.5 метр | 7.5 | 15 | 75 | 150 | | |
| C=3м; L = 3 метр | 6.8 | 14 | 70 | 140 | | |
| C=5м; L = 2.5 метр | 6 | 12 | 60 | 120 | | |
| C=5м; L = 3 метр | 5.5 | 11 | 55 | 110 | | |
| C=3м; L = 5 метр | 5.5 | 11 | 55 | 110 | | |
| C=5м; L = 5 метр | 4 | 8 | 40 | 80 | | |
|  | Хосолсон гурван савхан | Ган булан төмөр 40x40мм, Ган тууз 4x40мм: | | | | |
| C=3м; L = 2.5 метр | 4 | 8 | 40 | 80 | | |
| C=6м; L = 2.5 метр | 3 | 6 | 30 | 60 | | |
| C=7м; L = 3 метр | 2.7 | 5.4 | 27 | 55 | | |
| Ган саваа Ф10x20мм, Ган тууз 4x40мм: | | | | | | |

| Зураг | Төрөл | Материал | Хөрсний хувийн эсэргүүцэл, Ом.м, | | | |
|---|---------------------------------|--|----------------------------------|-----|------|------|
| | | | 50 | 100 | 500 | 1000 |
|  | | C=2,5M; L = 2.5 метр | 4.8 | 9.7 | 50 | 100 |
| | | C=2,5M; L = 2 метр | 4.4 | 8.9 | 45 | 90 |
| | | C=5м; L = 2.5 метр | 3.5 | 7.1 | 36 | 70 |
| | | C=5м; L = 3 метр | 3.3 | 6.6 | 33 | 65 |
| | | C=6м; L = 5 метр | 2.7 | 5.4 | 27 | 55 |
|  | Хосолсон таван савхан | Ган булан төмөр 40x40мм, Ган тууз 4x40мм: | | | | |
| | | C=5м; L = 2 метр | 2.2 | 4.4 | 22 | 44 |
| | | C=5м; L = 3 метр | 1.9 | 3.8 | 19 | 38 |
| | | C=7,5м; L = 2 метр | 1.8 | 3.7 | 18.5 | 37 |
| | | C=7,5м; L = 3 метр | 1.6 | 3.2 | 16 | 32 |
|  | Хосолсон дөрвөн савхан | Ган саваа Ф10x20мм, Ган тууз 4x40мм: | | | | |
| | | C=5м; L = 2 метр | 2.4 | 4.8 | 24 | 48 |
| | | C=5м; L = 3 метр | 2 | 4.1 | 20.5 | 41 |
| | | C=7,5м; L = 2 метр | 2 | 4 | 20 | 40 |
| | | C=7,5м; L = 3 метр | 1.7 | 3.5 | 17.5 | 35 |
| | | C=5м; L = 5 метр | 1.9 | 3.8 | 19 | 38 |
|  | Төвдөө гүйдлийн оролттой хэвтээ | Ган булан төмөр 40x40мм, Ган тууз 4x40мм: | | | | |
| | | C=6м; L=3 метр | 2.1 | 4.3 | 21.5 | 43 |
| | | Ган тууз 4x40мм: | | | | |
| | | D = 4 метр | 4.5 | 9 | 45 | 90 |
| | | D = 6 метр | 3.3 | 6 | 33 | 66 |
| | | D = 8 метр | 2.65 | 5.3 | 26.5 | 53 |
| | | D = 10 метр | 2.2 | 4.4 | 22 | 44 |
| | | D = 12 метр | 1.9 | 3.8 | 19 | 38 |

887. Газардуулагч бүр өөрийн импульсийн эсэргүүцлээр, өөрөөр хэлбэл аянгын гүйдэл сарних R_u эсэргүүцлээр тодорхойлогдоно. Газардуулагчийн импульсийн эсэргүүцэл R_u нь түгээмэл хэрэглэгддэг аргаар тооцоолон гаргаж авсан R_u - эсэргүүцлээс нэлээд ялгаатай. Түүний хэмжээг доорх томьёогоор тодорхойлно.

$$R_u = \alpha^* R, \sim \quad (8)$$

Энд α - аянгын гүйдлийн хэмжээ, хөрсний хувийн эсэргүүцэл, газардуулагчийн хийц зэргээс хамаарсан импульсийн итгэлцүүр.

Хөрсний янз бүрийн ρ хувийн эсэргүүцэлтэй үеийн $\alpha \leq 1$ байхыг батлаж байгаа хэвтээ газардуулагчийн уртын (хязгаарын) хэмжээг хүснэгт 22-т харуулав.

Хүснэгт 22. Хэвтээ газардуулагчийн уртын (хязгаарын) хэмжээ

| ρ , Ом.м | 500 хүртэлх | 500 | 1000 | 2000 | 4000 |
|------------------|-------------|-----|------|------|------|
| L_{max} , метр | 25 | 35 | 50 | 80 | 100 |

Их урттай газардуулагч нь L_{max} -ээс илүү гарсан урт хэсэг дээр импульсийн гүйдлийг бараг дамжуулж чаддаггүй.

Хөрсний янз бүрийн хувийн эсэргүүцэлтэй байх үеийн импульсийн α итгэлцүүрийн утгуудыг хүснэгт 23-д үзүүлэв.

Хүснэгт 23. Хөрсний янз бүрийн хувийн эсэргүүцэлтэй байх үеийн импульсийн α итгэлцүүр

| Газардуулагчийн төрөл | $\rho_{херс}$ гэсэн хөрсний хувийн эсэргүүцэлтэй, Ом.м байх үеийн импульсийн α итгэлцүүрийн утга | | | | |
|-----------------------|---|-----|-----|------|----------------------|
| | 100 хүртэлх | 100 | 500 | 1000 | 2000 ба түүнээс дээш |
| Босоо | 0.9 | 0.9 | 0.7 | 0.5 | 0.35 |
| Хэвтээ | 0.9 | 0.8 | 0.6 | 0.4 | 0.3 |
| Хосолсон | 0.9 | 0.7 | 0.5 | 0.3 | - |

Импульсийн итгэлцүүрийг аянгын гүйдлийн амплитиудын утга 60 кА ба крутизны утга 20 кА/мкс үед тодорхойлсон болно.

888. Газардуулагчийг угсарсны (монтажлах) дараа сарнилтын тооцооны эсэргүүцлийг шууд хэмжилтээр шалгана. Хэмжилтийг зуны улиралд, хуурай нөхцөлд хийнэ.

Хувийн эсэргүүцэл нь $\rho > 500$ Ом.м хөрсөнд бие даасан тусдаа газардуулагчийг өөр хооронд нь ган туузаар холбохыг зөвшөөрнө. Хэрэв газардуулагчийн хэмжилтээр гарсан эсэргүүцэл нь тооцооныхос хэтэрвэл, 500 Ом.м ба түүнээс дээш хувийн эсэргүүцэлтэй хөрсөнд хоорондоо энэхүү дүрмийн 876 дугаар зүйлд зааснаас илүүгүй зайдай байрласан зэргэлдээ агуулахуудын аянга зайлцуулагчийн газардуулагчийг өөр хооронд нь холбоно.

Тэсрэх материалын агуулахын аянгын хамгаалалтын төсөл зохиох, хүлээн авах

889. Төсөл нь доорх агуулгатай байна.

-хамаараагдаж байгаа бүх байгууламжийг багтаан хамтад нь харуулсан агуулахын дэвсгэр зураг;

-аянгын хамгаалалтын бүх элементийн үндэслэл, хэмжээ зэргийг харуулсан аянгын шууд цохилтын хамгаалалтын бүсийн тооцоо;

-шаардлагатай тохиолдолд аянгын хоёрдогч үйлчлэлийн хамгаалалтын тооцоо, эсхүл түүний шаардлагагүйг нотолсон тайлбар;

- бүтээцийн ажлын зураг;
- материалын тодорхойлолтын жагсаалт.

890. Угсарсан аянгын хамгаалалтын төхөөрөмжийг зөвхөн тогтсон журмын дагуу комисс хүлээн авсны дараа ашиглалтад орсонд тооцно.

Аянгын хамгаалалтыг шалгах

891. Тэсрэх материалын агуулах, үйлдвэрийн аянгын хамгаалалтыг аянга буух үеэс өмнөх улиралд жилд нэгээс доошгүй удаа, түүнчлэн холбогдох байгууламжид гэмтэл илэрсний дараа тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын томилсон комисс шалгана. Агуулах, үйлдвэрийг эзэмшигч байгууллагын комиссын бүрэлдэхүүнд цахилгаанчин (цахилгаан механик), тэсрэх материалын агуулах, үйлдвэрийн эрхлэгч, тэсэлгээний ажлын удирдагч зэрэг мэргэжилтнүүд оролцно.

Аянгын хамгаалалтын төхөөрөмжийн гаднах үзлэгийг агуулахын эрхлэгч тодорхой графикаар сард 1-ээс доошгүй удаа тогтмол хийнэ.

Аянгын хамгаалалтын үзлэг шалгалтад дараахь зүйл орно:

- а) аянгын хамгаалалтын төхөөрөмжийн гаднах өрөнхий үзлэг;
- б) аянгын хамгаалалтын газардуулагчийн эсэргүүцэл хэмжих;
- в) аянгын хоёрдогч үйлчлэлийн хамгаалалтын төхөөрөмжийн холболтуудын шилжилтийн эсэргүүцлийг шалгах.

892. Аянгын хамгаалалтын гадна үзлэгийн үр дүнгийн тухай акт үйлдэнэ. Харин газардуулагчийн эсэргүүцлийн хэмжилтийн үр дүнг тогтсон журмын дагуу аянгын хамгаалалтын газардуулагчийн байдлын дэвтэрт тэмдэглэл хийнэ.

893. Аянгын хамгаалалтын төхөөрөмжийн гаднах үзлэгээр аянга хүлээн авагч, гүйдэл зайлцуулагч, тулгууран багана болон аянгын хоёрдогч үйлчлэлийн хамгаалалтын газрын дээрх хэсгийн гагнаас ба холболтуудын хэвийн байдлыг заавал дуран ашиглан тодорхойлсон байна.

894. Аянга хүлээн авагчийн үзлэгийн үед конусан төгсгөвчийн бүтэн байдал, түүний тугалган түрхэцийн байдал, гүйдэл зайлцуулагчтай холбогдсон холболтын найдвартай нягт байдал, зэврэлт байгаа эсэх, боолтон холболтын гадаргуугийн цэвэр байдал зэргийг шалгасан байна. Үзлэгээр хөндлөн огтлолын талбайн гуравны нэгээс илүү хэсэг зэвэрсэн, хайлсан эсхүл гэмтсэн конусан төгсгөвчтэй аянга зайлцуулагч байвал түүнийг солино. Үзлэгийн дараа гэмтсэн тугалган түрхэц, цайрдалт зэргийг сэргээж, харилцах гадаргуугийн зэвийг арилгаж, супарсан холболтыг чангалаа.

895. Гүйдэл зайлцуулагчийн үзлэгийн үед түүнд нугаралт, мушгирант үүссэн эсэх, холболтын бүрэн бүтэн нягт байдал, зэврэлт ба гэмтэл зэргийг тодорхойлно. Зэвэрсэн гүйдэл зайлцуулагчийн хөндлөн огтлолын талбай 50 mm^2 -аас багассан байвал шинэчилнэ.

896. Үзлэгээр модон тулгууран баганын өмхөрсөн (мөөгөнцөрт идэгдсэн) зэрэглэлийг тодорхойлно. Хөндлөн огтлолын талбайн гуравны нэг нь өмхөрч муудсан баганыг шинээр солино.

897. Цахилгаан статик индукцээр үүсгэгдэх аянгын хоёрдогч үйлчлэлийн хамгаалалтын газрын дээрх хэсэгт үзлэг хийх үед торны ба гүйдэл зайлцуулагчийн бүрэн бүтэн байдал, тэдгээрийн холболтын нягт найдвартай байдал, зэврэлтээр гарсан гэмтлийн зэрэглэл зэргийг шалгана. Торны ба гүйдэл зайлцуулагчийн зэврэлтэд идэгдсэн хөндлөн огтлолын талбай 16 mm^2 -аас дээш хэмжээнд хүрсэн бол, гэмтсэн хэсгийг солино.


898. Аянгын хоёрдогч үйлчлэлийн хамгаалалтын төхөөрөмжийг шалгах үед богино холболтын бүрэн бүтэн байдлыг тодорхойлж, контактын шилжилтийн эсэргүүцлийг хэмжинэ. Тэр нь энэхүү дүрмийн 879-д заасан утгаас ихгүй байна. Энэ үед аянгын хоёрдогч үйлчлэлийн хамгаалалтын газардуулагчтай газардуулгын бүх элементүүдийн холбогдсон байдлыг шалгана.

899. Аянга хамгаалалтын газардуулагчийн эсэргүүцлийн хэмжилтийг цахилгаан хэмжлийн тусгай багажаар, эсвэл хөрсний өндөр хувийн эсэргүүцэлтэй үед вольтметр-амперметрийн гурван хэмжилтийн аргаар хийнэ. Холболтын эсэргүүцлийг микроомметр багажаар хэмжинэ. Хэмжигдсэн эсэргүүцлийг тогтсон журмын дагуу тэсрэх материалын агуулах дээр аянгын хамгаалалтын газардуулагчийн байдлын баримт дээр тэмдэглэнэ.

900. Гурван электродын схемээр газардуулагчийн эсэргүүцлийг хэмжинэ.

Газардуулагчийн эсэргүүцлийг хэмжихдээ энэ бүлгийн зураг 15-д үзүүлсэн гүйдлийн T ба потенциалын П электродуудын байрлалын жишиг схемийг хэрэглэнэ.

Зураг 15. Нийлмэл газардуулагчийн эсэргүүцлийг хэмжих үеийн электродуудын байрлалын схем



- а -хоёр цацрагтай;
- б -нэг цацрагтай;
- П -потенциалын электрод;
- Т -гүйдлийн электрод.


$D > 40$ метр үед α хэмжээ D -гээс багагүй байх ёстой. $D < 40$ метр үед α хэмжээ 40 метр байна. $D = 10$ метр үед $\alpha = 20$ метр байна.

Хэмжилтийн электродыг байрлуулах газрыг аянгын хамгаалалтын төсөл зохиох үед тогтооно. Хэмжилтийн электродыг аянгын хамгаалалтын газардуулагчийг байгуулах үед байрлуулна. Туслах газардуулагчаар хэмжигдэж байгаа газардуулагчтай холбогдоогүй, зэргэлдээ аянга зайлцууллагчийн аль нэгийг ашиглаж болно.

901. Газардуулагчийн эсэргүүцлийн хэмжилтийг вольтметр-амперметрийн гурван хэмжилтийн аргаар хийж болно. Энэ бүлгийн зураг 16-д дөрвөн аянга зайлцуулагчаас тусдаа бие даасан дөрвөн газардуулагчийн схем зургийг үзүүлэв.

1, 2, 3 дугаартай гурван газардуулагчийн эсэргүүцлийг Ом-оор хэмжихдээ хос хосоор хийнэ.

Зураг 16. Гурван хэмжилтийн аргаар газардуулагчийн эсэргүүцлийг хэмжих схем



$$\text{Хэмжилт 1} \quad R_1 + R_2 = a$$

$$\text{Хэмжилт 2} \quad R_1 + R_3 = b \quad (9)$$

$$\text{Хэмжилт 3} \quad R_2 + R_3 = c$$

Эндээс газардуулагч бүрийн эсэргүүцлийг Ом-оор олно:

$$\begin{aligned} R_1 &= \frac{a+b-c}{2}; \\ R_2 &= \frac{a+c-b}{2}; \\ R_3 &= \frac{b+c-a}{2}. \end{aligned} \quad (10)$$

4 газардуулагчийн эсэргүүцлийг олох зорилгоор өөр хоёр /дөрөв ба тав дах/ нэмэлт хэмжилтийг хийнэ.

$$\text{Хэмжилт 4} \quad R_4 + R_3 = d, \quad (11)$$

$$\text{Хэмжилт 5} \quad R_4 + R_2 = e.$$

Эндээс 4 газардуулагчийн эсэргүүцлийг олно.

$$R_4 = \frac{d+e-c}{2}, \quad (12)$$

Хэрэв олон газардуулагч байгаа бол бусад газардуулагчийн эсэргүүцлийг мөн дээрх томьёоны адил дэс дарааллан хэмжинэ.

Нэг газардуулагчтай үед нэг, хоёр газардуулагчтай үед хоёр ширхэг туслах газардуулагчийг хийнэ.

902. Газардуулагчийн импульсийн R_1 эсэргүүцлийг тодорхойлохын тулд түүний хэмжигдсэн эсэргүүцлийг газардуулагчийн төрөл, хөрсний хувийн эсэргүүцэл зэргээс хамааруулан, хүснэгт 18-д заасан α импульсийн итгэлцүүрээр үржүүлнэ. Хөрсний хувийн эсэргүүцлийг төсөл зохиохын өмнөх хайгуулын шатанд хэмжсэн байна. Ашиглалтын болон шинэчилэлийн үед мегаомм багажийг хэрэглэн 4 электродын схемээр хэмжилтийг хийнэ. Хөрсний хувийн эсэргүүцлийн тооцооны ρ утгыг $\rho=2\pi RaK_y$ томьёогоор тодорхойлно.

Энд: R – багажийн заалт, Ом; a -электрод хоорондын зайд, метр; K_y -хөрсний хөлдөлт болон гэсэлтээс хамаарсан улирлын итгэлцүүр

Хүснэгт 24. Тэсрэх материалын агуулахын аянгын хамгааллтын газардуулгын шалгалтын бүртгэл

I. Газардуулгын үндсэн үзүүлэлтүүд

| | | | | | | | | | | | |
|------------------|----------------------------------|--------------------------|------------------------------------|--------------------|-----------------|----------------|-----------------|---|----------|------------|------------|
| Агуулахын дугаар | Будууч дээрх газардуултын дугаар | Газардуулга хийсэн огноо | Газардуулгын бүтэц, зургийн дугаар | Цаг агаарын байдал | Хэмжилтийн өмнө | Хэмжилтийн үед | Хэмжилтийн арга | Хөрсний хувийн цахилгаан эсэргүүцэл, Ом * м | Тооцооны | Хэмжилтээр | Импульсийн |
|------------------|----------------------------------|--------------------------|------------------------------------|--------------------|-----------------|----------------|-----------------|---|----------|------------|------------|

Техникийн үзүүлэлтүүдийг оруулсан

(албан тушаал, овог нэр, гарын үсэг)

Хэмжилт хийсэн _____
(гарын үсэг)

II. Аянгын хамгаалалтын үзлэг, хэмжилтийн үр дүн

| | | | | | | | |
|--|-------------------------------------|-----------------|--------------------|-----------------|----------|----------------------------------|---------|
| | Агуулахын дугаар | | | | | | |
| | Будувч дээрх газардуулт гын дугаар | | | | | | |
| | Төхөөрөмжид үзлэг хийсэн огноо | | | | | | |
| | Төхөөрөмжийн гадаад үзлэгийн үр дүн | | Цаг агаарын байдал | | | | |
| | | Хэмжилтийн өмнө | | | | | |
| | | | Хэмжилтийн үед | | | | |
| | | | | Хэмжилтийн арга | | | |
| | | | | | Тооцооны | Гүйдэл тарж урсах эсэргүүцэл, Ом | |
| | | | | | | Хэмжилтээр | |
| | | | | | | | Дүгнэлт |

Үзлэг, хэмжилт гүйцэтгэсэн

(албан тушаал, овог нэр, гарын үсэг)

(албан тушаал, овог нэр, гарын үсэг)

Тэсрэх материалын агуулахын аянгын хамгаалалтын тооцооны жишээ

903. Урт нь 50 метр, дээврийн түвшин дэх өргөн 16 метр, гонхоны дээврийн өндөр 4.7 метр, агуулахын тэнхлэгээс гонхоны хаалга хүртэлх зайд 11.1 метр хэмжээтэй тэсрэх материал хадгалах байрны аянгын хамгаалалтыг тооцьё. Модон барилга. Хөрсний тооцооны хувийн цахилгаан эсэргүүцэл 450 Ом. Аянга зайлцуулагчийн газардуулагчийн шаардлагатай импульсийн эсэргүүцэл $R_u = 10$ Ом. Агуулахын барилгыг түүний хоёр буланд байрлуулсан хос савхан аянга зайлцуулагчаар аянгын шууд ниргэлтээс хамгаалах нь илүү тохиромжтой байх болно.

$R_u = 10$ Ом байхад савхан аянга зайлцуулагч болон агуулахын хоорондох газрын дээрх зөвшөөрөгдөх зайд (Энэ бүлгийн Зураг 3.) $S_e \approx 4$ метр. Агуулах, аянга зайлцуулагчийн хоорондуур машин явах шаардлагатайг тооцон дээрх зайд 5 метрээр авьяя. Ингээд хоёр савхан аянга зайлцуулагчийн хоорондын зайд $L = 50 + 2 * 5 = 60$ метр.

Тэсрэх материалын агуулахыг аянгын шууд ниргэлтээс найдвартай хамгаалахын тулд түүний бүх хэсэг h өндөртэй хоёр савхан аянга зайлцуулагчийн үүсгэсэн хамгаалалтын бүсэд бүтэн багтсан байр ёстой.

Хос савхан аянга зайлцуулагчийн хамгаалалтын хүрээ үүсгэх нөхцөлийн (энэ бүлгийн 2.1. зүйл) дагуу аянга зайлцуулагчийн шаардлагатай өндрийг тодорхойлъё.

$$h = L/3 = 60/3 = 20 \text{ метр}$$

Хамгаалалтын бүсийн булангийн хэсгийн үндсэн хэмжээсүүдийг ганц савхан аянга зайлуулагчийн хамгаалалтын бүсийн нэгэн адил энэ бүлгийн (1) томъёогоор тодорхойль ё.

Хамгаалалтын конусын оройн өндөр:

$$h_o = 0.85 * h = 0.85 * 20 = 17 \text{ метр}$$

Газар дээр үүсэх хамгаалалтын бүсийн радиус:

$$r_o = (1.1 - 0.002h)h = (1.1 - 0.002 * 20) * 20 = 21.2 \text{ метр}$$

Агуулахын тэнхлэгээс хамгийн хол ($r_y = 11.1$) цэг болох гонхоны дээврийн түвшинд ($h = 4.7$ метр) хийсэн хэвтээ хавтгайн огтлолын үүсгэх радиус:

$$r_x = (1.1 - 0.002h) * [h - (h_x / 0.85)] = (1.1 - 0.002 * 20) * [20 - (4.7 / 0.85)] = 15.35 \text{ метр}$$

Хос савхан аянга зайлуулагчийн хамгаалалтын бүсийг (3) томъёогоор тодорхойль ё.

Хос савхан аянга зайлуулагчийн хамгаалалтын бүсийн конусын оройн өндөр:

$$h_c = h_o - (0.17 + 3 * 10^{-4} * h) * (L - h) = 17 - (0.17 + 3 * 10^{-4} * 20) * (60 - 20) = 9.96 \text{ метр}$$

Газар дээрх хамгаалалтын бүсийн тойргийн радиус:

$$r_c = r_o = 21.2 \text{ метр}$$

Агуулахын тэнхлэгээс хамгийн хол зайд орших цэг болох $h = 4.7$ метр өндөр дэх хамгаалалтын бүсийн r_{cx} радиус:

$$r_{cx} = r_o * [(h_c - h_x) / h_c] = 21.2 * [(9.96 - 4.7) / 9.96] = 11.2 \text{ метр}$$

Энэ зайд нь $r_y = 11.1$ –ээс их байна.

Дээрх хэмжээсүүдээр хамгаалалтын бүсийн зурж шалгахад, агуулах нь $h = 20$ метр өндөртэй хос аянга зайлуулагчийн бүсэд бүрэн багтаж байна.

Аянга хүлээн авагчийн тулгуурыг 6.1.1-6.1.3. зүйлийн дагуу гүйцэтгэнэ.

Газардуулагчийг аянга зайлуулагч тус бүрийн суурийн дэргэд байрлуулна.

Манай жишээнд, 450 Ом.м. хувийн цахилгаан эсэргүүцэлтэй хөрсөнд шаардлагатай импульсийн эсэргүүцэл $R_u=10$ Ом байгаа. Түүнийг мөн газардуулагчаас агуулахтай холбоотой байгууламж хүртэлх газар доорх зайгаар тодорхойлно. Энэ тохиолдолд агуулахтай холбоотой газар доорх байгууламж нь агуулахыг тойруулан хананаас нь 0,8 метр зайд байрлуулсан аянгын хоёрдогч үйлчлэлээс хамгаалах зориулалттай ган тууз юм. Иймээс аянга зайлуулагчийн газардуулагчийн импульсийн эсэргүүцэл (энэхүү дүрмийн 876-р зүйлийг хар)

$$R_u \leq (S_3 / 0.5) = 5.0 / 0.5 = 10 \text{ Ом} - \text{oos илүүгүй байх ёстой.}$$

Аянга зайлцууллагчийн газардуулагчаар газрын гадаргуугаас 0,8 метр гүнд суулгасан, хэвтээ байрлалтай, 40x4 мм-ийн ган туузаар хийсэн, $l = 20$ метр урттай Зцацрагийг сонгож авъя.

Тийм газардуулагчийн үйлдвэрлэлийн давтамжтай гүйдлийн тархалтын эсэргүүцэл энэхүү хавсралтын хүснэгтэд заасныг (17 Ом) интерполяци хийсний дараа $R_u = 15.3$ Ом байна.

Импульсийн коэффициент α -г энэхүү бүлгийн Хүснэгт 6-ийн дагуу тодорхойлбол, $\rho = 450$ Ом.м хөрсний хувийн цахилгаан эсэргүүцэлтэй хэвтээ газардуулагчид $\alpha \approx 0.6$ байна.

Өгөгдсөн хөрсний хувийн цахилгаан эсэргүүцэл болон газардуулагчийн бүтцийн хувьд багажаар хэмжсэн 15.3 Ом эсэргүүцлийн тархалтанд $R_u = \alpha R_1 = 0.6 * 15.3 = 9.18$ Ом газардуулагчийн импульсийн эсэргүүцэл харгалзан тохирч байна.

Агуулахад метал байгууламжийн болон гэрэлтүүлгийн кабелийн оруулга байхыг харгалзан аянгын хоёрдогч үйлчлэлээс хамгаалах нь зүйтэй.

Хоёрдох үйлчлэлийн хамгаалалтыг барилга дээр ган утсааар тор татаж хийнэ. Ган утсыг барилгын нуруу, дээврийн хормой дагуулан байрлуулах бөгөөд 14 босоо буултаар хоёрдогч үйлчлэлийн хамгаалалтын газардуулгад холбоно. Мөн энэ газардуулгад гэрэлтүүлгийн кабелийн хамгаалалтын бүрээсийг холбоно.

ТЭСЭЛГЭЭНИЙ АЖЛЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ
ДҮРМИЙН ХАВСРАЛТУУД

ТЭСРЭХ МАТЕРИАЛЫН ХАМТАТГАХ БҮЛГИЙН АНГИЛАЛ

| Хамтатгах бүлэг (аюулын зэрэг) | Бодис, бүтээгдэхүүн |
|--------------------------------------|--|
| B | Өдөөгч тэсрэх бодис агуулсан бөгөөд хоёр хүртэл үл хамаарах хамгаалалтын төхөөрөмжтэй бүтээгдэхүүн. Түүнчлэн ердийн детонатор, детонатор агуулсан хэрэгсэл, ба өдөөгч тэсрэх бодис агуулаагүй детонаторууд орно. |
| C | Шидэх үйлчилгээтэй тэсрэх бодис ба бүтээгдэхүүн (утаагүй дарь) |
| D | Тэсрэх бодис. Тэсэлгээний хэрэгсэл ба шидэх үйлчилгээтэй цэнэг агуулаагүй тэсрэх бодис бүхий бүтээгдэхүүн. Өдөөгч тэсрэх бодис агуулсан бөгөөд хоёр ба түүнээс дээш тооны үл хамаарах хамгаалалтын төхөөрөмжтэй бүтээгдэхүүн |
| E | Тэсэлгээний хэрэгсэлгүй тэсрэх бодис агуулсан, гэхдээ шидэх үйлчилгээтэй цэнэг бүхий бүтээгдэхүүн (хялбархан дөл авалцдаг шингэн, гель буюу өөрөө шатдаг шингэнээс бусад) |
| F | Хоёрдогч тэсрэч дэлбэлэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ба шидэх үйлчилгээтэй цэнэг агуулсан, эсвэл шидэх үйлчилгээтэй цэнэг агуулаагүй бүтээгдэхүүн |
| G | Пиротехникийн бодис, түүнийг агуулсан бүтээгдэхүүн |
| N | Мэдрэмтгий чадвар нь онцгой муу тэсрэх бодис агуулсан бүтээгдэхүүн |
| S | Гадны гэнэтийн үйлдлээс цочрол авч тэсрэх аюул тохиолдоход түүний үйлчилгээг хязгаарлах сав, баглаа боодолтой, хэрэв сав баглаа нь галд өртөж гэмтвэл тэсрэлтийн нөлөө цацалт нь аваар устгах, гал унтраахаар сав баглааны дэргэд хүн ажиллахад саад болохгүйгээр тусгайлан бүтээгдсэн бодис, бүтээгдэхүүн |

ТЭСРЭХ МАТЕРИАЛЫН ДЭД АНГИЙН АНГИЛАЛ

| Дэд анги | Дэд ангийн нэр |
|----------|---|
| 1.1 | Бөөнөөр тэсрэх аюултай тэсрэх материалууд |
| 1.2 | Бөөнөөр тэсрэхгүй, гэхдээ тэсрэлтээр цацалт үүсгэх болон орчны зүйлийг гэмтээх аюултай тэсрэх материалууд |
| 1.3 | Бөөнөөр тэсрэхгүй, шатах аюултай тэсрэх материалууд |
| 1.4 | Тээвэрлэлтийн явцад гал гарах буюу өдөөсөн тохиолдолд бага зэргийн тэсрэлтийн аюултай тэсрэх материал. Тэсрэлтийн үйлчлэл нь сав баглаагаар хязгаарлагдана. Гадны өдөөх эх үүсвэр сав баглаа дотор огцом тэсрэлт үүсгэхгүй. |
| 1.5 | Бөөнөөр тэсрэх аюултай, гэхдээ мэдрэмтгий чадвар нь маш бага, тээвэрлэлтийн хэвийн нөхцөлд өдөөлт үүсэх ёсгүй буюу шаталтаас тэсрэлтэд шилжихгүй тэсрэх материалууд |
| 1.6 | Тохиолдлын өдөөлтөд өртөх магадлал багатай, бөөнөөр тэсрэхгүй, нэн бага мэдрэх чадвартай тэсрэх тэсрэх бодисоор хийсэн бүтээгдэхүүн. 1.6 дэд ангийн бүтээгдэхүүний аюул нь нэг бүтээгдэхүүний тэсрэлтээр хязгаарлагдана. |

“Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны
нэгдсэн дүрэм”-ийн Хавсралт 3

ТЭСРЭХ МАТЕРИАЛЫГ ХЭРЭГЛЭХ НӨХЦӨЛИЙН АНГИЛАЛ

| Тэсрэх бодисын анги | Тэсрэх бодисын групп | Тэсрэх бодисын төрөл ба хэрэглэх нөхцөл | Ялгах зурвас буюу боодлын өнгө |
|---------------------|----------------------|--|--------------------------------|
| I | - | Хамгаалалтгүй тэсрэх бодис Зөвхөн газрын гадарга дээр тэсэлгээ хийхэд хэрэглэнэ. | цагаан |
| II | - | Хамгаалалтгүй тэсрэх бодис Газрын гадарга дээрх болон газрын доорх шатамхай хий, нүүрс (занар)-ний тэсрэмтгий тоосны ялгаралтгүй малталаад буюу мөргөцгийг занаржуулж тэсрэмтгий орчин бий болохоос хамгаалсан нөхцөлд тэсэлгээ хийхэд хэрэглэнэ. | улаан |
| III | - | Хамгаалалттай тэсрэх бодис Тэсрэмтгий нүүрс (занар)-ний тоосны ялгаралтгүй, зөвхөн шатамхай хий ялгаруулдаг газрын доорх мөргөцгийн чулуулагт тэсэлгээ хийхэд хэрэглэнэ. | хөх |
| IV | - | Хамгаалалттай тэсрэх бодис Шатамхай хийн ялгаралтгүй, нүүрс (занар)-ний тоосны тэсрэлтийн аюултай далд уурхайн нүүрс, чулуулаг, шатамхай занарын малталаадын мөргөцөгт; Шатамхай хийн ялгаралтай, нүүрс хөрсний далд малталаадын нүүрсний давхаргаар нэвтэрч буй шатамхай хийн ихэссэн ялгаралтгүй мөргөцөгт; Нүүрсний далд уурхайн доргиох тэсэлгээнд тус тус хэрэглэнэ. | шар |
| V | - | Хамгаалалттай тэсрэх бодис Уулын чулуулгийн шпурт огтлогдсон ан цавын болон малталаад хий агаарын холимог шпурын цэнэгтэй шууд харьцахгүй байгаа тохиолдолд, шатамхай хийн ихэссэн ялгаралтай нүүрсний давхаргаар малтсан газрын доорх малталаадын нүүрс, чулуулагт тэсэлгээ хийхэд хэрэглэнэ. | шар |
| VI | - | Хамгаалалттай тэсрэх бодис Уулын чулуулгийн шпурт огтлогдсон ан цавын болон малталаад хий агаарын холимог шпурын цэнэгтэй шууд харьцахгүй байгаа тохиолдолд, шатамхай хийн ихэссэн | шар |

| | | | |
|------------|---|--|--------|
